МУИС-ийн Буддын Соёл Судалгааны төв

Лондон дахь Төвдийн фонд

ЛУВСАНЖАВЫН ЧУЛУУНБААТАР (Дэд доктор)

НҮҮДЭЛЧИН МОНГОЛЧУУДЫН БИЧИГ ҮСГИЙН СОЁЛ

/Лондон дахь Төвдийн фондын хамтын ажиллагааны төслийн хүрээнд хэвлэв/

Улаанбаатар
2002 он

The Research Centre for the Buddhist Culture, National University of Mongolia

Tibet Foundation in London

LUVSANJAVIIN CHULUUNBAATAR (Ph.D)

THE SCRIPT CULTURE OF NOMADIC MONGOLS

/Published in co-operation with
Tibet Foundation, London/

Ulaanbaatar
2002

Гарчиг

Уялга үг 5

Удиртгал 9

Нэгдүгээр бүлэг: Монгол нутагт төр улсаа байгуулж явсан эрт цагийн нүүдэлч ард түмнүүдийн соёлын түүхэн дэх бичиг үсгийн хэлбэрүүд.

▪1. Руни бичиг (Хүннү, Сүмбэ, Жужан, Турэг) 11

▪2. Эрт цагийн монгол бичиг (Их Нирун/Жужан/, Уйгар) 42

▪3. Хятадын дүрс үсгээс сэдэвлэж зохиосон бичиг үсэг. /Сүмбэ, Кидан/ 48

Хоёрдугаар бүлэг: Монголын эзэнт гүрний үеийн соёл, бичиг үсэг (1206-1368)

▪1. Монгол бичиг 56

▪2. Дөрвөлжин бичиг 84

Гуравдугаар бүлэг: XIV-XVIII үеийн Монголын нийгэм, соёлын түүхэнд бичиг үсгийн гүйцэтгэсэн үүрэг.

▪1. XIV-XVIII үеийн монгол бичгийн хөгжил болон түүхэнд гүйцэтгэсэн үүрэг 98

▪2. Монгол оронд Буддын шашин, соёл дэлгэрсэн хийгээд төвд бичиг үсгийн хэрэглээ 112

▪3. Галиг үсгийн систем үүссэн хийгээд Буддын соёл дэлгэрэхэд түүний гүйцэтгэсэн үүрэг (Аюуш Гүүшийн галиг үсэг) 147

▪4. Тод үсэг (Зая-бандида Намхай Жамц) 160

▪5. Өндөр гэгээн Занабазарын Соёмбо болон Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний соёл, түүхийн хүрээнд гүйцэтгэсэн үүрэг 168

▪6. Монгол үсгийн үндсэн дээр Манж үсгийг зохиосон хийгээд түүний хэрэглээ (XVI зууны II хагас - XIX зууны эхэн) 176

Дөрөвдүгээр бүлэг. XIX-XX зууны үеийн монголчуудын бичиг үсэг түүний халаа сэлгээ.

▪1. Вагиндарагийн үсэг буюу түүний зохиогч Агваан Дорж 188

▪2. Латин үсэгт шилжих төлөвлөгөө, түүний хэрэгжилт 194

▪3. Кирил үсгийг авсан хийгээд түүний цаашдын хөгжилт 206

▪4. 1990 оноос хойших Сонгодог монгол бичгийг сэргээн хэрэглэх хөдөлгөөн хийгээд үндсэн маргаан 213

Төгсгөлийн оронд 231

Ном зүй 240

Contents

Forward 5

Introduction 9

Part one. Scripts` shapes in the cultural history of ancient nomadic people who had been establishing their states in the territory of Mongolia

1. Runi script (Hunnu, Sumbe, Jujan, Turkye) 11
2. Ancient time`s Mongol script (Ikh Nirun/Jujan/, Uigar) 42
3. Script which was adapted from Chinese scripts (Sumbe, Kitan) 48

Part two. Scripts and Culture during the Mongolian Empire

1. Mongol script 56
2. Pagva`s script 84

Part three. Scripts` role in culture and society of Mongolia during the XIV-XVIII centuries

1. Development of Mongolian script and its role in history of XIV-XVIII centuries 98
2. Development of Buddhism and culture in Mongolian land and consumption of Tibetan script 112
3. Origin of transliteration and its role for development of Buddhist culture (Transliteration of Ayush güüsh) 147
4. Clear script (Zaya-pandita Namkhai Jamts) 160
5. Öndör Gegeen Zanabazar`s Soyombo and Horizontal square script and their role in culture and history 168
6. Composition of Manju script on base of Mongol script and its consumption (The 2nd part of XVI century and the beginning of XIX century) 176

Part four. Mongol script during the XIX-XX centuries and its change

1. Vagindra script and its composer Agvaan Dorj 188
2. Plan to adapt latin script and its process 194
3. Adapted cyrillic script and its further development 206
4. Movement of reusing Mongol script since 1990 and general argument 213

Conclusion 231

Bibliography 240

Уялга үг

Аль ч соёл иргэншлийн нэгэн адил Монгол дахь будд, төвдийн соёл судлал нь дорно дахины их, бага ухаан судлал, дээрх ухаануудад монголчуудын оруулсан хувь нэмрийн түүх судлал, бурханы шашин судлал, бурханы шашны улбаатай зан заншил судлал, эх бичиг судлал гээд өдий төдий чиглэл, талтай байх учиртай. МУИС-ийн Буддын соёл судлалын төвөөс аль болохоор буддын болон төвдийн соёл судлалыг боломжтой бүх чиглэлээр эрхлэж хэвшүүлэхийг зорилго болгодог болно.

Дэд доктор Л. Чулуунбаатар “Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл” хэмээх эл бүтээлээ бичиг үсэг судлалын түүхийн хүрээнд, бүр тодруулваас монголчууд МЭӨ III зууны үеэс эхлэн авиат бичиг үсэгтэй байсан тухай, цагийн аяст тохируулан нэг бичиг үсгээ нөгөөгөөр халж сольж байсан тухай, ийнхүү халагдан солигдох шаардлага зүй тогтлын тухай, монголчуудын хэрэглэж, заримыг өөрсдөө зохиож байсан арав гаруй бичиг үсэг дэх уламжлал, шинэчлэлийн харьцааны тухай, тэдгээр бичиг үсгийн тогтолцоонд төвд бичиг үсгийн эзлэх байр суурийн тухай, тэрхүү бичиг үсгээр дамжин, монголчуудын соёл иргэншилд буддын, төвдийн шашны үзүүлсэн нөлөөний тухай нэн тодорхой гаргасан байна. Л. Чулуунбаатарын эл бүтээл нь буддын судлалыг эх бичиг судлал талаас нь, монгол дахь төвд судлалыг бичиг үсэг талаас нь, төвд бичиг үсгийн соёл судлалыг монголчуудын хэрэглэсээр ирсэн уламжлалт өөр бусад эх бичигтэй харьцуулан авч үзсэн, энэ талаасаа уншигч олны төдийгүй соёл судлаач эрдэмтэн мэргэдийн сонирхлыг зүй ёсоор татахуйц бүтээл болжээ. Нүүдэлч монголчууд шиг төр улсынхаа үйл хэрэгт арав гаруй бичиг үсгийн тогтолцоог хэрэглэсэн улс гүрэн дэлхий ертөнцийн түүхэнд байхгүй. Монгол

нутагт оршин байсан нүүдэлч улс гүрэн нь 2000 гаруй жилийн тэртээгээс бичиг үсэг хэрэглэж ирсэн бөгөөд бурхны шашин ч энэ цагаас тэдний дунд дэлгэрч байсан байна. Бурхны шашин Энэтхэг, Төвдийн болон Дорно дахины соёлын ололтыг Монголын тал нутагт дэлгэрүүлсэн юм. Соёлыг тээгч хэрэгсэл бол бичиг үсэг мөн.

Л. Чулуунбаатар монголчуудын хэрэглэж байсан бүх бичиг үсгийг соёл, түүх, бурхны шашны соёлын харилцаа хамааралд нь гарган үзүүлсэн явдал түүх, бичиг соёлоо цогцоор ойлгоход чухал зүйл болжээ. Монголчуудын оюуны боловсролын хөгжилд Бурхны шашин хийгээд түүний бичиг үсгийн нөлөө зохих ёсны хувь нэмэртэй байсан гэдгийг бас гаргасан явдал Бурхны шашны соёл, дэвшилттэй бүхнийг судлан дэлгэрүүлэх гэсэн манай судалгааны төвийн зорилгод нийцэж байна.

Энэхүү бүтээл нь Лондон дахь Төвдийн фондтой хамтарч хэрэгжүүлж буй төслийн хүрээнд тус төвөөс эрхлэн хэвлүүлж буй гурав дахь ном болно.

Номын буян арвижих болтугай.

МУИС-ийн Буддын Соёлын Судалгааны Төвийн
захирал шинжлэх ухааны доктор, профессор Н. Хавх

2002 оны 05-р сарын 25-ны өдөр

Forward

The Studies of Buddhism and Tibetan culture in Mongolia carries out research on the contribution of the Mongols to the bigger five and smaller five sciences of the Buddhist philosophy along with the investigation of Buddhism, Buddhist rituals and textology. The Buddhist Research Centre, National University of Mongolia aims at, in all possible ways, to develop and to deepen the studies of Buddhism and tibetology.

“The script culture of Nomadic Mongolia” by Dr. L.Chuluunbaatar presents you some idea on, within the framework of scripture studies, phonemic scripture of the Mongols as early as III BC, changing of script in accordance with the time, the reasons of changing the script, the traditions and modification of over 10 different types of script, the influence of Buddhism and Tibetan culture in the Mongolian civilization through scripts. In terms of textology and scripture studies of Textology, the Tibetan studies in Mongolia rightfully attracts attention of scholars of the world.

There is no other nation in the world that used over ten different script at vaious times. The nomadic tribes and states existed for over 2000 years had their own scripts and Buddhism was practized among them. Thanks to Buddhism, Indian, Tibetan and Oriental culture made its way to spread on tha Mongolian soil.

Script is a bearer of culture of any nation. Dr. L.Chuluunbaatar wrote and noted that different kinds of script which were used among the Mongols had close relations among themselves in relation to culture, history and religions history. It is important for comprehensive understanding of scripts. Also he pointed out that in the development of spiritual education of Mongols, Buddhism and script influence made their own contribution. It

corresponds to aim of the Buddhist Research Center which is aimed to study and develop Buddhist Culture and its progressive heritage, among the Mongols.

May the fruits of scholarship flourish!

Dr. N. Khavkh
Director, The Buddhist Research Centre,
National University of Mongolia

25 May, 2002

Нүүдэлчин Монголчуудын бичиг үсгийн соёл

Удиртгал

Нийгмийн харилцаа өөрчлөгдөхийн хирээр Монголчууд өөрийн эх түүх, соёл, бичиг үсгийн асуудалд үзэл суртлын үүднээс бус бодит байдал нийгмийн өнөөгийн хэрэгцээ шаардлагын үүднээс хандах боллоо. Урьд өмнө монголчуудын бичиг үсгийн түүх болон гарал үүслийг товч төдий хийгээд үсэг тус бүрийнх нь хувьд салангад авч үзэж байсныг нэгэн сэдэвт багтаан бичиг үсгийн түүх, соёлын талаар олон түмэн болон оюутан залууст цэгцтэй мэдлэг олгохыг зорьж, 2000 гаруй жилийн хугацааг хамран бичихийг оролдов.

Улс орон үндэстэн ястны оршин тогтнох, өөрийн онцлогыг харуулахын үндэс нь хэл соёл, зан заншил хийгээд тэдгээрийг илэрхийлэгч өөрийн уламжлалт бичиг үсэг байдаг билээ. Олон зууны турш бичиг үсгийн арав гаруй тогтолцоог төр шашин болон дипломат харилцааны хэрэглүүр болгон хэрэглэж бичиг соёлын арвин баян түүхийг бүтээсэн Монгол нүүдэлч ард түмний бичиг үсгийн түүхийг залгамж холбоонд нь нэгтгэн дүгнэж дэлхийн бичиг үсгийн түүхэнд оруулсан зохих хувь нэмрий нь зүй ёсоор товойлгон гаргах нь өнөөгийн бидний чухал зорилго болж байна. Монголчууд бол Төв Азийн эртний оршин суугчид бөгөөд биеэ даасан соёл иргэншлийг буй болгосон авъяас билигт ард түмэн билээ. Тэр биеэ даасан соёл иргэншлийн нэг чухал хэсэг бол монгол нутагт оршин амьдарч, төр улсаа байгуулж явсан нүүдэлч улс гүрэн бүхэн төр улсын болон дипломат харилцааныхаа хэрэгцээнд бичиг үсэг хэрэглэж соёл боловсролоо хөгжүүлж, үүх түүхээ бичиж тэмдэглэн хойч үедээ

үлдээж ирсэн нандин уламжлалтай байв. Нүүдэлч монголчууд шиг төр улсынхаа үйл хэрэгт арав гаруй бичиг үсгийн тогтолцоог хэрэглэсэн улс гүрэн дэлхий ертөнцийн түүхэнд байхгүй. Тэр чинээгээрээ монголын нийгэм, соёлын түүхэнд бичиг үсгийн дотоод гадаад холбоо нөлөөлөл маш их үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэрхүү харилцаа холбоо хамаарлыг үе шат болгонд нь түүх соёлтой нь харгалдуулан судлаж үзэх нь маш чухал юм. Нөгөө талаас нь үзэхүл монголчууд үсэг бичиг авч хэлэндээ тохируулан боловсруулж хэрэглээд зогссонгүй хөрш зэргэлдээ оршиж нутаг савлан аж төрдөг, соёл боловсрол, улс төрийн хувьд хэлхээ холбоотой, Төв Азийн бусад ард түмний үсэг бичгийн хөгжилд гүнзгий нөлөөлж байсан нь ер нэгэн тохиолдлын чанартай буюу ганц нэгийн төдий байгаагүй тул эрдэмтэн судлаачдын анхаарлыг эртнээс зохих ёсоор татсаар ирсэн бөгөөд үсэг зүйн судалгааны талаар доктор Ц.Шагдарсүрэн болон бусад эрдэмтдийн чансаа өндөр бүтээлүүд гарсаар байна. Эдгээр бүтээлүүд нь Монголчуудын бичиг үсгийн судалгааны хоосон орон зайг нөхөж, монголын судлалд төдийгүй Төв Азийн соёл иргэншлийн түүхэнд бүр цаашилбал дэлхийн соёл иргэншлийн түүхэнд чухаг үнэт хувь нэмэр болох нь маргаангүй билээ.

Нэгдүгээр бүлэг: Монгол нутагт төр улсаа байгуулж явсан эрт цагийн нүүдэлч ард түмнүүдийн соёлын түүхэн дэх бичиг үсгийн хэлбэрүүд.

▪1. Руни бичиг (Хүннү, Сүмбэ, Их Нирун (Жужан), Турэг)

Хүн төрөлхтний бүтээсэн уламжлал болон түүхийн арвин баян хуудасны нэг хэсэг нь өвөрмөц нүүдлийн соёлыг цогцлоосон нүүдэлч ард түмний түүх хийгээд монгол түмний түүх, уламжлал юм.(1) Төв Азийн эрс тэс уур амьсгалтай хангай, говь, тал хээр хосолсон үржил шимт энэ нутаг эрт галавын цагаас хүн оршин суух таатай орчин болсоор ирсэн бөгөөд шинэ угсаатнууд үүсэн бий болох газар зүйн онцлог нөхцөл болсоор ирсэн байна. Хүннүчүүд Инь-Шань уулын ой мод бүхий энгэр хормой бүс нутагт бий болоод дараа нь монголын тал руу нүүж очсон. Уйгарууд Нан-Шань уулын бэлд, Түрэгүүд болохоор Алтай уулын бэлд, Монголчууд Хэнтий, Хангайн бэлд, Киданчууд Манжуурын ой, түүнтэй залгаа хээр талын уулзвар нутагт, Казаны татарууд болон эртний болгарын удмынхан болохоор ой, хээр тал хоёрын уулзвар нутагт, Киргизүүд Енисей Соён уулын бэл, Минусын талын уулзварт, Крымын татарууд Крымын тал, үргэлжилсэн их баян бүрдийн өмнө эргийн уулзвар нутагт бий болсон гэж Л.Н.Гумилев бичжээ.(2) Монгол нутаг бол зөвхөн монголчуудын түүх, соёлын төдийгүй дэлхий дахины соёл иргэншилд зохих нөлөөгөө оруулсан Төв Азийн нүүдэлч түмний соёлын дурсгалт зүйлийн эртний өлгий бөгөөд өрнөдийн зарим судлаачид хүн үүссэн өлгий нутаг бол Төв Ази тэр дундаа Монгол орон гэж үзэх нь буй. Хамгийн ойрын лавтай мэдээг

тулгуурлан хэлэхэд монгол нутагт 700000 жилийн өмнө хүн амьдарч байсныг нотлох үнс, нүүрс гэх мэтийн гал түлж байсны ул мөрийг Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуйгаас Монгол улсын ШУА-ын Түүхийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Новосибирскийн салбарын Археологи, угсаатны зүйн хүрээлэн, АНУ-ын Аризоны Их сургуулийн хүмүүнлэгийн ухааны салбарын хамтарсан экспедицийнхний олж судлан шинжилж гаргасныг дурьдаж болно.(3) Аливаа улс үндэстний бичиг үсгийн хуланц дээд өвгийг эрдэмтэд санаа бичиг гэж нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч, тэрхүү санаа бичгийг хөгжлийнх нь хувьд хоёр шат болгон хуваж, эхлээд эртний болзмол тэмдэг гэдэг хэлбэр буй болоод, дараа нь зураг бичиг гарсан хэмээн үздэг. Тэрхүү болзмол тэмдэг буюу “юм бичиг” нь тухайн хүн өөрийн санаа бодлыг эд юмсаар төлөөлүүлэн өөр нэгэндээ илгээж байсан хэлбэр юм. Зураг бичгийг манай эриний өмнөх дөрөвдөгч мянган жилийн дундуур Шумерт, дөрөвдөгч мянган жилийн эцсээр Египетэд, гуравдагч мянган жилийн дундуур Энэтхэгт, хоёрдох мянган жилийн дундуур Хятадад тус тус хэрэглэж байсан мэдээ бий. Дэлхий дахины хэмжээнд санаа бичгийн сонгодог дурсгал гэвэл Франц, Итали, Испани нутгаас олдсон эртний хүмүүсийн орон бууц нь болж байсан Ла Ферраси, Касилью, Дордони, Пэш мерль, Ляско, Фон дегом зэрэг чулуун зэвсгийн үеийн ханын хөшиг зураг зэрэг болно.(4) Монгол орноос сүг зураг буюу зураг бичгийн эртний ул мөр арвин олддог бөгөөд 15000-20000 жилийн өмнө харьяалагддаг бол Дорнот Сибирээс олддог тиймэрхүү төрлийн сүг зураг нь 10000-12000 жилийн өмнөхөд харьяалагддаг байна. Ховд аймгийн Манхан сумын Хойт Цэнхэрийн агуйгаас дээр дурдсан олон газрын дурсгалтай нэгэн цаг үеийн нэн сонин судлагдхууныг олсон билээ. Академич

А.П.Оклодников Төв Азид төдийгүй дэлхий нийтийн эртний судлалд шинэ чухаг нээлт болсон эл дурсгалыг үнэлж “...Франц, Испанийн агуйн зурагтай яг дүйх туургын хөшиг зургийг баруун Монголын Хойт Цэнхэрийн агуйгаас олоход хялбархан юм...Нэмэр чимэггүйгээр хэлбэл Монгол бол бүхэлдээ дүрс зургийн орон гэж хэлж болно” гэж дуу алдан бичсэн нь буй.(5) Дүрс зураг арвин ихтэй газрыг дурдвал Аршаан хад, Сүмийн гол, Тэвш уул, Бичигтийн ам, Цагаан гол, Ямаан ус, Их тэнгэрийн ам гэх мэтээр олон арвыг дурьдаж болно. Эдгээр дүрс зураг нь түүх, угсаатны зүй, зураг бичгийн үнэт хэрэглэгдэхүүн болж байгаа билээ. Эдгээр зургууд нь системтэй дараалсан зураг бичгээр ухагдахууныг илэрхийлдэггүй боловч тэр эрт цагт "Монгол нутагт арслан заан амьдарч байжээ”, “Монгол нутагт тэмээн хяруул амьдарч байжээ”, “Монголчууд ан хийхдээ нум сумыг хэрэглэж байжээ” гэх мэтийн өгүүлбэрийн түмэн гаргалгааг гаргаж болох бөгөөд энэ нь бидэнд ухагдахуун, өгүүлбэрийн хэлбэрээр мэдээллийг дамжуулж байгаа нэгэн төрлийн зураг бичгийн үүргийг гүйцэтгэж байна. Монгол нутаг дахь хадны эдгээр зураг нь эртний нүүдэлчдийн соёл иргэншлийг судлах үндсэн сурвалж мөн. Монгол нутагт эрт цагаас нүүдэлч овог аймаг оршин сууж байсныг археологийн олон тооны баримт гэрчилж байгаа бөгөөд Монгол нутагт өнө эрт цагаас оршин нутаглаж байсан Хүннү , Дун ху нар чухам хэдийгээс эхлэн түүхэнд нэр гарах болсон тухай хятадын алдартай эртний сурвалж бичиг, түүхийн тэмдэглэлийн баттай мэдээгээр 8 мянган жилийн өмнө буюу мезолитын төгсгөл үед Хүннү нь Сюньюй гэдэг нэрээр оршин байжээ.

Хойд Цэнхэрийн агуйн хадны зураг

Зураг №1

Бичигт хадны зураг

Зураг №2

Хүннү гэдэг нэр ийм олон мянган жилийн өмнөөс нэр гарсан явдал нь чухамдаа хятадын анхны хаан Хуан Ди, Сюньюй /Хүннү/ хоёр түүхэнд нэгэн зэрэг нэр гарч тэмдэглэгдэн үлдсэн явдал юм. Үүнээс үзэхэд Хүннү, Дун ху гэдэг хоёр язгуур аймаг, улс нь монголын түүхэнд олон мянган жилийн түүхийг хамаарч,

энэ монгол нутаг дээр оршин амьдарч ирсэн гэдгийг харуулж байна. Энэ тухай түүхийн холбогдох баримтуудыг сөхвөл Хятадын анхны нэвтэрхий түүх “Ши Цзи” түүхийн тэмдэглэл дэх таван эзэн хааны тэмдэглэлд бичихдээ “Хуанди (шар хаан) Сюньюйг - /Хүннүг/ умарт зүгт хөөв” гэж бичсэн байдаг. Энэ бол Хүннүгийн нэр анх удаа түүхэнд нэр гарч тэмдэглэгдэн үлдсэн сурвалж мэдээ мөн билээ. Хятадын Хуанди бол хятадын анхны хүй нэгдлийн овгийн байгууллын үеийн домогт хүн юм. Энэ үйл явдал болсон он цаг барагцаалбал МЭӨ 6 мянга орчим жилийн өмнөх үе гэж хятадын судлаачид нотолж байна.(6) МЭӨ IV зууны үед Хүннү Төв Азийн нүүдэлч ард түмний нийгэм улс төрийн түүхэнд асар их үүрэг гүйцэтгэж эхэлсэн байна. Хүннү гүрэн Модун шаньюйн үед өргөн уудам нутгийг эзэмшиж хүчирхэгийн туйлд хүрчээ. Хүннү нарын нутаг баруунаас дорнот Туркестаны хот улсууд зүүн зүгт дорнот ху аймгийн нутаглаж байсан Ля голын эхний хэсэг газар, өмнө зүгт хятадын урт цагаан хэрэм, хойт зүгт байгаль нуур хүрч байв.(7) Хүннүгийн ахуй амьдрал, соёлын давуу сайн зүйлүүд хөрш зэргэлдээ улс орнуудад нэвтрэх хийгээд мөн тэдний сайн зүйлсээс бас суралцаж ирж очих зэрэг өргөн харилцаатай байжээ. Тэд эрт цагаас малыг дайн байлдааны нарийн ажиллагаанд сургаж хүчирхэг, зохион байгуулалт сайтай морин цэрэгтэй байсны учир МЭӨ XI-III зуун хүртлэх хугацаанд Чжоу улсаас Цинь улс хүртэлх үед хятад үндэстнүүд тасралтгүй умартын нүүдэлч хүннүгийн довтолгоонд өртөж байсан хийгээд тэр үеийн байлдааанч “Янь, Чжоу зэрэг улсууд цагаан хэрмийг барьж хүннүгийн түрэмгийллийг халхалж байсан” хэмээн хятадын түүхч Ли Сунь “Умарт хилийг сүрдүүлж байсан хүчирхэг дайсан” өгүүлэлдээ дурджээ. Хүннү гүрэн, хан үндэстэн хоёрын хооронд олон

жилийн турш үргэлжилсэн тэмцэлд Хан улс нэрвэгдэн суларч Хүннү гүрний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, тэднийг аргадан үе үе бэлэг барьдаг болсон нь нэг ёсондоо алба байв. Хүннүгийн гарал үүслийг Гумелев болон зарим нэгэн хүн хятадаас гаралтай хэмээн үздэг нь баримтыг нягтлалгүй нэг талын баримтад шүтсэнийх юм. Доктор Ж.Батсуурь “Монголчуудын генийн сангийн голомт хүннү улсын нутаг дэвсгэр, түүний улс төрийн төвтэй яв цав давхцаж байгаа явдал өнөөгийн монголчуудын генийн сангийн голомт ямарч байсан Төв Азид хамгийн түрүүн төр улсаа байгуулан гарч ирсэн хүннү нараас өвлөн ирсэн болохыг тодорхой харуулж байна” хэмээн хятадаас ондоог судлан гаргасан хийгээд мөн тэрчлэн америкийн индианчуудын толгойн яс болон ахуй заншлын олон зүйл нэг байгаа нь эрт цагт хүннүгийн зарим хэсэг Берингийн хоолойгоор дамжин америкт нэвтэрсэн гэж үздэг зарим судлаачийн таамаглалыг бага боловч баталгаажуулж байгаа болой. МЭӨ 162 онд Хан улсын эзэн хаан Сяо-Вэньди Хүннүгийн Модун шаньюйгийн хүү Лаошанд явуулсан бичигтээ “Урт хотоос (цагаан хэрмээс) хойших нум сум барьсан улс (нүүдэлчдийн эзэмшил) шаньюйн цаазыг дагасугай. Урт хотоос дотогш дээл, малгайн улсыг би захирсугай” гэж албан ёсоор мэдэгджээ. Мөн энэ бичигт ”Хан, Хүннү хоёр эн чацуу зэргэлдээ улсууд мөн” гэж дурдсан байдаг.(8) Бүр МЭӨ 90-ээд оны үед Лоуланы (Крорайны) ван Хүннү, Хан улс хоёрыг их улс гэж байсан, тэр ч байтугай Хан улсын бусад хаад ч Хүннүг том улс гэж хүлээн зөвшөөрч байжээ. Хүннү улс биеэ даасан гадаад бодлого явуулж байсан болохоор тусгай боловсруулсан дипломат горимтой байжээ. Хүннүгийн шаньюй нар Хятад зэрэг орны хаанд илтгэх захидлаа тусгай өргөмжилсөн үгээр эхлэн бичдэг байсан бөгөөд

бичээч хэмээх албан тушаалтан ч байжээ. МЭӨ 119 онд Хятадын цэргийн жанжин Хо Цюй-бин хүннүгийн бичээчийг алж хороосон мэдээ байдаг. Модунь шаньюй МЭӨ 176 онд Хан улсын хаанд илгээсэн захидалдаа ”Тэнгэрийн ивээлээр суусан Хүннүгийн их шаньюй эзэн хааны амгаланг айлтгаж байна” гэх үгээр эхлэн бичжээ. “Ши цзи”-д МЭӨ 112 оны үеийн явдлыг бичихдээ “Хүннүгийн хуулиар хятадын элч гэрэгээгээ гадаа орхиод, нүүрээ бэхээр будалгүйгээр (шаньюйн) өргөөнд орох эрхгүй” гэжээ. Хүннүгийн элч нар гадаад оронд явахдаа шаньюйн гэрэгэтэй явдаг байв. МЭӨ II зууны Хүннүгийн элч Баруун хязгаарын (Дундад Азын) орноор явахдаа шаньюйн гэрэгэтэй байжээ. Хүннү элч бүр сүүлд МЭ 125 онд Хятадад очихдоо мөн л гэрэгэтэй очиж байв. Хүннү улсын гадаад бодлогын гол зарчим дараачийн нүүдэлчдэд ялангуяа монголчуудад нэн ихээр уламжлагдсан байна. Хүннү нарын өөрсдийн нүүдэл амьдралыг тусгасан соёлын бүхэл бүтэн олдвор монгол нутгын хөрснөөс олдсоор байна. Хүннү нарын соёлын тухай асуудал бол тэдний утга ба эдийн соёлын олон талыг хамарсан өргөн хүрээтэй нарийн цогцолбор асуудал юм. Төв Азын нүүдэлчдэд бичиг үсэг үүссэн тухай асуудал бол ерөнхий асуудлын салшгүй хэсэг мөн учир нилээд судлууштай асуудал юм. Хятад сурвалж бичигт Хүннү нар бичигтэй байсан тухай мэдээ үнэхээр байна. МЭӨ I зууны эхээр зохиогдсон “Яньте лунь” зохиолд бичсэн нь: ”Тэдэнд ёс журмын ном байхгүй боловч яс сийлэн /кэму/, модоор ороон, олон түшмэл тэмдэглэлцэх бөгөөд эзэн түшмэд, дээд дорд хэрэглэлцэнэ” гэжээ. Фэн Цзя-шэнь эл мэдээг дурдаагүй боловч Хүннү нар хятадын хаанд захидал илгээж байсан, гувчуур авах бүртгэл хөтлөж байсан, газрын зурагтай байсан болохоор бичиг хэрэглэж байсан, гэхдээ хятад бичигтэй байсан гэж үзжээ.(9)

Чжан Цянь Дундад Азийн олон улс орноор аялж ирээд хаандаа айлтгахдаа Усунаас Аньси хүртлэх орнууд Хүннүгийн Шаньюгийн гэрэгэтэй элч нарыг дотночлон үзэж, уналга хүнсээр хангах мөртлөө торго өгөхгүй бол бидэнд ер юм олгохгүй байлаа гэж бичсэн байв. Тэрхүү гэрэгэ нь ямар нэгэн бичигтэй байсан байж таарна. Гэтэл тэдгээр оронд хятад ямар нэгэн нөлөөгүй байсан болохоор гэрэгэ нь хятад бус бичигтэй байсан баймаар байна. Хүннү нар газар зүйн байрлал болон ахуй амьдралын шалтгаанаас болоод эртний хятадын системийн бичгээс эсхүл Дундад Азид хэрэглэж байсан бичгийн аль нэгний нь авч хэрэглэх боломжтой байв. (10) Хүннүгийн бичгийн талаар анх удаа Е.Блоше тодорхой санал тавьж “Хүннү нар МЭӨ III зууны үед ямар нэг армей бичгээс зээлдэж авсан бичигтэй байсныг жужанаар дамжуулан түрэгчүүд уламжлан авсан юм” гэж бичжээ. Ер нь Азийн нүүдэлчин аймгууд “кэму” буюу “мод сийлэн” гэдгийг хэрэглэж байсныг зарим эрдэмтэд мод хэрчих төдий зүйл гэж үзсээр ирсэн нь ихээхэн эндүү зүйл юм. Май Мөрөн “Хүннүгийн бичиг үсгийн тухай тугтам шинжилгээ” өгүүлэлдээ Хүннүчүүд өөрсдийн үндэсний бичиг үсэгтэй байсан эсэх тухай дотоод гадаадын эрдэмтэд ерөөс маргасаар ирсэн хэмээн дурдаад умарт европ, монгол болон дундад улсын нутаг дэвсгэрээс малтаж гаргасан хүннү, аварчуудын археологийн олдворуудад илэрсэн рун бичиг болон олон газрын хадны зураг дахь тамга тэмдэг, бичээс, үсэг зэргийг өргөнөөр хайж шүүгээд нийт 500 гаруй тэмдгийн дүрсийг цуглуулжээ. Зохиогчоос энэхүү материалд тулгуурлан Хүннүчүүд өөрийн бичиг үсэгтэй байлаа гэсэн үзэлт дэвшүүлэхийн дагуу энэхүү үсэг бичгийг хүннү бичиг хэмээн нэрийдсэн байна. Хүннүчүүд өөрсдийн үндэсний бичиг үсэгтэй байсан эсэх тухай гадаад дотоодын олон эрдэмтэн аль

хэдийнээс судлан анхаарсан боловч эдүгээ болтол тодорхой болгож чадсангүй байна. Хүннүгийн үеийн соёлын эд өлгийн зүйл монгол нутгаас арвин олдож соёлын дурсгалын баримт болсоор байна. Харин түүхийн тухай мэдээ занги агуулсан ном судар, хөшөө дурсгал, бичиг хар бидний үед хүрч ирсэнгүй. Судар түүх шастир дахь тэмдэглэлүүдийг үзвэл Хүннүчүүд Хятадын төр засагуудтай олон удаа бичиг захидалаар харилцаж байсан нь тэд бичиг үсэгтэй байсны баримт болно. Хүннүгийн үеийн хятад бичигтэй тамгын зүйлийг өнгөц судлаад хятадын зарим судлаачид хүннү хятад бичигтэй байсан хэмээн таамаглах нь буй. Өвөрмонголын эртэмтэн Тогтох “Эсгий туургатны түүх” бүтээлдээ Хүннүчүүд бичиг үсэгтэй байсан гэсэн мэдээг олонтой дурдсан байдаг. Тэр хүннүгийн булшнаас гарсан “Хүннү хү тао бидгэчийн тамга” гэснийг бодит баримт болгон энэ тамга бол хүннүчүүд өөрсдийн бичгийн түшмэлтэй байсан гэсэн санал дэвшүүлсэн байна. Мөн бас “Судар тэмдэглэл Вей Жанжин Пиюу Чи-гийн намтар”-т хүннү бичэчи хэмээх цолтой гэсэн тэмдэглэл буй. Энэхүү бидгэчи, бичэчи хэмээх цол бол одоогийн бидний хэрэглэдэг бичээч хэмээх үг болно. Гэхдээ тэр үеийн бичээч бол албан бичиг нооргложж, найруулж орчуулж бичдэг бичгийн өндөр боловсролтой хүний нэр байсан болой. Бас Хун Күнгийн “Давс Төмөрийн өгүүлэл, гавьяа зүтгэлийн тухай” хэмээх зохиолд “Хэдийгээр ёслол журмын ном байхгүй боловч ясан сийлмэл ба арьсан бичгээр олон түшмэд нь харилцан бичиж тэмдэглэх бөгөөд эзэн түшмэд дээрд доорд хоорондоон хэрэглэлцэмүй” хэмээн тэмдэглэжээ. Үүгээр үзэхэд хүннүчүүд өөрсдийнхөө үсгээр адгуусны яс буюу малын арьсан дээр сийлэн бичиж улсын их хэрэг явдал, засгийн зар тунхаг, хууль дүрмээн харилцан тэмдэглэн, хоорондоон нэвтрэлцэж байсныг гэрчлэн

байна. Хан улсын Юуван ди хаан умарт хүннүг түрэмгийлэн мөхөөсний дараа тэдний судар бичгийг хойт ордны эрхмүүддээ аваачиж гайхуулсан явдал нь мөн хүннү нар өөрсдийн үсэг бичигтэй байсны мэдээ болно. Үүнийг эрдэмтэн Тогтох бүтээлдээ "Хан Юуван ди хааны хойт ордны эрхмүүддээ үзүүлсэн хүннүгийн ном бичгүүд бол яг тэрхүү яс арьсанд сийлсэн хүннү үсгийн зохиол болно. Тэр нь нүдэнд нь ормооргүй тийм этгээд сонин зохиол биш зөвхөн хятадаар бичсэн энгийн ном зохиол байсан бол түүнийг тэгж нандин эрхэм болгож хойт ордондоо аваачиж гайхуулах явдал юу байх вэ" гэж дүгнэсэн байна. Хүннүгийн бичгийн уламжлал монгол туургатны дээдэс сяньби, жужан, хятан нарт уламжлаад зогссонгүй хүннүгийн их нүүдлийг даган монгол бус бусад ард түмний үсэг бичигт нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл хүннүгийн нүүдэллэсэн хэсэг /цагаан хүннү, европын хүннү ч гэдэг/ өөрсдийн бичиг соёлтойгоо явсан нь эргэлзээгүй билээ.(11) Чин улсын үеийн Хүн Жиюүний туурвисан "Юань улсын түүхийн орчуулгын нотлол, нөхвөрлөл" зохиолдоо өрнөдийн зохиол бүтээлээс ишлэж "Хүннүгийн Атила өрнө дахины улсуудтай элчин солилцох буюу тавцан босгож магтаал өргөх, шүлэг дуулал зохион уянгалуулах бүр цөм эртний хүннүгийн үсэг бичгээ хэрэглэдэг байж. Ромд хүннүгийн бичиг үсэгт нэвтэрсэн хүн байдаг бөгөөд хүннүд ч мөн латин хэл бичигт нэвтэрсэн хүмүүс байв" гэсэн тэмдэглэл буй. Үүнийг мөн Ф.Алтхайм эртний Грекийн түүхч Прискаас иш татахдаа "хүннү нар бичиг хэрэглэж байсан талаар Приск тод томруун бичиж байна. Жишээлэхэд Атилын ордонд жагсаалт хөтлөж, түүнийгээ чанга дуугаар сонсгон хөтлөдөг байжээ. Гэхдээ тэр жагсаалтыг дотоод хэрэгцээнд зориулан хөтлөдөг байсан болохоор грек буюу латин бичгээр байгаагүй байх. Тэр нь армей буюу перс

бичгийн нэгэн хувилбар байж болох юм” гэжээ.(12) Атила бол хойт хүннүгийн баруун тийш нүүдэллэж умарт европт хүрсэний сүүлээр дөрөвдүгээр зууны үеэр хүннүгийн хүчирхэг төрийг байгуулж европ дахиныг донсолгосон догшин хаан байсан билээ. Түүний гүрэн өрнө зүгт Рейн мөрөн, дорно зүгт Ижил мөрөн, умар зүгт Балтийн тэнгис, өмнө зүгт Адриатын тэнгис, Ирантай хиллэж, Ромчуудын варвар гэж нэрлэсэн герман, славян, скиф болон бусад нүүдэлчин ард түмнийг засаглаж байлаа.(13) Кавказаас урагш Баку, Тибилис хоёрын дунд байсан Арран нутгийн хамба лам VI зууны дунд үед библи судрыг хүннү хэлээр орчуулж байжээ. Ф.Алтхаймын үзэж байгаар Кавказын хүннү нар рун бичиг хэрэглэж байжээ.(14) Е.Блоше ч бас хүннү нарын тухай хятад, ром сурвалжуудыг харьцуулан судлаад хүннү нар рун бичигтэй байсан хэмээн дүгнэсэн. Сирийн он дараллын бичгийг зохиосон Захари Ритор /VI зуун/ “Хориод жилийн урьд хүннүчүүд өөрсдийн бичгээр бичдэг байсан” гэж тэмдэглэжээ.(15) С.Дончев скандино, германы рүн ба монголын малын тамгыг харьцуулсан судалгааныхаа дүнд скандинов, германы рүн, өвөг болгар бичиг нь хүннү бичигтэй холбоотой, хүннү нар бичгээ Төв Азиас Төв Европод аваачсан” гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна.(16) Зарим түүхчид Атилагийн хүннү бичиг үсэггүй байсан хэмээн бичдэг нь европын зарим түүхчдийн үгүйсгэсэн бодлогыг хэт хөнгөнөөр аялдан дагасан хэрэг юм. Хүннүгийн тамга үсэг хамгийн эртдээ XVIII зууны үеэр умарт европын оронд илэрчээ. Европын эрдэмтэд энэхүү үсгийг тайлагдашгүй, таагдашгүй гэсэн утгаар рун хэмээн анх нэрэлсэн ажээ. БНХАУ-ын Өвөрмонголын эрдэмтэн Май Мөрөн “Хүннүгийн бичиг үсгийн тугтам шинжилгээ” өгүүлэлдээ өмнө дурдсанаар “Хүннү бичиг” хэмээн нэрлэх санал дэвшүүлжээ.(17)

Доктор Ц.Шагдарсүрэн хүннүгийн үеийн бичиг үсгийн талаар судалгаа хийсэн эрдэмтэдийн бүтээл болон археологийн дурсгалуудыг харьцуулж судлаад “хүннүгийн үеийн бичиг үсэг нь хожмын жужанаар дамжин түрэгүүдэд уламжилсан “рун бичиг” гэсэн дүгнэлт хийсэн байна. Хүннүгийн үеийн бичиг үсгийн олдворуудаас товч үзүүлбэл:

1. Дундад ази болон умарт европын орноос олдсон хүннүгийн үед холбогдох архелогийн олдворууд.

А. Унгар дахь Аварын үеийн археологийн дурсгал дээрх хүннүгийн үеийн тэмдгүүд.

А1 - А18 бол Мажарын Яанушидын нэгэн эртний аварын хүний булшнаас малтаж гаргасан гурвалжин хэлбэртэй зүү утасны модон хайрцаг дээр сийлсэн тэмдгүүд болно. Үүнийг мажарын эрдэмтэн Яануш Харматт 1884 онд анх нийтэлсэн байна. А19 - А30 бол Унгарын Э.Таркань Сюч 1967 онд нийтэлсэн унгарын өмчийн ба нутгийн захиргааны тухай тамга тэмдгүүдийн судалгааны бүтээлдээ нийтэлжээ. Хожим Х.Пэрлээ “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь” хэмээх номдоо сийрүүлэн нийтэлсэн юм.

В. Герман ба Скандиновын орноос илэрсэн тэмдэгүүд:

В1-В38 тэмдгүүдийг Х.Пэрлээ дээр дурдсан бүтээлдээ Болгарын Т.Дончевын 1971 онд “Исторически прегед” сэтгүүлд нийтлүүлсэн үл уншигдах рун бичгийн тэмдгүүдийг сийрүүлэн мэдээлсэн. В30-В44 Сумьяабаатар “Өвөг монгол хэл бичгийн чухал дурсгал” номдоо нийтлүүлсэн.

C.Болгараас олдсон тэмдгүүд:

Х.Пэрлээ Болгарын Т.Дончевын 1971 онд эртний нийслэлээс ухаж гаргасан зүйл дээр байсан тэмдгүүдийг хэвлүүлснийг дээрх номдоо оруулжээ.

D.Швед, Норвегийн орноос олдсон тэмдгүүд:

E. Дани орноос олдсон тэмдгүүд:

D, E-ийг Сумьяабаатар дээр дурдсан номдоо хэвлүүлсэн.

F. Оросын нутгаас олдсон тэмдгүүд:

2. Монгол нутгаас олдсон археологийн олдвор болон хадны зурагт байгаа тэмдгүүд:

G.Рашаан хадны тэмдгүүд:

G1-G109 бол 1968 онд А.Пэрлээ зэрэг археологичид Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дахь Биндэрьяа уулын Рашаан хадны дэргэдэх том чулуун самбар дээрээс олсон тамга тэмдэг болно. Тэд монголчуудын овгийн тамга гэж үзэхийн хамт ямар нэгэн үл танигдах бичгийн зүйл байна гэж дүгнэсэн байна. Бусад нь рашаан хадны хавьд байгаа ханан хад ба тусгай чулуун дээр сийлсэн тамга тэмдгээс түүвэрлэж авсан зүйл болно. Энд нийлмэл буюу ямар нэгэн журмаар холбож сийлсэн бичээс нилээд олон бий. Жишээлбэл:

Н. Цагаан голын хадны зураг дахь тэмдгүүд:

Эдгээр нь Говь-Алтай аймгийн Цагаан голын хадны зургаас сийрүүлж авсан зүйл юм.

Н1-Н18 бол доктор Б.Ринчин “Цагаан голын хадны бичиг” нэртэй өгүүллийг 1966 онд Пионерийн нийгэмлэгийн сэтгүүлд нийтлүүлж мэдээлжээ. Н19-Н36 Ц.Дамдинсүрэнгийн “Говь-Алтайн цагаан голын хадны бичиг” хэмээх өгүүлэлдээ нийтлүүлсэн зүйлс болно. Дээрх хоёр хүний өгүүлэлд байгаа тэмдгүүд дотор 20 гаруй нийлмэл буюу харилцан хэлхээ холбоо бүхий бичээс буй. Жишээлбэл:

J.Төмст уулын тэмдгүүд.

Дээрх тэмдгүүд бол Хэнтий аймгийн Идэрмэг сумын Төмст уулын зүүн суг Дүн-гэнэдэгийн хавтгай билүүн 8 чулуунууд дээр сийлсэн тэмдэг тамгын дүрснүүд болно. Энэхүү хадны зурагт нийлмэл цогцтой бичээс нилээд бий.

K. Бичигт уулын хадны зураг дахь тэмдэгүүд:

Дээрх тэмдгүүд бол Х.Пэрлээгийн туурвисан “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь” гэдэг номын 4-р хүснэгтээс түүвэрлэн авсан тэмдгүүд болно. Эдгээр нь Төв аймгийн бичигт уулын хадны зурагт илэрсэн тэмдгүүд юм.

L. Баянлигийн хадны зураг дахь бичээс.

Энэ бүлэг тэмдгийг Н.Сэр-Оджавын туурвисан ”Баян-лигийн хадны зураг номоос” Өвөрмонголын эрдэмтэн Май Мөрөн түүвэрлэн авчээ. Н.Сэр-Оджавын саналаар эд-гээр хадны зураг

дээд тал нь дээд эртний үе буюу МЭӨ 1000 жил доод тал нь МЭ V-X зууны үед хамаарна гэж үзжээ. Дээрх тэмдэгүүдийн 40% нь өмнө олдсон тэмдгүүдтэй ижил байна.

М. Хүннүгийн “Алтан хүний” дээрх бичиг.

1983 онд Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь хүннүгийн үеийн булшнаас археологич Д.Навааан зэрэг эрдэмтэд малтаж гаргасан цээжин бие бүхий цул алтан пайзын дээрх бичээс болно. Май Мөрөн өгүүлэлдээ 1989 онд олсон хэмээн бичсэн нь он цагийг нарийн нягтлалгүй авч цааш цаашдаа ишлэл авахад эндэл гарахын үүд болжээ. 1987 онд Д.Навааан, Б.Сумьяабаатар нар “Өвөг монгол хэл, бичгийн чухал дурсгал” хэмээх ном бичиж археологийн талаас нь Д.Навааан, бичгийн дурсгалын талаас нь Б.Сумьябаатар судлан шинжилсэн байна. Д.Сумьяабаатар дээрх 7 тэмдгийг судлан үзэж уншихыг оролдсон нь хүннүгийн үеийн бичиг үсгийг тайлан унших талаар хийсэн хамгийн чансаатай бүтээл болсон юм. Тэрээр алтан хүний дээрх бичээсийн талаар:

а/ энэ нь салангад орших тэмдэг, тамгуудтай адилгүй, тодорхой мэдээлэл өгч буй бичээс байна.

б/ уул бичээс өөр өөр системийн бичгүүд хольцолдоогүй, нэг тогтолцооных байна.

в/ бичээсийг дээрээс доош журамласан байна.

г/ хүний цээж дүрсийн баруун гар тал /уншигчийн бол зүүн гар тал/-д доош цуварсан таван тэмдэг, зүүн гар тал /уншигчийн баруун гар тал/-д хоёр тэмдэг тод байна. Зүүн гар талд 4 тэмдэг байгаа мэт зургаас харагдах боловч,

- бүх тэмдэг маш тод товгор товигдсон байх ба харин дээд доод хоёр нь уул эхэд үзэгдэхгүй байна.
- хэв дардас дээр гарахгүй байна.
- микроскопоор 16,32 дахин өсгөж харахад тэмдэг үзэгдэхгүй байна.
- аливаа металл, түүний дотор нимгэн алтан дээр үсэг товиход, тухайн газрын алт сунаж үсэг товойх тул өнгөн талаас нь хичнээн дарж нидэрлээ ч гэсэн уг хэвдээ буцаж ордоггүй, заавал үрчийдэг хуультай. Үсэг нь мэдэгдэхгүй боллоо гэхэд үрчгэр ором үлдэж дардаст гарах ёстой. Гэтэл тийм ул мөр үгүй байна. Нөгөө талаар, хүний дүрс, нүд, хамар, бусад үсгүүд огт элэгдэж нухагдаж сэв суугаагүй байхад, оочин цоочин дээр дооpоос хоёрхон тэмдэг баларсан гэхэд эргэлзээтэй боловч ер үгүйсгэж болохгүй, цаашид нягтлах хэрэгтэй:
- баруун гар талын тэмдгүүдтэй зэргэцүүлэхэд хөндлөн хэм алдагдсан байна.
- баруун, зүүн гар талын тэмдгүүдтэй хэмнэхэд тэмдэг хоорондын зай алслагдсан, дээш доош хэтийдсэн, дээд тал нь зах руугаа шахаж товруунд тулсан, доод тал нь төв рүүгээ жишсэн, өөрөөр хэлбэл, босоо ба хөндлөн хэм алдагдсан байна.

Урлагийн хосгүй энэ бүтээлийн дархан, хэрхэн хэм нийцүүлсэн тухай урьд нэгэнт өгүүлсэн ба очиж очиж ганц нэгэн салангид тэмдгийн тухайд дээр дурдсан олон алдаа гаргана гэхэд санаанд багтахгүй зүйл. Гэхдээ судлаач хүн хувийн бодолдоо хөтлөгдөхөөс аль болох зайлсхийх нь зүйн доторхи асуудал:

- алтан хүний баруун мөр, хувцасны зах маш тод байгаа ба түүнтэй хэм таацуулан үзэхэд зүүн доод дүрс мэт зүйл нь хүнийхээ мөр хавьд байгаа зэргээс үзэхэд тэр нь тэмдэг биш бололтой" хэмээн нягтлаад финикээс гаралт цагаан толгойн эртний хэлбэрүүд болон Туяхтын алтан хүний дээрх бичээс, эртний энэтхэгийн тамгийн тэмдэг, фестийн хүрдний тэмдгүүд болон Пасхи арлын бичээс тэмдгүүдтэй харьцуулан шинжлээд хааны буюу шааны тамга хэмээн уншиж болох юм хэмээн таамаглал дэвшүүлсэн нь нилээд бодтой болсон хэмээн санагдана.(18) Шааны хэмээх нь шаньюйн тамга гэсэн үг гэжээ. Харин Май Мөрөн дээрх судалгааны "зүүн гар талд 4 тэмдэг байгаа мэт гэрэл зургаас харагдах боловч" гээд цааш бичсэнийг анзааралгүй 9 үсэг байсны хоёрыг дутуу уншсан гэж үзээд наран ургах чигийг баримтлан дөрвөн янзаар уншиж болохыг дурдсан нь жаахан ташаарсан мэт санагдана.

3. БНХАУ-ын нутгаас олдсон хүннү бичгийн тэмдгүүд.

N. Улаанцавын хадны зураг дахь тэмдэг.

Эдгээр тэмдгийг Гай Шай Лингийн "Улаанцавын хадны зураг"-аас Май Мөрөн түүвэрлэн авчээ. Гай Шай Лин эдгээр тэмдгийг турк цагаан толгойтой холбогдолтой хэмээн дурджээ. Энэ нь зарим судлаачийн хүннүгийн бичиг жужанаар дамжин туркэд уламжилсан гэдэг үзэлтэй ойр дөт мэт санагдана.

О. Хар хунгийн хадны зураг дахь бичгүүд:

Эдгээрийг мөн Гай Шай Лингийн “Хар хунгийн хадны зураг” хэмээх бүтээлээс хуулбарлан авчээ. Гай Шай Лин “Эдгээр нь анхны үсэг бичгийн шинжтэй юм” хэмээн дэмдэглэжээ. Май Мөрөн мөн эдгээр тэмдгийг бусад газраас олдсон тэмдгүүдтэй харьцуулан үзээд хар хунгийн хадны тэмдгүүдийн 85% гаруй нь яг адил байгаа нь цөм гарал нэгтэй гэдэг нь харагдаж байна” гэж

үзсэн байна. Басхүү түүний ажигласнаар туркийн рун бичгийн цагаан толгой нь цөм дээрх олон тэмдгүүд дотор багтаж байгаа нь рун бичгийн анхны хэлбэр нь хүннүгийн бичиг бөгөөд хүннүчүүд рун бичигтэй байсан гэсэн доктор Ц.Шагдарсүрэнгийн дүгнэлтийг баталгаажуулж байна.

Р. Хүннүгийн хутган дээрх бичиг тэмдэгүүд:

1972 онд А.Дамдинсүрэн “Археологийн шинжилгээгээр олдсон хүннүгийн бичиг дурсгал” хэмээх өгүүлэлдээ хятадын Чэн дэ-гээс олдсон хүрэл хутганууд дээрх үсгийг сийрүүлэн нийтэлсэн нь дээрх болой. Үүнийг Х.Пэрлээ “Хүннүгийн тамга ч байж болно эсвэл үсэг ч байж болно. Тийм болохоор аль ч талаас нь нягтлан шинжлэх хэрэгтэй” хэмээн бичжээ. Май Мөрөн 520-иод тэмдгийг 21 анги болгож дүрс ижилийн хэлбэрээр ангилсан нь шугам буюу зураасан тэмдэг 44, өнцөгт дүрс 56, алхан тэмдэг 12, сэрээ тэмдэг 26, нуман тэмдэг 9, сэрээ буюу саман тэмдэг 10, тоонолжин тэмдэг 28, хошуут буюу суман үзүүрт тэмдэг 11, дугуй буюу бөөрөнхийтэй тэмдэг 67, бундан тэмдэг 9, нахиа буюу салаалсан тэмдэг 11, гох буюу гогцоот тэмдэг 8, хүн болон хас хэлбэрийн тэмдэг 35, гурвалжин тэмдэг 22, дөрвөлжин тэмдэг 15, хагас дугуй хэлбэрийн тэмдэг 75, эвэр тэмдэг 14, тэргэн тэмдэг 4, бусад дүрсэт 12 гэх мэтээр ангилан гаргасан нь харьцуулан нягтлах хүнд хялбар болгосноороо сайшаалтай юм. Хүннүгийн бичиг үсгийг тайлан уншихийн тулд дэлхийн энд

тэндээс олдсон эртний бичээсүүдтэй харьцуулан үзэх хийгээд тэдгээр бичиг үсгийг тайлан унших оролдлого хийсэн зүйлүүдтэй нэг бүрчлэн танилцах хэрэгтэй юм. Жишээлбэл:

- 3000 -гаад жилийн түүхтэй газрын дундад тэнгисийн Крит арлын Фест хотын хааны ордноос Италын шинжилгээний ангийнхан 1908 онд олсон ар өвөртөө бичээс бүхий шавар дурсгал
- Алтайн туяхтаас олдсон алтан хүний бичээс
- Дравидын тамгийн бичээс
- Пасхи арлын дурсгалын бичээс
- Умарт америкийн Бразилын хадны бичиг
- Индианчуудын бэлгэдэл тэмдэг
- Кримын татарын тамганы судалгаа
- Туркын Огос хааны 24 овгийн тамга тэмдэг зэргийг дурьдаж болно.

Өөр нэгэн чухал зүйл бол эдгээрийн үүссэн он цагийг зөв тогтоох хийгээд овог аймгийн тамга хийгээд цагаан толгойн үсгийг ялган таньж унших явдал юм. Хүннүгийн бичиг үсгийн энэ уламжлал МЭ I зууны үед төр улсаа байгуулсан Сяньбид уламжилсан байна. Сяньбийн угсааны аймаг бол тоба, муюн, тугухунь нар бөгөөд тэдгээрийн байгуулсан улс монгол нутагт I-III зууны үед байсан Сяньби, Өвөрмонгол хийгээд хойт хятадад байсан Муюн нарын Түрүү Янь /285-370/, Хожуу Янь /384-409/, Баруун Янь /384-394/ зэрэг улс, Тобагийн Дай улс /338-376/, Их Вэй улс /386-538/, Хөх нуур хавь нутагт байсан Тугуханы улс /IV-VII зуун/ зэрэг болно. Сяньбийн эдгээр улс Төв Азийн түүхэнд ялангуяа монголын түүхэнд тод ул мөрөө үлдээжээ.(19) Сяньби нарын тухай тод томруун мэдээ хятад сурвалж бичгүүд болон хятадын төрийн түүхнээ байдаг. Хүннү, Сяньби хоёр бол нэн эрт

үеэс давхар байгууламжаар холбоотой байсан, угсаа гарлын хувьд нэгэн угсаатан мөн гэсэн гол дүгнэлтийг эрдэмтэд хийдэг байна. Яо Вэй юань IV-V зууны үеийн ху аймгуудын овгийг харшуулан судалсан ганц сэдэвт зохиолдоо тоба, тефу, туфа гэдэг гурван үгийг нэг үг сунжирсан нь хэмээгээд Тоба бол “хүннү сяньбийн цус холилдсон аймаг мөн” гэж дүгнэжээ. Түүхчдийн мэдээгээр Тоба 118 овог аймагтай байсан байна. Тобагийн аймгуудын дотор чину гэдэг монгол аймаг байгаа нь Тоба, Сяньби нар монгол аймаг болохын бас нэг давхар баталгаа билээ. Сяньби нар зэргэлдээ орших нүүдэлчин болон суурьшмал аймаг, улстай нягт харилцаатай байсан ажээ. Иймд Сяньби нар бичгийн соёлтой маш эрт үеэс танилцаж эхэлсэн хэмээн үзэж болно. Сяньби нар мод сийлэн тэмдэглэж байсан байна. Вэй Шоугийн “Вэй шугийн” нэгдүгээр бүлгийн оршилд “мод сийлэн /кэму/, таних тэмдэг тэмдэглэж хол ойрын хэрэг явдлыг улируулан уламжилсан нь түүхч түшмэлийн тэмдэглэл мэт болсон” гэжээ.(20) Ухунь, Тоба, Жужань, Түрэг, Кидан нар ямар нэгэн хэрэг явдлыг тэмдэглэн мод сийлдэг байсан нь “түүхч түшмэлийн тэмдэглэл” мэт болдог байсан нь хүннүгийн үеэс уламжилсан хүннү буюу рун бичиг байсан гэж үзэхэд болох юм. Ер нь рун маягийн үсгийг бичихэд тэр цагийн хамгийн тохиромжтой хэрэгсэл нь мод байсан гэж эрдэмтэд үзэж байна. Г.Сүхбаатар олон сурвалжийг харьцуулан үзээд “үнэндээ мод сийлэхийг бичиг хэмээн хэлж буй нь илхэн байна. Үүнд ямар нэг зөрчил алга байна. Ингэхээр тэр бол зураг бичиг ч бус, санаа бичиг ч бус чухам түрэг бичиг буюу орхоны бичиг мөн байна.... Бичих аргын хувьд орхоны /рун/ бичигтэй яг тохирч байна” хэмээн дүгнэжээ. Нүүдэлчдийн хөдөлгөөнт ахуйд торго, бөс, цаас зэрэг хэврэг материалын оронд мод, чулуу, яс /голлон мод/

зэргийн бичгийн хэрэгсэл, самбар болгох нь хүртээмжтэй төдийгүй бат бэх байв. Модон дээр хурц үзүүрт зүйлээр бяцалсхийж бичиглэхэд илүү дөхөмтэй хялбар, гарах дүрс нь хурц шулуун үсэглэвэр байх нь эргэлзээгүй. Бичээч, бичиг гэдэг энэ үг бичи- гэдэгтэй язгуур нэг үг болно. Хурц үзүүрт зүйлээр модыг бяцалж бичиглэдэг хүнийг бяцлагч буюу бичээч гэж нэрлэж байсан нь уул үгийн уугуул утга байна. Монгол нутагт байсан эртний аймгууд бүр хүрлийн үеэс хадан дээр элдэв сүг зураг зосоор зурдаг уламжлалтай байсан билээ. Алтай язгуурын турк хэлний дурсгалд бичиг сийлэх, хадах, огтлохыг бич, сийлэх, сийлбэрлэх хэрэгсэл хутгыг бичгү гэдэг байсан байна. Чухамхүү энэ “бич” язгуур бүхий бяцлах, бичих, бичээч гэдэг үгс бүгд нэг язгууртай үгс юм. Бичиг гэдэг үг анх тоба нараас гарсан гэж эрдэмтэдийн үздэгийг хүннү нараас анх гарсан гэж үзэх нь зүйтэй мэт.(21) Сяньби хэлний үгсийн дотор ч бичгийн түшмэлийг заасан бидэчжэнь гэж байгаа ба жужанд VI зууны эхээр бичгийн түшмэл “бичээч” байсан байна.(22) Мөн тэрчлэн өвөг монголчууд бичгийн тодорхой бүтээл туурвин гаргаж байсныг гэрчлэх мэдээ тэмдэглэл сяньбийн түүхэнд холбогдон үлдэж хоцорчээ. Тухайлбал сяньби хэлээрх 13 номын нэр нангиад бичигт хятадаар тэмдэглэгдэн үлдсэн байна.

1. Kouo-yu che-wou kiuan /Төрийн хэл, 15 бүлэг/
2. Kouo-yu che kiuan /Төрийн хэл 10 бүлэг/
3. Sien-pi yu won kiuan /Сяньби хэл, 5 бүлэг/
4. Kouo-yu wou-ming sseu kiuan /Төрийн хэлээрх захиа, зарлиг, 4 бүлэг/
5. Kouo-yu tchen ko che kiuan /Төрийн хэлээрх жинхэнэ дуу, 10 бүлэг/

6. Kouo-yi tsa wou-ming san kiuan /Элдэв зүйлийн төрийн хэлээрх нэр, 3 бүлэг/

7. Kouo-yu che-pa tchouan yi kiuan /Төрийн хэлээр 18 дэвтэр/

8. Kouo-yu yu-ko che-yi kiuan /Эзний дуу “төрийн хэлээр”, 11 бүлэг/

9. Sien-pi yu che kiuan /Сяньби хэл, 10 бүлэг/

10. Kouo-yu hao-ling sseu kiuan /Төрийн хэлээрх элдэв зохиол, 4 бүлэг/

11. Kouo-yu tsa wen che-wou kiuan /Төрийн хэлээрх элдэв зохиол, 15 бүлэг

12. Sien-pi hao-ling yi kiuan /Сяньби хэлээрх захиа зарлиг, 1 бүлэг/

13. Kouo-yo Hiao-king yi kiuan /Аав ээжид өргөх хүндэтгэлийн дуу, 1 бүлэг/

Үүний IV, VI ном нь сяньби-хятад хадмал толь, I-III, IX нь сяньби хэлний сурах бичиг ажээ. VII номыг түүхийн зохиол гэж үздэг. Сяньби нар өөрсдийн түүх бичлэгтэй байсан талаар сурвалжид тэмдэглэсэн байна. Тоба нар шинэ бичиг зохиосон нь /шинэ бичгийн тухай хойно дурдана/ нүүдэлчин аймгууд өөрсдийн нэг төр байгуулахаараа тэр төрийн бичигтэй болохыг эрмэлздэг байсан уламжлалтай холбоотой байх. (23) Тэгсэн хэдий ч Сяньбийн бусад аймгийн адил төрийн гол хэрэгт рун бичиг хэрэглэж байсан болтой. Тугуханы бичгийн тухайд “Цзинь шугийн” 97-р бүлэгт “тэд /тугухань/ бичиг сайн мэддэг” гэжээ. Тобагийн Их Вэй улсын Ян Сюаньчжи зохиосон “Лояны сүмийн тухай тэмдэглэл” хэмээх номд “тэдний улс бичигтэй, гэхдээ вэйгийнхтэй адил” гэжээ. Тугухань нар бол Сяньби улсын зүүн гарт багтаж байгаад IV зууны эхээр баруун тийш нүүсэн сяньби аймаг билээ. Г.Сүхбаатарын таамаглалаар тэд орхоны бичиг

буюу рун бичиг хэрэглэж байсан байх хэмээжээ. 425 онд зохиосон шинэ бичгийг хэрэглэхэд он цагийн хувьд дэндүү давчуу хийгээд тэдний өргөн харилцаатай байсан баруун зүгийн Согд зэрэг орнуудаар заншлахаар явж байсан хятадын элчүүдийн тэмдэглэлд юу ч дурдаагүйг үзэхэд дээрх таамаглал үнэний хувьтай байж болно. Хүннүгийн рун бичиг дээрх монгол аймгуудаар уламжлагдан Туркийн хаант улсын үед түүнийг улам боловсронгүй болгон хэрэглэсэн юм. Дундад Ази, Европын зарим хэсэгт хэрэглэгдэж байсан Хүннүгийн Атила хааны үеийн рун бичиг ойр зэргэлдээ оршиж байсан Туркуудэд уламжлагдан төр улсаа байгуулахад нь төрийн бичиг болжээ. 552 онд Алтайн түрэг тэргүүлсэн түрэг аймгуудын холбоо Монгол нутагт Жужан улсыг бут цохисны дараа, монгол нутагт төрийн шинэ нэгдэл болох Түрэгийн хаант улсыг байгуулжээ. Анх Жужанд хэрэглэсэн “Каган” цолыг хэрэглэж энэ нь цааш монгол, түрэг хэлтэн аймгуудад тархан улсыг тэргүүлэгчдийн цол болон уламжлагджээ. МЭ VI зууны 80-аад он болоход Түрэгийн хаант улс ихэд өргөжин түүний бүрэлдхүүнд янз бүрийн овог угсааны олон аймаг, ястан багтан орсон байна. Зүүн зүгт Солонгосын булангаас баруун зүгт Долоон усны газар хүртэл, өмнө зүг цагаан хэрмийн хавь газраас умарт зүг Байгал далай хүрч байжээ.Түрэгийн хаант улсын төв нь Орхон голын сав газар оршиж байсан тул ном зохиолд Орхоны түрэг гэж нэрлэгджээ. Түрэгийн үед хот байгуулах, архитектурын ухаан, чулууны ажил улам эрчтэй хөгжив. Соёлын салбарт олсон томоохон амжилт нь авиа тэмдэглэх бичгийг хэрэглэж байсан явдал юм.(24) Ли-дайгийн тэмдэглэлд “тэдний бичгийн үсэг нь ху аймгийнхтай адил”(25) гэжээ. Хэрэв түрэгийн рун бичиг хүннүгийн бичгээс өөр ялгаатай үсэг бичиг байсан бол “ху нарынхтай төстэй” гэхгүй нь

ойлгомжтой. Тийм болохоор хүннүгийн үсэгтэй адил хэмээсэн үг болой. Монгол нутагт Орхон-Енисейн бичиг буюу түрэгийн рун бичгийн дурсгал олон арав буй бөгөөд бусад олон бичиг үсгийн дурсгалуудын дотор хүндтэй байр эзэлж гадаад дотоодын эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихээхэн татдаг билээ. Энэ бичиг үсгийн талаалх эхний мэдээнүүд шинжлэх ухааны хүрээнд XVII зууны сүүлч, XVIII зууны эхээр гарч ирэхдээ юуны өмнө Енисейн сав газар хад, чулуунд сийлсэн бичиг үсгийн материалд тулгуурласан байлаа. Энэ тухай анхны мэдээг Амстердам хотын дарга Н.К.Ридян 1792 онд нийтлүүлсэн бөгөөд харин рун бичгийн дурсгал мөн эсэх талаар тодорхой юм дурдаагүй ажээ. Тэр цагаас хойш энэ үсгийн гарал үүслийн талаар янз бүрийн таамаг гарч байсан боловч шүүмжлэлийн хүрээнээс хэтэрч чадаагүй байна. Уг бичгийг судлаачдын дийлэнх нь монгол халимаг гаралтай гэх буюу эсвэл хүннү гаралтай гэж, зарим нь бүр ондоо овог аймгийн тамгаас гаралтай гэх боловч эдгээр саналууд нь таамаглал төдийгөөс хэтэрч байсангүй. Шинжлэх ухаанд 1870-аад оныг хүртэл гарч ирсэн энэ өргөн шүүмжлэл, урьдчилсан таамаглалуудын аль алиных нь хүрээнд эдүгээ манай нутгаас олдоод байгаа бичиг үсгийн дурсгалууд хамрагдаж чадаагүй байлаа. 1871 онд Падерин гэгч хүн Орхон голын хавьд олж ажиглан үзсэнээ нийтэлснээс хойш төдий их удалгүй “орхоны дурсгалууд” гэдэг цоо шинэ нэр томьёо шинжлэх ухаанд гарах болжээ. Энэ үйл явдлаас төдий л хожуугүй 1889 онд Оросын газар зүйн нийгэмлэгийн Дорнот Сибирийн салбарын Н.М.Ядринцеваар удирдуулсан шинжилгээний анги Хархорин, Харбалгасыг шинжиж, улмаар Орхоны хөндий, Хөшөө цайдамаас Билгэ хаан, хунтайж Күл-тегин нарт зориулан босгосон гэрэлт хөшөөг нээсэн явдал тэр үедээ эртний үл

таагдах бичээсүүдийн дотор тэмдэглэвэл зохих томоохон байр эзэлсэн байжээ. Энэ үеэс эхлэн үл тайлагдах бичээсүүдийг “Орхон Енисейн бичээс” гэдэг нэр томьёоны дор авч үзэх болсон юм.(26) Монголд Түрэг судлалын ажлыг “Күл-тегений хөшөө” гэж алдаршсан хөшөөний өргөн талд сийлсэн үгийг орос хэлнээс орчуулсанаар эхэлсэн гэж доктор Л.Болд үзсэн байна. Уг орчуулгыг түүхч Амарын зохиосон “Монголын товч түүх” номд хавсруулан оруулжээ. Эртний түрэг улсыг нэгтгэн байгуулах үйлст “...шөнө нойр хүрэхгүй, өдөр амрыг олохгүй, улаан цус, хар хөлсөө гарган...” хүчин зүтгэж явсан мэргэн Тоньюкук, мөн үйлст зүтгэн“...тойгтныг сөгдүүлж, толгойтныг бөхийлгэж явсан...” хун тайж Күл-теген нарын хөшөөний үгийг орчуулсан нь нэг талаар манай нутагт дээр үеэс иргэншин сууж байсан, феодалын түрүү үеийн хүчирхэг улсын нэгэн болох түрэг улсын түүхтэй танилцуулах зорилготой байсан нь илэрхий боловч... харийн түрэмгийллийн аюул заналаас сэрэмжлэн хойт үеийнхэндээ сургамжилсан сануулгыг агуулсан байна.(27) Элтэрэс хааны мэргэн сайд Тоньюкукийн хөшөө чулуу Налайхад, Түрэгийн Билгэ хааны хөшөө чулуу Архангай аймгийн Хашаат сумын нутаг Орхоны Хөшөө Цайдамд буй бөгөөд гадаад дотоодын олон үзэгчдийн үзэх дуртай газрын нэг болж олны нүд баясгаж байна. Л.Болд эртний түрэг хэлний энэ гол дурсгал бичгүүдийг А.Амар “Монголын товч түүх” зохиолдоо оруулснаар түрэг судлалын ажил эхэлсэн гэж тэмдэглэснийг дээр дурдсан бөгөөд энэ цагаас хойш А.Лувсандэндэв, Х,Пэрлээ, Н.Сэр-Оджав, Х.Лувсанбалдан, Б.Ринчин, М.Шинэхүү, М.Базылхан, С.Харжубай, Л.Болд, Ц.Баттулга нарын эрдэмтэд монгол нутгаас олдсон рун бичгийн дурсгалуудыг олон нийтэд мэдээлэх зорилгоор нийтлүүлэх

болон тайлан уншиж эдгээр ажлынхаа үр дүнг нийтлүүлсээр ирсэн билээ.

Íàëàéõûí Òîíüþê¿êèéí óðüä õºøººíèé áàðóóí õàæóó Çóðàã÷èí Äàãâàñàìáóó

Western side of the Southern monument to Tonyukuk in Nalaikha Photo by Dagwasambuu

1970-аад оны үеэс түрэг судлал манай оронд бие даасан салбар болон хөгжих урьдчилсан нөхцөлийг баттай олжээ. Үүний нэг тодорхой баримт бол эртний түрэг судлалын чиглэлээр манай эрдэмтэд бие даасан ганц сэдэвт зохиол, мөн хамтын бүтээл туурвин “Хэл зохиол“, ”Монголын судлал”, “Түүхийн судлал“, ”Археологийн судлал“ цувралуудад түрэг судлал тодорхой байр суурь эзлэх болсон явдал юм. Сүүлийн үеийн бүтээлүүд дотроос 1990 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн мэргэжилтнүүдээс доктор Л.Болдын удирдлагаар гүйцэтгэсэн “БНМАУ-ын нутаг дахь түрэг бичээс” хэмээх хамтын бүтээл бөгөөд энэ бүтээлдээ монгол нутгаас олдсон 40 рун бичгийн дурсгалын хуулбар болон хөшөө хадны зургийг нийтлүүлж урд өмнө тайлж уншсан болон өөрийн тайлж уншсаныг дүгнэлттэйгээр нэгтгэн гаргасан нь монгол хэлний болон алтайн хэлнүүдийн хөгжлийн түүхтэй холбогдсон ерөнхий ба тухайлсан асуудлууд, улмаар монгол түрэг, түрэг монгол хэлний харьцуулсан судалгаа, мөн тэрчлэн хүннүгийн үеийн рун бичгийг харьцуулан судлах, монгол нутагт төр улсаа байгуулж явсан улс гүрнүүдийн түүхийг тодочлох, монгол болон бусад овог аймгуудын хэлхээ холбооны түүхийг нэгэн мөр болгоход их ач холбогдолтой болсон нь маргаангүй юм. Рун бичгийн дурсгалын зүйл гагц түрэгийн мандаж байсан үеэр хязгаарлагдахгүй түрэгүүдийн дараа төр улсаа байгуулсан уйгаруудын үед хамаарагдах бичээс олон байдаг. Ийм бичээсүүдийн нэг нь нэрт эрдэмтэн Г.И.Рамстедтийн нээн олж улмаар үгчилсэн галиг, орчуулгыг нь хийсэн Сүүжийн дабааны түрэг бичээс юм. Доктор Л.Болд энэ бичээсийг нэмж судлаад “Сүүжийн дабааны түрэг бичээсийг бичих үеэс согд, уйгар нарын харилцаа өргөжин, төдий л удалгүй уйгарчууд согд бичиг буюу өнөөгийн бидний

нэрлэдгээр бол уйгаржин бичгийг авсан ажээ" хэмээн таамаг дэвшүүлжээ. Мөн тэрчлэн XIII зууны үед бас түрэг бичээс хэрэглэж байсны баримт нь Баахан Бандида гэдэг монгол эрдэмтэн 1686 онд энэтхэг хэлнээс орчуулсан "Гучин хоёр модон хүний үлгэр" гэдэг номын баринтагийн оосорт буй чулуун тээг дээрх А.Лувсандэндэвийн уншсан "1.Чинис каган, 2. алп каган эрмис" буюу "Чинис хаан баатар хаан байсан" гэсэн үг юм. Зохиогч энд гарах Чинис гэдэг үгийг монгол түрэг хэлний нилээд материалтай харьцуулсны эцэст энэ үг бол монголын хаан Чингисийн нэр даруй мөн гэж үзжээ.(28) Залуу эрдэмтэн Ц.Баттулга 1999 онд "Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын зарим судалгаа" хэмээх нэртэй доктор (Ph.D)-ын зэрэг горилсон зохиол бичсэн нь Түрэг судлалын салбарт гарсан дорвитой бүтээл болж, бас нэг шат ахиулсан судалгаа болсон юм. Үүндээ Монгол нутагт буй эртний түрэгийн бага дурсгалуудын үсэг зүй Енисей, Таласс, Хойт Кавказ, Туна-Булгар, Волго Дон, Мажарын Секлерийн дурсгалуудын үсэг тэмдэгтэй харьцуулан нягтлаад бага бичээсүүдийн нийтлэг тал, нэн ялангуа Енисейн дурсгалын үсэг тэмдэг, манайд буй бага бичээсүүдийн үсэг тэмдэгтэй адил олон хувилбар бичлэгтэй болохыг тогтоон, мөн цаашилбал Монгол нутагт буй эртний түрэг бичгийн дурсгалын он цагийн холбогдлыг тодруулан үечилж гаргасан нь нэн чухал зүйл болсон юм.(29) Шинэ мянганы эхэнд МУИС-ийн удирдлага, доктор (Ph.D) Ц.Баттулгын санаачлагаар Түрэг судлалын төв, Түрэг судлалын тэнхмийг МУИС-ийн МХСС дээр байгуулж шинэ анги нээж, мэргэжилтэн багш урин ирүүлж сургалт судалгаа явуулж байгаа нь Түрэг судлалын шинэ эрин эхэлсэнийг харуулж байна. Хүннү гүрний төрийн албан бичиг болон хэрэглэгдэж байсан руни бичиг дундад ази, европ дахинаа түгэн дэлгэрч соёлын

нэгэн хэрэглүүр болж байсан хийгээд хожим VI зуунд төр улсаа байгуулсан Түрэгийн хаант улсын албан бичиг болж түүгээр бичсэн хөшөө чулууны олон бичиг дурсгал хожмын бидэнд түүх, хэл шинжлэл, нүүдэлч ард түмний түүхийн олон чухал үнэ цэнэтэй мэдээллийг олгож байна. Хүннүгийн бичгийг тайлан унших явдал бас нэгэн судлаачийн хийх ёстой ажил мөнөөс мөн болно. Энд мөн цухас дурдахад Монгол нутгаас олдсон түрэгийн үеийн болон хожим хойдын хөшөө чулууны бичээс хэдийгээр судалгааны хүрээнд орж олны хүртээл болж байгаа боловч олигтой хадгалалт хамгаалалт үгүйгээс он цагийн урсгалд салхи бороо мөн тэрчлэн мал адгуус, ухвар мөчид хүмүүсийн үйл ажиллагаагаар муудсаар байна. 1924 онд Д.Нацагдорж Налайхад байх мэргэн Тоньюкукийн хөшөөнд саравч байр барих төсөл хүртэл гаргаж анхаарал тавьж байсан боловч зарим нэг хөшөө дурсгалд хайс барих төдийгөөс хэтэрсэнгүй нь харамсалтай. Тариатын түрэг бичээст “мянган жил түмэн өдөр дуурсах бичгийнхээ билиг тэмдгийг энд зассан чулуунаа сийрүүлэв би” хэмээн бичсэн буй. Түмэн жил дуурсгаж хойч үедээ үлдээхийн тулд эдгээр хөшөө дурсгалд онцгой хамгаалалт үгүйлэгдсээр байна.

▪2. Эрт цагийн монгол бичиг (Их Нирун /Жужан/, Уйгарын бичиг)

Тобагаас гадна бичиг үсгийн соёлтой байсан бас нэг улс бол Их Нирун улс юм. МЭ 330 орчим оноос 555 он хүртэл төр улсаа байгуулж байсан, Сүмбэ нартай удмын холбоотой, дорнот ху нарын удам монгол хэлтэн аймаг байсан бололтой. /Түүхч Г.Сүхбаатар анх Жужан улс хэмээн бичсэнээ хожмын бүтээлдээ Нирун улс хэмээн нэрлэх санал дэвшүүлж Их Нирун хэмээх

нэгэн сэдэвт зохиол бичсэн болой./ Их Нирун өмнө зүгт Говь, умар зүгт Байгаль нуур, өрнө зүгт Хар сайр, дорно зүгт Солонгос хүртлэх нутгийг эзлэн сууж байв. Тэд Сүн улс, Баруун газрын орнууд болон Солонгостой харилцаж гэрэгэтэй элчин илгээж байжээ. Жоужань сударт “бичиг тэмдэглэл мэддэггүй, цэргийн жанжин нь хонины хорголоор цэргийн тоог бүдүүвчлэн тэмдэглэдэг байв. Хожим мод сийлэн тэмдэглэл хийхийг сайн мэддэг болсон...Улсын засгийн явдал эгэл жирийн, ном зохиол мэддэггүй, мод сийлэн хэрэг явдлыг тэмдэглэдэг байв. Харин хожим яваандаа бичиг мэддэг болсон. Эдүгээ эрдэмтэй хүмүүс олон буй” хэмээжээ. Вэй улсын түүхийн энэ тэмдэглэл басамжилсан тал байвч бичигтэй болсны нь болон бичиг хэрэглэж байсныг үгүйсгээгүй байна. Е.Блоше 1898 он нийтлүүлсэн зохиолдоо “хойт семитийн /армейн/ нэг бичгийг авсан хүннүгээс Их Нирунаар дамжуулан түрэгчүүд рун бичиг авсан” хэмээн нотлох оролдлого хийсэн байна. Вэй улсын Тоба Цзюнь хааны (452-455) үед Сүн улсын болон Нируны бичгээр тунхаг зохиохыг бичгийн түшмэдүүддээ зарлиг буулгаж байсан байна. Тэгэхээр хятад бичиг хэрэглэж байгаагүй нь тодорхой бөгөөд “мод сийлэн хэрэг явдлыг тэмдэглэж байсан” гэснээс үзвэл рун юмуу худам бичиг хэрэглэж байсан бололтой. Нирун нарын бичгийн талаар дээр иш татсан зүйлст Нирун нар мод сийлэн хэрэг явдлаа тэмдэглэхийг сайн мэддэг, тийнхүү тэмдэглэж байснаа бичигтэй болсон хэмээн бичсэнийг бодоход урьдын нэгэн зүйл бичгээ өөр бичгээр сольсон шиг байна. Үүнээс ургуулан бодоход, Нирун нар мөн л хүннү, сяньби тобагийн хэрэглэж байсан рүн бичгийг хэрэглэж байгаад, Дундад Азийн гаралтай бичиг хэрэглэсэн бололтой хэмээн түүхч Г.Сүхбаатар таамаглаад худам бичиг хэрэглэж байсан гэжээ.

Өдгөө “Юань ши” /Юан улсын судар/ дэх нэгэн домог мэдээг иш болгон XIII зууны үед л монголчууд уйгур бичиг авч, бичигтэн аймаг улс болсон хэмээх санал ихэд дэлгэрч лавшран бараг үнэмлэхүй үнэн мэт болжээ. Б.Я Владимирцов тэрхүү домог мэдээнд үл итгэн бичихдээ: “Ингээд XIII зууны монгол бичгийн хэл бол хэдийн бүрэн боловсорчихсон зөв бичих зүйтэй хэл байгааг бид үзэж байна. Энэ бол монгол бичгийн хэл нэлээд түрүү үед ямар ч байсан Чингис хаанаас өмнө үүсчээ гэдгийг санагдуулж буй баримтат зүйл мөн” гэжээ. Академич Б.Ринчен XIII зууны үед бичигтэн болсон гэдэг үзлийн талаар хэлэхдээ: “Чингис, Өгэдэй, Мөнх хааны үеийн монгол бичгийн хэл, дүрэм нь маш боловсорсон шинжтэй нь олон тооны уламжлалт бичгийн тогтсон нарийн дүрэмт боловсорсон бичгийн хэлтэй байсныг нэн илэрхий гэрчилэн буй тул....дэмий л таамагласан нь ул үндэс муутай хэрэг” гэжээ. Мөн Б.Ринчен бас нэг өгүүлэлдээ “Монголчууд уйгур бичгийг Чингисээс бүр өмнө Буданцар дээдсийн үед мэддэг байсан“ гэж дүгнэсэн ажээ. Нируны хаад гадаад харилцаандаа гэрэгэтэй элчин илгээж, бичиг нот хэрэглэж байсан нь бичиг үсгийн өндөр боловсролтой байсан хийгээд түүнийг эрхэлдэг бичгийн мэргэн түшмэдүүдтэй байсан байна. Согд, Карашар зэрэг Дундад Азийн оронтой соёл, эдийн засгийн нилээд дэлгэр харилцаатай байсан мэдээ хятад сурвалж бичигт арвин буй. Иймд Нирун нар хуучин хэрэглэж байсан бичгээ орхиод, Дундад Азиас согд бичиг авч хэрэглэсэн баймаар бодогдоно. 420-478 оны үед Нирун улсын төрийн сайд Силинь зурхайн тоо мэддэг, мэрэг тайлж чаддаг, харь хэл, хятад хэлээр хэлэлцдэг байжээ. Мөн тэрчлэн хаан Шелунь огторгуйн зурхай, тооны ухаанаар оролдож байсан нь чухал баримтын нэг билээ.(30) Нируны мэргэд дундад азиар дамжин энэтхэг хүрч

дорно дахины болон буддын өндөр боловсрол олдог байсан байна. Энэтхэгийн лам Ратнаманти Энэтхэгийн таван ухаан, урлахуйн онолд сайн хүн бөгөөд Табгачийн Вэй улсын нийслэл Лоян хотод Ашид амгалан сүмд сууж байжээ. Тэр үед Вэй улсын Син Чжоу мужийн захирагч Цими Хуйвэнь...тэр энэтхэг ламтай ярилцахыг хүснэ, үл тооно. Баруун газрын орнуудад байх үеийн танил, тэр үед Лоян хотын нэг буудалд байсан, морь унасан, нэхий дээлтэй нэгэн нирун хүнтэй Ратнаманти сүмд уулзан, инээлдэн, алга хавсран өдөржин ярилцдаг байв. Тэр хятад түшмэл тэд харь хэлээр ярилцахыг үл ойлгон, хөндлөнгөөс сонсон сууна. Тэр түшмэл “Та одоо болтол надтай үг ярихгүй мөртлөө умар зүгийн араатан зүрхтэй, хүн нүүртэнтэй яагаад ингэж байна?” гэж ламаас асуухад лам: “Та түүнийг бүү басамжлагтун, түмэн хуйлаас ном уншсан ч түүнийг давшгүй” гэхэд түшмэл: “Түүний мэддэг юм гэвэл бөх барилдах, морь харах л юм” гэжээ. Лам: “Түшмэл та өөрөө юу мэддэг вэ? гэхэд, түшмэл: “Би уулын өндөр, усны гүнийг хэмжихгүй тодорхойлж чадна” гэжээ. Лам “Энэ бол хүүхдийн тоглоом” гэжээ. Тэр үед 7-р сар байсан болохоор асар том чавганы модны үр боловсорсон байв. “Энэ модны чавганы үрийн тоог бодож олж чадах уу?” гэж лам түшмэлээс асуухад чадахгүй гэж хариулжээ. “Энэ нирун хүн бодож чадна” гэж лам хэлэхэд түшмэл мориороо мөрий тавьжээ. Нирун хүн үзүүрт нь цагаан сувд хэлхсэн таван өнгийн утастай дэнсний нуруу шиг юмыг бүсэн дэх ширэн хавтганаасаа гаргаж ирээд, модыг дээрээс нь доош нь, хажуу тийш нь хэмжин удтал тойрон харж байгаад чавганы үрийн тоог хэлсэн нь яг таарчээ. Ингээд хятад түшмэлийн морийг авч буцсан байна.(31) Энэтхэгийн арван ухааныг шууд болон Согд мэтийн дундад азийн соёлт орноор дамжуулан суралцахаас гадна тэд

энэтхэгийн мэргэн багш нарыг урин залдаг байсан байна. Бурхны шашны судар, авидарма, санкхья гүн ухааныг тайлж чаддаг, шившлэг мэддэг лам Дармаприяг (? -489) Нируны төрийн багшаар томилон, 3000 өрх соёрхож байсан хийгээд умарт Энэтхэгийн Удьяана улсын лам Нарендраяшаг (489-589) зургуулаа замдаа дорно зүг Нирун улс хүрсэн байна. Тэдний лам нар бурхны шашны зан үйлийг төгс эзэмшсэн тул тэнгэр тахьж атиблан цасан шуурга тавиулж дайснаа мөрдөхөд саад хийж чаддаг байжээ.(32) Нирунчуудын хэлний хятад утга үсгээр галигласан үгс, зарим хүний нэрийг Б.Карлгрен, С.Ф.Ким нарын нэхэн сэргээлтийн тэр үеийн дуудлагаар үзэхэд монголын хуучин бичгийн хэлний дуудлагатай тун ойролцоо дуудлагатай байгааг “Нирунчуудын хэлний хятад утга үсгээр галигласан үгс, зарим хүний нэр нэхэн сэргээлтийн тэр үеийн дуудлагаар үзэхэд монголын хуучин бичгийн хэлний дуудлагатай тун ойролцоо дуудлагатай байна. Ингэхээр монгол судлаачдын үзэж байгаа Монгол бичгийн хэлний үл мэдэгдэх үед хамаарагдах эртний үе нь наана хэлэхэд нируны үед холбогдоно” гэж үзэх үндэстэй хэмээн түүхч Г.Сүхбаатарын үзсэн нь Нируны ид мандаж байсан 500-гаад оны үе болой.(33)

VIII зууны дөчөөд онд Зүүн түрэгийн хаант улс мөхсөний дараа түүний газар нутаг дээр Монгол оронд Уйгарын хүчирхэг нүүдэлчин гүрэн тогтжээ. Уйгарын хаант улсын бүрэлдэхүүнд олон тооны монгол, түрэг хэлтэн аймгууд багтан орсон бөгөөд тэд нийгэм эдийн засаг, соёлын хэм хэмжээний хувьд өөр өөр байжээ. Уйгарын хаант улсын эзлэн суусан нутаг нь баруун зүгт Алтайн уулнаас, зүүн зүгт Хянганы нуруу хүртэл, өмнө зүгт говь хүртэл, хойт зүгт Соён уул хүртэл байжээ. 758 онд Ордубалыкаас нилээд зайтай Сэлэнгэ мөрний хөвөөнд Уйгарууд

Бай-балык хотыг байгуулан соёлын төв болгож, Согдын лам нарыг авчирч шашны ном судар орчуулуулж байжээ. Уйгарууд орхон бичиг хэрэглэж байгаад Нирунчуудын хэрэглэж байсан Сири гаралтай согд цагаан толгойд үндэслэн үсэг бичиг зохион хэрэглэсэн нь соёлын нэг том чухал ололт болсон юм. Уйгарын эрхшээлд байсан Монгол болон бусад олон аймгууд энэ бичгийг авч ном, дэвтэр, судар, эрдэнэ, шүлэг зэрэг согд үг, сүм, суврага, хөрөг, эрдэм зэрэг энэтхэг үгс монгол хэлэнд оржээ. Монголын түүхч Зава Дамдин гавж, төвдөөр бичсэн “Монголын түүх” (Hor-chos’ byun) зохиолдоо: Чингис хааны үеэс даруй 700 жилийн урдаас монгол, уйгар, согд нар их л ойр харилцаатай байсныг дурдаад “Согдын мэргэн багш нар Уйгар хийгээд Монголчуудад үсэг бичиг унших ба бурхны дээд зарлигуудыг өөр өөрийн хэлээр орчуулах ёсыг үзүүлж сургав. Бас Согд нар Энэтхэг орноос бурхны номыг Монгол оронд залж ирсэн бөгөөд энэ шалтгаанаар номын хэлэнд энэтхэг, уйгар, монгол үг холимгоор оршсоор байна” гэжээ.(34) Энэ нь Чингисийг хаан суусан оноос урагш хөөвөл Их Нируны ид мандан байсан 500-гаад оны үед очиж байгаа нь монгол бичгийг согдоос авсан он цагийн давхар баталгаа болж байна. Энэ үеийн Согд, Монгол, Уйгар нарын харилцаа Уйгарын хаант улсын үе хүртэл үргэлжлэн байсан болтой. Энэ талаар Академич Б.Ренчин нэг өгүүлэлдээ “Монголчууд уйгар бичгийг Чингисээс бүр өмнө Буданцар дээдсийн үед мэддэг байсан” гэж дүгнэснийг дээр дурдсан билээ.(35) Нируны үед авсан бичгийг монгол нутагт оршин байсан том аймгууд Уйгарын хаант улсын үе болж ирэхэд улам төгөлдөржүүлэн хэрэглэж байсан учир нэг шинэ улс гүрэн гарахад өөрийн бие даасан үсэгтэй байх уламжлалт зарчмын үүднээс хийгээд биеэ даасан тусгаар улс болсны нэг илрэл

болохын үүднээс Түрэгийн хаант улсын төрийн бичиг байсан руныг хэрэглэж байгаад монгол бичгийг хэрэглэсэн байна. Уйгарын хаант улсыг мөхөхөд монголын гол том ханлигууд болох Хамаг монгол, Хэрэйд, Найман нарт хэрэглэгдсээр байсан бөгөөд Чингисийн үе болж ирэхэд энэ бэлэн боловсронгуй бичгийг авч хэрэглэсэн нь дамжиггүй юм.

▪3. Хятадын дүрс үсгээс сэдэвлэж зохиосон бичиг үсэг. /Сүмбэ, Кидан/

Монголчуудын дээд өвөг хөгжлийнхөө явцад үсэг бичигтээ шинэчлэл хийсээр ирснийг тоба нарын шинэ бичиг зохиосон баримтаас харж болно. Тобагийн Дай хаан /424-452/ 425 оны гуравдугаар сарын цагаан бич өдөр...цзюхуатан ордонд заларч, анх шинэ үсэг мянга гаруйг зохиосныг болгоож үзээд, зарлиг буулгасан нь: “Урьд Юань эзэн хааны үед юмс зохион бүтээхдээ Цан Цзед тушаан, жигүүртэн араатны мөрийг дууриалган, үсэг зохиолгосон амой. Түүнээс хойш цагийн улирлыг даган өөрчилснөөр тулгуур бичиг /чжунь/, завсарын бичиг /ли/, таталгаа бичиг /цао/, дүрэмт бичиг /кай/ зохион нийтэд бүгдийг хэрэглүүлжээ...өдгөө зохиосон үсгийг нийтэд хэрэглэхээр холхи, ойрход тараатугай. Хичээнгүйлэн журамлагтун” гэжээ.(36) Тобагийн тэр шинэ бичиг гэгчийн үсгийн тоо мянга гаруй, хятад бичиг зохиосон тухай домгийг дурьдсан зэргээс үзэхэд хятад бичгийг үндэслэн зохиосон нь маргаангүй. Ингэхлээр энэ бол киданы их бичигтэй адилавтар байсан бололтой.

Уйгарын дараа монголын түүх соёлд нэрээ үлдээсэн том монгол аймаг бол дорнот ху-гийн монголчуудтай нэг гаралтай X зууны дунд үеэс XII зууны эхэн үе (907-1125) хүртэл Умар зүг хар тэрэгтэн-шибэй нар, өрнө зүг Си /Кумоси/ зэрэг хөрш улсууд,

монгол нутгаас Киргизийг шахан хөөж, Уйгар, Хамниган, Мохэ, Нюйжэнь /Жүржэнь/, Бохай улс, Хятадын умарт ба дорнот хэсгийг эзлэн өргөн уудам нутагт оршин тогтнож байсан Кидан гүрэн юм. Х зууны дунд үе гэхэд Кидан гүрэн нэгэнт бүрэлдэн тогтоод улсаа Ляо хэмээн нэрлэх болжээ. Кидан гүрний тогтнож байсан тэр үе нь монгол оронд мянга гаруй жилийн турш олон овог аймгууд товойн гарч, нүүдэлчид төр улсаа ээлжлэн барих үйл явц биелэлээ олж байсан үе дуусаж, түүхийн тавцнаа угийн монголчууд, бусад монгол хэлтэн овог аймгууд Төв Азийн түүхэнд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэх болсон цаг билээ.(37) Киданы соёл өмнөх үеийн соёлтой харьцуулбал өндөр хөгжилтэй байжээ. Кидан нарын дунд буддын шашин Х зуунаас нилээд дэлгэрч, 942 онд лам нар таван түм байсан нь 1078 онд гурван бум 6 түм болжээ. Бөөгийн шашнаас бусад бүх шашин өөрийн үзэл, номлолыг дэлгэрүүлэхийн тулд бичиг үсгийн асуудалд маш няхуурч хандаж түүнийг боловсронгуй болгогч хийгээд түгээн дэлгэрүүлэгч болж байсан билээ. Кидан нар улсаа байгуулахаас өмнө өөрийн бичиг үсэгтэй байв. Ляо гүрнийг байгуулсны дараа Киданы эрдэмтэд хоёр төрлийн бичиг зохиосон бөгөөд тэдгээрийн нэгийг /920 онд/ Амбагяны ач Юлей Лугубу, Туйлюйбу хоёр нангиад дүрс бичгээс үлгэр авч хэдэн мянган үсэгт “Их бичиг” гэдгийг зохиожээ. Энэ бичиг нь Алтан улс даяар ихэд дэлгэрсэн бөгөөд түүний дурсгалууд Киданы хаадын булш, Чин толгойн балгас, Хэнтийн салбар уулс орчмоос олдсон билээ. Харин 925 онд Амбаганы хүү Елей Дэлагийн 400-аад тэмдэгт бүхий бага бичгийг уйгаржин бичигт тулгуурлан зохиосон гэж зарим судлаачид, манай түүхчид үзсээр ирсэн билээ.(38) Энэ талаар сүүлийн үед зарим судлаачид өөр саналтай байгаа бөгөөд үсэг зүй судлаач, нэрт эрдэмтэн, доктор Ц.Шагдарсүрэн

сүүлийн судалгааны номдоо “Одоогоор бидний мэдэж буй хятан “Их бичиг”, ”Бага бичиг”-ийн дурсгалуудыг авч үзэхэд уйгур үсгийн хэлбэрт шүтэж зохиосон гэмээр баримт, тухайлбал үсгийн хэлбэр, байдал, тэдгээрийг холбон бичих ёсон хийгээд хятан бичгийн талаар өнөөг хүртэл гарсан судалгааны дүнд сэргээн тэнхрүүлсэн дуудлага зэрэгт нэгээхэн бээр ч харагддаггүй билээ” хэмээгээд “Бага бичиг” бол “Их бичиг”-ээ боловсронгуй болгон зохиосон авиа үеийн бичиг мөн хэмээн дүгнэсэн нь цаашид нарийвчлан судлууштай үнэнд ойр, бодож үзүүштэй сонин санал байна.(39) Бичгийн их соёлт кидан нарын хувьд модон бараар хэвлэх, харь хэлээс орчуулах, бусадтай соёлын талаар харилцах зэрэг өргөн хэлхээ холбоотой байсан байна. Жишээлбэл: Солонгосоос кидан хэл сурч судлахаар хүмүүс ирж байсан байна. Кидан бичгийн тун цөөн дурсгал өнөө хүрч ирсэн бөгөөд нийт 20 гаруй дурсгал байна хэмээн бүртгэсэн хэдий ч бүрэн тайлж уншаагүй байна. Кидан үсэг бичгийн уламжлал 1125 оноос буюу Алтан улс, Сүн улстай хавсарч киданы төрийг унагааснаас хойш ч тасралгүй уламжилжээ. Тухайлбал зүрчидүүд киданы их бага бичигт дулдуйдаж өөрсдийн их бага бичгийг зохиосон байна. Их Ляо улс унаж халагдсан ч түүний зарим хэсэг баруун тийш нүүдэллэж, Хар Кидан улсыг Дундад Азид байгуулжээ. Энэ улс XIII зууны дунд үе хүртэл оршин тогтнохдоо кидан үсэг бичгийн уламжлалыг хадгалж байсан нь гарцаагүй. Мөн тангад бичгийг (1047) кидан үсгээс үлгэр авч зохиожээ. Өнөө үед олдоод байгаа кидан үсэг бичгийн дурсгал X-XII зууны үед хамаарч байна. Кидан нар монгол хэлтэн болохыг нангиад сурвалжид тэмдэглээстэй хоцорсон кидан хэлний хэрэглэгдэхүүн харуулж байна. Кидан нар өнөөгийн дагуур нарын өвөг дээдэс болно.(40) Кидан нар өөрийн төрөлх хэлээр бичсэн утга

Хэнтийн аймгийн Салбарын
Ханан хадны кидан бичээс

зохиолтой байсан бөгөөд Амбагяны ач Лунсянь “Цэцэглэг хүрээлэн” хэмээх утга зохиолын цоморлиг бичгийг зохион гаргажээ. Эзэн хаан Шеньзун (983-1030) 500 гаруй шүлэг бичиж, мөн хятадын нэрт яруу найрагч Бо Цзюйн “Ёгт хошин цоморлиг” гэдгийг кидан хэлнээ орчуулж байв. Киданы эрдэмтэд түүхийн үнэт олон зохиол бичиж байсан бөгөөд мал аж ахуй, гар үйлдвэрлэлтэй холбоотой мэдлэгээс гадна мал эмнэлэг, газар зүй, анагаах ухаан, одон орон, агроном зэрэг салбар кидан нарын дунд хөгжиж байснаас гадна уран зураг, баримал, модон сийлбэр, хөгжмийн боловсрол нилээд хөгжжээ. Буддизм Ляо гүрэнд хамгийн их нөлөөтэй нь байжээ.(41) Киданд IX зуунаас эхлэн хэл судлал, түүх, гүн ухаан, хууль их хөгжиж, улмаар биеэ даасан шинжлэл судлалын газартай болж эрдэмтэн мэргэд нь их таван ухаанаар сорилт шалгалт өгдөг байсан тухай түүхэн мэдээ бий. Тэр үеийн Киданы сэхээтнүүд самгард, хятад, солонгос хэлийг мэддэг байжээ.

Нэгдүгээр бүлэгт эшлэсэн эх сурвалж болон ном зохиол

1. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991, х.153
2. Монгол –Татарууд Ази Европт. УБ., 1984, х. 63
3. Ардын эрх, 1996-8-2, No 153/1371
4. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ.,1991, х.119
5. Э.А.Новогородова. Мир петроглифов Монголии. 1984, х. 3
6. А.Дамдинсүрэн. Хүннү гүрэн 6-8 мянган жилийн түүхтэй. /Дээжис/, 1997, 1 сар No.01
7. БНМАУ-ын түүх. х.114
8. Мөн тэнд х.116
9. Г.Сүхбаатар. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа, гарвал. УБ.,1980. х.112-113
10. Мөн тэнд х.114-115
11. Ж.Баянсан, Г.Одонтөр. Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн толь. УБ.,1995. х. 80-82
12. F.Altheim. Geschichte der Hunnen. Erster Band. Berlin, 1969, s.283-284
13. Л.Мөнх-Эрдэнэ, Европын Хүннү ба Атила, УБ., 2000, х.15
14. F.Altheim. Geschichte der Hunnen. Erster Band. Berlin 1969, s.286-288
15. Археологийн судлал. ред. Н.Сэр-Оджав, XIII:I,1987, х.180
16. Г.Сүхбаатар. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа, гарвал. УБ., 1988, х.188

17. Май Мөрөн. Хүннүгийн бичиг үсгийн тугтам шинжилгээ. Өвөрмонголын их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. 1996, No.6
18. Д.Наваан, Б.Сумъяабаатар. Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал. УБ., 1987, х.84-99
19. Г.Сүхбаатар. Сяньби. УБ., 1971, х.3
20. Мөн тэнд х.106
21. Мөн тэнд х.116
22. Ж.Баянсан, Ш.Одонтөр. Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь. УБ., 1995, х.74
23. Г.Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг. I, УБ., 1992, х34
24. БНМАУ-ын түүх.УБ.,1984, х.124-126
25. Г.Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг. УБ.,1992, х. 59
26. Л.Болд. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. УБ., 1990, х. 5
27. Мөн тэнд х. 7-8
28. Л.Болд. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. УБ., 1990, х. 73
29. Ц.Баттулга. Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын зарим судалгаа. УБ., 1999. Түүхийн ухааны дэд докторын зэрэг горилсон зохиол.
30. БНМАУ-ын түүх. УБ., 1984, х.123.
31. Г.Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг. УБ.,1992, х. 52-53
32. Мөн тэнд х. 54-55
33. Г.Сүхбаатар. Монголын нууц товчоон дахь эртний уламжлал. Mongolai, Vol 1 (22), 1990 х.110
34. (རྟམ་དིན། ཧོར་ཆོས་འབྱུན། Rtam din Hor-chos' byun)


35. Yongsiyebu Rincen. Les inscription inconnues sur pierre et les plaques d'or ornamentees du harnais de Toyoucouc. "Central Asiatic Journal" vol 4, No 4, p 20
36. Вэйшу. 4-р бүлэг
37. БНМАУ-ын түүх. УБ., 1984, х.136
38. Ж.Баянсан, Ш.Одонтөр. Хэл шинжлэлийн нэр томьёоны зүйлчилсэн тайлбар толь, УБ., 1995, х. 97-98
39. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ., 2001, х. 59
40. БНМАУ-ын түүх. УБ., 1984, х. 37
41. Д.Төмөртогоо. Монгол хэлний түүхэн хэлзүй. УБ., 1992, х. 34

Хоёрдугаар бүлэг: Монголын эзэнт гүрний үеийн соёл, бичиг үсэг (1206-1368)

▪1. Монгол бичиг

Төв Азийн нүүдэлчдийн анхны хүчирхэг их гүрэн Хүннү улс байгуулагдах үеэс эхлэн монгол, зүүн түрэг угсааны аймгуудын улс төр, эдийн засаг, соёлын нийтлэг уламжлал тогтсон юм. Тэр нь XIII-XIV зууны Монголын феодалын нэгдсэн төр улс, эзэнт гүрэн байгуулагдаж, удтал оршин тогтноход нэн хүчтэй илрэн хэрэгжсэн үзэгдэнэ. Монгол орон, монгол үндэстэн түүхийн тавцан дээр тодрон гарч, Монголын соёл, бичиг үсэг, гадаад харилцаа өргөжин хөгжих үйл хэрэгт XIII зууны эхээр Монгол үндэсний нэгдсэн тулгар төр болох Их Монгол улс байгуулагдаж, Ази, Европыг дамнасан эзэнт гүрэн болон хөгжсөн явдал ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Их Монгол улсыг байгуулахад XII зууны эхээр үүссэн, Онон, Хэрлэн, Туул гурван голын Хамаг Монголын ханлиг, түүний нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлсэн Тэмүжин Чингис хааны үйл ажиллагаа ихээхэн ач холбогдолтой болсон байна.(1) Чингис хаан бутарсан монгол аймгуудыг хураан нэгтгэж, нэг хаантай, нэг төртэй, нэг хуультай, нэгдмэл үсэг бичигтэй, нэгдмэл хүчирхэг армитай болгон монгол түмний нэрийг ертөнцийн чихнээ дуурсгасан нь түүний тэргүүн зэргийн гавьяа мөн билээ.(2) Гурван голын монголчууд бол нийт монгол үндэстний гол хэсэг буюу монгол генийн гол цөм нь байсан билээ. Нэгдсэн монгол улс байгуулагдсан явдал бол монгол угсаатан бүрэлдэхийн зэрэгцээгээр монгол хэл, монгол төрийн бичиг үсгийн хөгжлийн шинэ үе эхэлж нийтэд дэлгэрсэн нэгэн бичгийн хэл бий болохын гол үндэс бий болжээ. Монголын эзэнт гүрэн байгуулагдахаас олон зууны тэртээ монгол нутагт

улс гүрнээ байгуулж байсан монгол аймгууд бичиг үсэгтэй байсан бөгөөд Чингис хаан болон түүнийг залгамжлагч их хаад энэ нандин өвийг өвлөн авч цаашид улам хөгжүүлэн дэлгэрүүлсэн байна. Монголын нэгдсэн гүрэн бүрэлдэн буй болж улмаар түүнд нэгдэн орсон олон овог аймгууд улс төр, эдийн засаг, соёл шашныхаа талаар эрхбиш ойртож ирэхийн сацуу нийтийг хамарсан нэгэн нэгдмэл бичгийн хэл зайлшгүй шаардлагатай болжээ. Шинэ тутам гарч ирсэн энэхүү шаардлагыг хангахын тулд урьд цөөн зарим аймгийнхны дунд хэрэглэгдэж байсан уйгаржин монгол бичгийг нийт монгол аялгуунуудын дундын байдлыг адил тэгш тусгасан илүү боловсронгүй бичгийн хэл болгож, монгол хэл, соёлын хөгжилд туйлын том шинэтгэл хийсэн юм. Монгол бичгийн хэл бол монгол угсаатан, үндэстний олон зуун жилийн турш бий болгож, гарамгай зохиолч, гүн ухаантан, эрдэмтэн мэргэд, соён гийгүүлэгч зэрэг бичгийн хүмүүсийн баяжуулан сайжруулсан үндэсний хэлний дээд хэлбэр болсон бөгөөд тус орны эрдэм, соёл, утга зохиол, урлагын хөгжлийн чухал хэрэглүүр болсон билээ. Нэгдсэн Монгол улсыг байгуулаад, Чингис, хаан ширээнд суухдаа монгол бичгийг төрийн бичиг болгоод, төрийн тамгаа монгол бичгээр үйлдэж, тамганыхаа үгэнд монгол бичгийн цагаан толгойн бүх үсгийг багтааж өгчээ. Эдүгээ олон ном зохиолд Гүюг хааны тамгын бичиг гэж дурдан бичиж байгаа тэр зүйл Чингис хааны тамгын бичиг мөн бөгөөд “Чингис хааныг нас барснаас хойш Гүюгийг хаан суух хүртэлх 18 жилийн хугацаанд Монголын эзэнт улсын тамга үрэгдээгүй” гэж Өвөр Монголын эрдэмтэн Сайшаалт “Чингис хааны товчоо” номдоо бичжээ.(3) Үнэхээр энэ хугацаанд монголчууд дан гадагш хандаж байсан тул төрийн тамга үрэгдэх учиргүй гэх үндэстэй тул Гүюг хааны

барьж байсан тамга бол түүний өвөг эцэг Чингис хааны тамга мөн гэж үзэх бүрэн үндэстэй.(4) Монголчуудын эрт дээрээс уламжлалтай төрийн эрх сүр хүчнийг илтгэдэг төр ёсны нэн эрхэм зүйл бол төрийн тамга учир анхны үйлдсэн зүйлүүдийн нэг нь энэ бөгөөд монгол бичгийн цагаан толгойн 19 үсгийг тамгын үгэнд багтааж чадсан нь яавч сая бичиг үсэг авсан улс гүрний хийх ажил биш юм. Тамгын хамгийн сүүлийн үг болох  “аюутугай” хэмээх үг нь өмнө байгаа  “биширтүгэй” хэмээх үгээ утгын хувьд давтсан хийгээд эзэнт гүрний сүр хүчнийг илтгэхийг зорьжээ хэмээн үзмээр боловч энэ нь үгийн эхний  “a” үсгийг үзүүлэхийн тулд оруулж өгсөн нь энэ болой.

Үгийн дунд орсон “а,э” хоёрыг давхар үзүүлээд, эхэнд орох а-г үзүүлж чадахгүй тул энэ үгийг зориуд оруулж өгсөн нь илт байх мэт. Ингэж цагаан толгойн бүх үсгээ тамгандаа багтаасан улс гүрэн тэр цагт огт байсангүй нь монгол тамга болон бичиг үсгийн олон зууны нягт холбоог харуулан байна. Тамгын гол агуулга нь түүн дээр ямар нэгэн бичгээр гүн утга санааг илэрхийлдэгт оршино. Тийм ч учраас “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсын далай хааны зарлиг” хэмээн эхэлдэг нь тэнгэр шүтээнт их хааны сүр хүчнийг холхи ойрын олон түмэнд үзүүлж төрийн хамгийн дээд хууль ёсны баталгаа болгож байсан хэрэг юм. Түүхч Ч.Далайн саналаар Монгол улсын Их хасбуу тамгыг Өгэдэй хааны үед бүтээж Их Хуралдайгаар батлуулсан гэж үзсэн нь бас ч бодож үзэх, судалж үзэх ёстой зүйл юм. Гэвч эртний монголын нүүдэлч улсууд хийгээд овог аймгууд өөр өөрсдийн овгийн тамгатай байсан хийгээд гэргэ буюу пайз хэрэглэж байсан уламжлал, Чингисийн үеийн ханлиг улсууд тамга хэрэглэж байсан зэрэг нь Их Монгол улсыг байгуулаад Чингис төрийн тамгийг бий болгосон гэж үзэх үндэс бүрэн байгаа болой. Чингис хаан 1205 онд Найманы Таян хааны бичгийн сайд Тататунгааг төрийн тамгын хамт олзлон аваад бичигтэй тамгын учрыг асууж мэдэн, тиймэрхүү маягийн тамгыг төрийн хэрэгт хэрэглэх болж, мөн уйгаржин монгол бичгийг өөрийн үр хүүхэд угсаа төрлийн ноёдод зааж сургахыг Тататунгаад тушаасан(5) хэмээн Юань улсын сударт байдаг цухас домог мэдээг гадаадын зарим эрдэмтэн үндэс болгож, Монголчууд XIII зууны үеэс уйгар бичиг авч хэрэглэсэн хэмээн үзэж ирсэн бөгөөд энэ санал ихэд дэлгэрч лавшран үнэмлэхүй үнэн мэт болсон нь ихээхэн учир дутагдалтай бөгөөд монголын зарим аймаг нэгэнт авч хэрэглээд удсан монгол бичиг Чингисийн үед нийт Монгол даяар тархан

дэлгэрч, нэгдсэн Монгол улсын албан бичиг болсон гэж үзүүштэй(6) гэсэн Монголын түүхч, нангиадач эрдэмтэн Ч.Далайн санал илүү үнэмшилтэй байна. “Юан улсын судар”-ын 124 дүгээр ботид байгаа тэр домогт “Чингис өрнөш дайлж, Найман улс эвдэрхүйд Тататунга тамгыг өвөрлөн дайжаад баригдав. Чингис хаан ухавчлан асууруун: -Даяны иргэд, нутаг цөм миний болсон бөгөөтөл чи бээр тамга өвөрлөн хааш эчмүй хэмээхэд тэрбээр: “Түшмэлийн тушаал болой. Үхтэл сахиж угийн эзэнд өгсү хэмээмүй. Ямар аймшиггүй өөрийг сэтгэх аж” хэмээжүхүй. Хаан зарлиг болж, “Шударга элбэрэлт хүн ажгуу” хэмээгээд тамгыг юунд хэрэглэхийг асууваас, “Аму цалинг оруулах, гаргах эрдэмтнийг өргөмжлөх аливаа үйлд хэрэглэж итгэмж болгомуй” хэмээсэнд хаан таалж шадар болгожухуй. Түүнээс хойш засаг зарлиг тэргүүтэнд тамга хэрэглэн үүсгэж мөн түүгээр захируулав. Хаан “Чи тус улсын бичгийг нэвтэрхий мэдмүй” гэхэд Тататунгаа сурснаа өчсөн нь зарлигт нийлэлцсэн тул даруй хөвгүүд, дүү нарт уйгар үсгээр улсын хэлийг тэмдэглэхийг сургагтун хэмээн захив” гэсэн байдаг. Тататунгаагийн өвөрлөж явсан тамгыг үзээд огт гайхалгүй тамга хэмээн хэлж байгаа нь тэр тамгыг аль эртнээс мэддэг байсан нь илэрхий юм. Чингис хаан Найманыг 1204 онд эзэлж авсан нь үнэн. Харин энэ үед монголчууд анх бичиг үсэгтэй болсон хэрэг огт бус бөгөөд алдарт монголч эрдэмтэн Б.Я.Владимерцовын бичсэнчлэн Чингис хаан өөрийн эзэнт улсын хэрэгцээнд ихээхэн боловсорсон бэлэн утга зохиолын хэлийг авч хэрэглэсэн ажээ. Өөрөөр хэлбэл монголын зарим аймагт хэрэглэж байсан бичгийг Чингис хаан эзэнт улсынхаа хүрээнд хэрэглэжээ. Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн Г.Д.Санжеев энэ тухай “Ямар ч гэсэн 1204 онд Чингис хаан Найманыг бут цохиж, Найманы Даян

хааны тамгыг барьж байсан нэгэн уйгарыг олзолж, түүний тусламжаар төрийнхөө бичиг хэрэгт уйгар үсэг дээр үндэслэсэн монгол бичиг үсгийг хэрэглэсэн бололтой гэсэн нэгэн домог байдаг. Гэвч хэргийн гол нь Чингис хаан төрийнхөө бичиг хэргийг Согдоор дамжиж, Арамэйгээс ирсэн шинэ үсгээр явуулах тухай тушаал гаргасанд бус, харин Чингис хааны үед монголчууд нэгэнт ямар нэгэн хэмжээгээр бэлхэн болоод байсан утга зохиолын хэлийг хэрэглэж эхэлсэнд оршино" гээд цааш нь "монгол бичгийн хэл нь бүр XIII зууны үед сайтар хэвшин тогтсон дүрэмзүй, хэл найруулга бүхүй боловсронгүй бичгийн хэл байснаас үзвэл тэр нь монгол гүрэн бүрэлдэн тогтохоос ч бүр өмнө үүсэн бүрэлдсэн бололтой" гэжээ.(7) Дээрх домог нь зөвхөн бичиг зааж сургах тухай мэдээ төдий бөгөөд энэ тухай Рашид-ад-дины зохиол, Монголын нууц товчоо зэрэг тэр үеийн гол сурвалжид байхгүй бөгөөд харин Мэргэн гэгээний 1765 онд зохиосон "Алтан товч"-д "Хасар Тататунгааг багш барин, бичиг, хууль, цэргийн бодлого тэргүүтэн олон зүйл бичиг, утга заалгаж удалгүй сурав"(8) гэсэн байдаг. П.Пеллио "Тататунгаа Чингисийн хүүхдүүдэд бичиг сургасан"(9) гэжээ. Д.Кара "Тататунгаа монголчуудад уйгар бичиг заасан. Гэвч тэр монгол бичгийг зохиогч байсан гэдэг тухай тодорхой нотолгоо энэ домогт байхгүй. Тэр монголчуудтай ямар хэлээр харилцаж байсан нь тодорхойгүй, тэрчлэн урьд нь түүний алба хааж байсан найманууд монгол хэлтэн үү, түрэг хэлтэн үү эсвэл тэд хоёр хэлээр ярьдаг байсан уу гэдэг нь тодорхойгүй байна"(10) гэжээ. Ингэхлээр энэ нь бичиг зохиосон, бичиг зээлдэж авсан тухай мэдээ бус, зөвхөн бичиг заасан тухай мэдээ байна. Чингис хаанаас өмнө байсан Хамаг Монголын хаад болох Хабул, Амбагай болон түүний эцэг Есүгэй баатарын үед ч тэр үеийн

хүчирхэг ханлигуудаас гадна Зүрчидийн Алтан улс мэтийн дорнын улс оронтой харилцаж байсан нь төрийн хэрэг болон угсаа гарлын түүхийг бичиж тэмдэглэж байсан байх гэх таамаглал “Монголын нууц товчоо”-г уншихад өөрийн эрхгүй төрдөг болой. Монголын нууц товчооны 203-р зүйлд бичиг, дэвтэр, цаас мэтийн бичиг соёлын хэвшсэн үгс байна. Энэ бол монголчууд нэн эртний үеийн бичгийн соёлын уламжлалтайн гэрч. Рашид-Ад-Дин Монголын нууц товчоо зохиогдохоос өмнө Алтан дэвтэр хэмээх нууц түүх байсан бөгөөд үүний үрээр нууц товчоонд хаадын уг гарлыг ийм тодорхой гаргасан болой хэмээсэн нь буй. Мөн тэрээр “Монголчууд “үнэн түүхийг” үе улируулан монгол хэлээр монгол бичгээр тэмдэглэж бичсэн байдаг боловч, цуглуулж цэгцлээгүй, тус тусад нь хэсэг хэсгээр санд хадгалж байсан” гэж бас тэмдэглэсэнээс үзвэл нилээд боловсорсон монгол бичгээр түүх судраа хөтөлж тэмдэглэж байжээ. Тиймээс Чингисээс бүр өмнө түүний өвөг дээдэс удмынхаа түүхийг бичиж тэмдэглэсэн байсан гэж зарим эрдэмтэд таамаг гаргадаг. Ийм болохоор үе дамжин уламжилсан бичгийн мэргэд байсан байж таарах ёстой. 1210 он гэхэд Их Монгол улсад монгол бичгийн сургууль хэд хэд байгуулагдаж монгол дээдсийн хүүхдүүд суралцаж, монгол бичгийн багш нь Тататунга, Шихихутуг нарын хэд хэдэн бичгийн өндөр боловсролт монгол хүн байжээ. Ер нь Чингис Монголын төрийн ажил хэргийг эхэн үедээ дан өөрийн монгол төрийн зүтгэлтний хүчинд дулдуйдан явуулж байсан бөгөөд хожим Елюй Чу-цай гэх мэтийн цөөн тооны гадаадын бичгийн хүн, эрдэмтэн нарыг ашиглаж байсан бөгөөд тэд Чингисийн үед төдий л олон байгаагүй бөгөөд нөлөө нь ч ялимгүй байжээ. Тэгэхлээр төрийн зүтгэлтэн болон бичгийн мэргэдийг үе

уламжлан бэлддэг байсан байх ёстой. Тататунгааг барьж авснаас хойш хэдхэн сарын дараа Шихихутугийг төрийн заргачаар томилж аливаа хэргийг хөх дэвтэрт бичиж байхыг даалгасан нь яавч хэдхэн сар бичиг үсэг сурсан хүний хийх ажил биш болой. Найман аймгийг уйгар түрэг гаралтай, түрэг хэлээр ярьж байсан монгол аймаг, тэдний хэрэглэж байсан бичгийг уйгар бичиг гэх мэтээр судалсан зарим эрдэмтэдийн судалгааг хараахан зөвшөөрч боломгүй санагдана.(11) Найман бол ойрад монголын нүүдэлчдийн нэг хэсэг байсан. Монголын нууц товчоонд Чингис, Таян хан ярилцахдаа болон Тататунгааг барьж аваад ямар нэг хэлмэрч хэрэглээгүй. Найманыг монгол аймаг байсан тухай Рашид-ад-дин “Хэрэйд, Найман, Оннигуудыг монгол аймгуудаас хамгийн түрүүнд төр улстай байсан”(12) гэжээ. Юан гүрний үеийн сурвалжид уйгаржин монгол бичгийг уйгар бичиг, уйгаржин монгол бичигтэй хүнийг уйгар хүн гэх мэтээр хутгаж бичсэн тал бий.(13) Үүнийг уламжлан өрнөдийн сүүлийн үеийн ном зохиолд монгол бичгийг уйгар бичиг(14) гэж бичих болсон нь их харамсалтай бөгөөд эндүүтэй хэрэг юм. 1920-иод оны үед монгол бичгийн хэлийг гүнзгий судалсан Б.Я.Владимерцов “Уйгаржин монгол бичгийг монголын ямар нэгэн нутгийн аялгууг түшиглэн авсан нь дамжиггүй. Монгол бичгийн хэл анх Хэрэйд, Найманы дотор бий болж Чингис хааны үе хүртэл хэвээр хадгалагдан ирсэн бололтой. Саяхан болтол эртний монгол бичгийн хэлний уг үндэс нь эртний Найман аялгуу байсан гэж хэлж болох юм. XIII зууны монгол бичгийн хэл бол хэдийн бүрэн боловсорчихсон зөв бичих зүйтэй хэл байгааг бид үзэж байна. Энэ бол монгол бичгийн хэл нилээд түрүү үед ямарч байсан Чингис хаанаас өмнө үүсчээ гэдгийг санагдуулж буй баримтат зүйл мөн”(15) гэж бичиж байв. Монгол түрэг хэлэн дэх

ижил үгсийн хоорондын бүтэц, авиан зүйн талын зөрөөг /Жишээлбэл: орчин цагийн монгол хэлний “эр”, “ эрх “ мэтийн үг нь түрэгийн орхон- енисэйн бичигт “эр“, “эрк“, хуучин монгол бичигт 𐰀𐰺 𐰃 𐰀𐰺𐰃 “эр-э“, “эрк-э “ гэж байна гэх мэт/ судалж үзээд монголын хэлбэр нь орхоны түрэг бичгийн хэлбэрээс эртнийх юм гэж Г.Рамстедт, Б.Я.Владиморцов, Н.Поппе, В.Банг, С.Мураяма, У.Пош зэрэг уг асуудлыг судалсан монгол, түрэг судлалын эрдэмтэдийн олонхи нь үзэж байна. Руни бичгийн дурсгал дахь “о, у”, “ө, ү”-г монгол бичгийн “о, у”, “ө, ү”-тэй адил нэг тэмдэгтээр тэмдэглэсний нь харахад ч монгол бичгээс санаа авсан юмуу эсвэл монгол бичгийн болон брахма бичгийн боловсролтой хүн зохиосон байх гэж бодогдмоор байдаг. А.Лувсандэндэв төв Азийн нүүдэлчдийн бичгийн уламжлалыг судлаад “Уйгар цагаан толгой нь дан монгол хэлэнд зориулан тусгайлан зохиосон юм шиг байна. Тэр нь дунд үеийн монгол хэлэнд сайн тохирдог шигээ уйгарт ч хуучин узбек /цагаадайн/ хэлэнд ч тохирохгүй байна.(16) гэжээ. Бидэнд одоогоор мэдэгдэж байгаа Монгол бичгийн хамгийн эртний гэж хэлж болох 1220-1225 онд холбогдох“ Чингисийн чулууны бичиг“-ийн бичиг нь тэр үеийн уйгар бичиг баримтынхаас жаахан ялгаатайг Л.Лигети анхааруулжээ.(17) Доктор Б.Ренчин “Чингис, Өгөөдэй, Мөнх хааны үеийн монгол бичиг тогтсон нарийн дүрэмтэй, боловсорсон бичгийн хэлтэй байсныг нэн илэрхий гэрчлэн буй тул ...дэмий л таамагласан нь ул үндэс муутай хэрэг“(18) гэжээ. Мөн Б.Ренчин бас нэг өгүүлэлдээ: “Монголчууд уйгар бичгийг Чингисээс бүр өмнө Буданцар дээдсийн үед мэддэг байсан“(19) гэж дүгнэсэн ажээ. Буданцар дээдэс гэдэг маань Чингисээс 9 үеийн өмнөх дээдэс бөгөөд ойролцоогоор 650-700 жилийн өмнөх үе юм. Энэ нь V зууны үед хамаарч байгаа хэрэг.

Монголын түүхч Зава Дамдин гавж, төвдөөр бичсэн “Монголын түүх” /ཧོར་ཆོས་འབྱུང་/ Hor- chos’ byun/ зохиолдоо: Чингис хааны үеэс даруй 700 жилийн урдаас монгол, уйгар, согд нар их л ойр харилцаатай байсныг дурдаад “Согдын мэргэн багш нар Уйгар хийгээд Монголчуудад үсэг бичиг унших ба бурхны дээд ном, зарлигуудыг өөр өөрийн хэлээр орчуулах ёсыг үзүүлж сургав. Бас Согд нар Энэтхэг орноос бурхны номыг Монгол оронд залж ирсэн бөгөөд энэ шалтгаанаар номын хэлэнд, энэтхэг, уйгар, монгол үг холимгоор оршсоор байна“(20) гэжээ. Монголын түүхч Г.Сүхбаатар “Сяньби“ хэмээх судалгааны бүтээлдээ “ Монголын эртний аймаг болох Нирун нар ч мөн V зууны үед бичиг авсан бололтой. Ингэхлээр Согд бичгийг Уйгар, Монгол хоёр нэгэн зэрэг авсан байж болох юм “(21) гэж таамаглажээ. Монголын хэл шинжлэлч доктор Ц.Шагдарсүрэн “Монгол үсэг зүй“ номдоо: “Олон улсын бичиг үсгийн түүхэнд хүчэрхэгжин буй улс мөхөж байгаа улсын бичиг үсгийг авч байсан баримт нэг ч үгүй” гээд монгол бичгийн хэлний зарим үгийг табгач хэлний зарим үгтэй харьцуулж судлаад “монгол бичгийн хэл нь табгач хэлний онцлогтой их л ойр байгаа нь XIII зуунд монгол бичгийг уйгараас авсан гэж үзэхэд их л эргэлзэл төрүүлж байна”(22) гээд энэ номдоо Уйгар, Монгол хоёр Согдоос зэрэг бичиг үсэг авсан байж болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Академич Л.Лигети авгай Сяньби хэлний нэгэн аялгуу болох табгач хэл нь эртний монгол хэлний байдлыг тусгажээ(23) хэмээн дүгнэсэн билээ. Монголын хэл шинжлэлч, соёл судлаач А.Дамдинсүрэн “Дөрвөлжин үсэг“ номдоо “Нууц товчоон дотор байгаа олон шүлгийн айзам хэмжээ, толгой холболт, яруу сайхан хэллэг зэргийг ч ингэж нарийн тааруулсан, тийм том хэмжээний ном туурвихад монгол хэл

бичгийг зөвхөн уншиж бичдэг төдий боловсролтой хүн хангалтгүй, харин бүр асар их яруу найраг, утга зохиолын боловсрол бүхий мэргэшсэн бичгийн хүмүүс бий болсны үндсэн дээр зохиогдсон нь харагдаж байна. Урьд өмнө ямарч бичиг үсэг хэрэглэж байгаагүй бэлтгэл суурьгүй, анх тулгар бичиг үсэгтэй болсон ард түмний оюуны соёлын түвшин нь ийм хэмжээний ном бичиж чаддаг болоход хэдий хирийн хугацаа шаардахыг тэр үеийн яруу найрагч, зохиогч, бичгийн хүмүүсийн чадварын байдлаар барагцаалан тоймлож үзэхэд 5-6 зуун жил шаардагдана гэж үзэж байна“(24) гэжээ. Монголчууд XIII зуунаас хол эрт бичгийн хэлтэй байсны гол баримт бол уйгаржин бичгийн хэл XIII-XIV зууны монгол хэлний аман аялгуунаас ихээхэн ялгаатай байгаа явдал юм. XIII-XIV зууны монгол аялгууг бусад хэлэнд галиглан тэмдэглэсэн ном зохиол, толь, бичиг тэргүүтнээс бид тухайн үеийн монгол үгсийн дуудлагыг олж мэдэж болдог билээ. Хэл гэдэг тийм цөөн жилийн дотор амархан өөрчлөгддөг зүйл биш бөгөөд алгуур аажим хувьсдаг учраас бичгийн хэл нь аман аялгуунаасаа ихээхэн зөрөөтэй байна гэдэг бол тэрхүү бичгийн хэл, бичиг үсэг олон зуун жилийн өмнө үүссэн гэж үзэх бүрэн үндэстэй юм. Монголчууд XIII зууны үед боловсорсон утга зохиолын хэлтэй, бичиг хэрэг хөтлөх тогтсон уламжлалтай байсны нэг нотолгоо бол 1225 онд бичсэн Чингисийн чулууны бичиг болон энэ үеийн бичгийн дурсгалууд болон түүний дараах үеийн Ил хаадын Ромын Папад илгээсэн захидал зэргийн хэлний шинжийг ажиглахад илэрдэг бөгөөд дөнгөж сая бүрэлдэн тогтож байгаа бичгийн хэл бус харин бичлэгийн дүрэм зүй, хэл найруулгынхаа талаар сайтар боловсорсон бичгийн хэл болох нь тодорхой байдаг. Тэгвэл тэрхүү боловсронгүй бичгийн хэл анх үүсэж бүрэлдэж эхэлсэн

цаг үе нь XIII зуунаас хэдэн зуун жилийн өмнөх хэрэг гэдэг нь тодорхой болно. Монгол бичгийн хэл нь авиа, хэл зүйнхээ шинжийг маш тогтвортой хадгалж ирсэн тул түүний анх үүсэж бүрэлдэж байсан үеийн хэлний онцлог байдлыг сэргээн тогтооход төдий л бэрхшээлтэй биш юм. Түүний суурь болсон тухайн тэр аялгууны онцлог нь эртний монгол хэлний сүүлч үе буюу барагцаалбал IX-X зууны үеийн монгол хэлний байдлыг маш тод тусгаж байна. Ийм болохоор 400-500 жилийн хугацаанд ярианы хэлний хөгжилд өөрчлөлт гарсан боловч бичгийн хэлэнд нэг их өөрчлөлт энэ хугацаанд гарахгүй нь 1000 гаруй жилийн монгол бичгийг хэрэглэж ирсэн түүх бэлхнээ гэрчилж байна. Проф.Н.Поппе, Ш.Лувсанвандан нар ч энэ талаар цухас тэмдэглэсэн билээ.(25) Д.Төмөртогоогийн саналаар “Монгол бичгийн хэл үүсэн бүрэлдсэн цаг үе нь гадаад нөхцөлөөрөө ч, дотоод онцлогоороо ч барагцаалбал IX-X зууны үе хамрагдаж байна” гэжээ. Сүүлийн үед монгол бичгийн хэлийг Хэрэйд, Найман аймгийнхны дунд бус, харин Хятанчуудын аялгуун дээр тулгуурлан буй болсон гэдэг шинэ таамаглалыг Академич Л.Лигети дэвшүүлснийг оросын эрдэмтэн Л.Л.Викторова дэмжиж байна. Тэдний үзэхээр “Хятаны бага бичгийг уйгараас зээлдэн авсан” гэжээ. Гэвч энэ санаа эргэлзээтэйг доктор Ц.Шагдарсүрэн өөрийн судалгаандаа дурьдаж байна. Мөн өвөр Монголын эрдэмтэн Данзан ”Монгол бичгийн үүслийн цагийн асуудал” гэдэг шинжилгааний томоохон өгүүлэлдээ “Эртний монголын хэл аялгууны байдал, эртний монгол орон дахь бичгийн соёлын байдал, эртний монгол орны аймаг угсаатны соёлын харилцааны байдал ба хуучин монгол бичиг дэх хэлний болон үсэг зүйн онцлог зэргийг ерөнхийд нь шинжилж үзвэл, монголчууд XIII зуунаас хол эрт согд гаралтай уйгар үсгийг авч хэрэглэсэн

бөгөөд бодитой цагийн талаар 8О5-84О оны хооронд буюу эсхүл 971-1125 оны хооронд гэх хоёр цаг үед хэрэглэж эхэлсэн боломж нь өөр үеэс илүү байна" гээд үүнийгээ олон баримтаар батлахыг хичээсэн байна. Ер нь бичгийн хэлний гарлын тухай асуудал нь угтаа монгол овог аймгуудын угсаа гарлын хамаадалтай нягт холбоотой байна. Найман, Хэрэйд аймгуудын угсаа гарлын тухай асуудалд эрдэмтэд өөр өөр зөрчилтэй саналтай байна. Эдгээр эрдэмтэдийн санал нь ойрхны баримтад суурилж монгол бичгийг авсан он цаг үеийг хэтэрхий наашлуулж байгаа нь эртнээс нааш монгол нутагт төр гүрнээ байгуулж байсан нүүдэлч улс гүрнүүд маш боловсронгүй бичиг үсгийн системүүдийг хэрэглэж, тэдгээр бичиг үсгүүд нь хоорондоо маш нарийн гинжин холбоотой байсан гэдгийг анхаарч үзээгүй хэрэг юм. Ийнхүү монгол хэл шинжлэлийн дурсгалт бичгүүд болон монгол хэл, монголын түүхийг судалсан олон хүний санал таамаглал нь монгол бичгийн гарал үүслийг Чингисээс бүр өмнө үед аваачиж байгааг бид үзэж байна. Юуны учир хэл шинжлэлч болон түүхчин нарийн санал таамаглалыг холимгоор оруулав хэмээвээс бичиг үсгийн гарал үүслийн асуудлыг зөвхөн нэг талыг нь баримтлан шийдвэрлэх ахул өрөөсгөл зүйл болох бөгөөд Монголын түүхч Г.Сүхбаатарын "Ер нь бичгийн үүсэл, дэлгэрэлт, хөгжлийн тухай асуудал бол "Түүх- хэл шинжлэл" гэх бүхэл систем юм. Иймд түүхийн талыг нягталсаны үндсэн дээр хэл шинжлэлийн үүднээс авч үзэх ёстой гэж бодно"(26) гэснийг бид судалгаандаа ямагт санаж байх нь зүйтэй мэт санагдана. Дэлхийн нэрт монголч нарын бүтээлд ч Чингисийн үед монгол бичиг зээлж авсан хэмээх "Юан улсын судрын" домог мэдээг үнэмлэхүй үнэн хэмээн баттайгаар нотолж бичсэн нь үгүй билээ. Монгол бичгийн гарал үүсэл нь Чингисээс бүр өмнө эрт цагийн

үүсэлтэй гэсэн энэ санал таамаглалыг батлахад ултай судалгаа, түүхийн үнэн баримтуудыг ухан гаргах нь шаардлагатай нь дамжиггүй юм. Мөн монгол нутагт байгаа руни, согд болон брахма согд үсэг холилдсон бичигт хөшөө зэргийг тайлан унших нь бас нэг гол түлхүүр болох ёстой. Гэсэн хэдий боловч дээрх санал таамаглалуудыг үндэслэлгүй зүйл гэж болохгүй бөгөөд МЭӨ IV зууны үед төр улсаа мандуулж явсан Монголын эртний өвөг Хүннү гүрэн хийгээд түүний дараачийн монгол аймгууд болох Сүмбэ, Их Нирун, Түрэг, Уйгар, Кидан нарын үед ч бичиг үсэг хэрэглэж байсныг эрдэмтэд бичиж байгаа бөгөөд энэ тухай өмнөх бүлэгт дурьдсан билээ. Монголын эзэнт гүрнийг байгуулсан эзэн Чингис хааныг бичиг үсэг мэддэггүй булаан эзлэгч дайн хийгч харгис нэгэн байсан хэмээн зарим судлаачид үзсэн нь буй. 1219 онд Хорезмыг дайлаар мордож байхдаа урьд алдары нь олонтой сонссон Өмнөт Сүн улсын Бумбын шашны лам Чанчун бумбыг урин залж уулзсан явдал буй бөгөөд урин залсан зарлигийн бичигтээ “Мэргэд эрдэмтэнийг урин сонгох нь дэлхий дахиныг төвшитгэх хэрэгцээ болой” хэмээн дурдсан нь улс гүрнийг тохинуулах төрийг жолоодоход эрдэм боловсрол, эрдэмтэн мэргэд их чухал гэдгийг онцлон дурдсан хэрэг юм. Өмнө Чанчун бумба түүнийг урьсан Алтан улсын болон Сүн улсын хааны урилгыг хүлээн авсан боловч очоогүй хийгээд харин Чингис хааны урилгыг хүлээн авч Монгол нутгаар дайрч түмэн газрын урт замыг туулан Хорезмын нутагт 1222 оны 4 сарын 5-ны өдөр очиж Чингис хаантай уулзжээ. Чингис хаан түүнтэй хэдэнтээ уулзан ном номлохыг нь сонсохдоо уйгар, хятад бичгээр бичиж автугай хэмээн дэргэдийн хүмүүстээ тушааж байсан байна. Түүний үзүүлсэн зарим судар номыг Чингис хаан түр үзэхээр гуйн авч үлдэж байсан нь эрдэм

боловсрол бичигт хүмүүний шинж болой. Гурван жилийн аяны эцэст Чанчун аршийг буцах болоход гүн хүндэтгэлийг үзүүлж доорд шавь нарт нь ч “Алба гувчуураас хэлтрүүлэхийг тушаасан бичиг”-ийг үйлдэж хааны тамга дарсан зарлигийн бичгийг соёрхсон байна. Чанчун аршийг урин залж уулзсан энэ явдал бол төрийн хэргийг төвшитгэх болон таван өнгө гурван харийг нэгэн жолоонд оруулахад номын хутагтын мэргэн ухаанаас суралцахыг зорьсон нь болой. Их Монгол Улсын үед төрийн албан хэрэг, бүх албан бичиг, гадаадад явах бичиг, захидал, хаад ноёдын хэн хүнтэй ярьсан чухал ярианы тэмдэглэл, гэрээс захиа сэлтийг бүгдийг монгол бичгээрээ хөтөлж байжээ. Өгөдэйг хааныг сууринд залахад Их хуралдай дээр Тулуй, Чингис хааны бичгээр захиж үлдээсэн гэрээсийг уншин сонсгож байжээ. Ер нь төрд зүтгэх бичгийн сайдуудыг эртнээс бэлдэж байсны баримт нь 1206 онд нэгдсэн Монгол улсыг байгуулаад Шихихутугийг төрийн заргачаар томилж аливаа хэргийг цагаан цаасан дээр хөх бэхээр тэмдэглэн бичиж үлдээж байхыг тушааснаас гадна түүний тасалсан хэргийг хэн боловч өөрчлөх эрхгүй, мөрдөн дагаж байхаар тогтоосон нь бичиг хэргийн бүх зүйлийг түүгээр ахлуулахаар даалгасан хэрэг юм. Шихихутуг Өөлөн эхийн гэрт хүмүүжихдээ бусад өргөмөл хөвгүүдээс нэн илүү бичиг хэргийн эрдэмд боловсорсон байв. Монгол улсын төрийн цааз хууль нь “Их засаг” байсан бөгөөд түүнийг 1189 оноос зохиож эхэлсэн гэсэн зарим судлаачдын таамаг байдаг нь Тэмүүжин хамаг монголын хаанд өргөмжлөгдсөн үеийг тооцсон хэрэг юм. Үүнийг үнэн гэж үзвэл Их хааны сууринд суух хүртэл 17 жилийн хэрэг явдал болон “Их засаг”-ийн заалтуудыг тэмдэглэж ирсэн байх ёстой. “Их засаг”-т дотоодын дагаж мөрдөх журмаас гадна олон улстай харилцах журмыг оруулж өгсөн нь дипломат харилцааны

нэгдсэн бодлогын эхийг тавьж өгсөн чухал зүйл байсан бөгөөд өөрийгөө хамгаалах хүчин чадал өсөн нэмэгдэж монголчууд дэлхийн түүхийн тавцанд бие даан гарч ирсний баталгаа байсан юм. Шихихутуг “Их засаг” хуулийг зохиохдоо Монголын ард түмний олон зуун жилийн дадал заншил, үзэл бодлын уламжлалд үндэслэж, улс даяар журамлан дагах төрийн дээд хүч бүхий албан ёсны хууль болгожээ. Рашид-Ад-дин өөрийн бүтээлдээ “Чингис хаан Их хурилдай зарлан хуралдуулж уламжлалт ёс болон хууль эрхийн шинэ тогтоомжууд орсон засгийг батлуулж “Их засаг” хэмээн нэрлэтүгэй хэмээн зарлиг болов. Ийм шинэ хууль ёс тогтоох тухай шийдвэр анх 1206 онд гарчээ” гэж тэмдэглэсэн байна. Доктор И.Дашням: “Их засаг” бол Монголын төрийн хэлбэр, дэглэм, түүний байгууллагуудын тогтолцоо, эрх үүрэг, ажиллах журам, албан тушаалтны зэрэглэл, дарх ямба, хааны эрх хэмжээ, ёс төр, улсын гадаад дотоод бодлого, удирдах ёсон, засаг захиргааны хуваарь, газар нутаг, өмч хөрөнгө, өв залгамжлал, байгаль ертөнцөө ариусган хамгаалах горим, хүн нийгмийн харилцаанд мөрдөх ёс заншил, эрүүгийн бодлого, ял шийтгэл, шүүн таслах журам зэргийг тогтоож бэхжүүлсэн хууль байсан байж болох юм”(27) гэж үзсэн байна. Монгол төрийн анхны хууль “Их засаг”-ийг Чингис хааны зарлигаар нэг хувийг болд самбар дээр сийлж мөнхжүүлэх зорилгоор тусгай хадгалсан гэдэг. Гэвч энэ нь бидний үе хүртэл үлдэж хоцорсонгүй. Чингис хааныг нас барсны дараа Шихихутуг Өгөдэй хааны үед ч улсын их заргач байж хэвтүүлийн дүрэм, их хурилдайн журам, албан татварын хууль, өртөөний хууль зэрэг олон тооны хууль дүрэм тогтоожээ. Шихихутуг бүхий л амьдралынхаа туршид улсын их заргач буюу төрийн хууль цаазын зөвлөх байснаар барахгүй цэргийн нэрт жанжин, бичиг

хэргийн төрийн нэрт түшээ байлаа. Хувилай сэцэн хаан хятад зөвлөгч Жан Дэ Хуйгаас цэрэг эрхлэх, иргэний засах аргыг асуухад “Хааны угсаа дотроос цэцэн гэвэл Бэлгүүтэйн гуравдугаар хүү Гүнбух байна. Цэрэг эрхлэх ахмад сайд гэвэл Шихихутуг байна. Дэлхий дахины иргэний эрхлэгчид цөм түүний хишгийг хүртжээ. Эрхэм гавьяа нь ийм дээдэд хүрчээ” гэж хариулсан нь үнэн болой. Тэрээр улсын дотор бичиг соёлыг хөгжүүлэх, эрдэм ухааныг дэлгэрүүлэхэд их анхаарч хууль эрхийн үндсийг боловсруулан, хот суурин байгуулахад ч санаа тавьж байлаа. 1237 онд улс даяар бичгийн шалгалт явуулах дүрэм боловсруулж, бичгийн мэргэд төдийгүй боол зардсаныг хүртэл оролцуулан 4030 хүнийг шилэн авч олон газрын заргач түшмэл, төрийн албан тушаалтан болгож, судар бичгийн хүрээлэн байгуулан түүх шаштир зохиолгох ажилд оролцжээ. Тэрээр Өгөдэй хааны зарлигаар Хархорумд Монгол үндэсний хоёр сургууль байгуулан монгол ноёдын хөвгүүдийг суралцуулж байв. Мөн хаадын хэргийн нууц архивын газар, номын сан байгуулсан байна. Чингисийн төрийн их сайд Елюй Чуцай, Чингай болон Юан гүрний үеийн Пагва багш, Гарма багш зэрэг бичгийн их соёлт хүмүүстэй их ойр дотно байсан бөгөөд тэдний хүндэтгэлийг зүй ёсоор хүлээдэг байлаа.(28) Кидан монголын гарлын мэргэн сайд Елюй Чуцай бол монгол төрийн түүхэнд 30-аад жил зүтгэж ихийг хийсэн бичгийн их сайд байв. Толуй эзэн болон Өгөөдэй хааны засаглалын үед Елюй Чуцайн төрийн хэрэгт нөлөөлөх жин илтэд өсч улмаар 1234 онд Алтан улсыг эзлэн авсны дараа түүний төрийн байгуулалтын үлгэр маягийг ашиглан “Чжүншушэн” гэдэг засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамыг байгуулж ерөнхий сайдаар нь тэрээр томилогдож байв. Энэ нь эзэлсэн умарт хятадыг захиран баримтлахад авч

хэрэглэсэн яам бөгөөд Их Монгол улсын төрд шууд үйлчилж байгаагүй байна. Чингис хааны дэргэд 9 жил алба хаасан түүнийг тэрээр нас барахаасаа өмнө Өгөдэй хүүдээ “Сайхан сахалтыг тэнгэрээс манд заяажээ. Хожим төр улсын том үйлэнд тушаан хэрэглэвээс зохино” хэмээн гэрээслэж байсан билээ. Елюй Чуцайн ийнхүү засаг төрийн өндөр албанд зүтгэж байсныг зөвхөн Чингис хааны гэрээстэй холбон тайлбарлаж болохгүй, бичгийн мэргэд хэрэглэгдэх дотоод учир шалтгаан бүрэлдсэнийх юм. Шинэ тутам байгуулагдсан Монголын төр цэргийн засаглалаас иргэний засаглалд шилжих хөгжлийн түүхэн үе шатанд тэр ажиллаж байсан бөгөөд Өгөдэй хааныг нас барсны дараа ч гэсэн төрийн үйл хэрэг, бичиг үйлийн ажилд чигч шударгыг хадгалан сэтгэл санааны дарамтан дор 3 жил хүнд албыг залгуулж хөх луу жил /1244/ тэнгэрт хальсан билээ. Турхан хатан түүнийг дуудаж төрийн тамгатай сул цааснуудыг Абдурхманд өг. Тэр өөрийн дураар үйлдэж байх ёстой гэж тушаажээ. Елюй Чуцай эсэргүүцжээ. Тэгэхэд хатан өөр зүйлийг шаардсан байна. “Их хааныг нөгчсөнөөс хойш Абдурхман төрийн төлөө асар ихийг хийв. Иймээс түүний гавьяаг сударт бичиж үлдээ” гэжээ. Елюй Чуцай сүрдүүлгээс ч айсангүй аанай л хүлээж авсангүй.(29) Ийнхүү Чингис хаан гүйцэтгэх эрх мэдлээ хэрэгжүүлэх зорилгоор улс орны олон талт амьдралын асуудал эрхэлсэн төрийн сайд нарыг томилж байжээ. Энэ ёсоор Мухулай Го ван буюу улсын ван хэмээх хааны дараах дээд албан тушаалыг хүлээсэн аж. Энэ утгаар Мухулайг Их Монгол улмын анхны ерөнхий сайд байсан гэж зарим эрдэмтэд үзжээ.(30) Харин орчин цагийн засаглал хуваах онолын үүднээс үзвэл, тэр үедээ их хаан гүйцэтгэх эрх мэдлээ бүрэн эдэлж, ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байсан гэж хэлж болох юм. Чингэвээс

Мухулай бол хараахан ерөнхий сайд биш, харин хааны тэргүүн шадар сайд байжээ. Тэрхүү тэргүүн шадар сайд нь төрийн тамга, бичиг хэргийг эрхлэлцэж, засгийн төв байгууллагыг гардан удирдаж байсан байна. Арай хожим энэ албан үүргийг Чингай гүйцэтгэж байсан болтой. “Их хаанд биднийг бараалхуулах болоход Тэргүүн түшмэл Чингай биднийг хэн болох, хэний элчин болж ирсэн болохыг бас Солонгосын болон бусад ноёдын нэр усыг аан уунгүй бичиглэж аваад их хаан болон бусад ноёдын өмнө өндөр дуугаар уншин сонсгов” хэмээн Жиованни “Монголчуудын түүх” номдоо бичсэн байдаг.(31) Энэ бол Гүюүг хааныг их хаан суусны дараахан болсон хэрэг юм. Тэрээр Чингис, Өгөдэй, Гүюг хааны үед шадар сайд байж, монголын төрийн үйл хэрэгт 50 шахам жил хүчин зүтгэжээ. Их бичээч хэмээх нь жирийн нэгэн бичиг хэрэг хөтлөгч бус, харин төрийн албан хэргийг гардан хөтлөгч, хааны төрийн аппаратыг бүхэлд нь удирддаг гол шадар сайд байжээ” гэдгийг тодруулан тэмдэглэмээр байна. Гүюгийн дараа Мөнх, хаан болмогц Булгайг их бичээч болгон улсын дотоод бодлого, эдийн засгийг хамруулж байснаас үзэхэд тодорхой байдаг. Төрийн их заргач болсон Шихихутгын албан тушаал бол бас нэг тэргүүн шадар сайдын хэмжээнд байсан нь эргэлзээгүй.(32) Их Монгол Улсын хаадын ордонд монгол, уйгар, арав, перс, хятад, тангад хэлтэй нилээд бичээч нар байж, гадаад орнуудаас ирсэн бичиг захидлыг орчуулж, хаад ноёдод танилцуулах, гадагш илгээх бичгийг анх зохиосон монгол эхээс бусад хэлнээ хөрвүүлэх буюу уг хэлээр нь эх зохиох ажил хийж дипломат харилцааны нарийн үйлийг залгуулж байв. Гүюг хаан Ромын Папын захидлыг тусгай бичээчээр дуудуулан уншуулж сонсоод, хэсэг дуугүй сууснаа Плано Карпининаас “Танай тэнд чинь монгол, орос, араб хэл

мэддэг хүмүүн байгаа юу?” гэж асуужээ. Тэрээр “За эзэнтэн үнэнийг хэлэхэд манай тэнд энэ гурван хэлийг мэдэх хүмүүн байхгүй” гэж өчжээ. Гүюг хаан “Та нар яасан тэнэг, боловсролгүй улсууд вэ” хэмээн уурласан дүр үзүүлээд бичгийн мэргэн сайд Чингайг дуудаж хариу захидал бичих зарлиг буулгаж байсан байна. Гадаадад явуулах баримт бичгийг тэрээр хариуцдаг байсан учир Ромын Папад илгээх бичгийг Кадак, Бала зэрэг бичээч нартай хамтран зохиож, уул бичгийг Плано Карпинид тайлбарлан хэлж өгч орчуулуулаад хянасны дараа латин, сарацин хоёр хэлээр бичиж илгээж байжээ.(33) Түүхэнд Гүюг хааны бичиг хэмээн алдаршсан энэ захианы уг эх нь Парижид хадгалагдаж байна. Дипломат харилцааны хүрээнд иймэрхүү байдлаар бичиж илгээсэн, одоо бидэнд үлдэж хоцорсон монголын их хаадын болон бага хаадын бичиг захидал гэвэл дээрх Гүюг хааны бичгээс гадна монгол бичгээр монгол хэлээр бичсэн 1320 оны Абу Сайд, 1326 оны Кебек, 1348 буюу 1360, 1351 буюу 1363, 1352, 1353 онуудын Түглэг Төмөр, 1267 буюу 1279 оны Абака, 1289 оны Аргун, 1302 оны Махмуд Газан, 1305 оны Өлзийт хааны бичиг захидлыг нэрлэж болох бөгөөд турк, дөрвөлжин бичиг, хятад араб, персээр бичсэн захидал бичгүүд олон арав байгаа бөгөөд монголын эрдэмтэдийн зүгээс судлах эзнээ хүлээж байна. Энэ талаар цухас боловч судалсан Оросын эрдэмтэн А.П.Григорьевын ном болон академич Б.Ширэндэвийн өгүүллүүд бий. Харин саяхан Ватиканы номын санд айлчилсан доктор Ш.Бира, доктор Д.Цэрэнсодном нар латин хэлээр бичсэн монголын хаадын нилээд захидал олсон нь залуу судлаачдад туйлын сонирхолтой бөгөөд хорхой хүргэсэн мэдээ болж байна.

Тэр үеийн амьдралыг тод томруун харуулсан бүтээл бол хятад үсгээр монгол хэлээр бидэнд уламжилж ирсэн, Өгөдэй

хааны үе буюу 1240 онд туурвин дуусгасан “Монголын нууц товчоо” хэмээх түүх, уран сайхны зохиол бөгөөд сүүлийн үеийн зарим судлаачийн саналаар монголчууд түүхээ мэдүүлэхийн тул өөрсдөө хятад үсгээр монгол хэлээр зориуд хуулан бичиж үлдээсэн хэмээн санал гаргаж байгаа нь сонин байна. “Монголын нууц товчоо”-г судалсан нэрт эрдэмтэн Б.Я. Владимирцов “Хээр талын цэцгийн үнэр ханхалсан ийм яруу тансаг зохиол, бүтээлийг тэр цагийн нэг ч нүүдэлч овог аймаг туурвисангүй” хэмээн бахархан тэмдэглэсэн нь буй. Ер нь монголын дорно талын аймгууд хятад бичгийг эртнээс хэрэглэж, улмаар XII-XIV зууны үе болж ирэхэд хятад үсгээр монгол үгийг тэмдэглэх аргыг нэгэнт нарийн нягт боловсруулсан байв. Хятад үсгээр бичсэн “Монголын нууц товчоо”, “Хуа-и-и-юу” толь бичиг, Монгол, Хятад хаадын харилцан илгээсэн 12 захидал бичиг зэрэг дурсгалууд үлджээ. Монгол бичгээр бичигдэж үлдсэн дурсгал ч гэсэн цөөн тоотой буй бөгөөд Юань гүрний үетэй холбогдох Өлзийт хааны захидал, Татарын бичиг, Нэвтэрхий хуулийн хэсэг хуудас, Ачлалт ном, Турфанаас олдсон өдөр үзэх судар, Кайпин фугийн суваргын бичиг, Турфанаас олдсон захидал харилцаа, зарлиг тушаалын холбогдолтой бичгүүд, Аруг вангийн хөшөөний бичиг, Хархорумын хөшөөний монгол бичээс, Дунь-хуаны хадан дээрх Төлөг Төгсийн бичиг, Богд уулын хадны бичиг, Чжан Цзинжүйн хөшөөний бичиг, Жигүнтэйн хөшөөний бичиг зэрэг болно.

Монголын эртний улс гүрнүүдийн бичиг үсгийн системд Финик, Согд, Рунээр дамжсан эртний Энэтхэгийн Панины хэлзүйн, хэл шинжлэлийн уламжлал хожим XIII зуунаас эхлээд Төвдөөр дамжин монголчуудын бичиг үсгийн системийг боловсронгүй болгоход бодитой туссан нь үзэгдэнэ. Тухайлбал






XIII зууны хэлзүйч эрдэмтэн Сажа бандида Гунгаажалцан монгол бичгийн хэлний талаар урьд гарсан бүх туршлагуудыг нэгтгэн дүгнэж, нэмэн боловсруулсан “Зүрхний тольт” хэмээх хэлзүйн бичиг гаргасан нь монгол бичгийн хэл хэвшин тогтоход чухал хувь нэмэр болсон байна. Түүний хойно XIV зууны эхээр нэрт хэлзүйч эрдэмтэн Чойжи-Одсэр бичгийн хэлээ улам боловсронгүй болгохын үүднээс монгол үсгийн бүрэлдхүүнийг нэмэн дэлгэрүүлж, үсгийн дүрэм, хэлзүй тэргүүтнийг улам нарийвчлан тайлбарласан “Зүрхний тольтын тайлбар” хэмээх хэлзүйн бичиг туурвиад улмаар “Бодисадва нарын явдалд орохуй”, “Банзрагч” зэрэг эртний энэтхэгийн гүн ухааны алдарт бүтээлүүдийг орчуулж, монгол бичгийн хэлээр хэрхэн яруу сайхан найруулж болохын бодтой жишээг өөрийн биеэр үлгэрлэн үзүүлжээ.(34) XIII, XIV зууны үеэс монгол газар бурхны шашин дахин хүчтэй дэлгэрч, шашин сургаал номлол хийгээд дуун ухаан, анагаах ухаан, одон зурхай, учир шалтгааны ухааны өдий төдий ном зохиолыг монгол хэлээр орчуулан гаргах болсон нь бичгийнхээ хэлийг цаашид улам боловсронгүй болгоход чухал түлхэц болсон байна. Монголын эзэнт гүрэн байгуулагдахаас өмнө хятадтай хөрш зэргэлдээ оршиж байсан Ляо улс, Алтан улс зэргээр уламжлан монголын бичгийн мэргэд цаас, бийр, янтай зэргийг олж авдаг байсан бөгөөд Монгол гүрэн байгуулагдаж дипломат харилцаа, соёл боловсрол өргөжихийн хирээр эдгээр бичиг хэргийн зүйлийг эзлэгдсэн улс орноос татварын журмаар авдаг болжээ. Солонгос, Монгол, Жүрчидийн хамтын хүчинд хүрээлэгдсэн киданчууд 1219 онд бууж өглөө. Солонгосын эрх баригчид монголчуудтай найрамдалт харилцаа тогтоохыг зөвшөөрчээ. Солонгост монгол элч нарын очих нь олширч хааныхаа нэрийн өмнөөс ... албан татвар ба бэлэг сэлт

шаардах боллоо. Ийнхүү 1221 онд монголын элч Кэгёнд очоод минжийн арьс 10 мянга, торго 3 мянган толгой, мөн тийм хэмжээний бүс даавуу, том хэмжээний цаас 10 мянган хуудас гэх зэргийг шаардав.(35) Саритай хорчи дахин шинээр илгээлт бичиг явуулж улам хатуу шаардлага тавьсан байна гэснээс үзэхэд бичиг номын үйл ихэд дэлгэрч цаасны хэрэгцээ ихэд өссөнийг харуулж байв.

Нэн эрт цагт үсэг бичгээ боловсруулсан мэргэд маань олон нутгийн аялгууг нэн сайтар анхаарч, нутаг нутагт сэлгэн хэлдэг авиаг адил дүрсээр тэмдэглэсэн байдаг. Жишээ нь эрт одоогийн зарим аялгуунд үгийн эхэнд “ж” нь “я” болдог үзэгдлийг нарийн ажиглаж адил дүрсээр тэмдэглэсэн тул засаг, ясаг, жасаг гэж дуудах бүрэн бололцоотой байдаг. Үе үеийн олон мэргэд монгол бичгийг засаж өөрчлөлгүй явж ирсний гол шалтгаан бол Төв Азийн өргөн уудам нутагт тархан суусан олон нутгийн аялгуутай монгол туургатныхаа алинд ч бэрхшээл түвэггүй ойлгогдох нарийн увдистай бичиг болохыг мэдэрснийх болой. Өөрөөр хэлбэл бичгийн авиан зүйн тогтолцоонд монгол хэлний нутгийн олон аялгууны онцлогийг бахдууштай сайхан тусгаж чадсанд л хамаг учир байгаа билээ. Монгол үсгийн бас нэг онцлогийн академич Ш.Лувсанвандан багш тайлахдаа: ”Хуучин монгол үсгийн нэг онцлог нь нэг үсэг үгийн эхэн, дунд, адагт янз бүрээр хувирдагт оршино. Ингэж нэг үсэг янз бүрээр хувирах нь эртний согд, уйгар үсэгт ч нэгэн адил байсан юм. Нэг үсгийн янз бүрийн хэлбэртэй болсон нь үсгээр үг үсгүүдийг бие биеэс нь салангид биш, залгаж бичихтэй холбогдон гарч ирсэн байна. Үг хэлэхэд хүний амнаас цувран гарах авиа бие биедээ нөлөөлж, мөн нэг авиа үгийн эхэн, дунд, адагт янз бүрээр хувилдгийн адил үсгийг цуврууллан залгаж бичихэд мөн нэг

үсгийн хэлбэр зэрэгцээ үсгийн бичлэгээс болж янз бүрийн хэлбэртэй болох нь зүйн хэрэг. Нэг авиа нөгөө зэрэгцээ авианыхаа нөлөөгөөр хувирдаг бол мөнхүү авиаг тэмдэглэсэн үсгийн хувилбарт зохих тусгалаа олж болох юм. Энэ учраас бид нэг авиаг тэмдэглэсэн үсгийн янз бүрийн хувилбарыг мөн нэг фонемын янз бүрийн хувилбартай харьцуулж үзэх бүрэн үндэстэй юм" гэсэн билээ. Монгол бичиг он цагийн уртыг туулан боловсорч ирэхдээ эрт цагийн үгийн бүтцийг өчүүхэн ч алдагдуулалгүйгээр бидэнд хүргэж авчирсан нь чухамдаа монгол хэлний хөгжил хувьсал бүхнийг ташаагүй үнэн тэмдэглэсэн түүхэн сурвалж бичиг мэт болжээ. Унгарын монголч эрдэмтэн Д.Кара "Монголын нүүдэлчдийн ном" бүтээлдээ "Монгол бичигтэй номоос арц хүж тэргүүтэн анхилж, аагтай шаргал цай хамар цоргилон, аргалын цэнхэр утаа үнэртдэг юм" хэмээн судлаач хүний билгийн нүдээр энгүй ихээр бахархан бичсэн нь буй.(36) Орчин цагийн монгол хэлний дуудлагаас өөрөөр бичиж байгаа үг бүрийн цаана эх хэлний маань түүхэн хувьсал үгийн гарлын учир шалтгаан, үндэсний хэл сэтгэхүйн маань бүхэл бүтэн түүх байгаа гэдгийг онцлон дурдах хэрэгтэй юм. Монгол бичгээ сурч судлахыг хичээх болсон өнөө үед, зарим хүн монгол бичгийг одоогийн аялгуунд тохируулан өөрчлөх санал гаргах нь хааяа тохиолддог. Энэ бол туйлын аминчхан үзлийн илрэл бөгөөд хэл болон бичиг үсгийн дотоод нарийн холбоо, бичиг үсгийн соёл түүхийн гүн холбоог огт ойлгодоггүйн шинж юм. Монгол бичгээр бичдэг ёсыг зөрчиж, хэлэх аялгаа баримтлан бичнэ гэдэг эх хэлнийхээ эд эсийг зэмдэглэн тайрч хаяна гэсэн үг бөгөөд түүгээр хойч үеийнхнийхээ өмнө уучилшгүй нүгэлтэн болж мэднэ. Учир нь монгол хэл, монгол бичиг гэгч ганц өнөөгийн бидний өмч биш. Өнгөрсөн, ирээдүй, одоо гурван

цагийн түм буман монголчуудын өмч учраас нэгэн үеийн бид дур мэдэн бичиг үсгээ өөрчилж засамжлан, хойч үеийнхнээ эх хэлсэтгэхүйнх нь түүхнээс холтгох эрхгүй.

Монгол бичиг бол монгол хэлний үгийн түүх гарлыг нягтлан тольдох толь бичиг мөн. Наад захын үгээр жишээлэхэд хутга, хядах, хяргах, хөрөө, чарга, чирэх гэх мэт үгийг монгол бичгээр  хитуга,  хидуху, хиргаху,  хирүгэ,  чирга,  чирхү гэж бичнэ. Эхний дөрвөн үгийн язгуур нь хи- бөгөөд хядаж, хяргах буюу уг үйлийг хийдэг зэмсгийг заасан нь илт харагдана. Нөгөө хоёр үгийн язгуур нь  чир-бөгөөд чирч явдаг юмыг чарга гэдэг болох нь тодорхой байна.

Үсэг зүйн хувьд авч үзвэл, XVI-XVII зууны үе хүртэлх бичгийн хэв маяг, үсгийн зурлага уугуул согд, уйгар үсэгтэй их төстэй байсан бөгөөд тийм ч учраас энэ үеийн монгол бичгийг уйгаржин монгол бичиг гэж нэрлэх нь бий. XVI-XVII зуунаас хойш, өдгөөгийн монгол бичиг үсгийн хэв маягийг олж, үсгийн зурлага, нэмэлт тэмдэг сэлт нь тогтворжиж боловсорч, харь хэлний үгийг тэмдэглэх галиг үсгийн бүхэл бүтэн тогтолцоотой болж зөв бичих дүрэм ч жигдрэн цэгцэрсэн байна.

XVI-XVII зууны үед монголчуудын ном бичгийн үйлс нэн өрнөж, ном барлах, орчуулах туурвих үйл мандан дэлгэрч, сонгодог бичгийн хэл бүрэлдэн тогтжээ. Монгол бичгийн зөв бичих дүрэм жигдрэн цэгцрэхэд XIII зуунаас эхлэн удаа дараа туурвиж ирсэн олон арван хэл зүйн бичиг, олон зүйлийн толь бичиг нэн чухал байв. Эдгээр “Зүрхэн тольт“ хэмээх хэл зүйн бүтээл цагаан толгой, үсгийн дүрмийг хамарсан төдийгүй хэл шинжлэл буюу дуун ухааны олон талыг багтааж байжээ. Дээр

дурьдсан бандида Чойжи- Одсэр монгол бичгийн хэл зүйн бүтээл “Зүрхэн тольт“- доо монгол хэлний авиа зүй, хэл зүйн онцлогийг сайн тусгаж, үгийн эцэст үе битүүлэн орж чадах гийгүүлэгч үсгийг бүртгэн тогтоож 11 дэвсгэр үсэг гэж нэрлэжээ. Эртний монгол хэлний 11 дэвсгэр гийгүүлэгчээс 9 нь орчин цагийн монгол хэлэнд нэгэн адил дэвсгэрлэн орж байгаагаас үзэхэд тэр эрт цагт монгол хэлний гийгүүлэгч авиалбарын байрлалын чухал хуулийг нээсэн ажээ. XIII зуунаас эхлэн Саж Бандид Гунгаажалцан, Чойжи-Одсэр, Рабжамба Дагзандагва, Алшаа Дандар Лхаарамба, О.Жамъян, С.Шагж тэргүүтэн олон мэргэд, олон арван цагаан толгой, “Зүрхэн тольт” хэмээх хэл зүйн дүрмийг боловсруулсаар ирсэн билээ. XX зууны эхэн үед С.Шагж багшийн “Үсгийн дүрмийн толь” гарч, өдгөө хүртэл Өвөр Монгол, БНМАУ, Буриад бүгд л энэ толийг зөв бичих зүйн хувьд мөрдлөг болгож байна. XIII, XIV зууны үеэс монгол газар бурхны шашин дахин хүчтэй дэлгэрч, шашин сургаал номлол хийгээд дуун ухаан, анагаах ухаан, одон зурхай, учир шалтгааны ухааны өдий төдий ном зохиолыг монгол хэлээр орчуулан гаргах болсон нь бичгийнхээ хэлийг цаашид улам боловсронгүй болгоход чухал түлхэц болж, олон зууны турш оюуны соёлын хосгүй арвин өв санг бүтээжээ. Цаг цагийн гамшиг, үе үеийн үрэгдлийг тэсч өнгөрөөсөн нь л бидэнд хүрч иржээ гэж бодоход өдгөө Монгол оронд болон дэлхийн олон орны номын санд хадгалагдаж байгаа монгол номыг мэдсэн дуулсны хэрээр хэмжээлэн санахад өөрийн эрхгүй бахдан бишрэх сэтгэл төрөх ажээ. Зөвхөн улсын нийтийн номын санд монгол бичгээр туурвисан 20000 орчим судар шастир хадгалагдаж байна. ОХУ, БНХАУ, АНУ, Англи, Япон, БНГУ, Швед, Польш, Унгар, Франц зэрэг дэлхийн олон орны номын санд монгол бичгээр туурвисан судар шастир үлэмж

тоотой байгаа бөгөөд зарим орны эрдэмтэн өөрийн оронд байгаа монгол номын гарчгийг хэвлүүлсэн нь тусгай тусгай ном, том том боть болсон байна. Монгол туургатны дотроос ухаан билгээрээ тодрон гарсан олон мэргэд зүйл зүйлийн ухааны нэн арвин шастир судар туурвисан байхаас гадна эртний дорно дахины соёлт орнуудын шилдэг зохиолын орчуулгын баялаг сан хөмрөг буй болгожээ. Ганцхан жишээ дурдахад Монголын их хаадын намтар, хатад, хөвгүүд, гавъяатан сайд, түшмэдийн шастир болон Юань улсын үеийн монголын эдийн засаг, соёлын түүхийг өргөн хамарч бичсэн “Юань улсын судар” хэмээх 210 дэвтэр номыг монголын нэрт бичгийн хүн, хятадач Дандаа /чухам нэр нь Дэмчигдорж/ 1917- 1923 оны хооронд орчуулсан нь гар бичмэлээр Улсын нийтийн номын санд хадгалагдаж байна. Мөн энэхүү “Юань улсын судар“-ын 14 дүгээр дэвтэр манж хураангуйг орчуулсан нь бас байна. Ганжуур, Данжуур тэргүүтэй өдий төдий судар шастирыг төвд хэлнээс орчуулсныг хэн бүхэн мэдэж байгаа билээ. Монгол бичгээр байгаа орчуулгын сан хөмрөгт 1921-1945 он хүртэл өрнө дахины хэлнээс орчуулсан бас нилээд арвин ном зохиол бий билээ. Монгол бичгээр бидэнд уламжлагдан ирсэн судар, шастир, намтар түүх, илтгэл, шастир, данс хараа, алба албан бичиг тэргүүтэн нь монгол туургатны туулж ирсэн зам мөр, туурвиж бүтээсэн оюун ухаан, мандаж буурсан түүхэн үнэн, шүтэж баримталсан зан үйлийг танин мэдэх гол түлхүүр бөгөөд сонгодог бичгийн найруулгын ур маяг, эх хэлнийхээ яруу сайхан, арвин баялаг үгийн санг гагцхүү монголын бичгийнхээ сан хөмрөгөөс л сурч мэдэж болох билээ. Төгсгөлд тэмдэглэхэд монгол бичиг нь монгол туургатны тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг, олон аялгуутныг соёлоор холбох гүүр,

дэлхийн бичиг үсгийн түүхэнд монголчуудын оруулсан үлэмж том соёл, үеийн үед Монголчуудын бахархаж явах зүйл билээ.

2. Монголын дөрвөлжин бичиг:

Мөнх хааныг нас барсны дараа Хубилай 1260 онд 46 насандаа Аригбөхтэй нэгэн зэрэг өөрийгөө Их Монгол улсын хаанд өргөмжилж 1265 он буюу Аригбөхийн тэмцэл эцэс болсон үеэс өөрийн биеийг Монголын Их хаан төдийгүй хятадын хаан ширээг зүй ёсоор залгамжлагч хэмээн үзэж улсын нэрийг өөрчлөн Их Юань Улс гэж нэрлээд хятадын эзлэгдээгүй үлдсэн өмнөт хэсгийг байлдан дагуулж, улмаар хятадаар төвлөж, нийт Монгол гүрнийг бататган бэхжүүлэх хэрэгт гол анхаарлаа хандуулжээ. 1294 онд нас сүүдэр ная хүрээд тэнгэрт хальжээ. Түүнийг өвөг дээдсийнх нь мөнх нойрссон хамаг монголын уугуул нутаг гурван голын эх, Хэнтийн нуруунд нь авчирч оршуулсан гэдэг. Хубилай хааны дэргэд 17 жил алба хаасан, алдарт жуулчин Марко Пологийн бичсэнээр “Олон олон хан тэргүүлэгчдийн их эзэн болсон Хубилай хааны гадаад дүр байдал ямар буй хэмээвээс тэрбээр өндөр ч бус, намхан ч бус, дунд зэргийн нуруутай бие бялдар сайхан махлаг, дүүрэн чийрэг сайхан эр ажгуу. Нүүр царай нь туяаран гэрэлтэх нь сарнайн адил, нүд нь ухаалаг агаад мойл хар, хамар тэгш бөгөөд өндөр” хүн байсан ажээ. Ухаалаг мэргэнээрээ Сэцэн хэмээн алдаршсан Хубилай хаан их гүрэн байгуулж, 35 жил төр барихдаа төр ёсны шинэтгэл, монголын нийгмийн сэтгэлгээний түүхэнд энэ зууны эхэн хүртэл уламжилсан ертөнцийн засаг хийгээд номын засгийг тэгшид явуулах зорилго бүхий хоёр ёсны номлолыг буй болгосон юм. Хубилай хар багаасаа эрдэм номын ажлыг хичээнгүйлэн суралцаж, хэд хэдэн хятад эрдэмтэн хүнийг ашиглаж хятад хэл

заалгаж, хятадын түүх судар яриулж байснаас гадна хятад эрдэмтэдийн үгэнд их итгэж кунзын сургаалийг заалгадаг байжээ. Хятад хэл бичиг заалгахаас татгалздаг байсан гэж Д.Пеллип(37) бичсэн боловч Хубилай хятад хэл мэддэг байжээ. Хубилай хаан төрийг төвхнүүлэх, харийн улсыг эзлэн захирах олон үйлийг зэрэгцүүлэхийн хамт бичиг соёлд багагүй анхаарч байжээ. Нэгэн жишээ татахад Бээжингийн хойд талд байгуулсан Ханбилиг /хааны хот/ буюу Дайду /Их нийслэлд/ хотод улсын судар шастир зохиох хүрээлэн хэмээх монгол, хятад, перс, төвд зэрэг олон үндэстний түүхчдийг оролцуулсан тусгай байгууллага ажиллаж байсан бөгөөд энэ хүрээлэнг 1264 онд Хубилай хааны зарлигаар анх байгуулжээ. Энэхүү хүрээлэнгийн бүтээл нь арай хожуу Мин улсын үед эмхлэн зохиосон “Юан улсын судар” гэдэг 210 дэвтэр том зохиолын үндсэн сурвалж нь болжээ. Монголын дөрвөлжин бичгийг Хубилай хаан улсын багш Пагва лам Лодойжалцангаар зохиолгосон бөгөөд түүгээрээ их Юан гүрний бүрэлдэхүүнд багтсан бүх улс үндэстний хэлийг нэгэн зэрэг үйлчилж чадах бичиг болгохыг зорьжээ. Монгол хэлний авианы түүхэн хөгжлийн улмаас XII-XIII зуун болж ирэхэд монгол бичгийн хэл нь аман ярианы хэлнээс нилээд зөрүүтэй болсон байна. Тийм учраас ярианы хэлэнд гарсан зарим хувьслыг бичгийн хэлэндээ тусгах хандлага зарим талаар илэрч урьд нэгэнт хэвшин тогтсон дүрэм зүй гажуудахад хүрсэн төдийгүй, аман ярианы хэлэнд тохирсон бичгийн хэлтэй болох гэсэн шинэ хандлага буй болжээ. Нөгөө талаар XIII зууны сүүлийн хагаст бүрэлдэн тогтсон Юань гүрний доторхи олон овог аймгуудын хэл аялгууг адил тэгш тэмдэглэж чадахуйц “олон улс дундын” бичгийн хэлтэй болох гэсэн эзэнт улсын төрийн бодлого давамгайлан гарч ирсэн байна. Пагва лам Лодойжалцан /1235-

1280/ бол төвдийн сажа нутгийн алдарт бандид Гунгаажалцаны ач хүү бөгөөд түүний эцгийг Содномжалцан гэдэг байжээ. Таван ухаанд мэргэшсэн бандид Гунгаажалцан /1182-1251/ бол хэн бүхний мэдэх яруу найргийн алдарт зохиол “Субашидыг” зохиосон бөгөөд XIII зууны дунд үед Өгөдэй хааны хүү Годан ноёны урилгаар Хөх нуурт ирж, монгол бичгийн анхны хэл зүй “Зүрхэн тольт”-ыг зохиосон бөгөөд энэ үедээ ач Лодойжалцангаа дагуулан ирж байжээ. Төвд эх сурвалжид дурдсанаар хожим Хубилай хаан Сажа бандидыг ордондоо залах гэж элч явуулсан боловч нас барсан тул түүний ач хүү Лодойжалцанг 18 настай байхад нь 1253 онд залж ирсэн ажээ. Лодойжалцан бол мэргэн бандидын дэргэд хүмүүжсэнээс гадна төрөлхийн гоц авьяастай хүн байсныг тэмдэглэсэн баримт олон буй. Долоон настайдаа хэдэн арван түмэн үсэгтэй судрыг уншин төгсгөсөн ба 1258 онд Бумбын ёсны мэргэдтэй ном хаялцаад ялж нэн ихэд алдаршсан байжээ. Саган сэцэний “Эрдэнийн товчид” дурдсанаар Хубилай хаан түүний эрдмийг ихэд биширч багш шавийн барилдлагаа барьж, огоот туулсан дөрвөн авшигийг” хүртэж, Лодойжалцанд “Гурван газрын номын хаан Пагва хутагт лам” цолыг өргөж, хас тамга хүртээжээ. Монголын дөрвөлжин бичиг хэмээх шинэ үсэг бичгийг Хубилай хааны даалгавраар Пагва лам 9 жилийн туршид нүдээн чилээж, гараан эцээж, зохион дуусгаад, дөрвөлжин үсгийн анхны сургуулийг өөрөө гардан явуулж байв. Монголын дөрвөлжин бичгийг төвд үсэгт тулгуурлан уйгаржин монгол үсгийн үг бүтэх, бичих системийг судалж зохиосон бөгөөд энэ тухай академич Ш.Лувсанвандан “Дөрвөлжин үсгийн дурсгалын зүйлийг үзэхэд Пагва лам тэр цагийн монгол ярианы хэлний авиа зүйг сайн ажигласан төдийгүй уйгаржин монгол үсгийн систем, зөв бичих дүрмийг сайн судалж байж дөрвөлжин үсгээ

зохиосон болох нь илэрхий байна” хэмээн өгүүлжээ. Шинэ тутам зохиосон дөрвөлжин бичиг нь бичилбэрийн систем, хэлний зүй, үгсийн сан, хэл найруулгынхаа хувьд урьдаас сайтар хэвшин тогтсон монгол бичгийн хэлэнд тулгуурласан учир тэр нь бүх талаараа биеэ даасан цоо шинэ бичгийн хэл бус, харин монгол бичгийн хэлний нэгэн хувилбар болсон юм. Өөрөөр хэлбэл тэр нь сонгодог монгол бичгийн өмнөх монгол бичгийн хэлний нэгэн бүрэлдхүүн хэсэг нь билээ. Ер нь дөрвөлжин бичгийн хэл нь бичлэгийн дүрэм, хэлзүйнхээ талаар бүрэн хэвшин тогтож хараахан амжаагүй ч гэсэн XIII-XIV зууны үеийн монгол хэлний зарим нэг аялгууны онцлог шинжийг нилээд нарийн сайн тусгасан тул түүний бичгийн дурсгалууд нь дундад зууны үеийн монгол хэлний үнэтэй чухал материал болж байна. Пагва лам Лодойжалцан Хубилай хааны зарлигаар монголын дөрвөлжин үсгийг зохиож дуусмагц, 1269 онд гүрэн даяар хэрэгт хэрэглэх тухай Хубилай хааны зарлиг гарчээ. Уг зарлиг нь “Би санаваас үсгээр үгийг бичмүй. Үгээр хэргийг тэмдэглэмүй. Энэ нь эрт ба өдгөөгийн нэвтэрхий хууль болой. Манай улс умард газар тулгар байгуулсан тул суртал нь хэмжээтэй, эртнийг эрхлэх тул дүрэм тогтоол үүсгэж завдсангүй. Аливаа хэрэглэх үсэг бичиг нь хятадын хичээнгүйлэх ба жич уйгар үсгийг хэрэглэж, манай улсын үгийг нэвтрүүлжүхүй. Ляо улс, Алтан улс ба жич холхи олон улсын дүрмийг хянаваас тус тусдаа үсэг буй амуй. Өдгөө бичгийн засаг улмаар хөгжих бөгөөд үсэг бичгийг тогтоох нь дутуу, бүрдээгүй тул ийнхүү тусгайлан улсын багш Пагвад тушааж, монголын шинэ үсгийг үүсгэн зохиолгов. Аливаа бичиг үсгийг орчуулан бичихэд үгийг дагаж хэргийг нэвтрүүлэхийг эрмэлзэх амуй. Үүнээс хойш аливаа хас тамга дарж, бичиг тархаан буулгахад монголын шинэ үсгийг хэрэглэж, басхүү

хамтаар тус тусад нь түүний улсын үсэг бичгийг хавсруулагтун”(38) хэмээсэн байдаг. Энэ зарлигаас үзвэл Хубилай хаан өөрийн байгуулсан их Юан улсын хэмжээнд хэрэглэх тусгай шинэ бичигтэй болохыг эрмэлзсэн санаа тод харагдаж байна. Одоо олдоод байгаа дөрвөлжин бичгийн дурсгалын зүйлс дотор монголоос гадна хятад, төвд, санскрит, турк хэлний дөрвөлжин үсгээр бичсэн материал нэгэн адил олдоод байгаа бөгөөд алдарт монголч эрдэмтэн Б.Я.Владимерцов монголын дөрвөлжин бичгийг “олон улсын цагаан толгой” хэмээн нэрлэсэн билээ. Шинэ үсэг зохиох болсон туслах шалтгаан бол тухайн үеэс олон жилийн өмнө боловсорсон уйгаржин монгол бичиг нь XIII зууны монголын аман аялгуунаас зохих хэмжээний зөрөөтэй болсон байсан бөгөөд нөгөө талаар уйгаржин монгол бичгийн цагаан толгойн үсгүүд хятад, төвд, уйгар зэрэг Юань улсын бүрэлдэхүүнд байсан улс, үндэстний хэлний авиаг нарийн тэмдэглэхэд хүрэлцэхгүй байсан явдал болон төвдөөс уламжилсан бурхны шашныг төрийн шашин болгохыг зорьсонтой ч бас холбоотой байж болох юм. Өмнөх зарлигаас үзэхэд монголын дөрвөлжин бичгийг хэрэглэхдээ бусад үндэстний хэрэглэж байсан уйгаржин монгол, хятад, төвд зэрэг үсэг бичгийг дор нь халсангүй, харин хамтад нь хэрэглэх шилжилтийн арга хэрэглэсэн нь тодорхой байдаг. Тиймийн тул монголын дөрвөлжин бичгийг түгээн дэлгэрүүлэх талаар Хубилай хаан олон зүйлийн ажил зохиосон бөгөөд тухайлбал 1269 онд Юан улсын бүх 169 замд дөрвөлжин бичгийн сургуулиудыг үүсгэн байгуулж 1272 онд дөрвөлжин бичгийг заах улсын тусгай сургуулийг байгуулж голдуу монгол ноёд, түшмэдийн хөвгүүдийг сонгон авч сургаж байжээ.

1275 онд дөрвөлжин бичгийн хэргийг эрхэлсэн эрдмийн тусгай хүрээлэн байгуулжээ. Үүнээс гадна монгол бичгийн, хятад, араб, төвд зэрэг гадаад хэлний олон сургууль байснаас гадна эмнэлгийн, зурхайн сургууль бас байсан бөгөөд монгол ба эзлэгдсэн орны хөвгүүдээс бичигтэй авьяастайгий нь шилж ном зааж байжээ. Дөрвөлжин бичиг нь төвд, санскрит үсэгт тулгуурлан зохиосон үет үсэг бөгөөд Юан улсын үед амьдарч байсан Шэн-Си-Мин гэдэг хүний “Ф-Шу-Као” гэдэг номд дөчин гурван үсэгтэй гэж дурдсан боловч бүх үсгийг гүйцэд тодорхойлоогүй ба “Юан улсын сударт” 41 үсэгтэй гэж тэмдэглэжээ.(39) Дөрвөлжин бичгийн цагаан толгойн 41 үсгээс жинхэнэ монгол үгийг тэмдэглэхэд хэрэглэдэг нь 28-аас хэтрэхгүй юм. Үлдсэн үсэг нь харь хэлний үгийг тэмдэглэх шаардлагыг хангасан үсгүүд байжээ. Үсгийн дүрс хэлбэрийг төвд үсгээр үлгэр болгосон болохоор дөрвөлжин дүр байдалтай харагддаг хийгээд бичихдээ үе үеэр тасалж, уйгаржин монгол бичиг шиг дээрээс доош буулган бичдэг. Өөрөөр хэлбэл Пагва лам дөрвөлжин үсгийг төвд үсэгт тулгуурласан боловч бичлэгийн системийг монгол бичигт тулгуурлажээ. Дөрвөлжин бичиг нь үеийн бичиг бөгөөд гийгүүлэгч үсэг бүрийг төвд үсгийн адил ”а” эгшгээр амилуулж унших бөгөөд харин гийгүүлэгчийн дараа “а”-гаас өөр эгшиг хэлэгдвэл тэр эгшгийг залгаж бичдэг байна. Хэрвээ үеийн эцэст ардаа эгшиггүй гийгүүлэгч хэлэгдвэл түүнийг дээд үсэгтэй нь залган бичнэ. Өөрөөр хэлбэл монгол бичгийн дэвсгэр үсгийг дөрвөлжин бичигт тэмдэглэхдээ тухайн дэвсгэр гийгүүлэгч үсгийг өмнөх үсэгтэй нь залган бичих арга ажээ. Гийгүүлэгч үсгийн үгийн эхэнд болон тэргүүн биш үед орох хэлбэр нь ялгаатай байдаг. Дөрвөлжин бичигт үндсэн долоон эгшиг байхаас гадна урагшилсан “а” эгшгийг тусгай дүрсээр

тэмдэглэсэн байдаг. Дөрвөлжин үсгийн судлалаар гарсан хамгийн анхны эрдэм шинжилгээний бүтээл бол Германы эрдэмтэн Х.К.Габеленцийн 1839 онд хэвлүүлсэн “Эртний Монголын нэгэн бичээсийн тухай” хэмээх өгүүлэл юм.(40) Зохиогч энэ бүтээлдээ Буянт хааны нэгэн зарлигийг латин үсгээр галиглан, герман орчуулга, тайлбарын хамт хэвлүүлсэн байна. Энэ цагаас хойш янз бүрийн үед олдсон дурсгалт олдворуудад олон орны эрдэмтэд судалгаа хийсэн бөгөөд Г.Потье, А.Уайли, П.Р.Бонапарт, Л.Д.Ваделл, Е.Х.Вольш, доктор А.Х.Франке, А.М.Позднеев, Э.Шаванн, Г.И. Рамстедт, П.Аалто, А.А. Драгунов, Х..Ошибучи, М.Левицки, Э.Хэниш, Н.Поппе, Л.Лигети, Давид М.Фаркухар, М.Накано, профессор Зуунаст нарын судалгааны бүтээлүүд гарсан юм.

1911 онд Фининийн алдарт монголч эрдэмтэн Г.И.Рамтседт нэгэн номын өчүүхэн тасархай хуудсыг дөрвөлжин үсгээр бичсэн номын хуудас мөн хэмээн судалсныг 41 жилийн дараа түүний шавь П.Аалто “Эрдэнийн сан Субашид”-ын монгол орчуулгын тасархай болохыг нээн гаргасан байна. Монгол судлалд мөнхийн олон бүтээлээ зориулсан профессор Н.Поппе “Дөрвөлжин бичиг” хэмээх номыг 1941 онд Москва-Ленинград хотноо хэвлүүлсэн бөгөөд энэ бүтээл дөрвөлжин үсгийн судлалд шинэ эрин үеийг нээсэн мөнхийн туурвил болсон юм.(41)

Монголын эрдэмтэдээс дөрвөлжин үсгийн талаар хамгийн нухацтай судалгаа хийсэн хүн бол академич Ш.Лувсанвандан юм. Дөрвөлжин үсгийн судлалд зохих хувь нэмрээ оруулсан эрдэмтэд гэвэл академич Д.Төмөртогоо, доктор Ц.Шагдарсүрэн, эрдэмтэн Х.Лувсанбалдан, доктор Х.Пэрлээ, Ж.Надмид, А.Дамдинсүрэн нар болно. Дөрвөлжин үсгийн хэлний онцлог шинжийг академич Д.Төмөртогоо, үсэг зүйн онцлогийг

доктор Ц.Шагдарсүрэн судалсан байхад хоёр жилийн өмнө залуу эрдэмтэн Ё.Жанчив “Дөрвөлжин үсгийн монгол дурсгалын судалгаа” хэмээх эрдмийн зэрэг горилсон зохиол бичиж доктор(Ph.D) хамгаалсан бөгөөд уг зохиолдоо дөрвөлжин бичгийн хэлний авиан зүйн судалгаа, үгийн бүтэц, үг бүтээх дагаврын судалгааг шинэ шатанд гаргаж олон эрдэмтэдийн нүд, оюуныг баясаасан бүтээл туурвисан юм. (42)

Академич Ш.Лувсанвандан, доктор Ц.Шагдарсүрэн, Д.Төмөртогоо нарын шинжлэн бичсэнээр дөрвөлжин үсгийн нийлмэл бүтэц нь монгол бичгийн үсгийн бүтэцтэй шууд холбоотой юм. Дөрвөлжин бичгийн дурсгалыг ажиглахад ерөнхийдөө монгол бичгийн зөв бичих дүрэмтэй тохирох боловч дунд үеийн монгол хэлний аман аялгууны онцлогийг тусгасан байдаг тул судалгааны хувьд тун сонин баримт олон байдаг. Дөрвөлжин бичгийг хэрэгжүүлж ирсэн анхны үед уйгаржин монгол бичгээс ялгахын тул “Монголын шинэ үсэг” хэмээн нэрийдэж байв. Гэтэл “Үүнээс хойш монгол үсгийг шинэ үсэг хэмээн дуудаж болохгүй” гэж хааны зарлиг тусгайлан гарсны улмаас “Монголын улсын үсэг”, ”Юан улсын үсэг” гэж нэрийдэх болжээ. Хожмын судлаачдын дунд “Дөрвөлжин бичиг”, “Пагвын үсэг” гэж алдаршсан билээ. 1271 онд Хубилай хаан бас зарлиг нийтэлж, дөрвөлжин үсгийг хэрэгжүүлсэн хоёр жилийн турш ахицгүй байгааг зэмлэж, цаашид дэлгэрүүлэх тухай арван нэгэн зурвас зарлигийг гаргажээ. Уг зарлигт дөрвөлжин үсгийг заан сургах сургуулийг түгээмэл байгуулах, холбогдол бүхий сайд түшмэд, албан хаагчдад “Зуун өдрийн дотор монгол бичгийг /дөрвөлжин бичгийг/ заавал сайтар сурч эзэмшихийг” шаардсаны хамт хүмүүсийн сурах дур сонирхлыг хөгжөөхийн тулд дөрвөлжин үсэг сурагчдыг “Алба улаанаас хэлтрүүлэх“, сайтар

сурч боловсорсон хүнд “Зүй зохисыг нь үзэж алба тушаал олгох” зэрэг зарлиг тогтоол гаргасан байна. Ингэж төрийн зүгээс зүйл зүйлийн арга хэмжээ авсан хэдий ч 100 гаруй жил хэрэглэгдээд зогссон байна. Яагаад түгэн дэлгэрч чадаагүйн учир гэвэл:

1. Юан улсын бүрэлдэхүүнд байсан монгол, хятад, төвд, уйгар зэрэг улс нь цөм дадан хэвшсэн эртний бичиг үсэгтэй, боловсорсон утга зохиолын хэлтэй байсан тул шинэ үсгийг тийм амархан авч чадахгүй байлаа.

2. Дөрвөлжин бичгийг уйгаржин монгол бичигтэй харьцуулбал бичихэд хялбар бус, таслан бичиж цэг тэмдэг хэрэглэдэггүй тул үг, өгүүлбэрийн зааг тодорхойгүй байдаг дутагдалтай байлаа.

3. Уйгаржин монгол бичигт монголын олон аялгуунд сэлгэн хэлдэг авианууды адил дүрсээр тэмдэглэсэн байдгийг Пагва лам дөрвөлжин бичигтээ ялган тэмдэглэх үсэг зохиосон билээ. Энэ нь монгол туургатны дунд түгээмэл түгэхэд саад болсон бололтой.

Өдгөө бидэнд дөрвөлжин бичгээр уламжлан ирсэн, олдсоор байгаа дурсгалууд нь монгол, хятад, төвд, түрэг, араб хэлээр байгаа билээ. Энд зөвхөн дөрвөлжин үсгээр монгол хэлээр тэмдэглэсэн дурсгалын тоймыг өгүүлбэл:

1. Хаад болон бусад хүмүүсийн зарлиг бичгүүд нэлээд олон олдоод байгаа бөгөөд агуулгын хувьд ойролцоо байдаг. Голдуу хаданд сийлсэн зарлиг байх бөгөөд хятад бичээсийг хажууд сийлсэн ч бий. Ийм дурсгал одоо ч олдож байгаа бөгөөд БНХАУ-ын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн үндэстний судлах газрын ажилтан Зуун-наст хэдэн жилийн өмнө Гуандун мужийн нэгэн сүмээс Буянт хааны /1285-1320/ хоёр зарлиг олж нийтэлжээ.

2. Элч, төлөөлөгчид олгосон дөрвөлжин бичгийн бичээс бүхий пайзууд байх бөгөөд голдуу төмөрлөг зүйл ба хас чулуугаар үйлдсэн дүгрэг, урт дөрвөлжин хэлбэртэй, оосорлон авч явах нүх бүхий байдаг. Пайзуудын үг, агуулга нь ойролцоо бөгөөд жишээлбэл монгол хэлээр дөрвөлжин үсгээр бичсэн бичээс бүхий нэгэн ширмэн пайзын үг нь “Мөнх тэнгэрийн хүчинд хааны зарлиг, хэн эс бишэрвээс алдтугай” гэжээ.

3. Түүхэн сурвалжийн мэдээ, эрдэмтдийн судалгааг үзвэл Юан улсын үед олон ном судрыг дөрвөлжин үсгээр бичиж, барлаж байсан бөгөөд өдгөө бидний үед уламжлан ирсэн нь тун ховор ажээ. Сажа Бандид Гунгаажалцаны зохиосон “Субашид” хэмээх яруу найргийн зохиолыг орчуулаад дөрвөлжин бичгээр барлаж байсны баримт дөрвөлжин бичгээр барласан номын нэгэн тасархай хуудсыг Финляндын нэг жуулчин 1906 онд Дорнод Туркестанаас олсныг Финляндын эрдэмтэн Г.Рамстедт эхлэн судалж, түүний шавь П.Алто Субашидын хуудас болохыг баталсныг дээр дурьдсан билээ.

4. Зоос мөнгө, тамга, тэмдэг, сүм хийдийн барилга дээрх бичээс зэрэг орно.

Одоогоор олдож байгаа дөрвөлжин бичгийн дурсгалууд нь он цагийн хувьд хамгийн сүүлчийнх нь 1377, 1382 оны дурсгал юм. Их Юань улсын үед ном судар зохиож, бусад хэлнээс орчуулан барлан хэвлэдэг байснаас гадна мөнгөн тэмдэгт цаас үйлдвэрлэдэг байжээ. Энэ тухай их хаан Хубилайн дэргэд удаан хугацаагаар сууж байсан Италийн жуулчин Марко Поло бичихдээ хааны ордны ойролцоо “Мөнгөний харш” хэмээх мөнгөн тэмдэгт цаас бусад зүйл хэвлэдэг газар байсан гэжээ.

Хоёрдугаар бүлэгт эшлэсэн
эх сурвалж болон ном зохиол

1. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ., 1995, х.3-7
2. Ч.Далай. Их Монгол улс. 1206-1260, Дэд дэвтэр, УБ., 1994, х.121
3. Сайшаалт. Чингис хааны товчоон. Хөх хот, 1985, Дэд дэвтэр, х.63
4. Н.Тогтох. Монгол хаадын тамгийн нууц. /Монголын жаран сонин/, №1, 1990
5. Ч.Дандаагийн орчуулга. Юань улсын судар. гар бичмэл, Улсын номын сан
6. Ч.Далай. Юан гүрний үеийн монгол. Улаанбаатар, 1973, х.162
7. Г.Д.Санжаев. Старо-письменный монгольский язык. М.,1964, х.89
8. П.Б.Балданжапов. Altan Tobchi. Монгольская летопись XVIII в. Улан-Удэ., 1970
9. P.Pelliot. Les syste’mes d’ecriture en usage chez les anciens mongols. “AM” vol. Secumdum: 1925, p.285
10. Д.Кара. Книги монгольских кочевников. Москва, 1972, х.18
11. Ч.Далай. Юан гүрний үеийн монгол. УБ., 1973, х.163
12. Мөн тэнд х.163
13. Мөн тэнд х.163
14. Robert L.Binnick. Modern Mongolian A Transformational Syntax. University of Toronto, 1979, p.19-20
15. Б.Я.Владимерцов. Монгольские литературные языки. Записки Института Востоковедения Академи Наук СССР. Том 1. Ленинград, 1939, стр.740

16. Роль кочевых народов в цивилизации Центральной Азий. Улаанбаатар, 1974
17. A.Rona Tas. Some notes on the terminology of Mongolian writing. “AON”, T18, 1965, p.121
18. Б.Ренчин. Монгол үсгийн гарал, хөгжил. Хөх хот, х.5-6
19. Yongsiyebu Rincen. Les inscriptions inconnues sur pierre et les plaques d’or ornamentees du harnais de Tonyoucouc. Central Asiatic Journal, vol. 4. No.4, p. 2
20. རྒྱལ་དིང། ཆོར་ཚོས་འབྱུང།
21. Г.Сүхбаатар. Сяньби. УБ., 1971, х.113
22. Ц.Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. УБ., 1981, х.10
23. L.Ligeti. Le Tabghatch, un dialecte de la language sien-pi. Mongolian Studies. Budapest, 1970, х.265-308
24. А.Дамдинсүрэн. Монгол дөрвөлжин бичиг. УБ., 1986, х.3
25. Д.Төмөртогоо. Монгол хэлний түүхэн хэлзүй, УБ., 1992, х.38
26. Г.Сүхбаатар. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал. УБ., 1980, х.111-112
27. Эзэн богд Чингисийн “Их Засаг”. УБ., 1995
28. С.Бадарч. Улсын дээд шүүгч. Чингисийн туг, 1990, х.40
29. Т.Мандир. Хөх төрийн хөтөч. Чингисийн туг, 1990, х.31-35
30. Ч.Далай. Монголын түүх. Их Монгол улс. /1206-1260/, Дэд дэвтэр, УБ., 1994, х.59-60
31. Жиованни Дель, Планокарпини. Монголчуудын түүх. УБ., 1988, х.72
32. Ж.Болдбаатар, Д.Лүндаажанцан. Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997, х.54-55
33. Д.Төмөртогоо. Монгол хэлний түүхэн хэлзүй. УБ., 1992, х.37
34. Монгол -Татарууд Ази Европод. УБ., 1984, х.173

35. Joirnal of the American Oriental Society. vol., 83, 1963, No.2, p.234
36. Д.Кара. Книги монгольских кочевников. Москва, 1972, х.40
37. E.D.Phillips. The Mongols. London, 1969, p.100
38. Д.Чойжилсүрэн. Монгол дөрвөлжин үсэг. УБ., 1974, 12т, х.3
39. Ч.Далай. Юан гүрний үеийн Монгол. УБ., 1973, х.157-158
40. H.C.Gabelentz, Versuch uber eine alte mongolische Inschrift. ZKM II.1, 1939, pp.1-21
41. Е.Жанчив. Дөрвөлжин үсгийн монгол дурсгалын хэлний судалгаа. Диссертаци, УБ., 2000. х.18-22
42. Мөн тэнд. х.18-22

Гуравдугаар бүлэг. XIV-XVIII үеийн Монголын нийгэм, соёлын түүхэнд бичиг үсгийн гүйцэтгэсэн үүрэг.

▪1. XVI-XVII зууны үеийн Монголын түүхэн дэх монгол бичгийн хөгжил болон түүний үүрэг.

XVII зуун бол Монголын түүхийн чухал зааг үе билээ. Тэр цагт монголчууд феодалын бутралыг даван туулах эцсийн оролдлого хийж нийтийн шинэ дайсан манж нарыг эсэргүүцэн, Монголын олон зуун жилийн төрийн тусгаар тогтнолыг хамгаалан тэмцсэн үе юм. XVII зууны эхэнд Монгол орон хэд хэдэн хаант улс болж хуваагдсан байв. Батмөнх даян хаан олон жил үргэлжилсэн феодалын хямрал тэмцлийг зогсоож монгол орныг улс төрийн талаар түр хугацаанд нэгтгэсэн боловч захирсан газар орон, албат ардаа хөвгүүддээ өмч болгон тасдан хуваасны харгаагаар биеэ даасан жижиг хаад, ноёд дахин олноор гарч иржээ. Батмөнхийн дараа түүний ахмад хөвүүний үр угсаанаас монголын их хаан болж байв. Гэвч жижиг ханлиг улсын хаад их хаанд захирагдахгүй, хэрэг дээрээ биеэ даан оршиж байжээ. Монголын эртний заншлаар монголчуудын өлгий нутаг, төрийн гал голомт Ар монгол Халхыг Даян хааны отгон хүү Гэрсэнзэд өмч болгон олгожээ. Гэрсэнзийг нас барсны дараа түүний их хатан Хатанхай халхыг долоон хөвүүндээ хувиарлан өгч захируулах болсноор Халх долоон хэсэг болон бутарч Халх долоон хошуу үүсчээ. Гэрсэнзийн угсааны ноёд угаас хаан цолыг зүүж байгаагүй, харин зүүн гарыг захирсан Гэрсэнзийн гуравдугаар хөвүүн Ноонох үйзэнгийн ахмад хөвүүн Автай Далай ламаас хан цол олж ирснээс эхлэн Түшээт хан гэж нэрлэгдэх

болжээ. Түүний дараа халхын зүүн гарын бас нэгэн ноён Гэрсэнзийн тавдугаар хөвүүн Амин дуралын ач Шолой биеэ хан өргөмжилж Сэцэн хан гэж алдаршжээ. Ашихайн ач хөвүүн Лайхур бас биеэ хан гэж дуудах болж, түүний хөвүүн Субадайн үед Засагт хан гэдэг болжээ. Өвөр монгол тэр үед Цахар, Хорчин, Ордос, Түмэд, Харчин зэрэг хэдэн жижиг ханлиг болон хуваагдаж байв. Халх ба Өвөрмонголын эдгээр ханлиг улс буюу зүүн монголыг нийтэд нь зургаан түмэн буюу зургаан улс гэж тэр цагт нэрлэж байв. XVI зууны сүүл, XVII зууны эхээр Баруун монголд мөн л улс төрийн тархай бутархай байдал зонхилж байв. Ойрадуудыг товчлон захирсан нэгэн хаан байсангүй хошууд, цорос, дөрвөд, торгууд зэрэг Ойрадын аймгуудыг үе улиран угсаа залгамжилсан ноёд толгойлон байв. Энэ үед ойрдын ноёдын хүч ихэд өсч байв. Монголын их хаан тэр үед Лигдэн /1592-1634/ байлаа. Лигдэн хаан болоод ханлигуудын биеэ даасан тусгаар байдлыг устган, тэдгээрийг эрхэндээ бүрэн оруулан нэгтгэн захирахыг чухалчилжээ. Алтан хаан, Түмэн засагт хааны нэгэн адил шашин төрийг хослон тэтгэж шашныг өөрийн төрийг нэгтгэх бодлогод ашиглахыг зорьжээ. Лигдэн улсдаа шашны төв буй болгохыг эрмэлзэн байжээ. Алтан хааны үед шинэ шашны төв нь Баруун түмэнд оршиж байсан бол тэр нь зүүн түмэн Цахарт шилжсэн байна. Лигдэн шашныг зүйл бүрээр тэтгэн сүм дуган олныг байгуулан, Далай ламын монгол дахь төлөөлөгч Майдар хутагт мэтийн том лам нарыг өргөн хүндэлж тэднээр биеэ шашин төрийг хослон тэтгэгч их хаан хэмээн зарлуулж байжээ. Зүүн, баруун түмний жононгууд Лигдэнд ёс төдий захирагдаж байв. Лигдэн эхний үед эв эеэр эрхэндээ оруулахыг эрмэлзэж байсан боловч энэ бүтэлгүй болж хүчээр нэгтгэх бодлогод орсон юм. Гэвч Өвөр Монголын Манжид дагаар

орсон ноёдтой болон Манжийн цэрэгтэй тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсээр байсан боловч хүчин мөхөстөн Хөх нуурт байсан Халхын Цогт хун тайжтай нийлэхээр явах замдаа өвчнөөр нас барж, Өвөр монгол манжийн эрхэнд орсон нь нийт Монголчууд Манжийн эрхэнд орохын эхэн болсон билээ. Энэ цаг үед монгол бичгийн хэл нь үндэстний хэлний хэлбэрийг төгс олж хөгжсөн юм. Тэгэхдээ монгол үндэстний бичгийн хэл нь халх, буриад, өвөрлөгчдийн аялгууны аль алинд нь байдаг түгээмэл шинж, сонгодог бичгийн хэлэнд олон зуун жилийн турш хуримтлагдсан хамгийн шилдэг зүйлсийг уламжлан авчээ.(1) Орчин үеийн монгол бичгийн хэл бүрэлдэн тогтоход олон зуун жилийн түүхтэй монголын сонгодог бичгийн хэл сайн нөлөө болжээ. Сонгодог бичгийн хэлний үед ойлгогдохгүй болсон хуучин үгс хэрэгцээнээс гарч нутгийн аялгууны нөлөө дахин хүчтэй болж, төвд хэлнээс зээлдэн авсан үгс олширчээ. Үсгийн хэлбэр нь уйгар үсгээс ялгарахгүй байсан нь цаашдаа өөрчлөгдөж, одоо хүртэл хэрэглэгдэж байгаа жинхэнэ монгол үсгийн хэлбэр тогтворжиж, үсгийн дүрэм, найруулга нь нилээд журамшин, модон бараар ном судар арвин ихээр хэвлэх болжээ. Эрдэмтэдийн судалснаар монголын сонгодог бичгийн хэл нь XVI зууны эцсээс эхлэн бүрэлдэж, XIX, XX зууны үе хүртэл монголын олонхи нутагт үлэмжхэн тархаж, үсгийн дүрэм, хэл зүйн талаар хатуу тогтворжиж ирсэн боловч олон нутгийн монголчуудын аялгуунаас хоцорч, шашны судар номын хэл болоход хүрчээ. Иймээс монголчууд хуучин монгол бичгийн хэлээр бичсэн утга зохиолыг уншихдаа уул бичгийн хэлний анхны авианы бүрэлдэхүүнийг огт хайхрахгүй өөр өөрийн нутгийн авианы зохих бүрэлдэхүүнээр сольж уншдаг нутгийн ардын ярианы хэлэнд ихээхэн ойртсон нутаг нутгийн, бичгийн хэл болсон байна. Энэ

нь үгийг хэдий хуучин үсгийн дүрмээр бичивч, дуудалгыг нутаг нутгийн аялгууны дуудалгаар хэлэх заншил тогтож, амьдралын хэрэгцээ нь монгол бичгийн хэлийг ярианы хэлэнд ойртуулах өвөрмөц сонин аргыг олж чадсан байна. Нутаг, нутгийн аялгуугаар дуудах энэ заншил нь яван явсаар хуучин монгол бичгийн зөв бичих дүрмийг алгуурхнаар эвдэж нутгийн аялгуугаар буюу яаж хэлдэгээрээ тэмдэглэх зуршилыг бий болгожээ. Энэ бүгд монголчуудын ярьдаг, бичдэг нь нэгдмэл бичгийн хэлийг бий болгох зүй ёсны шаардлагын өмнө хүргэжээ. Монгол Данжуурт дорно дахины таван ухааны гурван мянга дөрвөн зуу гаруй бүтээл орсны дотор эртний энэтхэг хэл шинжлэлийн сонгодог зохиолууд чухал байр эзэлж байна. Монгол Данжуурын 204, 205, 220-224-р ботиудад “Дохио тохиолдуулсан Панин-ийн судар”, “Сайтар барилдуулсан үүдний судар, ертөнцийн итгэл”, “Эгшигт эхийн дохио таниулагч судар”, “Үгүүлэх бүхэнд орох аялгын шастир, хамгийг айлдагч”, “Сайтар номолсон чандманыг удирдагч тэрэг”, “Голын чуулган” зэрэг 50 гаруй алдартай зохиол орсон байна. Хоёр мянга гаруй жилийн турш самгарьд хэлний хамгийн нэвтэрхий бүтээл болсоор ирсэн Панини-ийн хэлзүй болон түүний тайлбаруудад хэлний авианы бүтэх байр, арга, үгийн бүтэц дэх авианы байрлал, хэлний хам бүтэц, аналоги, хувьсал, нууц бүтээвэр, өгүүлбэрийн доторхи үгсийн харьцаа зэрэг олон талт үзэгдлүүдийг нарийн тусгажээ. Монгол хэлзүйчид Панини-ий хэлзүй болон түүний тайлбаруудтай бүр XIII-XIV зууны үеэс танилцаж, улмаар тэдгээрийг эх хэлнээ орчуулан хэвлэсээр ирсэн нь монгол хэл шинжлэлийн сэтгэлгээний хөгжилд чухлаар нөлөөлж, монгол хэл шинжлэл нь дорно дахины хэл шинжлэлийн биеэ даасан өвөрмөц нэгэн чиглэл болжээ. XIV зууны хэлзүйч Чойжи-Одсэр,

XVIII зууны хэлзүйч равжамба Агваандандар, Сумадираднаа, Дэлэгжунай нарын бүтээлүүдэд эртний энэтхэг хэл шинжлэлийн зохиолуудад байдаг өдий төдий нэр томьёо, үг ухагдахуун, ангилал ялгал байдаг. Гэвч тэдгээр эрдэмтэд энэтхэг хэл шинжлэлийн бүтээлүүдээс хуулбарласан бус харин түүний онолын үндэс, судалгааны арга хэлнийхээ өвөрмөц онцлогт тохируулан бүтээлчээр хөгжүүлжээ. (2) XVII зууны үед Гунгаа-Одсэр “Зүрхний тольт” зохиосон мэдээ байгаа боловч бидэнд уламжилж ирсэнгүй. XVIII зууны эхэн үед Молом равжамба Данзандагва “Зүрхний тольтийн тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маань хэмээгч оршивой” хэмээх хэлзүйн зохиол, XVIII зууны сүүлийн хагаст Алшаа Агваандандарын “Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг”, 1789 онд Дамчай-Равжаан “Монголын нэгэн зуун толгой үсэг оршив” 1864 онд Хөлөнбуйрын Тогтохтөрийн “Оюун билгийн сонирхол” гэх мэтийн хэлзүйн бүтээлүүд гарч монгол бичгийн дүрмийг цэгцтэй болгон цаашдын хөгжилд чухал зүйл болсон юм. Үүнээс гадна мөн хугацаанд толь бичгийн ажил ихээхэн хөгжиж олон зүйлийн толь бичиг гарсан нь монголын утга зохиолын хэлний үгсийн сангийн баяжилт, тогтворжилтонд чухал зүйл болсон билээ.(3) Мөн тэрчлэн шашин номын олон арван зохиолыг хуулах болон амин хувь хийгээд албаны элдэв хэрэг явдлыг алдалгүй түргэн шуурхай тэмдэглэх, албан бичиг сийрүүлэх, тэмдэглэх, ном зохиолын эх ноорог хийх, ялангуяа хүний ярьсныг үг гээлгүй түргэн бичиж авах хэрэгцээнээс үүдэн мөн нөгөөтэйгүүр төвдийн шар бичгийн нөлөөгөөр монгол бичгийн таталган бичилгийн хэлбэр энэ үед үүсчээ. Б.Я.Владимерцовын саналаар манжийн хурдан бичгийн нөлөөгөөр таталган бичиг үүссэн гэсэн нь манж нар монгол бичиг

хэрэглэж байгаад монгол бичигт тулгуурлан бичиг үсгээ зохиосныг харгалзаагүй хэрэг юм.(4),(5)

Энэ хэлбэр нь Европ зэрэг орны стенографитай дүйх бөгөөд энэ нь европ дахинд нилээд хожуу үүссэн хийгээд үгийг товчилсон тусгай олон тэмдэгтээс бүрдэж түүнийг зориудаар хэдэн жилийн хөдөлмөр заран суралцах хэрэгтэй болдог бөгөөд ингэж сурсан хүн л тэр бичгээр бичиж чадах болон уншиж чаддаг байна. Харин монгол таталган бичиг бол сайн монголтой хүн төвөггүй бичиж уншдаг. Англи хэлээр хурдан бичих гэвэл давын өмнө түгээмэл хэрэглэгдэх 8000 гаруй үгсийн хураангүй тэмдэгтийг тогтоох хэрэгтэй болдог. Монгол бичгээр сайн таталган бичдэг хүн европ дахины тусгай сургууль хийсэн таталган бичгийн мэргэжилтэн шиг хурдан бичиж ганц хормын дотор 90-100 үг бичиж чадах ажээ.(6) Ц.Шагдарсүрэн “Монгол бичиг” номдоо хичээнгүй бичгээр албан бичиг, өргөх бичиг зэргийг, таталган бичгээр эх зохиох, хувийн тэмдэглэл, навтарга ноорог, цаг давчуу үед үг гээлгүй тэмдэглэх шаардлагаар хэрэглэдэг, эвхмэл янзын тамга, захирлаг, номын тэмдэг болон гоёл чимэглэлийн зүйлд хэрэглэдэг ялгавартай байсан гэжээ. Дэлхийн олон оронд Монголыг төлөөлж төр улсынхаа нэр хүндийг өндөрт өргөж явсан ахмад дипломатич Б.Жаргалсайхан “Олон жилийн хууч” номондоо “Монгол бичиг шиг тусгай тэмдэг хэрэглэхгүйгээр хүний хэлснийг түргэн тэмдэглэдэг хурдан бичгийг би хуьдаа үзээгүй” хэмээн онцлон тэмдэглэжээ.(7) Эвхмэл хэлбэрийн уран гоё бичлэг, барилгын зураг чимэглэл, тамгын дардас зэрэг олдсоор байгаа бөгөөд гадна, дотнын эрдэмтэд судалгаагаа зориулсаар байна. Д.Кара, Б.Ренчин, Ц.Шагдарсүрэн, Чой.Лувсанжав, Л.Дарамбал нарыг дурьдаж болно. Мөн бас дөрвөлжин, соёмбо үсгээр эвхэж бичсэн хэлбэр ч олдож байна. Энэ үед монголчуудын соёлын амьдралд олон өөрчлөлтүүд гарч олон зуун жил үргэлжилсэн дайн дажин намжиж, зарим зохиол

бүтээл хэвлэгдэж байлаа. Мөн монголын түүх бичлэгийн талаар ихээхэн амжилт олж олон зохиол гарч байв. Нөгөө талаар бурхны шашин монголд хүчтэй дэлгэрч, шашны төрөл бүрийн зохиол, хутагт хувилгаадын намтар зохиолууд зохиогдон болон орчуулагдан гарах болов. Үүнд Халхын анхдугаар Жабзандамба хутагтын “Өндөр богдын намтар”, “Өндөр гэгээний намтар”, “Дээрхийн уг эх” хэмээх олон янзын бичмэлээс гадна Зая бандид Лувсанпэрэнлэйн “Богд Жабзандамбатаны цадиг оршибай” /бичмэл, Улсын төв номын сан/, “Далай Манзушири Нэйж Тойны намтар оршибай” /бар, Улсын номын сан/, Раднаабадарын “Рабжамба зая бандидын тууж сарны гэрэл хэмээгдэхүй”(8), ”Буриад тойн гүүшийн ах дүү гурванд ирээдүй цагийн байдлын дуртгал оршибай” /бичмэл, улсын номын сан/ зэргийг дурдах хэрэгтэй. Энэ үеийн монголчуудын хууль зүйлийн бичгийн нэг нь 1617 оны орчим зохиосон эмэгтэйчүүд, хүүхдийн тухай хуулийн үлдэц 8 зүйл /Улсын номын сан/ болох ба мөн 1640 онд Ойрадын нутагт Дөчин дөрвөн /Халх, ойрад/ хоёрын эрх баригчид, цэргийн зүтгэлтэн нарын чуулганаар тогтоосон хууль цаазын хураамж юм. XVII зууны монголчуудын түүх, бичиг үсгийн түүхийн асуудлыг судлахад тэр цагийн жуух бичиг, гэрэлт хөшөө, тамга мутрын тэмдэг бичээс, хад чулуунаа сийлсэн монгол, төвд, манж зэрэг хэлний бичээс товч хураангуй бичгийн зүйлсийг үзэх нь чухал юм. Төвд хэлээр зохиосон ”Хор чойнжун” мэтийн монголын түүхийн нилээд зохиол бүтээл нь бичиг үсгийн түүхийн гарал үүсэлд бас л холбогдож очно. Өрнөдийн түүхчид монгол хэл дээрх арвин зүйлс хийгээд түүнтэй холбогдсон эд өлгийн зүйлсийг үзэлгүйгээр өрнөдөд гарсан цөөн тооны хэрэглэгдэхүүний тухай мэдээллээс монголчууд бичиг соёлын асуудалд ихээхэн ядуу байсан мэтээр ташаа ойлгодог байна.

Ж.Ж.Саундерс “Монголын байлдан дагуулал” зохиолдоо “Тэд бичмэл дурсгал тун бага үлдээжээ. Маш эртний түрэг хэлэн дэх наймдугаар зууны үеийн Орхоны бичээс, XIII зууны үеийн “Монголын нууц товчоо” зэрэг нь бичиг үсэггүй бүдүүлэг аймгийнхны түүхийн ганцхан баримтууд юм. Тэдний бүдэг бадаг он дараллын бичгийг соёлт дайснууд нь бичдэг байлаа” гэх мэтээр бичсэн нь буй.(9) Тэр үеийн ном хэвлэлийн ажиллагааны тод нэгэн жишээ нь Сажа бандида Гунгаажалцаны зохиол “Эрдэнийн сан субашид” гэдэг яруу сайхан зохиолыг дахин орчуулан хэвлэсэн явдал юм. 1906 онд Финляндын нэгэн жуулчин Туркестаны дорнот хэсгээс хуучны номын ганц хуудас олсныг Финляндын монголч эрдэмтэн Рамстедт судлан шинжилж, монголын дөрвөлжин үсгээр хэвлэгдсэн номын тасархай болохыг 1911 онд нотолсон байна. 41 жилийн дараа түүний шавь П.Аалто “Эрдэнийн сан субашид”-ын монгол орчуулгын тасархай болохыг баталжээ. Монголын дөрвөлжин үсэг 1269 онд зохиогдсоноор үзэхэд тэр ном тэр үед орчуулагдсан нь тодорхой юм. Энэ ном түүнээс хойш монгол хэлэнд хэд хэдэн удаа орчуулагдан хэвлэгджээ. XIII зууны эцэс, XIV зууны эхэнд Соном Гара орчуулсныг XVIII зууны эцсээр цахар гэвш Лувсанчүлтэм дахин орчуулж “Субашидийн тайлбар Чандманийн түлхүүр” хэмээн нэрлэж 1878-1879 оны үед зохион Өвөрмонголын цагаан уулын сүмд хэвлэн гаргаж байсан хийгээд тэр номыг XIX зууны эцэст Буриадын Агын дацанд Лувсанрэнчин засамжлан хэвлэж байжээ. XIII зууны үед модон бараар монгол хэлнээ хэвлэсэн Кунзын сургаалын Ачлалт ном одоо Бээжингийн ордны номын санд хадгалагдаж байна. Эрдэмтэн Чойжи-Одсэр 1305 онд Энэтхэгийн гүн ухааны яруу найргийн нэг болох “Бодичара авадара” хэмээхийг орчуулсан нь 1312 онд хэвлэгдэн

гарч 1748 онд Гүүш Билгийн далай дахин засамжлан хэвлэжээ. 1330 оны үед “Долоон өвгөн” хэмээх судрыг монголчилж 2000 хувиар хэвлэж байжээ. Тэр үеийн нэрт орчуулагчдын нэг бол Шаравсэнгэ юм. Энэ хүний орчуулга болох “Бурхны 12 зохионгүй”, “Алтангэрэл” зэрэг олон ном хэд хэдэн удаа модон бараар хэвлэгдэж байснаас гадна бичмэлээр ихээхэн тархсан байна. XV зууны үед ланз, төвд, монгол гурван үсгээр модон бараар хэвлэгдсэн “Жамбалцанжид” гэдэг ном байхаас гадна Хөх хотын Гүүш Цоржийн орчуулсан “Молом тойн эхийнхээ ачийг хариулсан судар” 1708 онд Бээжинд модон бараар хэвлэгдэж XIX зуунд Буриадын Хамбын хүрээнд дахин хэвлэгдсэн мэдээ байдаг. Заяа бандида Намхайжамц 1648 онд тод бичиг зохиогоод 1650-1662 оны хооронд 170 гаруй ном төвд хэлнээс орчуулжээ. Эдгээр номын ихэнх нь бурхны шашны зохиол Итгэл, Банзрагч, Алтангэрэл, Доржжодов, Үлгэрийн далай болон иргэний зохиол ч нилээд байжээ. Монголын соёл, хэвлэлийн нэгэн том ололт бол Ганжуур, Данжуур хэмээх Энэтхэгийн олон арван боть алдарт зохиолыг монгол хэлнээ орчуулан хэвлэсэн явдал юм. Монголчууд Ганжуурын доторхи зарим зохиолыг дээр үеэс орчуулж эхэлсэн боловч бүрнээр нэгтгэн орчуулах ажлыг Цахарын Лигдэн хааны /1604-1634/ зарлигаар бандида Гунгаа-Одсэр, дархан лам Самдансэнгэ, Билигт Эрдэнэ дай гүүш, тойн Санрав нарын 50 гаруй хэлмэрчид 1629 онд орчуулж дуусгажээ. Лигдэн хааны үед орчуулагдсан энэхүү Ганжуур /Зарлигийн орчуулга/ 100 шахам жил гар бичмэлээр дэлгэрч байгаад Энх-Амгалан хааны зарлигаар 1717-1720 оны хооронд модон бараар хэвлэгдсэн ажээ.(10) Ганжуур нь ихэвчлэн Бурхан багшийн айлдсан зарлиг сургаалыг түүний шавь нар хийгээд хожмын мэргэцүүл сударчлан буулгасан буддын шашны номлолын их

цоморлиг юм. Гэвч түүний дотор ардын үлгэр домог, аман яруу найргаас эх үндэстэй элдэв домог, сургаалын шүлэг тэргүүтэн уран зохиолын түүхэнд авч хэлэлцэх зүйл нилээд байдаг байна. Тухайлбал жинхэнэ уран зохиолын дурсгалд тооцож болох 500 орчим цадиг Ганжуурт байдаг тухай судлаачид тэмдэглэсэн буй.(11) Данжуур /Шастирын орчуулга/ нь эртний энэтхэг, төвдийн эрдэмтэн бандида нарын их бага таван ухаанаар туурвисан 3400 гаруй зохиолын цоморлиг юм. Данжуур номын их, бага таван ухааны зохиолоос XIII-XIV үед төвд хэлнээ орчуулж эхлээд XIV зууны эхээр тусгай цоморлог болгосон байна. Монголчууд бүр XIV зууны эхэн үеэс орчуулж, тайлбар судалгаа хийж байлаа. Бүхэлд нь орчуулж хэвлэх ажлыг XVIII зууны тэргүүн хагаст анхдугаар Жанжаа хутагт Агваанчойндон /1642-1714/, хоёрдугаар Жанжаа Ролбийдорж /1717-1786/ нарын удирдлагаар монголын олон хошуудаас цугларсан 200 орчим хэлмэрчид асар богино хугацаанд амжилттай орчуулан дуусгасан ажээ.(12) Ард түмний дунд гар бичмэлээр тархан дэлгэрч байсан монголын эртний утга зохиолын шилдэг бүтээлүүд бол 1240 онд зохиогдсон “Монголын нууц товчоо”, “Увш хун тайжийн тууж”, 1716 онд эхний 7 бүлэг нь хэвлэгдсэн “Гэсэрийн тууж” 1910 онд тод бичгээр хэвлэгдсэн “Жангарын тууж” зэрэг болно. Түүнчлэн янз бүрийн үед зохиогдсон түүхийн үнэт зохиолиуд олон бий. XVII зууны үеийн зохиол ”Алтан товч” “Шар тууж” XVIII зууны үеийн “Алтан ургийн дөт түүх”, XIX зууны үеийн “Болор толь”, “Эрдэнийн эрхи” зэрэг уран сайхнаар бичигдсэн зохиолуудыг нэрлэж болно. Тэр үеийн нэлээн олон тооны зохиол нь анги хоорондын зөрчлийг харуулсан, далд, янз бүрийн утгатай зохиолууд байдаг байв. Жишээ нь: “Алтан ордны үйсэн дээрх бичиг“, “Эр хоёр загалын тууж”, “Есөн өрлөгтэй

өнчин хөвгүүний цэцэлсэн шашдир”, Ишданзанванжилын сургаал шүлэг, Инжинашийн роман, туужууд орох бөгөөд эдгээр нь гараар бичигдэн, модон бараар хэвлэгдэн тарж байв. Монголчууд эрт дээр үед зөвхөн орчуулж, зохиож хэвлээд зогсоогүй мөн дүрслэх урлагыг ихээхэн хэмжээгээр хөгжүүлжээ. Эрт дээр цагаас элдвийн хээ угалз, хөрөг зэрэг зүйлс ард түмний дунд өргөн дэлгэрснээс гадна бурхны янз бүрийн зураг сийлэн барлаж байсан байна. Дээр үеэс эхлэн одоо болтол манайд “Эвтэй дөрвөн амьтан” гэдэг урлал зураг модон барын аргаар хэвлэгдэн тарсан байдаг. Энэ зураг нь зөвхөн монголчуудаас гадна Дорно дахины ард түмний дунд ихэд тархсан бөгөөд Ази, Африкийн Бандугийн бага хурлаас дэвшүүлсэн энх тайваны таван зарчимын үндсэн үзэл нь болсон юм. Монголчууд XIII зуунаас эхлэн өөрийн бичиг үсгийг хэдэнтээ өөрчилж зохиосон нь хэвлэлийн ажиллагаанд зохих нөлөөгөө үзүүлсээр ирсэн байна. Жишээ нь дөрвөлжин үсгээр нилээд олон орчуулгын зохиол хэвлэж байсан бол монгол үсгээр манай гол түүх, уран зохиолын номыг хэвлэж байсан. Түүнчлэн “тод” үсгээр монголын утга зохиолын сонгодог зохиолын нэг болох Жангарын тууж болон бас бус номыг хэвлэсэн байдаг билээ. XVIII зууны үед Хятадын сонгодог уран зохиолыг монгол хэлнээ ихэд орчуулж гар бичмэлээр буюу модон бараар хэвлэн тархааж байжээ. Жишээ нь “Гурван улсын түүх”, “Улаан асрын түүх”, “Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зэрэг бичгийг орчуулсны дотор “Гурван улсын түүх”, “Ляо Зай-жи” зэрэг нь хэд хэдэн удаа хэвлэгдэж монголын өөрийн зохиол мэт дэлгэрсэн байна. XIX зууны үеэс шүүмжлэлийн олон арван зохиол зохиогджээ. Гэндэн Мээрэнгийн “Хав, муур, хулгана гурвын үлгэр”, “Ингэ ботгоны үлгэр”, хуульч Сандагийн “Чонын үг”,

“Хавханд орсон зээрийн үг”, “Ингэ ботгоны үг”, Равжаагийн шүлгүүд бичигдэж хэвлэгдэн тархаж ирэв. Монголд XIII-XVIII зууныг хүртэл модон бараар хэвлэж XIX зуунаас чулуун бар дэлгэрч эхэлжээ. Цаас анх үүссэн хятад оронтой хил залгаа байсан явдал хэвлэх ажиллагаанд нөлөөлжээ. Модон бараар хэвлэх явдалд XVII зууны үеэс монголд хүчтэй дэлгэрсэн шарын шашин ихээхэн нөлөө үзүүлсэн бөгөөд сүм хийдийн дэргэд Бархан хэмээх ном судар дармаллах газар байгуулагдаж эхэлсэн байна. Модон барын хэвлэл Халх, Буриад, Өвөрмонголд байсан хүрээ хийдийн газар дэлгэрэн хөгжсөн байлаа. Энэ нь янз янзын юмаар номын бар хийдэг тус тусад нь боловсруулсан аргаар хэвлэж чаддаг байв. Их хүрээн дэх Зүүн хүрээний цогчин дацангийн дэргэд Ихийн сүмбүм хэмээх модон барын газар байсан нь Монголын хэвлэлийн төв нь болж байв. Энд хувьсгалын өмнө 1000 гаруй номын бар байсны дотор “Монгол үсгийн цагаан толгой”, “Зөв бичгийн дүрэм”, “Монгол Ганжуур”, “Данжуур” болон шашны элдэв сургаал зэрэг 30 гаруй зохиолын монгол номын бар байжээ. Түүнчлэн Үйзэн вангийн хүрээнд нэр төрлийн тоогоор дээрхээс дутуугүй модон бар байсны 100 гаруй нь төвдөөс орчуулсан монгол номын бар байжээ. Монголын томоохон сүм хийдийн дэргэдэх модон барын газар тийз, зоосны тэмдэг гэх мэтийн мөнгөн тэмдэгт цаасыг хэвлэн гаргаж гүйлгээнд хэрэглэдэг байсан байна. 300 гаруй жилийн өмнө тэр хийдийг байгуулсны дараа цаасан тэмдэгт үйлдвэрлэх болж тавин жил болоод нэг удаа тусгай төлөвлөгөөтэйгээр үйлдвэрлэдэг байжээ. 1917-1918 оны үед тав дахь удаагийн хэвлэлт болсон байна. Түүнчлэн XVII-XIX зуунаас эхлэн монголчууд ном судрыг модон дээр сийлбэрлэхийн хажуугаар яс, мөнгө зэрэг зүйлс дээр сийлэх буюу янз бүрийн металл

бодисын холимгоор бичих, торгон дээр хатгамаллаж оёх зэргээр хийх явдал дэлгэрчээ. Манай улсын номын санд байгаа үнэт зүйлсийн дотор есөн эрдэнээр бичсэн “Ганжуур” байдаг. XIX зууны үед дан алтаар бичсэн төвд “Данжуур”, хар торгон дээр шар утсаар зүү ороож урласан хатгамал “Итгэл” гэдэг ном бий. Мөн үед монгол дархан Дагва тэргүүтэй хэсэг хүмүүс “Сандуйнжүд” хэмээх судрыг дан мөнгөн хуудсан дээр товойлгон хийсэн бөгөөд манлай, төгсгөлийн үсгийг шар алтаар цоолборлон ухаж хийгээд хадаж тогтоосон байдаг. Энэ ном 222 хуудастай бөгөөд үүнд нийт 52 кг 560 г мөнгө орсон ажээ. XX зууны эхээр дархан Бор Чүлтэм, Дүнхийн Шар нар зэс хуудсан дээр ухаж сийлбэрлэсэн “Найман мянгат” гэдэг уран зохиолын 1494 хуудас ном бий. Одоо номын санд буй хуучны бичмэл ба дармал номын бүртгэлээр барагцаалан үзэхэд 2320 гаруй нэр төрлийн ном байгаа болой.(13)

▪2. Монгол оронд Буддын шашин, соёл дэлгэрсэн хийгээд төвд бичиг үсгийн хэрэглээ

Бурхны шашин бол эртний энэтхэг, хятад, төвд, монгол зэрэг оронд олон зуун жилийн тэртээгээс дэлгэрч ирсэн дэлхийн том шашны нэг юм. Өөрөөр хэлбэл бурхны шашин үүссэн цаг үеийнхээ хувьд ч, хамаарах хүрээ хэмжээгээрээ ч дэлхийн том шашны нэг болно. Энэ зууны эхэн үеийн байдлаар гэхэд бурхны шашин дэлхийн бүх шашинтны 40%, христос 26%, мусульман дөнгөж 12.5%-ийг эзэлж байжээ.(14) 2000 жилийн тэртээгээс бурхны шашин Төв Азийн нүүдэлчдийн дунд нэвтэрч эхэлсэн юм. Язгуур монголын улс болох Монгол-Нирун улсад 420-450 оны үед лам Дармаприяг судар шастир, зурхай мэддэг болохоор Монгол Нирун улсын төрийн багшаар томилон 3000 өрх

соёрхсон байна. Энэ бол эртний энэтхэгийн төрийн уламжлал юм. Нирун улсын арав гаруй хаан бурхны шашны уламжлалаар өөрийн нэрээс гадна өргөмжилсөн нэр хэрэглэж байсны жишээ нь Шэлунь хаан /402-409/ “хутагтай” гэдэг өргөмжилсөн нэртэй байв. Зарим хаан санскрит нэртэй байсан. 521-524 онд төр барьж байсан хаан Брахман гэдэг нэртэй байсан байна. Монгол Нирун улс V-VI зууны үед Монгол орны бурхны шашны төв болж байв. Бурхны шашин монгол оронд нэвтрэхийн хамт монгол, нирунчууд энэтхэгчүүд хоорондоо харилцаж, энэтхэгийн эрдэм соёлын зүйл Монголд нэвтэрч эхэлжээ. 552 онд умарт энэтхэгийн Удьяана улсын лам Наренда-Яша таван нөхөдтэйгээ Нирун улсын нутгаар явж байжээ. Табгачийн Вэй улсын нийслэл Лоян хотын нэг сүмд сууж байсан энэтхэгийн таван ухаанд мэргэжсэн лам Ратнаманти Дундад азид байх үеийн өөрийн танил бөгөөд Лоян хотод ирсэн нирун монгол хүнтэй өдөржин ярилцдаг байв. Тэр нирун хүн чавганы модны боловсорсон үрийн тоог таана гээд хятад түшмэдтэй мөрий тавин, зөв тааж морий нь хожиж байсан байна.(15)

Монголын эзэнт гүрний доторхи ард түмнүүд нийгмийн хөгжлийн харилцан адилгүй шатанд оршиж, түүний нилээд нь хөгжлийн хувьд монголоос давуу байсан тул бөөгийн шашин нэгдмэл үзэл суртал болж чадахгүй байжээ. Монголын Юань гүрний үед бурхны суртахууны лам нар их нөлөөтэй болж, ном судар орчуулах, хэвлэх ажилд их хүч чармайлт гаргах болжээ. Хааны ордонд лам нар ихэд хүндлэгдэж, аливаа албан татвараас бүрэн чөлөөлөгдөж байв. Монголын хаад лам нарт онцгой эрх мэдэл олгосон тэмдэгт зэргийг олгодог байсан төдийгүй зарим лам нар “Улсын багш”, зарим нь бүр хааны зөвлөх болдог болжээ. Хувилай хаан 1260 оноос эхлэн Төвдийн

Пагва лам Лодойжалцанг улсын багш болгон өргөмжилж, бурхны шашныг төрийн албан ёсны шашин болгох зарлиг буулгасан билээ. Монголчууд ийнхүү бурхны шашныг албан ёсоор хүлээн авсан нь тэр үеийн монголд дэвшилт ач холбогдол бүхий үйл явдал болж энэтхэгийн өндөр соёлыг Монголд нэвтрүүлэн, дэлгэрүүлэхэд хүргэсэн билээ. Энэ нь гүрний төрийг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлж, дорно дахины бурхны суртахуунтай орнуудтай Монголын хэлхээ холбоог бэхжүүлж өгчээ. Тэр үеийн бурхны суртахууны сүм хийд шинэ соёл, нийгмийн сэтгэлгээ хөгжих төв болж иржээ.(16)

Юань гүрэн мөхсөний улмаас бурхны шашныг дэлгэрүүлэх гол төв болж байсан Төвд, Монголын хоорондын харилцаа хэсэг зуур тасалджээ. Тиймээс нийт монголчуудын шүтлэг аанай л бөөгийн мөргөл хэвээр байсаар байжээ. Гэвч бөө мөргөл нь Монгол газар 200 гаруй жил үргэлжилсэн ноёд, язгуурtны дажин хямралыг таслан зогсоох, нийт монголчуудын нэгдлийг хангах үзэл суртлын хэрэгсэл болж чадахгүй нь улам бүр мэдэгдэх болов. Үүнийг Түмэн засагт хаан, Алтан хаан нар бүр илүү ухаарч нийт монголчуудыг эрхэндээ оруулан нэгтгэн захирах хэрэгт нөлөөлөх үзэл суртлын үлэмж нарийн хэрэгсэл бол бурхны шашин хэмээн санал нэгтэй үзэх болжээ. Түмэн засагт хаан анх 1576 оны улаан хулгана жил Төвдийн бурхны шашны улаан малгайтны урсгалын их лам, илд зангидагч Гарма багшийг урьж авчирч, шавь орж Цахар, Халх түмний дунд бурхны шашныг дэлгэрүүлэх ажлыг зохиожээ. Энэ нь санамсаргүй хэрэг биш бөгөөд өмнөх их хаадын төр, шашны харилцааны уламжлалыг харгалзан үзсэний зэрэгцээ тэр үед Төвд оронд бурхны улаан малгайтны урсгал улс төрийн талаар ч, шашин суртахууны хувьд ч хүчирхэг байсныг тооцож үзсэн

хэрэг юм. Дараа жил нь 1577 онд Түмэдийн Алтан хаан, Хутугтай Сэцэн хунтайж нар Төвдийн бурхны шашны шар малгайтны тэргүүн лам Содномжамцыг /1542-1588/ Монголд ирэхийг урьжээ. Тэгээд хөх нуурын Цавчаал гэдэг газар сүм байгуулж, Алтан хаан, Хутугтай Сэцэн хунтайж нар өөрсдөө манлайлан өмнөт монголын олон ноёд бурхны шашинд оржээ. Алтан хаан, Содномжамц ламтанд “Далай лам” хэмээх цол өргөмжилжээ. III Далай лам Содномжамц хариуд нь Алтан хааныг Хубилай хааны бүх цол гуншинг хэрэглэхийг зөвшөөрчээ. Нэг хоёрхон жилийн дотор болсон эдгээр үйл явдлыг шинжлээд, академич Н.Ишжамц “...Содномжамцыг Далай ламд өргөмжлөөд түүнтэй багш шавын барилдлагаа барьж, Түмэд, Ордосыг шарын шашинд оруулсан нь чухамдаа Түмэн засагт хаантай санаа нийлэхгүй, өрсөлдөж зөрсөндөө биш болов уу. Монгол хаад ноёд Түвдтэй шашин, төрийн эвсэл холбоо байгуулахын тулд хамгийн нөлөө бүхий улаан, шар малгайтны аль алиныг талдаа татаж, эцэстээ аль илүү ашигтай гэснээ бүрэн дэмжиж ашиглах бодлого баримтлан, ажлаа хуваарилж явуулсан бололтой байдаг. Учир нь Түмэн засагт хааныг улааны шашинд орж байхад нь Алтан хаан, Хутугтай Сэцэн хунтайж нар дургуйцээгүй, сүүлчийн хоёрыг шарын шашинд орохыг Түмэн засагт хаан эсэргүүцээгүй байна. Түүгээр үл барам, Түмэн засагт хаан, Автай Сайн хан нар цаашдаа Далай ламд урилга заллага ирүүлж, нэн түрүүн Цахар, Халхыг бас шарын шашинд оруулсан байдаг” гэж бичжээ. Мөн энэ үед Ойрадын Мэргэн Тэвнэ ноён шарын шашинд орж, хүүгээ Түвдийн Лхас хотноо илгээж 1580-1590-ээд онд бурхны ном үзүүлжээ. Хүү нь бурхны номд нэвтэрч, Нэйж тойн хэмээн алдаршиж, баруун монголд шарын шашныг дэлгэрүүлсэн байна. Ийнхүү нийт Монголчуудын оюун санаанд бурхны шашин баттай

үр үндсээ суулгаж, улмаар хаан төрийн үзэл суртлын гол хэрэгсэл болон ашиглагдах болсон билээ.(17) 1586 онд Халхын Автай Сайн хан Эрдэнэзуу хийдийг анх байгуулжээ. Монгол газар том хүрээ хийд, жижиг хурлын сүмүүд өдий төдийгөөр байгуулагдан бурхны хөрөг зураг, баримал цутгамал үйлдэх, ном барлах ажлыг өрнүүлжээ. XX зууны эхээр 600 орчим том хүрээ, 1000 гаруй жижиг дуган, хурлууд байсан бөгөөд тэдгээрт 113000 лам нар, 160 орчим хутагт хувилгаад байжээ. XIV-XVII зууны үед урьд өмнийн хууль цаазын баялаг уламжлалд тулгуурлан “Алтан ханы цаазын бичиг”, “Хутугтай Сэцэн хун тайжийн шашны цааз”, “Халхын цааз эрхэмжийн бичиг”, “Монгол-Ойрадын хууль” төр, шашны хоёр ёсыг тодорхойлон тусгасан цаазын бичгүүд нийгмийн шаардлагаар урган гарчээ. Өвөрмонгол Манжид эзлэгдэж харийн түрэмгийллийн аюул нөмрөн ирсэн үед Халхын зарим ноёд хүчээ нэгтгэж, манжийн эсрэг тэмцэх, арга зам сүвэгчлэх болов. Ойрадын ноёд ч тэднийг дэмжжээ. Үүний тод илрэл нь Ойрадын Баатар хунтайжийн санаачлагаар 1640 оны Халх, Ойрадын ноёдын чуулган хийж, цаазын бичиг баталсан явдал юм. Халхын том ноёд хүн ардын оюун санааны нэгдлийг хангахын тулд Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг Халх Монголын шарын шашны тэргүүнд өргөмжлөв. Тэрбээр түүхэнд анхдугаар Богд Жибзандамба хутагт буюу Өндөр гэгээн хэмээн алдаршсан билээ. Түүнчлэн Өвөрмонголын зарим ноёдыг талдаа татах, Оростой холбоо тогтоох оролдлого хийж байлаа. Гэтэл 1650-иад онд эл үйл хэргийн ноён нуруу түшиж байсан төрийн томоохон зүтгэлтэн Түшээт хан Гомбодорж, Сэцэн хан Шолой нар бие барж, оронд нь баахан тавьтар муутай залуу ноёд гарч иржээ. Энэ нь халх, ойрдын улс төрийн байдалд таагүй нөлөө үзүүлж, дажин хямрал дэгдэхэд хүргэсэн юм.

Бурхны шашин Монголд дэлгэрсэн явдал бол монголчуудын оюуны болон бичиг үсгийн соёлд гарсан том өөрчлөлт байсан юм. Монголын олон зуун мэргэд бурхны шашны гол төв болж байсан Төвдөд арван ухааны эрдэмд мэргэжин түүний үр шимийг монгол нутгийн хөрсөнд соёолуулж, бурхны шашин, соёлыг ихэд дэлгэрүүлэн монгол дахь бурхны шашны биеэ даасан салбарыг бий болгосон билээ. Тэд арван ухааныг цааш нэмэн дэлгэрүүлж төвд хэлт утга зохиолыг бий болгон номт гурван улсын мэргэдийн дунд алдараа дуурсгасан нь нэн олон. Тэр цагт төвд хэл монголчуудын дунд ихэд дэлгэрч зөвхөн шашны төдийгүй ном бүтээл туурвих эрдмийн хэлний үүргийг гүйцэтгэх болсон юм. Төвд хэлээр монгол мэргэдийн бичиж үлдээсэн зохиол бүтээл арвин их бөгөөд монголчуудын соёл, шинжлэх ухааны түүхийг судлах хэрэгт шавхагдашгүй их баялаг хэрэглэгдэхүүн болж байна. Энэхүү зохиол бүтээлийг шинжлэх ухааны үүднээс судлан шинжлэх ажлыг Д.Ёндон, Ч.Жүгдэр, Д.Алтангэрэл нар хийж байсан бөгөөд сүүлийн үед идэхжиж Ш.Бира, Д.Цэрэнсодном, Х.Гаадан, Л.Хүрэлбаатар, П.Лувсанцэрэн, Т.Содномдаргиа, Ш.Чоймаа, Ш.Сонинбаяр, Р.Бямбаа, Д.Бүрнээ. Л.Цэдэв, О.Сүхбаатар, Л.Тэрбиш, Б.Болдсайхан нарын эрдэмтэд хүч оюунаа дайчлан байгаа нь сайшаалтай байна. Оросын эрдэмтэдээс монголчууд төвд хэлээр ном зохиол бичиж байсныг сонирхон тэмдэглэж байсан удаа бий. Академич Б.Я.Владимирцов “Төвдөөр зохиол бичиж байсан бөгөөд Төвдөд хүртэл их нэртэй болсон олон тооны гарамгай зохиолч, утга зохиолын зүтгэлтэн хүмүүс сүүлийн хоёр зуун жилд монголчууд дотроос төрөн гарчээ”(18) Мөн Ю.Н.Рерих 1961 онд бичсэн Төвд хэл номдоо “Монголын нүүдэлчдийн дунд томоохон эрдэмтэн, зохиолчид төрөн гарсан бөгөөд төвд хэлээр

туурвисан үлэмж их хэмжээний зохиол бүтээлийг үлдээсэн юм. Эдгээр бүтээлийн олонх нь шинжлэх ухааны ашиг сонирхолд нийцнэ гэдэг нь маргаангүй" гэсэн байдаг.(19) Тэдгээр мэргэд төвд хэлээр зохиол бүтээл туурвихаас гадна маш олон тооны зохиолыг төвд хэлнээс монгол хэлэнд орчуулсан юм. Буддын шашин, соёлын тайлбар толь зохиохдоо бид төвдөөр зохиол бүтээл бичсэн 300 гаруй мэргэдийн нэрсийг оруулсан билээ. Энд би жишээ болгон хоёр хүний товч намтрыг оруулав.

Агваанбалдан དཀོན་དབང་དཔལལྡན། /1797-1864/ Буддын гүн ухаанаар мэргэшсэн Их хүрээний таван Агвааны нэг, Занын Агваанбалдан Халх Цэцэн хан аймгийн Хардал жанжин бэйсийн хошуу, өдгөөгийн Хэнтий аймгийн Галшир сумын нутагт 1797 оны 10-р сарын 24-ны өдөр ард Занын гэрт мэндэлсэн бөгөөд тэрээр 6 настайгаасаа төвд бичиг заалгаж, цааш бурхны номонд шамдан суралцаж, зохих шүүлэг шалгалтыг амжилттай өгсөөр Их хүрээний Гандан хийдэд их, бага арван ухааны эрдмийг дэс дараалан судалж төвд, санскрит хэл чадамгай эзэмшин эртний Энэтхэгийн Нагаржуна, Асанга, Васубанди, Дигнага, Дармакирти болон сүүлийн үеийн төвдийн нэрт сэтгэгч Богд Зонхова, Жамьяаншадав нарын зэрэг их эрдэмтэдийн бүтээлүүдийг шамдан судалсаар гүн ухааны өндөр боловсрол олж Төвд, Хятад, Хөх нуур, Өвөрмонголоор удаа дараа аялан явж, номын мэргэдээс эрдэм ухаан сурч, мэдлэгээ байнга гүнзгийрүүлэн баяжуулж байжээ. Тэрээр 1831 онд Лхас хотноо буддын гүн ухааны "Линсрэй гавж"-ийн дамжаа барьж, номын далайн титэм хүртжээ. Багшийнхаа хэрхэн хамгаалсан тухай түүний шавь Жигмэддорж бичихдээ: "Гавжийн зэрэг хамгаалж байх үед нь олон мэргэд сүсэглэх, бишрэх, дурлах, турших зэргээр оролдсон

боловч тэр нэртэй мэргэдүүд лүгээ олон хоногийн турш ном хаялцахдаа өөрийн хэлсэн үндэслэлүүдтэй харшилж эргэж буцсан зүйл огт үгүй тул хол ойрын дацангаас ирсэн олон мэргэд цөм шагшин магтаж байв. Хариу өгөхдөө түргэн шаламгай, хурц тодорхой, биеийн байдал, дууны өнгө тэргүүтэн аль нэг талаар гайхамшиг сэргэлэн цогтой байв. Мэргэн тэнэг бүгдийн сэтгэлийг хөдөлгөж, тэд нарын сайшаан хашгиралдах нь хөгжмийн эгшиг мэт" гэжээ.

Энэ үеийн монголын нэрт эрдэмтэн Шижээ, багш Агваанбалдангынхаа мэдлэгийн гүн гүнзгий, ямарваа нэг юмыг учир шалтгааны ухааны үүднээс үндэслэхдээ маш чадамгай, шашныхаа ёс журмыг биелүүлэхдээ нарийн нягт, эрдэм мэдлэгийн төлөө бүхий л амьдралаа зориулагч, хүнд чин сэтгэлээсээ тусалдаг зэргийг нь зүйл зүйлээр тодосгож бичээд түүнийг Замбуу тивийн зургаан чимэг гэж алдаршсан эртний Энэтхэгийн нэрт сэтгэгч Нагаржуна, Аръядэва, Асанга, Васубанду, Дигнага, Дармакирти нартай зүйрлэжээ. Төвдийн Шаравжамц маарамба түүний тухай "Би монгол лам нарын гүн ухааны зохиолуудаас нэлээдийг уншсан хүн. Монголд Агваанхайдав, Агваанбалдан, Шижээ гавж гэх мэт олон сайчууд байжээ. Төвдийн лам нар бид тэдний зохиолыг цөм хүндэтгэн уншдаг юм. Агваанбалдан бол буддын гүн ухааны тогтолцоот ёсыг бүхэлд нь гүнзгий эзэмшсэн учраас бүх талаараа тэгш боловсорсон хүн гэж манай төвдийн мэргэд үздэг юм. Төвдийн буддын гүн ухааны сүм хийдүүд Агваанбалдангийн зохиолуудыг нэгэн чухал сурах бичгийн журмаар хэрэглэдэг юм. Түүгээр ч барахгүй Гүмбүмээс холгүй оршдог Дисагомбо хэмээх хийдийн гүн ухааны сургууль бол дан ганц Агваанбалдангийн зохиосон гүн ухааны номуудыг судлахад зориулан байгуулагдсан юм"

гэжээ. Мөн Лхасын лхаарамба Лувсанпэрэнлэй “Монголын Агваанбалдангийн зохиосон номыг төвдийн шашны бүх салбар чиглэлүүд дуртай хэрэглэдэг. Агваанбалдан бол гүн ухааны үргэлжилсэн их маргаанд шийдвэрлэх ач холбогдол бүхий олон ном бичсэн хүн юм. Буддын олон салбар ухааныг гүнзгий ухаарсан хүн гэж түүнийг манай багш нар хэлдэг байсан. Бичсэн номууд нь үнэхээр гүн гүнзгий бөгөөд их ухаан мэдлэг шаардаж байж сая учрыг нь олдог байж билээ” хэмээн онцлон дурджээ.

Шарын шашныг үндэслэгч Төвдийн лам Зонхавын XIV зууны үед бичсэн “Их бодь мөрийн зэрэг” (ламрим чэн бо) хэмээх алдарт зохиолыг Агваанбалдан үг үсгийн хувьд ч утга агуулгын хувьд ч нарийн сайн мэддэг байжээ. Гэтэл уг зохиолд үг утгын хувьд эргэлзээтэй хэдэн зүйл байв. Түүнийг учир шалтгааны ухааны үүднээс Агваанбалдан, Богд Зонхава ингэж бичсэн байх ёсгүй гэж бодоод янз бүрийн үед, янз бүрийн оронд тэр үе хүртэл хэвлэгдсэн уг номын 25 удаагийн хэвлэлийг нэг бүрчлэн шүүн үзэхэд цөм тэрхүү эргэлзээтэй үг утгаараа байж байжээ. Тэгэхэд нь Агваанбалдан богд Зонхава зүй нь ийм үг, утгаар л бичсэн байх ёстой гэсэн томъёололуудыг зохион бичээд өөртөө хадгалжээ. Тавдугаар богд Жавзандамба таалал төгсөж, түүний хойт зургаа дахь дүрийг залах асуудлаар 1843 онд Агваанбалдан Төвд орж, уг асуудлыг сонирхох аятайхан далим гарчээ. Тэр үеийн төвдийн шашны удирдах зүтгэлтнүүд уг номын талаар Агваанбалдангийн тавьсан асуудлыг ихэд сонирхож, Зонхавын өөрийн нь анхны гар бичмэлтэй тулгаж үзэх шийдвэр гаргажээ. Гэтэл тэрхүү анхны гар бичмэлийг Зонхаватай хамт оршуулаад олон зуун жил болсон байжээ. Гэвч тэрхүү оршуулсан суваргыг ухаж, анхны эхийг гаргаж үзэхэд Агваанбалдангийн өөрийн нь томъёолж байсан үг, утгаараа яг

тохирч, уг номын тэрхүү 25 удаагийн хэвлэл цөм алдаатай байсан нь батлагджээ. Үүнтэй холбогдуулан төвдийн нэрт эрдэмтэн Лхасын Лосолин хийдийн тэргүүн Чүлтэмнамжил “Да Хүрээний их гэвш Агваанбалдан Төвд орноо ирсэн явдал төвдийн шашин номын үйлсэд маш их тус нэмэр боллоо” гэж өндөр дуугаар хэлж байжээ.

Албан тушаал, өндөр суудал, нэр зэрэгт угийн дургүй зөвхөн номын мөр хөөсөн энэ лам цоржийн албан тушаалаас удаа дараа чөлөө гуйж байсан боловч зөвшөөрөгдөхгүй явсаар арав гаруй жил болсон бөгөөд энэ хугацаанд доод суудал барьж, жирийн ламын ядуу даржин амьдралаар амьдарч, доорд лам нар болон сүсэгтэн олонтой ойр дотно байж, ном үзэх, номлох, бусдын номлосныг сонсох, өөрөө туурвих зэргээр эрдэм номын ажилдаа шамдан хичээсээр байжээ.

Эртний Энэтхэгийн болон сүүлийн үеийн төвдийн нэрт мэргэдүүдийн хийсэн буддын гүн ухааны хамгийн нарийн төвөгтэй зохиолуудад үг, утгын том жижиг хэмжээний олон тайлбар, мөн монгол, төвдийн бурхны сүм хийдийн дэргэдэх гүн ухааны сургуулиудад үздэг бараг бүх сурах бичигт тайлбар хийхэд Агваанбалдангийн бүтээлийн гол чиглэж байв. Гэхдээ тэр зөвхөн тайлбарлагч байсангүй, мөн өөрөө гүн ухааны биеэ даасан олон зохиол бүтээсэн томоохон сэтгэгч, мэргэжлийн гүн ухаантан хүн байсан ажээ.

1832 онд бичиж, Их Хүрээнд хэвлүүлсэн 98 хуудас “Чирдан жи намшаг” хэмээх зохиолдоо Агваанбалдан эртний энэтхэг, төвдийн олон мэргэдээс буддын зан суртахууны ухаанд холбогдуулан туурвисан зохиолуудыг өөрийн үеийн үзлийн үүднээс шүүмжлэн боловсруулж, буддын шашны сүм хийд, лам нарын дагаж мөрдөх дэг журам, зохион байгуулалт, сахилга

батын тухай сургаалыг тайлбарлан хөгжүүлж, буддын өөрийн нь баримтлан биелүүлж, номлон дэлгэрүүлж байсан ёс суртахууны хатуу хэм хэмжээг нарийн чанд сахиж, нийгмийн дунд биеэ зөв авч явах нь шашин юугаан ариун тунгалаг байлгаж, эрдэм ном сайн сурч, шашин амьтны тус үйлдэх чухал нөхцөл мөн гэдгийг тод томруун гаргажээ.

1835 онд бичиж, Их Хүрээнд хэвлүүлсэн 112 хуудас “Дубта-ши-гий дэнь ни” буюу (Дөрвөн тогтсон тааллын ёсон дахь хоёр үнэний тайлбар) хэмээх зохиол бол Агваанбалдангийн гүн ухааны их алдаршсан нэг чухал бүтээл бөгөөд түүндээ тэр буддын гүн ухааны нэг том зангилаа асуудал болох үнэний тухай асуудлыг хэрхэн яаж авч үздэгийг тусгайлан судлан боловсруулжээ.

Эртний Энэтхэгийн нэрт сэтгэгч Ейгнэнгийн (Васубандугийн) туурвисан “Абхидхармакоша” хэмээх гүн ухааны гол номыг төвдийн мэргэд, ялангуяа Жамъяншадав улируулан судалж, өөрийн үеийн хүмүүст тус болох зорилгоор буддын сүм хийдийн дэргэдэх гүн ухааны сургуулиудад үзэх абхидармын сурах бичиг хийжээ. Тэрхүү сурах бичгийн утга агуулгыг учирлан тайлбарлаж, ойлгож мэдэхэд хялбар дөхөм болгож, гүн ухааны харилцан ярилцах, маргах хэлбэрт оруулсан 107 хуудас “Чой онба зоджи догжад” хэмээх зохиолыг Агваанбалдан 1846 онд бичиж, дараа нь Их Хүрээнд хэвлүүлжээ.

1848 онд Агваанбалдан “Дүй цигжи чандэл” буюу “Цаг улирлын тайлбар, бэрх оньсын зуун үүдийг нээгч түлхүүр” хэмээх нэртэй 30 хуудас тоо, одон орны судлалын сонирхолтой нэгэн зохиол бичжээ. Энэ зохиол бол төвдийн эрдэмтэн Жамъяншадавын винайн сурах бичигт оруулсан цаг улирлын тухай хэсгийг дэлгэрүүлж тодотгосон бүтээл бөгөөд энэ тухай

тусгайлан авч үзсэн зохиол бүтээл төвд, монголд урьд өмнө гарч байгаагүй учир мэргэдийн дунд ихэд дэлгэрэн алдаршжээ.

Агваанбалдангийн 1857 онд бичиж Их Хүрээнд хэвлүүлсэн 184 хуудас “Парчин жидон жи сүрчан” хэмээх зохиол бол буддын шашны гүн ухааны сургуулиудад үзэхээр зориулж төвдийн эрдэмтэн Ванчин Содномдагва (1478-1554)-ын бичсэн ”Парчин-хутагт билгийн цаад хязгаарт хүрэх оюун ухаан, оюун бодлын онолын сурах бичиг”-т хийсэн тусгай тайлбар юм. Найман бүлэг бүхий энэ номдоо Агваанбалдан хутагтын дөрвөн үнэн, сэтгэл төдийтний бүхний суурь хэмээх сэтгэл санааг анхдагч болгон үздэг үзэл, төв үзлийн ранжүдвийн ёсны хоёр үнэн, хутагтын найман гишүүнт мөр, 12 шүтэн барилдахуй хэмээх шалтгаант чанар зэрэг их бага хөлгөний гүн ухааны үзэл сургаалуудыг дэлгэрүүлэн тайлбарлажээ. Ийм бүхнийг хамарсан шинжтэй бөгөөд утга санааг гүнзгий гаргасан тайлбар зохиол урьд өмнө Төвд, Монголд төдий л гарч байгаагүй учир энэ зохиолыг мэргэд ихэд хүндэтгэн үзэж, буддын гүн ухааны нэгэн чухал эх сурвалж болгон хэрэглэсээр иржээ. “Агваанбалдангийн энэ ном бол энэтхэг, төвдийн хэдэн зуун мянган шашдирын хамгийн бэрх оньсыг бүрэн гүйцэд харуулсан толь мэт юм. Төвдөд ихэнх хүмүүс гүн ухааны хийсвэр үгээр хөөцөлдөж байгаа одоо цагт халх Монгол орноос төвдийн шударга мэргэдэд урьд өмнө гараагүй сонин гайхалтай номлолын шинэ их бэлгийг ирүүлсэн нь бишрэлтэй. Энэ ном бол Зонхава ба түүний шавь нарын сургаалыг гүн гүнзгий бөгөөд эрэмбэ дараатай ойлгоход ёстой нүд нь болох бөгөөд гэхдээ хоосон яриа маргаанаар өдөр өнгөрүүлж байдаг хүмүүст энэ ном огт хэрэг болохгүй, харин энэтхэг, төвдийн олон мэргэдийн зохиосон гүн ухааны үй түмэн ном судрын доторх чухам үнэнийг эрж олохын төлөө зүтгэн

мэрийж буй тийм үнэнч мэргэдэд үлэмжийн их тус болох нь гарцаагүй" гэж уг зохиолыг Төвдөд хэвлүүлэхэд Шаамарцан өөрийн хийсэн төгсгөлийн өгүүлэлдээ үнэлжээ.

Эртний Энэтхэгийн нэрт сэтгэгч Гомболүдэв (Нагаржуна) буддын их хөлгөний гүн ухааныг үндэслэсэн 6 ном бичжээ. Түүний нэг "Муламадхьямакакарика" буюу "Дундад үзэлд орохын хураангуй" хэмээх номд Энэтхэгийн бандида Даваадагва "Мадхьямакавритти" хэмээх тайлбарыг манай тооллын VI зууны орчим хийжээ. Тэр тайлбарт Агваанбалдан 1861 онд 188 хуудас "Вума ла жугпи цигдэл" хэмээх их тайлбар бичиж Их Хүрээнээ хэвлүүлжээ.

Агваанбалдангийн энэхүү зохиолын гол утга нь амьтан бүхнээс урьдаж оюун ухаан ёс суртахуунаа боловсронгуй болгодог бодисатва нарын үзэл бодол, үйл ажиллагааны онол практикийн олон талыг арван газрын бодисатва нарын явдал, тухайлбал 6 барамидад хураангуйлж өгүүлсэнд оршино. Үүнд ядуу хоосон хүнд эд агуурсын болон сэтгэл санааны сэтгэл харамгүй тусламж үзүүлэх өглөг барамид, бусдын тусын тулд хүчин зүтгэхдээ ямар нэгэн харамсах сэтгэл, шуналгүйгээр чин сэтгэлээс зүтгэх шагшаабад барамид, бусдын тусын тулд хүчин зүтгэхдээ уурлах хилэгнэхийг тэвчсэн хүлцэнгүй барамид, бусдын тусын тулд зүтгэхдээ ямар нэгэн залхуурах хойргошихыг тэвчсэн хичээнгүй барамид, бусдын тусын тулд хүчин зүтгэхдээ сэтгэл санаагаа ямар нэг хэмжээгээр хоёрдуулахгүй нэгэн зүгт бүгдийг төвлөрүүлэх дияан барамид, бусдын тусын тулд хүчин зүтгэхдээ мунхагийн харанхуйг арилгаж, ертөнцийн жам, хоосон чанарын онолыг танин мэдэх билэг барамидуудыг өгүүлжээ.

Тэрээр 1836-1847 онд Их хүрээний цоржийн эрхэм тушаал хүлээж байсан бөгөөд шашин номын бүхий л хэргийг

удирдан зохион байгуулж, олны дунд Балдан цорж, Тунгалаг цорж, Намдилангийн лам гэх зэрэг янз бүрийн нэрээр алдаршиж байсан байна. Агваанбалдан цаггүй их ажлынхаа чөлөө заванд төвд хэлээр том жижиг хэмжээний 96 зохиол туурвисан нь зургаан боть сүмбүмээр барлагджээ. Түүнээс одоо УТН санд 30 гаруй зохиолоос бүрдсэн 4 боть сүмбүм нь хадгалагдаж байна.(20),(21),(22),(23)

Дамдин རྡམ་གྲིན། /1867-1937/ Зава Дамдин гавж Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошууны хүрээний гавж, Шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн хүн байв. /Энэхүү зава хэмээх нь 5 ухааны номыг тайлан мэдэгч гэсэн утга бүхий цол/. Дундговь аймгийн Бага газрын Чулуу хэмээх уулын ойролцоо Дэлгэр уулын өвөрт гүн шандын ойролцоо Дэлгэрийн хийдийг байгуулсан нь “Чойрын хийд” хэмээн алдаршжээ. XV жарны Улаагчин туулай жилийн цагаан сарын шинийн гурваны өдөр буюу 1867 оны хоёрдугаар сарын долоонд аав Шагдар, ээж Содномпил нарын дөрөвдүгээр хүү болон мэндэлжээ. Дөрөв, таван настай байхдаа ах лам Жинба зурхайчаар цагаан толгой заалган төвд бичиг үсгийг хоромхон зуур сурч, өөрөө “Ламаадан”, “Итгэл”, “Ганданлхавжаа” сэлтийг цээжилсэн бөгөөд ах лам нь дэмжин өгч Чойжид болон Арван хангал, Гүнриг, Сундуй, Дэмчог тэргүүтэн хүрээний уншлагыг гүйцэд цээжилж нутгийнхан түүний авъяас билгийг магтаж байлаа. Дамдин арван долоотойдоо Да хүрээний Гунгаачойлин дацанд ирж суралцан гүн ухааны долоон игчааны ээдрээтэй бэрх онолыг сайтар нягтлан суралцаад, домын дамжааг 1891 онд амжилттай барьж, дацангийн гавж мэргэдэд гайхагдаж байв. Буддын гүн ухааны охь шим бологч хамгийн бэрх утгатай дундад гүн ухааныг Боржигин Жамц, Минжүүр

аграмба, Ханд вангийн Дандар аграмба нараар заалган судалжээ. Хорин хэдэн наснаас эхлэн төвд хэлээр ном зохиол бичиж, нийт арвандолоон боть зохиол туурвисан нь өнөө бидний үеийг хүртэл уламжлан ирсэн бөгөөд монголын соёл шинжлэх ухаанд түүний оруулсан гайхамшигт хувь нэмэр болон үлджээ. Буддын гүн ухааны таван боть гэж алдаршсан Намдэл, Парчин, Ум, Зод, Дүлбаа хэмээх далай мэт гүн онолыг судлан суралцаад 1905 онд 39 насандаа гавж хэмээх эрдмийн өндөр мяндаг цолыг хүртсэн байна. 1984 онд Энэтхэг орны Дармасала хотод байх “Тэгчин чойлон зүглэг хан” дуганд 500 ламын дүнчүүр маань хурж, үрэл бүтээх ёслолын нээлт болж байлаа. Судар тарнийн шашны эзэн, мутартаа цагаан лянхуатын хувилгаан XIV Далай лам Монголын Чойрын хийдийн хамба лам Зава Дамдин агсны “Их нигүүлсэхүйг магтсан зуун найман бадаг болор эрдэнэ эрх оршивой” хэмээх номыг хувийн сангаасаа хөрөнгө гарган нэгэн түмэн хувь хэвлүүлснээ хувраг нарт тараагаад “Энэ бол монгол ламын айлдсан ном болой. Улаанбаатар хотод энэ номыг нэг лам надад өгөхөд нь уншаад уйлсан юм аа. Үнэхээрийн нигүүлсэхүй сэтгэлийг олж, энэрэхүйн эрдмийн чинад хүрсэн хүн л ингэж бичиж чадах амой. Энэ номыг миний бие та бүхэнд заах гэж байгаа бус, харин хамт унших гэсэн билээ” гэж айлдан, өөрөө дагуулан номловой. Энэ дэлхийн амьд бүхнийг энэрэх эрмэлзэл, тэднийг энэрэхүй сэтгэлтэй болгох хүслээ гадаад хэлээр бичсэн шүлгээр илэрхийлээд тэр хэлтний өр зүрхийг уяраана гэдэг хүнд тэр бүр үл заяах авьяас юм. Ш.Дамдины 364 зохиол бүтээлийг багтаасан 17 боть сүмбүмийг Гүрдава ринбүчи Дели хотноо хэвлүүлснийг Ази, Америкийн олон номын сан захиалан авчээ. Зава Дамдинг үнэлсэн дэлхийн ухаантан олон. Өдгөө Нобелийн шагналт Далай лам 1986 онд Энэтхэгийн

Бодгаяа хотноо ном айлдахдаа “Монголын Зава Дамдин ламын “Дүйнхарын салам” хэмээх номыг үзэж байж би бан тавьсан” гэжээ. Энэ номыг Энэтхэгийн Намжил дацанд Дүйнхарын ном үздэг хүнд зориулан сурах бичиг болгон хэвлэжээ. Бурхны шашны гурван игчааны нэг Банчин Сономдагвын таван ухааны номыг судалдаг 1000 ламтай Өмнөд Энэтхэгийн Буддын гүн ухааны институт /Лосоолон дацан/-д “Билиг бэлгийн чинад хүрэхийн өгүүлэгдэхүүн найман бодот ба далан утгыг эцэст нь шинжлэгч эш ухааны тэнгэрийн дуу хэмээгч оршвой” номыг нь сурах бичиг болгож, Энэтхэгт олдохоо больсон Сономдагвын игчааны номыг орлуулж, Сономдагвын үзэл хийгээд банчин игчааны үндсийг судалж байна. Түүнчлэн “Их нигүүлсэхүйн магтаалыг” нь англи хэлээр орчуулан гаргажээ. Тэрээр 1910 хэдэн оны дундуур “Цагаан лавайн дуун эгшиг” гэдэг түүхэн бүтээлээрээ Цастын орон хэмээх Төвд хийгээд бусад олон газар оронд согву Лувсандаян хэмээн алдаршжээ. Далай ламын багш, Вагиндрагийн үсэг зохиогч буриад лхаарамба Агваандорж уг бүтээлийн талаар найман асуулт бүхий захидал ирүүлж байжээ. Оросын академич Шербатский, Тубянский нар Дамдинг ихэд тоодог байжээ. Дамдин, эртний Энэтхэгийн алдарт гүн ухаантан бөгөөд дундад үзлийн гол төлөөлөгч Нагаржунайн бүтээлийг судалж, “Төв үзлийн ерөнхий утгын тайлбар, гүн утгыг машид тодруулагч зул” ном туурвижээ. XIV Далай ламын хоёр багш энэ номыг ихэд үнэлж, Энэтхэгт хэвлүүлсэн байна. Мөн Дармасалагийн Камтул Дондов ринбүчи хувилгаан Дамдинг “Монголын Шантидэва” гэж нэрлэн, дундад үзлийн том төлөөлөгч гэгддэг Энэтхэгийн тэр их сэтгэгчтэй /VIII/ зүйрлэсэн нь ийм учиртай буюу. Дамдин эртний Энэтхэгийн сэтгэл төдийтөн /йогачар/ чиглэлийн нэрт учир шалтгааны ухаантан

Дармакирти, мөн Төвдийн Банчин Сономдагвын логикийн үзлийг баримталж “Оюун судлалын ёсон” бүтээл туурвижээ. Дамдин гүн ухаантан, учир шалтгааны ухаантан төдийгүй нэрт түүхч байлаа. Заваа Дамдины түүх, гүн ухаанаар туурвисан олон бүтээл болох 17 боть сүмбүмээс гол “Төв үзлийн ерөнхий утгын тайлбар, гүн ухааныг машид тодруулсан зул”, “Билгийн чанд хүрэхүйн өгүүлэгдэхүүн найман бодит ба далан утгыг эцэст нь шинжлэгч эш ухааны тэнгэрийн дуу хэмээгч оршив”, “Дундад үзлийн шастирын утга санааг нягт ялгасан тайлбар”, түүх судлалын талаар “Оюун судлалын ёс зүрхний чимэг”, “Гунга-Чойлингийн түүх”, ”Монгол дахь шарын шашны түүх”, 1919-1931 оны хооронд бичсэн “Хорчойнжун” буюу “Замбу тивийн умар зүгийн их монгол улс орны домгийг өгүүлсэн шастир, ухаантныг баясгагч алтан дэвтэр” зэрэг түүхийн зохиол юм. Энэтхэг, Төвдийн хаад, шашны түүхийг эхэлж өгүүлдэг байсан урьдын монгол түүхчийн уламжлалыг эвдэж, Монголын түүхийг өгүүлсэн нь төвд хэлээр бичсэн Монголын түүхэн утга зохиолд шинэ үзэгдэл болсон гэж академич Ш.Бира Ш.Дамдины “Алтан дэвтэр”-ийн тухай бүтээлдээ дурдсан байна. Энэхүү “Алтан дэвтэр”-т монгол бичгийн гарал үүслийн талаар онцлон тэмдэглэсэн зүйл байдаг билээ. Дамдин дуун ухаан, яруу найргийн онолыг төгс эзэмшсэн шүлэгч байсныг судлаач Ш.Сонинбаяр батлан бичиж байна. Тэрээр бас дуун хөрвүүлэгч байлаа. Хятадын эртний нэрт жуулчин Фа Сяний замын тэмдэглэл болох “Бурхны ном дэлгэрсэн улсууд тур жуулчилсан бичиг”-ийг 1918 онд монгол хэлнээс төвдөд орчуулжээ. Мөн Жийдаан Хуушааны намтрыг хэсэгчлэн төвд хэлээр орчуулж, хятадаас “Их Юань улсын түүх”-ийг монголчилж байжээ. Тэрээр бас орос хэл мэддэг байсны дээр самгарьд хэлний гүнзгий

мэдлэгтэй байсан бөгөөд түүнийг Судар бичгийн хүрээлэнгийн сурвалжлагч болон жинхэнэ гишүүнээр сонгож байсны баримт 1924 оны Хүрээлэнгийн тогтоолд буй аж. Монголын шашин соёлын түүхэнд жинтэй хувь нэмэр оруулсан энэ их эрдэмтэн лам бие чилээрхэн байсаар 70 насандаа Улаанбаатар хотод, Гандангийн дэнж дээр 1937 оны зун таалал төгсчээ.(24),(25),(26) Агваанбалдан бол гүн ухааны зохиол бүтээл туурвигчдын төлөөлөгч болж байхад Зава Дамдин гүн ухаан болон түүхийн зохиол бүтээл туурвигчдын шилдэг төлөөлөгч билээ. Зава Дамдингийн адил төвдөөр түүхийн зохиол бичсэн нилээд мэргэд бий. Үүнд: Заяа бандида Лувсанпэрэнлэйн /1642-1715/ “Тодорхой толь” /Салба ‘и мэлон/, Сүмбэ хамба Ишбалжирын /1704-1784/ “Галбарвасан модон” /Паг сам жонсан/ гэдэг Энэтхэг, Хятад, Төвд, Монголд шашин дэлгэрсэний түүх, “Хөх нуурын домог”, гүн Гомбожавын /XVIII зуун/ “Хятадад бурхны шашин дэлгэрсэний түүх” /Жанаг чойнжун/, цахар гэвш Лувсанчүлтэмийн /1740-1810/ түүхийн зохиолууд, Цэмбэл гүүшийн /XVIII зууны эцэс XIX зууны эх/ “Монголд бурхны шашин дэлгэрсэн түүх” /Хор чойн-жун/, Дармадалайн “Монголд бурхны шашин дэлгэрсэн түүх” /Хор чойн-жун/ зэрэг томоохон зохиолуудыг нэрлэж болно.(27) Монгол оточ нарын анагаах ухааны салбарт төвд хэлээр туурвисан ажил үлэмж буй. Монгол эмч нар онол туршлагаараа олж мэдсэн зүйлээрээ монгол төдийгүй төвд эмнэлгийн ухааныг хөгжүүлсэн юм. Монголд хүн эмнэлгийн биеэ даасан дэг сургууль байсан бөгөөд Юань улсын судрын 81-р бүлэгт “Хубилай хаан Жун тунгийн 2-р оны 5-р сард...эмчийн сургууль байгуулав...” гэсэн мэдээ байдаг. Энэ нь 1261 он юм. Үүнээс гадна монголд байсан бүх хүрээ хийдэд манба дацан монгол эмч нарыг тусгайлан бэлтгэдэг сургуулийн газар байсан

билээ. Их эмч, төвдөч Н.Дашзэвэг авгайн бичсэнээр монголд байсан сүм хийдийн 70-80 орчим хувьд уул дацан байсан хэмээжээ.(28) Монгол эмч нар хүний эрүүл биеийн тогтоц, элдэв өвчний үүсэх шалтгаан, өвчний шинж тэмдэг, анагаах арга болон өвчнөөс сэргийлэх арга зам, эмийн найрлаг, эм бэлтгэх арга ухаан зэрэг асуудлыг судлан шинжлэж тухайн цагт Төв Азийн олон орны хувьд Lingua Franca болж байсан төвд хэлээр бичдэг, бас эмчилгээний бүх арга барилд биеэрээ үлгэрлэн дагуулж шавь нараа сурган бэлтгэдэг уламжлалтай байсан билээ. Монголын ууган оточ Лувсанданзанжанцаны “Анагаах ухааны язгуур үндэсний тайлбар, тодорхой зул” /Зажүдийн дэлба салби донмэ/, “Өвчний ялгалтыг сайтар өгүүлж тодорхойлсон нь” /Наджи ева нам шад салжид/, Өвчний үндсийг арилгагч туулгын бүлгийн товчлол” /Шала ла дон дову/, “Рашааны цацрал” /Дүзи сэгма/, “Хорин тавт эмийн аймаг хэсэг” /Нэра дэцан/, гүн Гомбожавын ”Номлолын үндэсний тайлбар” /Шаджүдийн дадол/, “Анагаах засал дэлгэрэхийн сан” /Со чад жайвий гор жод/, “Бодь өвчнийг номхотгон засах” /Брүмбү дүлба и тавай/, Ишбалжирын “Рашааны ундрал” /Дүзи чүжүн/, “Рашааны цагаан шүүдэр” /Дүзи сэлгар/, “Рашааны дусал” /Дүзи тигва/, “Рашааны хурим” /Дүзи дэр/, “Эмийн нэр ба эмт бодисыг таних болор толь” /Ойнзин шилгар мэлон/, Ишбалжирын шавь Лувсанванжилын “Лхантав чандал”, Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Эм таних ухаан” /Ман о шэй жид/, “Багсамын тосон эмийг хийх ёсон” /Багсам мамар цэр сүл/, “Судал шинжлэх товчхон” /Задаг сүл дор дой/, Хөх нуурын Миндол Жамбалын “Увдисын далай” /Манаг ринчинжунай/, “Нүдний үзэсгэлэнт чимэг” /Зэцэрмигжан/, Далай вангийн Чоймболын “Түүвэрлэн хураасан зүрхний чандмань” /Жидүй нин нор/, Ловон Мижиддоржийн “Бүхнээ туслах рашаан зүрхний шим”

/Шанпан дүзий нинху/, Ишданзанванжилын “Шүрэн унжлага” /Жүрдошал/, Ёндон оточийн “Цогт дөрвөн үндэсний түүвэр нэр нүүр царайг тодорхойлогч толь” /Балдан жүд ши дүймэн шинрай салби мэлон/, Далай вангийн хошууны Лүнрэг Дандарын “Эмийн дөрвөн үндэсний зарим дохионы утгыг тайлсан” /намжал арүри прэнба зэй жан/, Их хүрээний оточ Чойжамцын “Гайхамшигт баясгалант хуримын сан” /Онцор гадон дэр зод/ зэрэг олон бүтээлүүдийг дурьдаж болно.(29) Энэ дашрамд тэмдэглэхэд тэр цагт төвд хэл Европ дахинаа латин хэл ном судрын хэл болж байсантай нэгэн адил Төв Азийн олон орны хувьд ном бичгийн хэл болж байсан тул монголын бичгийн хүмүүс эх хэлнийхээ хажуугаар төвд хэлээр их бага таван ухааны номыг өдий төдий ботиор зохиож монголдоо төдийгүй төвд, энэтхэгт гайхагдаж ирсэн” хэмээн доктор Ц.Шагдарсүрэн онцлон тэмдэглэсэн билээ.(30) XIV зууны эцсээс Монголд их хөлгөний буддизм шарын шашны хэлбэрээр хүчтэй дэлгэрчээ. Үүний зэрэгцээгээр бурхны шашны ном судрын хамт анагаах ухааны нилээд зохиол манай оронд орж иржээ. Монгол оточ нарын гол гарын авлага болж байсан “Жүдши” номыг төвдөөр нь хэрэглэж байсны зэрэгцээ монгол хэлэнд орчуулж олон дахин хэвлэсэн байна. Гэхдээ энэ номыг хэдийд хэн гэгч хүн анх орчуулсан болох нь тодорхойгүй үлджээ. Германы эрдэмтэн Хайссиг бичихдээ “Жүд ши”-г XIV зууны үед Чойжи-Одсэр орчуулж дараа нь Лигдэн хааны /1604-1634/ үед дахин завсарлан орчуулсан болно гэжээ. Сүүлд нь Ойрдын Галданцэрэн хааны /1727-1745/ үед тод үсгээр олон хувь барласан байна. Бидний үе хүртэл дамжиж ирсэн орчуулгын төгсгөлд “Судар тарнийн ухааныг олонтоо сонссон их буяны садан Минжүүр цорж төвдөөс монголд орчуулав” гэсэн аж. XVI зууны сүүлчээр Монголын ууган оточ Данзанжанцан

одоогийн Баянхонгор аймгийн Баянзүрх сумын нутагт 1685 онд эмчийн сургууль байгуулан суралцагчдад зориулан анагаах ухааны дөрвөн үндсийн барыг шинээр хийлгэж олноор барлажээ. Ийнхүү “Анагаах ухааны дөрвөн үндэс” ном монгол орноо уламжлагдан ирж уг номонд тухайн үеийн монгол эмч нар тайлбар хийх, агуулга санааг улам баяжуулсан ном зохиолууд олныг бүтээх болжээ. Монгол оточ нар дээр дурьдсан Лувсанданзанжанцанг монголын ууган оточ гэж нэрлэх болсон бөгөөд түүний бичсэн эмийн номыг сургууль бүхэнд заавал зааж сургах зарчмыг тогтоожээ. XIV зуунаас XX зуун хүртэл монголчуудын зохиож бүтээсэн уламжлалт эмнэлгийн ном зохиолууд энэ мэт нилээд байгаа бөгөөд манай уламжлалт анагаах ухаан судалдаг орчин цагийн номтой оточ доктор Ц.Хайдав, Ч.Баавгай, доктор Б.Болдсайхан, Н.Дашзэвгэ, доктор Г.Давгацэрэн нар судлан шинжилж олны хүртээл болгож байгаа хийгээд болгохоор чармайсаар байна. Энэтхэгээс төвдөд уламжлан ирсэн эртний анагаах ухааны сурвалж бичгүүдийг монголчууд улам баяжуулан зохих хувь нэмрийг оруулснаар ардын уламжлалт эмнэлгийн баялаг сан хөмрөгтэй болжээ.(31) Мал эмнэлгийн уламжлалын талаар Халхын сайн ноён хан аймгийн Үйзэн вангийн хошууны Мэргэн бандида хувилгаан хэмээн нийтэд алдаршиж ирсэн арван боть сүмбүмтэй, соёлын их зүтгэлтэн Шагдарцэвээний Цэвэлванчугдорж /1836-1894/-ийн “Малчин сүсэгтэн тэргүүтэнд тус хүргэхэд үйлдэх учир мал сүргийг тэтгэх дараалал нугуудаас нийт хийгээд ялгал ямаа, хонь, тэмээ ба хайнаг, үхэр, морины өвчнийг засахын аймаг болой” хэмээх зохиол болой. Мөн тэрчлэн утга зохиол, хэл шинжлэлийн салбарт төвдийн өөрсдийн мэргэдээс дутуугүйгээр тэргүүлэх бүтээл туурвиж байсны жишээ нь Алшаагийн

Агваандандарын зохиосон “Төвд хэлний зүй”-н номыг нь одоо болтол Лхасын төвдүүд болон Дармасалагийн төвдүүдийн дунд дахин дахин хэвлэн сурах бичиг болгон хэрэглэсээр байгаа явдал юм. Доктор Ц.Шагдарсүрэн энэ тухай “Төвд бичгийн хэлний хөгжил хийгээд их бага таван ухааны салбарт монголчуудын оруулсан бодтой хувь нэмэр их байсан гэдгийг төвд, энэтхэгийн бичгийн их хүмүүс хүлээн зөвшөөрсөөр ирсэн байна.” хэмээн онцлон дурьдсан.(32) Ингэж төвдөөр зохиол бүтээл туурвих заншил манай үеийг хүртэл үргэлжилж иржээ. Буддын соёлыг даган төвд хэл Монголд нэвтрэхдээ колоничлолын хэлтэй адил хүчирхийллийн замаар биш, бараг цэвэр гэж хэлж болох оюун санааны хөрсөн дээр дэлгэрсэн билээ. Энэ учраас төвд хэл нь монголчуудын нийгэм, улс төрийн амьдрал, монгол хэлний оршихуйд тодийлөн сөрөг нөлөө үзүүлээгүй, харин ч зарим талаараа эерэг нөлөө үзүүлжээ. Энэ үед Ганжуур, Данжуур зэрэг Энэтхэг, Төвдийн шашин, шинжлэх ухааны хөлгөн их судруудыг монгол хэлнээ орчуулж, монголын бичиг номын мэргэд бүтээл туурвилаа төвд хэлээр бичиж байх явцад төрөл бүрийн шинжлэх ухааны монгол нэр томъёо боловсрон хөгжсөн байна.(33) Бөөгийн мөргөлтэй жишиж үзэхэд бурхны шашин XVI зууны монголын аж байдалд тодорхой хугацаанд соён гэгээрүүлэх үүрэг гүйцэтгэжээ. Бөөгийн мөргөлийн зэрлэг бүдүүлэг зан үйлийг халж өөрчлөхийн хамт монголын тал нутагт Энэтхэг, Төвдийн соёлын зарим ололтыг авчран дэлгэрүүлсэн байна. Тархай бутархай монголчууд нэгэн шүтлэгтэй болсноор оюун санааны барилдлагаар холбогдож зарим үед тэр нь тэдний улс төрийн талаар нэгдэхэд нь чухал хүчин зүйл болж байжээ. Бурхны шашныг хүлээн авсан нь овгийн байгууллын үеийн үлдэцийг устгахад нөлөөлсөнөөр барахгүй

монголын нийгмийн феодалжих процессыг цаашид түргэтгэсэн байна. Шарын шашин нь монголчуудын соёл боловсролын амьдралд томоохон үйл явдал байлаа. Санскрит, төвд хэлнээс шашны олон судар номыг орчуулсан нь монгол бичиг соёлын хөгжилд үлэмжхэн түлхэц болсон байна. Монгол хэлнээ хөрвүүлсэн ном судрын дотор зөвхөн шашны төдийгүй төр ёсны, шинжлэх ухааны зохиол багагүй байсан бөгөөд тэдгээр нь их, бага алин боловч монгол хүний оюуныг нээгдүүлэх тусыг үзүүлсэн байна. Монголчууд эрт дээр цагаас төвд, санскритын олон ухааны ном зохиолыг орчуулж ирсэн баялаг уламжлалтай бөгөөд одоогоор дээрх хэлнүүдээс 6000 гаруй номыг эх хэлэндээ орчуулсныг 10-аад жилийн өмнө Энэтхэгт болсон төвд, санскрит ном орчуулагчдын их хурал дээр энэтхэг эрдэмтэн албан ёсоор зарласан. …Өнөөдөр дэлхий дээр манайхаас өөр ийм олон номыг төвд, санскрит хэлнээс эх хэлэндээ орчуулсан орон дэлхийд байхгүй байна. Энэ нь төвд, санскрит орчуулгын төв үнэндээ манай эх оронд байна гэсэн үг юм.(34) Энэтхэг, Төвдийн соёлын нөлөөгөөр Монголд үндэсний урлаг, утга зохиол хөгжиж, хүрээ хийдийн хөгжлийг дагалдан уран барилга, гарын урлал тэргүүтэн ихэд хөгжиж дэлгэрсэн байна. Ийнхүү бурхны шашин нь тодорхой хугацаанд соён гэгээрүүлэх түүхэн үүргээ биелүүлж, монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцлийн зарим үед зохих хэмжээний эерэг үйлдлийг үзүүлж байсан.(35)

Бичиг үсэг сурах, сургахын хувьд бурхны шашин хүчтэй нэвтэрхийн хирээр XVI зууны хоёрдугаар хагасаас төвдийн бичгийн хэл монгол бичгийн хэлтэй эн зэрэгцэн гарч ирж, аажимдаа шашин суртахуун, шинжлэх ухааны асар их ном судар, засаг сүм хийдийн хүчтэй түрэлт, дэмжлэгтэйгээр монгол бичгийн хэлтэй эн зэрэгцэх давамгайлах байрыг эзлэх болсон

байна. Энэ үеийн монгол орны байдлыг Финляндын монголч эрдэмтэн Рамстедт “Монгол бичгийн хэл, Халхын Хүрээний аман аялгуу хоёрыг харшуулан шинжилсэн бичиг” хэмээх номдоо “Бүр хожим үеэс шарын шашин монгол газар дангаараа ноёрхож монголчуудын аж амьдралын завсар болгонд нэвтрэн шингээд, монгол ардын бичиг үсгийг боловсрол, хөгжлийн хэрэглүүрийн хувьд огтхон ч хэрэгцээгүй болгоод оронд нь төвд ном зохиолыг эрдэм сурах, дэвшин дээшлэхийн ганц зам болгожээ. Ийм байдлаас болж өдгөө Монгол бичгээ сайн мэддэг гэхийг байя гэхэд ядаж монгол хэл цагаан толгойгоо мэддэг хүн тун ч ховор тохиолдох болжээ. Гэтэл бүх эрчүүдийн 5/8 хувийг эзлэх лам нар цөмөөрөө төвд ном зохиолыг буюу наад зах нь төвд цагаан толгой, ойр зуурын хэдэн төвд уншлагатай байдаг. Монголтой гэдэг тийм хүн ч гэсэн ганц үг зөв бичээд арван үгийг алдаатай бичдэг байна”(36) гэжээ. Энэ тухай Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн Б.Я. Владимерцов ч ажиглан тэмдэглэсэн зүйл буй. 30 жилийн өмнө эрдэмтэн Пагва “Төвд үсгээр үгчилсэн монгол ном зохиол” хэмээх бүтээлдээ ”Монгол нуган хөвүүд 5-6 наснаасаа хийд, сүмд шавилан сууж юу юуны түрүүнд төвд цагаан толгой заалган түүнийгээ бодисадын мөрт эн тэргүүний тангаргийг олох ганц зөв зам хэмээн үздэг байсан тул монгол бичигт суралцахын бололцоо үгүй байв. Төвдийн бичгийн хэлэнд нэвтэрхий мэргэжсэн монгол хүн хэдэн арван жил төвдийн бичиг зохиолд нас биеэ зориулаад монгол бичгээ сурахыг эрмэлзэх нь цөөн байв”(37) хэмээн дурдсан байна. Гэвч цагаан толгой төдийхөнийг мэддэг ламаас авахуулаад төвд бичгийн хэлэнд мэргэжсэн бичгийн хүмүүст хүртэл харилцааны гол хэрэглүүр болсон хэлээ бичгээр илэрхийлэх шаардлага аяндаа гарч иржээ. Энэ тухай эрдэмтэн Пагва “Төвд хэлний үг, хэллэгийн утга учрыг

мартахгүйн тул, орчуулгы нь хадахдаа монгол бичиг мэдэхгүй учир төвд үсгээр үгчилж тэмдэглэх нь аргагүй шаардагдав" хэмээсэн байна. Одоо бидний үед хүрч ирсэн төвд үсгээр монгол хэлээр бичсэн төвдийн гүн ухаан, уран зохиол, шашны зохиол, төвд монгол толь зэрэг олон арван ном бүтээл нь үгчилж бичих явдал нийтэд өргөн дэлгэрч байсны баталгаа болж байна. Д.Кара "Монголын нүүдэлчдийн ном"-доо Ишдоржийн толь, аман зохиолын зүйлс, лам нарын сэтгүүл гарч байсныг товч дурьджээ. Эдгээр салбарын ном судрын доторх хуучирсан үгс, хатуу үгсийг түүвэрлэн авч тайлбарлан орчуулсан дүймэн хэмээх түүвэрлэсэн нэрийн ном олон болсон байна. Үгчилсэн зохиолын тоо, нэр төрөл улам улмаар олширч сүм хийдийн данс хараа, хувийн захидал бичгээс авахуулаад гүн ухаан, уран зохиол, шашны ном судар, тэрчлэн ардын аман зохиолын зүйл ч үгчлэн тэмдэглэх болжээ. Энэ уламжлалын ёсоор ардын хувьсгалын дараа 30-аад онд намын төв хорооны тогтоолоор төвд үсгээр монгол хэлээр лам нарт зориулсан лам нарын сэтгүүлийг гаргаж байсан билээ. Энэ тухай "Лам нарт зориулж тусгай сонин гаргах явдлыг эрхэлж гүйцэтгэвээс зохих бөгөөд энэхүү сонины зорилго болбоос лам нарыг улс төрийн хүмүүжлээр хүмүүжүүлэхэд оршино. Үүнийг хоёр долоо хоногт нэгэн удаа монгол хэл дээр монгол ба төвд үсгээр гаргаж болно" хэмээн тодорхой заажээ.(38) Жишээ болгож ерөөлч Гэлэгбалсангийн наадмын ерөөлийг оруулав.

Баяр бэлгийн магнайд

ཡ་ཡང་ལེ་ལེག་གི་ཏིང་མག་ནས་དུ།

Барилдахын наадам нь

པ་རིལ་དུ་ཉའིང་ན་ཀ་དམ་ནི།

Бахтай сайхан хэмээлцэхэд

པ་ཉ་ཐས་ས་འི་ཉང་ཉེ་མེལ་ཚེ་ཉ་དུ།

Бага настай залуучууд нь

པ་ཀ་ན་ས་ཐས་ཅ་ལྷ་ཚྭད་ཀི།

Бариу давчуухан зодгуудыг чинь

པ་རི་འ་ད་བ་ཆི་ཉང་ཅོ་དོ་ག་འ་ད་དུ་ཆི་ཀི།

Багтаж ядан өмсөлцөөд

པག་ཟླ་ཇི་ལ་དང་འ་ལྷ་མ་ཞེལ་ལྷེད།

Барьж даасан засуул нь

པ་རི་ཇི་ད་ཀག་ས་ང་ཅ་སུལ་ལུ་འད་ཀི།

Баруун зүүн талаас нь

པ་རུ་ད་ཙུ་འད་ཐ་ལྷ་ས་ཀི།

Бараа бараагаар нь тавилцаад

པ་རུ་པ་རུ་ཀྱི་ཐ་པི་ལ་ཚྭད།

Бачим түргэн дэвэлцээд

པ་ཆི་མ་ཟླར་གེང་དེ་པེལ་ལྷེད།

Барилцсан төдийд давалцаад

པ་རིལ་ཚག་སང་ཐུ་དུས་དེ་ད་པལ་ཚྭད།

Байнга тогтмол идээгээн хүртээд

པའིང་ཀ་ཐོག་ཐ་མལ་འི་དེ་གེའེང་ཁྱར་ཐེ་གེད།

Бараг төлөв гүйцэлдэж байх нь

པ་ར་ཐ་ཐུ་ལྷབ་གྱས་ཆེལ་དེ་ཅི་པས་ཀ་ཀི།

Хойгуур урдуур сөнгөөн тавьж

ཧོས་ཀུར་འུར་དུ་ར་སྱང་ཀྱུའང་ཐ་པི་ཅི།

Хонин шүүс идээгээн өрж

ཧོ་ཀིང་ཤུ་སེ་ཐེ་འི་དེ་གེང་འུ་རུ་ཅི།

Хол хэтийн барааг харалцаж

ཧོ་འེ་ཧེ་ཐེའིང་པ་རུ་གི་ཧ་རལ་ཆ་ཅི།

Холч морийг аялан дуулж байтал

ཧོ་འེ་ཆི་མོ་རི་གི་འ་ཡ་ལང་དུ་ལ་ཅི་པས་ཐལ།

Тэнд эндээс дуудалцаад


ཐེང་དེ་འེང་དེ་ས་དུ་དལ་ཚྭད།

Тэргүүн морь нь айсуй хэмээхэд

ཐེར་ཀྱང་མོ་རི་ཀི་འས་སུས་ཧེ་མེ་ཧེ་དེ།(39)


Төвд үсгээр үгчлэн бичих энэ ёсны тухай Б.Я.Владимерцовоос гадна Лигети, профессор Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн нар зохиол бүтээлдээ заан дурьдсан байдаг. Энэ ёсны гийгүүлэгч болон эгшиг авианы тэмдэглэх байдлын талаар эрдэмтэн Т.Пагва болон МУИС-ийн багш Л.Чулуунбаатар нарын судалгаанууд буй болой. Эрдэмтэн Т.Пагва дээр дурдсан бүтээлдээ энэ үгчлэх байдлын тухай тодорхойлон бичиж төвд үсгийн монгол дуудлагыг монгол авианы байдалтай харьцуулан шинжилсэн нь судалгааны эрхэм зүйлийн эхлэл болсон юм. Мөн монголын эгшиг авиаг төвдийн эгшиг авиагаар хэрхэн тэмдэглэснийг товч төдий үзүүлэн латин галигаар зарим үсгийг хадмаллан үзүүлсэн. Гэвч хадмаллан оноогоогүй болон латин галигаар зарим үсгийг галигласан нь төвд цагаан толгой мэдэхгүй судлагч төвд үсгээр үгчилсэн ном зохиолыг уншин судлахад тусалж чадахгүй юм. Дашрамд хэлэхэд хуучин монгол бичиг болон төвд хэл, төвд үсгээр үгчилсэн ном зохиол зэргээс эш татахдаа тэр үсгээр нь буулган авах нь хойч хойчийн судлагчдын судлан шинжлэхэд дөхөмийг үзүүлж уг зүйлийг эхээр нь хадгалан үлдээх ач холбогдолтой. Бусад галигаар буулгах нь буруутай бус боловч тэр галигаар бичсэнээс эргүүлээд тэр үсэгт буулгахад буруу буулгаж тэр зүйлийн утга агуулгыг андуу болгох талтай.

Төвд хэл таван эгшигтэй бөгөөд “а” гэсэн эгшиг нь үндсэн гийгүүлэгчтэйгээ ямагт хамт хэлэгдэнэ. Нөгөө дөрөв нь гигү буюу ི/и/, шабжу буюу ུ/ү/, дэнбү буюу ེ/э/, наро буюу ོ/о/ эдгээр болой. Эдгээр нь монгол хэлний долоон а, э, и, о, ү-тэй дүйцнэ. Ингэж ч дүйцүүлэн үгчилсэн байна. Гэтэл ө, ү, авиалбарыг тэмдэглэх үсэг хэрэгтэй болсон байна. Эрдэмтэн Т.Пагва “Монгол хэлний “ө” авиаг голдуу “ou”, “u”, “eu” гэж тэмдэглэсэн

үзэгдэнэ” хэмээн тэмдэглэжээ. Энэ нь , гэж бичсэн үг

юм. Үүнээс гадна бас “ө”-г хэмээн үндсэн үсгийн дор васарт

үсгийн үсэгт зүүдэг хэлбэрийг зүүгээд мөн дор нь дахин шабжу зүүж тэмдэглэсэн нь Гэлэгбалсангийн “Наадмын ерөөл” зохиолд тааралдаж байна. “У”-г тэмдэглэсэн байдлыг эрдэмтэн Т.Пагва васарт үсгийн зүүдэг хэлбэрээр голдуу тэмдэглэсэн хэмээн дурджээ. Энэ нь  ийм хэлбэртэй. Гэвч Гэлэгбалсангийн зохиол,

лам нарын сэтгүүлүүдэд энэ авиалбарыг  хэмээн

өөр өөрөөр тэмдэглэсэн мөртлөө хойшхи үед нарийн ялгаагүй бичсэнээс болж ийм олон янз болжээ. Үүнийг эрдэмтэн Т.Пагва “хуучин монгол бичгийн о, у, ө, ү авиалбарыг хоёр үсгээр тэмдэглэдэг болон монгол нутгийн олон аялгууны о, у, ө, ү эгшгийг хутгах нь түгээмэл байснаас шалтгаалсан” хэмээн зүйтэй дүгнэсэн байна.

Богино эгшгийг үгчилснийг хүснэгтээр үзүүлбэл:

Богино эгшиг / Зохиолч	а	э	и	о	у	ө	ү
Гэлэгбалсан “Наадмын ерөөл”							
Ишдорж “Төвд монгол толь”							
Лам нарын сэтгүүл 1937							

Эрдэмтэн Т.Пагва “Хуучин бичгийн хэлний дуудлагын дагуу үгчлэн бичсэн газар урт эгшгийг аяндаа тэмдэглэх хэрэгцээ гараагүй байна” хэмээгээд bayiɣsan хэмээх хуучин монгол үгийг spas-ˑag-san гэж үгчилсэн жишээ татжээ. Ийм жишээ Гэлэгбалсангийн зохиолд наадам - ནཱ་ག་དམ /на-га-дам/, Идоржийн төвд монгол үгчилсэн тольд гадаад - གད་གཱ་དུ /гад-гаа-ду/ гэх мэт олон арав байна. Энэ нь аман бичгийн уламжлалыг дагасан гэж үзэх талтай боловч эдгээр зохиолчид уг хуучин монгол бичгээ сайн мэддэг байсан бөгөөд тухайн үеийн манж чин улсын бодлогын улмаас болон олон зуун мянган хүн төвд үсэг мэддэгийг бодолцон тэднийг энэтхэг төвдийн эрдэм ухаан, уран зохиолын яруу сайхантай танилцуулах эх оронч сэтгэлийн үүднээс төвд үсгээр үгчлэн зохиол бүтээлээ бичиж байжээ гэж үзэж болох талтай. Мөн тухайн үсгийн дээр эгшгий нь бичээд ард нь бас шанаган а / ཱ /-г эгшигтэй нь давхарлан бичиж тэмдэглэ-жээ. Эрдэмтэн Т.Пагва “Яриа хэлний дагуу үгчилсэн газраа урт эгшгийг хоёр үсэг давхарлан тэмдэглэсэн байв” хэмээсэн боловч ямар үсгийг яаж давхарлан бичсэнийг үзүүлээгүй нь харамсалтай.

Урт эгшгээр үгчилснийг үзүүлбэл:

Богино эгшиг / Зохиолч	аа	ээ	Ии	оо	уу	өө	үү
Гэлэгбалсан “Наадмын ерөөл”							
Ишдорж “Төвд монгол толь”							
Лам нарын сэтгүүл 1937							

Хос эгшгийг тэмдэглэсэн байдлыг авч үзье.

Эрдэмтэн Т.Пагва “зохих эгшгийн ард шороон “са” залган “as”-аар ай, “os”-оор ой, “us”, “es”-ээр эй-г тэмдэглэх” зэргээр тэмдэглэсэн нь арвин байна. Түүнчлэн “ямар нэгэн эгшгийн ард “gigu” залгаж “ai”-ай, “oi”-ой, “ui”-үй гэх зэргээр тэмдэглэсэн нь ч мөн хааяа тохиолдож байна” хэмээжээ. Монголчууд дахин ордог дагаврыг хос эгшиг ай мэт дууддаг тул ямар нэгэн эгшигтэй гийгүүлэгчийн араас бичиж урт эгшгийг - ай, - ой, - үй хэмээн тэмдэглэсэн нь олон байна. Харин гигү буюу /и/-г залгаж бичиж урт эгшгийг тэмдэглэсэн нь ховор бөгөөд уул

эгшигтэй гийгүүлэгчийн дараа ི /и/-тэй шанаган “а”-г давхарлан бичиж үзүүлсэн нь арвин байна. Жишээлбэл: ай-г□ི, эй-г □ེ, үй-г □ྲི гэх мэтээр бичжээ.

Хос эгшгийг үгчилсэн байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

Богино эгшиг / Зохиолч	ай	эй	ой	уй	үй	иу
Гэлэгбалсан “Наадмын ерөөл”	འདས □ས □ནི		□ོས	□ུས	□ྱས	□ཀྱུ
Ишдорж “Төвд монгол толь”	□ནི འདས	□ེ	□ོནི □ོས	□ིནི □ོས	□ྱེ	
Лам нарын сэтгүүл 1937	□ས □ནི		□ོནི	□ྱི	□ ས	

Чингэвч зарим номд жишээлбэл: “Долоон гаригийн мэрэг болой” དོ་ལོང་ཀར་གེ་མེད་གི་བོ་ལས།། хэмээхэд урт хос эгшгийг огт тэмдэглээгүй дан төвдийн таван эгшгээр монгол хэлний бүх эгшгийг үгчилсэн байна. Энэ ялдамд гийгүүлэгчийн үгчилсэн байдлыг дурдвал: б-ད, в-ཝ, га-ག, г-ག, д-ད, з-ཟ, л-ལ, м-མ, н-ན, нг-ང,

п-ᡯᠠ, р-ᡵᠠ, с-ᡯᡳ, т-ᡨᡠ, ч-ᠴᡳ, ц-ᠴᡠ, ш-ᡧᡳ, я-ᡭᠠ хэмээн оноосон байна. Төвд үсгээр үгчлэх зарчим алгуур нарийсан сайжирч байсан боловч тусгай дүрэм, бичиг байгаагүй, гагцхүү уламжлалаар тогтсоор ирсэн учир хөдлөшгүй зарчим бүрмөсөн тогтож чадаагүй бөгөөд зохиогч бүр өөрийн оюуны хэрээр онолдуулан бичиж байсан байна. Ийнхүү монголчууд төвдөөр олон арван зохиол бүтээл туурвихын зэрэгцээ төвд үсгээр монгол хэлээр зохиол бүтээл зохиож мөн хоорондоо бичиг захидал солилцон харилцааны хэрэглүүр болгож байсан нь нийт олныг хамраагүй боловч төвд үсэг мэдэх хүмүүсийн хоорондын харилцааны хэрэгцээг хангаж явцуу хүрээнд бичгийн хэлний үүргийг гүйцэтгэж байжээ.

Үндэсний бичиг соёлоо хөгжүүлж байсан эрдэмт мэргэдийн хажуугаар энэ мэт төвд үсгээр ном зохиол үгчлэн бичиж, гэгээрч амь албаны бичиг зохиол бичилцэн солилцож байсан хийгээд төвдийн цагаан толгой мэдэж наад захын хэдэн маань төвөггүй уншдаг байсан тэр хүмүүсийг бичиг үсэгтэн хэмээн тооцоход тухайн цагт монголчуудын нийт олонхи нь бичиг үсэг мэддэг бичигтэн ард түмэн байжээ.


▪3. Галиг үсгийн үүсэл болон Монголд бурхны шашны соёл дэлгэрэхэд түүний гүйцэтгэсэн үүрэг /Али Гали үсэг/

Монголчууд түүхэн хөгжлийнхөө туршид үсэг бичгийн арав гаруй тогтолцоог хэрэглэж ирсэн бөгөөд бараг тэр болгоны нийтлэг нэгэн онцлог гэвэл төвд, самгарьд, хятад, түрэг, орос зэрэг олон хэлний нэр томьёо болон бусад шаардлагатай хэрэглэгдэхүүнийг тухайн хэлээр тэмдэглэж чаддаг галиг үсгийн тусгай хэсэгтэй байсан явдал билээ. Энэ нь эрт цагаас манай монголчууд олон хэлний ард түмний соёл боловсролыг эрх тэгш хүндэтгэж, монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсэг нь ч олон ард түмний бие биесээ баяжуулах соёлын өвөрмөц зууч болсоор байсны нутлагаа буюу.(40) Бурхны шашин монголд дэлгэрсний улмаас монголчуудын зан заншил ахуй амьдралын олон зүйлд төвд үгс нэвтрэн орохоос гадна сүм хийд болон онгон шүтлэгтэй уул усны нэрийг төвдөөр нэрлэж, эхлээд хутагт хувилгаад хийгээд цаашдаа жирийн хүний нэр хүртэл төвдөөр нэрлэх болсон нь тэдгээр нэрсийг монголоор зөв буулган бичих хэрэгцээг буй болгосон юм. Монголд төвд хэл шашны хэлний үүргийг гүйцэтгэж монгол утга зохиолын хэлийг түрэн гаргах шахаж, үүгээрээ төвд хэл монгол утга зохиолын зарим үүргийг гүйцэтгэдэг болоод, хүн амын дотор түүний дэлгэрэхийн шалтгаан болж, ардын ярианы хэлэнд ч төвд үг нилээн орж, газар усны нэр ч төвдөөр нэрлэгдсэн нь олонтой болжээ. Энэ үеийн монгол бичгийн хэлэнд самгарьд, хятад, төвд зэрэг гадаад хэлний үг ухагдахуун, нэр томьёо олноор нэвтрэн орсон нь тэр бүхнийг нарийн зөв тэмдэглэн бичих шаардлагыг буй болгожээ. Гэтэл урьд зөвхөн монгол хэлний үг авиаг тэмдэглэхэд зориулан зохиосон 123 үсэг нь тэрхүү шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байлаа. Тийм учраас Харчины Аюуш гүүш гадаад үгийг

тэмдэглэх галиг үсгийг анх зохиосон бөгөөд хожим XVIII зууны дундуур гүн Гомбожав түүнийг цааш дэлгэрүүлэн нэмж зассан билээ.(41) Монгол үсэгт эл галиг үсэг нэмэн зохиосноор даруй шинжлэх ухааны нарийн тэмдэглэл хийх үсэг бүрдэж Аюуш гүүшийн зохиосон галиг үсгээр энэтхэг, төвд үсгийг нарийн тэмдэглэх болсон нь хожуу хойно Европын эрдэмтэн энэтхэгч, төвдөчийн зохион боловсруулж латин галиг хийсэнтэй зарчим яг ив ижил. Энэтхэг Төвд үсгээр бичсэн зүйлийг Аюуш гүүшийн галигаар тэмдэглэх нь Европын латин галигаар тэмдэглэх лүгээ ширхэгийн ч зөрөөгүйг үзэхэд сонин бөгөөд монголчуудын энэтхэгийн судлал, төвдийн судлал тухайн үед өндөр байсныг гэрчлэн үзүүлж, XVI зууны үеийн хэлний шинжлэлтэн Аюуш гүүш европ нөхдөөсөө бараг 200-гаад жилийн өмнө галиглах зарчмыг монгол үсэгтээ хэрэглэсэн байнам. Аюуш гүүшийн энэтхэг үсэг тэмдэглэх галиг үсэг нь энэтхэг, европ хэлтэн бүгдийн үг үсгийг тэмдэглэхэд нэгэн адил хүрэлцээтэй бөгөөд Энэтхэгээс үлгэр авч Томи Самбадаагийн VI-VII зууны үед зохиосон төвд үсгийг нарийвчлан тэмдэглэхэд бүрэн тохирохоор үл барам нангиад үг үсгийг бас нарийвчлан тэмдэглэх бололцоотой болж өгсөн учир, эл галиг үсэг мэдэх хүн Энэтхэг үсэг түүнээс үндэслэн Бирм, Камбож зэрэг улсын үсэг, төвд үсэг, нангиад үг, Нангиадаас утга үсэг авч хэрэглэсэн буюу хэл төрөл бүхий улс Вьетнам, Лаос, Солонгос, Япон зэрэг улсын үг үсэг тэмдэглэхээс гадна энэтхэг хэлний үсэг авиа тэмдэглэх үсэг бүрдсэнээр цаашлаад Энэтхэг европ хэлтэн гэж одооны хэлний шинжлэлд үздэг европын олон улсын хэрэглэдэг латин үсэгтэн бүх улсын үг үгсгийг тэмдэглэх нарийн үсэг Аюуш гүүшийн ачаар бүрдсэн билээ.(42) Европ нөхдөөс өмнө байсан гэдгийн баталгаа Буриадын эрдэмтэн Б.Д.Бадараевын “Об основах транскрипции и транслитерации


для Тибетского языка” хэмээх номд байна. 1720-оод онд Иртыш мөрний эрэг дээр орших Аблайн-Хит хэмээх хуучин хийдийн нуранган дооройос модон барын ганц хуудас төвд бичвэр олджээ. Энэ тухай Зөвлөлтийн нэрт дорно дахин судлаач А.И.Востриков тэмдэглэн бичихдээ: “Петр I хааны номын санч Шумахер энэхүү ганц хуудас бичгийн учир утгыг олохоор Европын нутгийн энд тэндгүй хэрэн явж тухайн үедээ “Дэлхийн нийслэл” хэмээн алдаршиж байсан Парист очиж төвд хэлийг буулган бичдэг авианы хийгээд үсгийн ямар нэгэн галиг үсэг олоогүйгээр үл барам төвд хэл, бичиг гадарладаг ганцын төдий ч хүнийг үл олон арга мухарджээ. Хожим нилээд хэдэн жилийн дараа алдарт жуулчин, Сибирь судлаач, түүхч Миллер энэхүү Аблай-Хитээс олдсон бичээсийг буриадын бурханы шашны хийдийн хамба, Цонголын дуганыг үндэслэн байгуулсан алдарт цорж ламтан Агваан-Пунцагт өргөн барихад бурханч ламтан бичгийг төвд хэлнээс монгол хэлэнд монгол галиг үсгээр буулган бичиж өгснийг монголгүй Миллер дотнын анд Петр Смирновт үзүүлж, уул бичгийг монгол хэлнээс орос хэлэнд орчуулган, орос үсгээр галиглуулан бичиж авсан байна. Үүнийгээ 1747 онд латинаар галиглан бичиж хэвлүүлжээ. Ийнхүү төвд хэлт бичвэрийг монгол, орос хэлээр дамжуулан буулгаж латинчилсан түүхтэй бөгөөд төвдийн бурханы шашны ном зохиол монгол хэл, монгол галиг, монгол бичгээр дамжиж Европ дахинд түгэн дэлгэрчээ. Аюуш гүүшийн галигийг хожмын хэлний шинжлэлтэн, монголын төвдөч эрдэмтэн нар ашиглаж харь үсгийг түүгээр тэмдэглэн бичсэн сонгодог олон толь бичиг зохиосон нь Монголын дорно дахины судлалд чухал үүрэг гүйцэтгэж, хожмын эрдэмтэдийн шинжлэн судлах их өв болон үлджээ. Аюуш гүүш санскрит үсэг болон төвд

үсгийг галиглах галигийг тус тусад нь зохиожээ. Санскрит үсгийн галиг нь:



эдгээр болой.

Төвд үсгийн галиг нь:



эдгээр болно.

Аюуш гүүш бол тухайн үеийнхээ хэлний шинжлэлийн гүн мэдлэгтэн байсан учир санскрит, төвд хоёр хэлний адил бичлэгтэй боловч авиалбарын хувьд нарийн ялгаатай үсгийг

шинжлэн мэдэж санскрит хэлний ཛ-г ཇཱ aap, ཛཱ -г ཇཱ aap, төвд хэлний ཛ-г ཇཱ aap, ཛཱ-г ཟཱ aap тус тус тэмдэглэн ялгасан байна. Аюуш гүүшийн өөр нэг онцгой ажигласан зүйл бол монгол хүнд нэгэн ижил авиалбараар дуудагдах ཇ་ཧ /жа/ ཟ་ཧ /за/ - дөрвийг үгийн утга ялгах дөрвөн өөр авиалбар юм гэдгийг мэдсэн явдал юм. Чингээд монгол хэлэнд ж, з-г үгийн эхэнд ཇཱ -аар, үгийн дунд ཛཱ -аар тэмдэглэдэг эртнээс аваад Чойжи-Одсэрээс инагш уламжилж ирсэн энэ хоёр дүрсээр гол болгон ཇ -г ཇཱ, ཇ -г ཇཱ, ཟ -г ཛཱ, ཟ -г ཛཱ хэмээн дөрвөн ялгаатай тэмдэглэн өгчээ. Учир нь төвд хэлний үсэг ཇ-г ཇ орлохгүй, үсэг ཟ -г ཟ орлохгүй бөгөөд үгийн утга ялгах тус тус бие даасан авиалбарын үүрэгтэй юм. Мөн монгол хэлэнд хоёр өөр авиалбараар дуудагдах боловч нэг дүрсээр тэмдэглэдэг ча, ца авиалбартай тохирох ཆ་ཧ хоёрыг, энэ хоёрыг тэмдэглэдэг үндсэн дүрс ཅཱ -г ашиглан ཆ -г ཅཱ, ཚ -г ཙཱ хэмээн ялгажээ. Үүнээс гадна монгол хүн ижил дуудлагаар дууддаг ཤ་ཡ /ша/, ཟ་ཡ /са/ дөрвийг дээрхийн адил утга ялгах авиалбарын

онцлогыг харгалзан ཅ ཿ བ ཤ хэмээн ялган тэмдэглэсэн байна. Ингэсэн нь ижил дуудлагатай олон үсгийг үсэгчлэн буулгахад огт андуурах явдалгүй болгож төвд үгийг монгол үсгээр тэмдэглэх бэрхшээлийг бүрэн арилгажээ. Аюуш гүүшийн галиг үсгээс 60-аад жилийн дараа Ойрадын Заяа бандида Намхайжамц тод үсгийг зохиохдоо төвд үсгийг галиглах галигийг давхар зохиосон байна. Чингихдээ төвдийн 30 гийгүүлэгчийг галиглах байдлыг Аюуш гүүшийн галигласнаар бараг хэвэээр хэрэглэж གཙང་ гурван үсгийн галигийг ཁཉ བཉ ཏཉ болгон өөрчлөн галиглажээ. Мөн зарим зүүлтэт үсэгт өөрөөр хандаж ཀྱ зүүсэн үсгийг төвдийн зүүдэг хэлбэрийг хэвээр нь зүүж тэмдэглэсэн байна. Жишээлбэл: ཀྱ үсгийг ཀྱ гэх мэт. Намхайжамц ойрад монголын аялгуунд тааруулж тод үсгийг зохиосон болохоор төвд үсгийг галиглахдаа эл аялгуунд тохируулж зарим зүйлийг өөрчилсөн нь ойлгомжтой юм. Түүнээс хойших үеийн эрдэмтэд жишээлбэл: “Төвд монгол дохионы бичиг нэр, үг, утга гурваныг тодотгогч оршвой” хэмээх төвд монгол толь зохиосон Гирдбазар буюу Дагвадорж, “Төвд, монгол дохионы бичиг нэр, үг, утга гурваныг тодруулан харанхуйг арилгагч зул оршвой” нэрт төвд, монгол толь зохиосон Сумади Раднаа буюу Лувсанринчин нар Аюуш гүүшийн галиглах байдлыг ёсчлон дагаж хэрэглэж иржээ. Жишээлбэл: Гирдбазарын тольд ཙཁ་དན་ хэмээх үгийг ཙཁཧྲཱི་ དྲྀ хэмээх үгийг ཙཁཿ хэмээн галигласан байна. Сумадираднаагийн тольд ཙཾཀོ་ར хэмээх


үгийг ཀཱཏྱཱཡན་ ཀྱཱཏ་ хэмээх үгийг ཀཱཏྱཱཡན་ хэмээн буулгасан байдаг. Гэвч эдгээр эрдэмтэд болон зарим модон барын төвд үсгийг галигласан галиг, бичмэл галигуудад ཏ་ хоёр үсгийг ཏྲ་ хэмээн ганц үсгээр тэмдэглэсэн байх юм. Энэ нь энэ хоёр үсгийн адил дуудлагыг харгалзсанаас бус үгийн утга ялгах авиалбарын онцгой үүргий нь ажиглаагүй байна. Нэг үсгээр хоёр авиаг тэмдэглэсэн энэ алдаа хойшхи үеийн эрдэмтдэд давтагдсан нь харамсалтай. Харин энэ хоёр эрдэмтэн төвд үсгийн ཀ་ཁ хоёрыг ཀྵ་ ཀྵ་ хэмээн Аюуш гүүшийн адил зөвөөр тэмдэглэн бичжээ. Гэтэл сүүлийн үеийн манай эрдэмтэдийн бүтээлд ихэнх үсгийг зөвөөр буулгасан боловч ཀ་ཁ་ཅ་ཏ་ཐ་ зургаан үсгийн галигийг Аюуш гүүшийн галигаас өөрөөр янз бүр галигласан нь үзэгдэх боллоо. Профессор Ц.Дорж 1961 оны “Төвд хэл бичиг дор суралцах дэвтэр” номдоо ཅ үсгийг ཙྪ་ -аар, ཇ үсгийг ཛྷ་ -аар галиглаж энэ хоёр үсгийн галиглах байрыг сольжээ. Энэ нь Дорж багшийн санамсаргүй алдаа буюу хэвлэлийн алдаа байж болох талтай. Учир юун хэмээвэл уг номын өмнөх оршлын үгэнд гарч байгаа སྤྱོད་བཟང་སྨན་པོ། ལགས། хэмээх үгнүүдийг ཤཱཀྱཐུབ་ ཐུབ་ ཤཱཀྱཐུབ་ ཅཱཀྱ་ хэмээн зөв буулгасан байх юм. Мөн ཀ་-г ཀྵ་, ཁ་-г ཀྵ་ хэмээн Аюуш гүүшийн төвд үсгийг галигласныг авалгүй, санскрит үсгийг галигласныг

авч бичсэн байна. Эдгээр алдаа нь 1967 оны Б.Д.Бадараевын “Об основах транскрипции и транслитерации для тибетского языка”, 1978 оны Д.Чойжилсүрэнгийн “Монгол хуучин бичгийн цагаан толгой, зөв бичих дүрэм”, 1979 оны С.Мөөмөөгийн “Монгол хэлний авиа зүй”, 1986 оны Чой.Лувсанжав, Ж.Лувсандорж нарын зохиосон “Монгол бичиг” номуудад давтан орсон байна. Мөн 1964 онд зохиосон Б.Ринчин зохиосон “Монгол бичгийн хэлний зүй” номд ཨ་ үсгийг ཨཱ -аар, ཨི་ үсгийг ཨཱི -аар галиглаж Заябандида Намхайжамцын төвд үсгийг тодоор галигласан байдлыг хуулан авчээ. Бас ཡ་ཁ хоёр үсгийг Ц.Дорж профессорын адил авсан байна. Эдгээр алдаа нь 1981 онд Ц.Шагдарсүрэнгийн бичсэн “Монголын үсэг зүй”, 1986 он Чой.Лувсанжав, Ж.Лувсандорж нарын “Монгол бичиг”, 1995 онд Ш.Чоймаа, Д.Бүрнээ нарын бичсэн “Төвд хэл бичигт суралцах дэвтэр” номуудад давтан орсон байна. Санскрит үсгийн галигаар ཡ་ཁ хоёр үсгийг ཉ ཉ хэмээн галигласан нь хоёр хэлэнд байдаг хоёр үсгийг андуурахгүй таньж чадах боловч эдгээр үсгээр бичиж, дээрх алдаатай монгол галигаар буулгасан төвд үгийг уншаад санскрит үг хэмээн андуу бодох муу талтай. Галигийн байрыг сольсон Ц.Доржийн энэ алдаа нь монголоор галиглан бичсэн үгийг төвдөөр буулгахад өөр үсгээр бууж үгийн утга өөрчлөгдөхөд хүрэх юм. Жишээ нь: དཔལ་ཆེན་ཏོག་ гэснийг төвдөөр үсэгчлэн буулгавал རྡེ་བཙུན་དམ་ཚི། болно. Гэвч энэ үг ийм бус


རྗེ་བཙུན་དམ་པ། байх ёстой юм. Энэ нь дуудлага өөрчлөгдөхгүй боловч үгийн утга өөр болно. Б.Ренчингийн галигласан байдал тод үсгийн зүйлд тааралдахаас бус төвд үгийг монгол галигаар бичсэн зүйлд тааралдахгүй байна. Хэдийгээр галиглах ёсыг улам тодорхой болгох оролдлого гэж үзэх талтай боловч өмнөх үеийн эрдэмтэдийн 400-гаад жилийн турш мөрдөж ирсэн галиглах ёсыг зөрчиж тэдний зохиол бүтээлийг судлах, монгол галигийг төвдөөр буулгах зэрэгт эндүү гаргаж болох талтай юм. Мөн хоёрдахь анхаарлаа хандуулбал зохих андуутай зүйл бол төвдийн ཨ་ зүүсэн үсгийг монголоор галигласан байдаг юм. 1960 оноос хойших манай эрдэмтэдийн бүтээлд эл үсгийг галигласан байдал бас л олон янз байна. Аюуш гүүшийн зохиосон галиг үсэг буюу хожмын мэргэдийн хуулж бичсэн хадмал гар бичмэл хуулбар, модон барын “Төвдийн гийгүүлэгч 30 үсэг хийгээд дөрвөн эгшиг оршвой” хэмээх жижиг судруудад ཨ་ зүүсэн үсгийг доорхи байдлаар галиглажээ.

ཀ་ ཁ་ ག་ ང་ ཅ་ ཆ་ ཇ་ ཉ་ ཏ་ ཐ་ ད་ ན་ པ་ ཕ་
ཀ ཁ ག ང ཅ ཆ ཇ ཉ ཏ ཐ ད ན པ ཕ
བ་ མ་
བ མ

Профессор Ц.Дорж 1961 оны “Төвд хэл бичигт суралцах дэвтэр” номынхоо 73-р нүүрт:



гэж галиглаад 138-р хуудсанд мөн эдгээр үсгийг



гэж галигласан байна.

Эхнийхдээ ཀྲ་ ཁྲ་ གྲ་ үсгийг ཏྲ ཐྲ དྲ гэж буруугаар галиглажээ. 138-р хуудасны галиг бүгд зөв боловч ཙྷ үсгийг ཚ г галигалдаг ཏྲ -аар ཚྲ үсгийг ཙ -г галигалдаг ཏྲ -аар буруу галиглан андуу гаргасан байна. Ц.Шагдарсүрэнгийн 1981 оны “Монголын үсэг зүй” номд эдгээр үсгийн заримыг жишээ болгон галиглахдаа дараах байдлаар бичжээ.



/124- р талд буй/.

Хэрэв эдгээр галигийг төвдөөр үсэгчлэн буулгавал ཀྲད་ཅན་གྲབ་ཆུབ болон бууна. Энэ нь Аюуш гүүшийн галиглах зарчмаас ихээхэн зөрж үгийг огт өөрөөр ухаарахаар болжээ.

Мөн Чой.Лувсанжав, Ж.Лувсандорж нарын зохиосон 1986 оны “Монгол бичиг” номд Бодисадва хэмээх төвд үгийг хуучин монголоор галиглах байдлыг ཨཱརྱ་ བྷཊ་ ཊ་ ཏ་ (ཨཱརྱ་བྷ་ཊ་) ཨཱཙཱརྱཱཎཱ (ཨཱཙཱརྱ་ཎཱ) хэмээн хоёр янзаар галигалсан байна. Эхнийнх нь зүүсэн

үсгийг үсэгчлэн галиглах тод монголын галиг юм. Ренчин доктор Монгол бичгийн хэлний зүй номынхоо 165-р талд Ойрдын Заябандидагийн төвд үсгийг тодоор галигласан байдлыг үзүүлээд ᠳᠥᠩᠭᠦᠷ хэмээх төвд үгийг тодоор ᠥᠩᠭᠤᠷ хуучин монголоор ᠥᠨᠭᠤᠷ ᠭ хэмээн галиглаж жишээ татсан нь буй. Хоёрдугаар хэлбэр болох ᠥᠨᠭᠤᠷᠢᠨ᠋ хэмээх нь монголооос дүрс авч бичиг үсгээ зохиосон манж нарын төвд үгийг галигладаг байдалтай төсөөтэй байна. Жишээлбэл: ᠳᠦ-г манжаар галиглахдаа ᡩᡠᠨ᠊ хэмээн таван хэлний тольд бичжээ. Манж нар монгол галигийн зарчимд хүрч чадаагүй тул төвд нэг үсгийг янз янзаар бичих зэргийн дутуу боловсруулсан зүйл манж бичгийн баримтанд үзэгддэг хэмээн Б.Ренчин доктор дурдсан байдаг. Үгийг тэмдэглэх Аюуш гүүшийн нарийн галигийн зэрэгцээ зөвхөн монгол үгээ тэмдэглэж, галиггүй цагаан үсгийн төдийхнийг мэдэх түшмэл бичээч, үсэг барагтайхан мэддэг хүмүүсийн мэдлэгэд тохируулан дуудлага дагуу ойртуулсхийн бичдэг бас нэг ёс байсан байна. Б.Ренчин доктор энэ тухай ”Монгол бичгийн хэлний зүй” номдоо: “Тэр ёс нь санскрит, төвд нэртэй хүний нэрийг бичих албан бичиг, амин харилцааны захидал зэрэг аж төрөх байдалд дэлгэрээд уг үсгийн дагуу тэмдэглэх нарийн журам, дуудлага дагуу тэмдэглэх бүдүүн журам хоёулаа бие биедээ саад харшгүй зэрэгцэн өөр өөрийнхөө зүйлд зэрэгцэн оршисоор ирж нэг нь хөлгөн судар ном, нөгөө нь амь албаны бичиг харилцааны хүрээнд хэрэглэгдэж байлаа” хэмээн дурдсан нь буй. Төвд үсгийг монголоор галиглах Аюуш гүүшийн галиглах зарчим хэл шинжлэлийн нарийн үндэстэй бөгөөд европын

галиглах системтэй яг таардаг онцлогтой учир цаашид бичгийн мэргэд галиглахдаа энэ зарчмыг баримтлаж учрыг олох ёстой болж байна. Энэ нь авианы бус үсгийн галгийн тухай ярьж байгаа үг юм. Харин Ж.Баянсан, Ш.Одонтөр нарын 1995 онд зохиосон “Хэл шинжлэлийн нэр томьёоны зүйлчилсэн тайлбар толь”-д Аюуш гүүшийн галигласан хэлбэрээр алдаа мадаггүй зөв бичиж оруулсан нь цаашид суралцах оюутан, судлаач нарт зөв чигийг зааж өгөх буянт ажил болжээ гэдэгт гүнээ талархан байнам. Али Гали хэмээх галиг үсгийн систем зохиогдсон нь сүм хийд болон онгон шүтлэгтэй уул усны нэр, хутагт хувилгаад болон бурхдын нэр, ном судрын нэрсийг монголоор зөв буулган бичих хэрэгцээг бүрэн хангаж монгол бичгийн хөгжилд шинэ үеийг бий болгосон юм. Харин авианы галигийн систем тэр бүдүүн журам дотор байгаа бөгөөд үүнийг цаашид нарийн судлууштай.

▪4. Тод бичиг (Зая-бандида Намхай Жамц)

XVII зууны дөчөөд он бол монголын тусгаар тогтнолын түүхэнд түгшүүртэй үе байлаа. 1635 оноос эхлэн Баатархун тайжийн улс төрийн эрх нөлөө өсөж, шинэ байгуулагдсан Зүүнгар улсын эзэн болсон байна. Баатар хун тайжийн улс төрийн дотоод, гадаад бодлого нь шинэ мандсан Ойрад улсыг бэхжүүлж, монгол угсаатны нэгдсэн чармайлтаар харийн түрэмгийллийг эсэргүүцэн тулах, Оростой улс төр, эдийн засаг ялангуяа худалдааны найрсаг харилцаа тогтооход чиглэгджээ. Тэр үе Ойрадын дотоодын дайн самуун намжин, төвлөрсөн засаг батжиж, аж ахуй нь сэргээд цэргийн хүчний хувьд сүрхий бэхэжжээ. Энэ үе бол Манж Чин улсын булаан эзлэгчид Өвөр монголыг эзлэн авч Халх, Зүүн гарыг заналхийлж байсан үе юм. Тэр үед Халх, Зүүн гарын ноёд өөрсдийн дотоодын бутрал самууныг намжааж, харийн түрэмгийлэгчдийн эсрэг нэгдэн тэмцэх оролдлого гарч байсан билээ. 164О оны 9-р сард Халхаас засагт хан, Түшээт хан биеэр, Цэцэн ханы хоёр хүү, Хөх нуураас Гүүш хан, Ижил мөрнөөс Хоо өрлөг, Зүүн гарын Эрдэнэ баатар хун тайж, Очирт тайж зэрэг нэртэй томхон ноёд Зүүнгар улсын нутаг Тарвагатайд хүрэлцэн ирж чуулаад “Дөчин дөрвөн хоёрын их цаазыг” тогтоосон байна. Энэхүү “Их цаазын“ нэгдүгээр зүйлд Монгол, Ойрад хоёрын нэгдлийн тухай зүйлийг оруулсан байна, “Алив хүн энэ төрийг эвдэн, их аймаг улсыг алж талж авбал монгол ойрд хоёр нэгдээд түүнээс ганц биеий нь тавиад, биш бүхнийг цөм авч, тавигчид хагасыг нь өгөөд үлдсэн хоёр хагасыг авах болов“(42) гэжээ. Мөнхүү хуулийн дараачийн зүйлүүдэд харийн дайсныг /Манжийн түрэмгийлэлийг/ сэргэмжлэх асуудлыг чухалчлан заасан байна. “Монгол Ойрадод дайсан ирвэл хэл өг. Тэр хэл сонсож байж захын их ноёд эс

ирвэл зуун хуяг, зуун тэмээ, мянган адуу авах. Бага ноёд эс ирвэл арван хуяг, арван тэмээ, зуун адуу авах болов”(43) гэжээ. Цааш нь “Их дайсныг үзэж сонсож байж эс хэлбэл үрийн үр хөөж алъяа, талъяа”(44) гэж тогтоосон байна. Энэхүү Халх ойрадын нэгдлийг ихэд анхаарсан 164О оны “Их цааз”-ыг хэн санаачилж зохиосон бэ гэдэг асуудлын тухай эрдэмтэн түүхч И.Я.Златкин бичихдээ уг хуулийн эх нооргийг зохиож чуулганыг зарлан хуралдуулагч нь Зүүн гарын хан Баатар хун тайж мөн бололтой гэжээ.(45) Бас 164О оны ноёдын чуулганыг Халх, Хөх нуур, Ижил мөрөнд бус Зүүн гар улсын нутаг Тарвагатайд хийсэн явдал бол Баатар хун тайжийн санаачилсан гэдэг баримтыг батлах нэмэлт зүйл болохыг түүхч И.Я.Златкин бичсэн байна.(46) Намхайжамц Ил Тарвагатайн чуулганд оролцож “Их засаг”-ийг батлахад байлцсан хийгээд тэнд Халхын ноёдын сэтгэлийг татаж, дараа жил нь Засагт хан, Түшээт хан, Цэцэн хан нарт залагдаж ном тавьж байжээ. 1642 онд ойрадод буцаж ирсний дараахан 1645 онд Ижил мөрний халимагт зочилж байсан нь түүний намтраас тодорхой байдаг. Тийм болохоор Тарвагатайн чуулганд Намхайжамц оролцсон хийгээд Баатар хун тайжийн удирдлагаар уг хуулийг гардан зохиолцсон хийгээд бичиг хэргийн ажлыг гардан гүйцэтгэлцсэн хүн байж болох талтай байна. Чуулганы дараа Халх, Ойрад, Халимагт зочилж байсан нь даруй уг гэрээний шийдвэр биелэлтийг баталгаажуулах, цаашид дэлгэрүүлэн түгээх ажил хийж явсан бололтой. Энэ үед ноёд түшмэдийн хооронд болон гэрээ боловсруулах зэрэгт нийт монгол даяар монгол бичиг нэн өргөнөөр хэрэглэгдэж байсан болой. Зүүнгарын улсыг байгуулсан явдал бол дөрвөн ойрадыг нэгэн жолоонд нэгтгэн үйлдвэрлэх хүчнийг урагш хөгжүүлж, шашин соёлыг дэлгэрүүлэхэд их түлхэц болсон юм. Ойрадын

Зая бандид Намхайжамц /1599-1662/ 1648 онд тод үсгийг зохиосон явдал үүний нэг гэрч юм. Тод үсгийг Зүүнгарын дипломат харилцаа хийгээд бичиг соёлын хэрэгцээнд болон Дөрвөн ойрадод зориулан зохиосон мэт боловч түүний зохиосон “Үсгийн найрлага” хэмээх цагаан толгойд “Омог монгол улсын хувьтанд” зориулан зохиосон гэж бичсэн болохоор монгол туургатныг нэгтгэсэн цагт нийт монгол даяарын бичиг болгохыг зорьж байсан бололтой. Тэрээр дөрвөлжин үсгийг зохиосны адил харийн үсгээс үлгэр авсангүй бөгөөд монгол үсгээ тодорхой болгож ярианы хэлэнд ойртуулсан тод үсэг зохиох чигийг баримталжээ. Тод үсэг хэдийгээр Ойрадын дотор ч монгол бичгийг шахан гаргаж чадаагүй боловч Зүүнгарын улсын дотоод нэгдлийг бэхжүүлэх, түүний оюуны боловсролын хэмжээг дээшлүүлэхэд дөхөм үзүүлсэн бөгөөд Баруун монголын соёлын түүхэнд гарсан нэгэн дэвшил байлаа. Тэрээр Юань гүрний үеийн төвдийн мэргэн багш Пагва ламын дөрвөлжин үсэг зохиосноос 379 жилийн дараа анх удаа монгол хүн дуун ухааны онолыг гарамгай эзэмшин үсэг бичгээ засан сайжруулж амьд ярианы хэлэнд ойртуулах оролдлого байсан хийгээд хожмын олон бичиг үсэг зохиогдон гарахын орон болсон билээ. Ойрадын аялгуунд тохирох шинэ цагаан толгой зохиосноор ойрадын бичгийн хэл буюу утга зохиолын хэл хөгжих үүслийг тавьжээ. Түүний олон жилийн хөдөлмөр бүтээл нь ойрадын бичгийн хэлийг хөгжүүлэн өргөжүүлэх үндэс суурийг буй болгохын төлөө хүчин зүтгэж байсныг илтгэн харуулж байна. Үүний тод баримт нь тэрээр өөрийн шавь нарын хамт 1650-1662 оны хооронд гол төлөв бурхан шашны холбогдолтой 177 ном зохиолыг төвд хэлээс орчуулан тод үсгээр буулгажээ. Мөн түүний шавь нар багшийнхаа үүсгэсэн үйлийг цааш үргэлжлүүлж 37 зохиол нэмэн

орчуулжээ. Эдгээр орчуулгын зохиол нь бараг төлөв Манжийн эзлэн түрэмгийлэгчдийн хөл үймээнээр үрэн таран болж үлдсэн цөөн нь одоо Монгол улсын Хэл зохиолын хүрээлэн, Улсын номын сан, Ховдын багшийн дээд сургууль, хувь хүн болон Санктпетрбург хотын номын сан, Улаан-Үүд хотын монгол, төвд, буддын судлалын хүрээлэнгийн монгол номын сан хөмрөгт хадгалагдаж байна. Намхайжамцын шавь нар орчуулга хийгээд зогсоогүй багшийнхаа намтрыг бичсэн нь ойрадын утга зохиол өргөжихөд чухал хувь нэмэр болсон байна. Ингэснээрээ дундад зууны үед бусад улс гүрний утга зохиолын нэгэн төрөл болж байсан хувь хүний намтар буюу аж байдлын төрөл зүйл Ойрадын утга зохиолд шинээр буй болохын эхлэлийг тавьсан байна. Энэхүү намтрыг түүний дотнын шавь Раднабадра бичжээ.(47) Шашны зүтгэлтэн нарын бусад бичмэл намтартай төстэй энэхүү намтар анх төвдөөр зохиогдоод хожим ойрад болон монгол хэлэнд орчуулагдсан байх гэж академич Б.Ренчин үзсэн байна.(48) Энэ таамаглал нь Зая Бандида өөрөө төвдөөр бичдэг, шавь нар нь ч энэ хэлийг төгс эзэмшиж байснаас үзэхэд үндэстэй байж болох юм. Ер нь ариун хэл гэж тооцогддог байсан төвд хэлээр шашны гэгээнтнүүдийн намтрыг бичдэг байсан уламжлал ч зохих нөлөө үзүүлсэн байж болох үндэстэй юм. Огторгуйн далай Намхайжамц бол Баруун монголын их соён гэгээрүүлэгч, бурхны шашны сонгодог боловсролтон, энэрэнгүй үзэлтэн байв. 1599 онд Дөрвөн Ойрадын нэр нөлөө бүхий язгууртан Баавханы 5-р хүү болон мэндэлжээ. Равжамба Зая Бандида уг гарлаараа Ойрадын Гөрөөчин отгийн Шангас овогт хүн юм. Тэрээр 17 насандаа Манжшир хутагтаас гэцлийн санваар, 19 насандаа Богд ламаас гэлэнгийн сахил хүртжээ. 1616 онд Цастын оронд /Төвдөд/ очиж цанидын номд 20-иод жил

суралцан, зуугийн равжамба цол хамгаалсан ажгуу. 1639 оны намар Монгол нутагтаа эргэн ирээд 1662 он хүртэл Монгол орны нийгэм, улс төр, шашин, соёлын амьдралд идэвхийлэн оролцож улс орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах, шарын шашныг дэлгэрүүлэх, соёлыг хөгжүүлэх талаар нилээд их зүйл хийж, шашин номын үйлийг ихэд тэтгэжээ. Үүний зэрэгцээ Халимаг, Ил тарвагатай, Алтайн зүүн гарын нутгаар явж, шашин номын ёсыг номлож,, шашны үйлст ихээхэн хүчин зүтгэжээ. Зая бандидын намтарт, “Найман түм 4 мянган номын цогцийн утгыг нарийн гүн ухаанаар дотроо сайтар хичээн оруулж, нармай олон сайн хувьтны үндсэнд ялган үзүүлэгч наран мэт шажныг тодруулагч Равжамба Зая Бандида” гэсэн буй. Тэр “Алтангэрэл”, “Жадамба”, “Банзрагч”, “Цагаан шүхэрт”, “Үлгэрийн далай”, “Мөрийн зул”, “Төв дор орохуй”, “Эрдэнэ шастир” зэрэг шашин суртахууны олон зохиол орчуулсан хийгээд номын их багш хүний хувьд Ойрадын их хүрээний дэргэд номч мэргэдийн дуун хөрвүүлэг, эрдэм ухаанд сургах “Бичгийн сургууль”-ийг байгуулж Раднаабадраа, Эрх Цорж буюу Огторгуйн ялгуусан билэгт, Ачит Цорж, Нанс нарын билэг оюун хурц, бичиг номын мэргэдийг төрүүлэн гаргасан юм.(49),(50),(51) Ховдын Багшийн Дээд Сургуулийн багш Жамъянгийн хуулбарлан авсан тод үсгийн цагаан толгойг энд хавсаргав.

▪5. Өндөр гэгээн Занабазарын Соёмбо болон Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний соёл, түүхийн хүрээнд гүйцэтгэсэн үүрэг

Өвөрмонгол Манжид эзлэгдэж харийн түрэмгийллийн аюул нөмрөн ирсэн үед Халхын зарим ноёд хүчээ нэгтгэж, манжийн эсрэг тэмцэх, арга зам сүвэгчлэх болов. Ойрадын ноёд ч тэднийг дэмжжээ. Үүний тод илрэл нь Ойрадын Баатар хутайжийн санаачлагаар 1640 оны Халх, Ойрадын ноёдын чуулган хийж, цаазын бичиг баталсан явдал юм. Халхын том ноёд хүн ардын оюун санааны нэгдлийг хангахын тулд Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг Халх Монголын шарын шашны тэргүүнд өргөмжлөв. Тэрбээр түүхэнд анхдугаар Богд Жибзандамба хутагт буюу Өндөр гэгээн хэмээн алдаршсан билээ. Халхын шашны тэргүүн анхдугаар Богд Жавзандамба хутагт Лувсандамбийжалцан /1635-1723/ буюу “Өндөр гэгээн” хэмээх сонсголон яруу алдар нь хотолд түгээмэл, Монголын бурхны шашны нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч Занабазар Очир Түшээт хан хэмээх, шашин, төр хоёрыг аугаа ихэд тэтгэсэн Гомбодоржийн өргөөнөө Модон гахай жил /1635/ -ийн 9-р сарын 25-ны өглөө өдгөөгийн Өвөрхангай аймгийн Зүйл сумын нутаг “Усан зүйл” хэмээх газар олон гайхамшигт өлзий бэлгэ үзүүлэн мэндэлжээ. Занабазарыг 5 настайд Монголын шашны тэргүүн гэгээний ширээнд залж, Лувсандамбийжалцан алдар өргөжээ. Занабазар шашин номын ёсыг дэлгэрүүлэх үйлсэд ихэд хичээн зүтгэж, олны дунд алдар түгжээ. Бүр хүүхэд ахуй цагаас эрдэм номын мөр хөөж, олон зүйл үсэг бичгийн язгуур санскрит, төвд хэлэнд гийн сайжирчээ. 15 настайдаа Баруун зуу /Лхас/-д морилон Далай ламд шавь орж, суралцсан ба V Далай лам түүнийг Жамъян цоржийн хувилгаан хэмээж Жавзандамба

хутагтаар өргөмжлөн шар торгон шүхэр, тамга шагнажээ. Тэрээр 13 настайдаа “Баруун хүрээ” буюу Шанхын хүрээг байгуулж, мөргөлийн төв болгосон бөгөөд 20 настайдаа 7 аймаг бүхий Их хүрээ, өөрийн нутгийн ойролцоо Хангай ханы Төвхөн нэртэй газар бүтээлийн сүм, 75 настайдаа Хэрлэний зүүн хүрээг байгуулж, Их хүрээний цогчин дуганы зураг төслийг зохиожээ. Жавзандамба нийгэм улс төрийн хэрэгт идэвхтэй оролцон, төр түмэндээ эв эеийг тунхаглаж байсан улс төрийн холч мэргэн бодлоготон, эх оронч бөгөөд Монгол оронд бурхан шашны ёс дэг, зан үйл, хурал номын уншлага, ая дан, горим журмыг тогтоон дэлгэрүүлэх үйл хэрэгт үлэмж гавъяа байгуулан Энэтхэгийн Бурханы шашин, Төвдийн Гэлүгбаагийн шашныг монгол хөрсөн дээр шинэчлэн зохицуулж, цаашид боловсруулан, Монгол Бурхны шашин болгон хөгжүүлсэн шашны нэрт зүтгэлтэн төдийгүй Дорно дахины их, бага таван ухаанд мэргэшсэн, ялангуяа урлахуй хийгээд дуун ухааны эрдэмд гаршсан дахин давтагдашгүй аугаа их авьяас билэгтэн, соён гэгээрүүлэгч, уран барималч, номын мэргэн багш байжээ. Тэрээр хүн төрөлхтний оюуны санд мөнхрөх олон гайхамшигт бүтээл туурвисан билээ. Буддын гүн ухааны тайлбар, шашны зан үйлийн талаар нэгэн боть зохиолыг төвд хэлээр айлдсан ба “Зохист аялгууны” онол ухаанаар зохиол бүтээлээ чимэглэн номлож байжээ. Түүний зохиосон “Соёмбо сүлд” бол 36 жил бясалган бүтээсэн бүтээл бөгөөд Монгол Улс үүрд мөнх тусгаар тогтнон оршиж, шашин ном ариун байх, энэ дэлхийн хүн ард энх амгалан аж төрөхийн бэлгэдэл болох асар гүн утга агуулсан сүлд шүтээн билээ. 1686 онд Энэтхэг ланз үсгээс үлгэр авч түүний зохиосон “Соёмбо бичиг” бол 90 орчим үет үсэгтэй, дүрс хэлбэр төгөлдөр, босоо, хэвтээ аль ч чиглэлээр бичиж болдог, Монгол, Төвд, Энэтхэг

номт гурван хэлээр бичих бүрэн боломжтой, улс төр хийгээд шашин номын тусгай зорилгоор зохиосон үсэг билээ. Улс төрийн учир холбогдол нь Манжийн эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг үндэсний тусгаар тогтнол, өнө мөнхийн бие даасан байдлыг билэгдэж, шашин номын хувьд гэвэл монголын төр шашны бүхий л албан хэрэг хөтлөх, ном хэвлэх, ялангуяа Дорно дахины соёл шинжлэх ухааны бүтээлийг бичиж байх зорилго тавьсан хийгээд номт гурван улсын хэлний үгийг тэмдэглэж чадахуйц бичгийн тогтолцоог буй болгохыг зорьсон нь монгол бичиг үсгийн түүхэнд том байр эзэлж үлдсэн юм. Соёмбо гэсэн нь санскритийн sva-yan-bhu гэдгээс үүссэн бөгөөд “өөрөө гийсэн гэгээн үсэг” гэсэн үг ажээ. Соёмбо үсэг тэр цагийн судлаач нарын анхаарлыг ихэд татаж байсан бөгөөд энэ талаар бичсэн олон ном зохиол бидний үеийг хүрч ирсэн байна. 1952 онд академич Б.Ренчин “XVII зууны монголын үл мэдэгдэх хоёр бичиг” гэдэг өгүүлэл бичиж Унгарын “Acta Oriental” сэтгүүлд нийтэлж соёмбо үсгийн цагаан толгой, барын соёмбо Итгэлийн гэрэл зургын хуулгыг хавсаргаж, дэлхийн монголч эрдэмтэдийн анхааралд толилуулсан билээ. Дараахан нь Лигети соёмбо үсгийн ач холбогдлын талаар “соёмбо үсгээр бичсэн ном байдаг уу гэдгийг нарийвчлан шалгаж үзмээр байна” гэж бичиж байв. Соёмбо үсгээр барласан “Итгэл”–ийн судалгааг 1959 онд Унгарын монголч эрдэмтэн Д.Кара хийсэн байна. 1967 онд Ж.Надмид “Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм” номдоо соёмбо үсэг болон түүгээр бичсэн Итгэлийн хэлний зарим онцлогын тухай бичсэн. Энэхүү Итгэлийн орчуулгын онцлогыг доктор Ц.Шагдарсүрэн 1975 онд судалж хэвлүүлсэн билээ. Хожим 1981 онд доктор Ц.Шагдарсүрэн “Монгол үсэг” номдоо соёмбо үсгийн цагаан толгойн онцлогууд болон түүний тухай тэмдэглэн бичиж 12

номын нэр дурьдсан бөгөөд цаашид судлах зүйлийн онцлогыг заан дурьдсан билээ. Судлаач Отгонбаатар соёмбо үсгээр олдсон материалдаа түшиглэн нилээд хэдэн өгүүлэл бичсэн болой. Соёмбо үсгээр бичсэн дурсгал гагц монгол хэл дээр бус бас санскрит, төвд хэлээр олдож байгаа билээ. Соёмбыг хэвтээ, босоо хоёр янзаар бичдэг байсан бөгөөд бичих горим хоорондоо адилгүй байдаг байна. Соёмбо бичиг зохиогчийн бодож байсанчлан түгэн дэлгэрч чадсангүй зөвхөн сүм хийдийн хаяг, шашны зарим нэг ном зохиолыг бичихээс хэтэрсэнгүй. Энэ бичгээр бичсэн зүйлийн ихэнх нь халх аялгууны онцлогыг хадгалсан байдгийг академич Б.Ренчин онцлон тэмдэглэжээ. Энэ нь энэ үеийн авиан зүйн судалгаа хийхэд үнэт хэрэглэгдэхүүн болох юм. Соёмбо үсэг нь тухайн үедээ утга зохиолын хэлний авиалбарын тогтолцоог дорно дахины хэл шинжлэлийн сонгодог уламжлал, Энэтхэгийн хэл шинжлэлийн арга билгийн зарчим, авиа үсгийн дайсагнах садагнах ёс, таван махбодын онолд тулгуурлан мөнхдөх тасархайдахын хоёр хэтийдэлд эс унан, хамгийн зөв ухаарч, хэдэн зууны дараах хэл шинжлэлийн төвшинд хүртэл хүргэж шийдсэн шинжлэх ухааны үнэ цэнэ байлаа. Энэ бол тухайн үедээ XIV зууны үеийн Сажийн Пагва ламын дөрвөлжин үсэг, XVI зууны Харчин Аюуш гүүшийн али гали үсэг, XVII зууны Хошуудын Зая бандидын тод үсгийн дөхөм ололт бүхнийг багтааж, чухамхүү өмнөх олон зууны турш “Монгол үсгийг засан сайжруулахаар ирэгсдийн” жингийн цувааны сүүлчийн хонхон дууг хол хожмын олон мэргэдийн сонорт хүргэж дэлдсэн хэрэг байлаа.(52) Өндөр гэгээн Занабазарын зохиосон бас нэг үсэг бол соёмбо үсгийг зохиосон тэр цаг үед мөн нэгэн адил зохиосон хэвтээ дөрвөлжин үсэг болой. Энэ үсгийн тухай П.С.Паллас 1803 онд анх дурьдаж

И.Клапрот, Банзарын Дорж, А.Бобровников. А.Уйли нарын бүтээлд “hor-yig” хэмээх нэрийдэн дурьдаж байсан хийгээд 1952 онд профессор Б.Ренчин энэ үсгийн тухай анхны мэдээг шинжилгээнд оруулж Занабазар зохиосон болохыг тодорхой дурьдсан. 1972 онд Д.Кара “Монголын нүүдэлчдийн ном”-доо хэвтээ дөрвөлжин цагаан толгойг авиа зүйн латин галигийн хамт судалгаанд оруулж Ж.Цэвээний цуглуулгаас олдсон нэгэн тамгын дардсыг хавсаргажээ. 1981 онд доктор Ц.Шагдарсүрэн “Монгол үсэг зүй” номдоо судлагдсан байдлыг товч дурьдан цагаан толгойн онцлог тус бүрийг гаргаж А.Позднеевийн уншсан болон Д.Карагийн хэвлүүлсэн тамгийн зураг, мөн шинээр нэг ханын чимэг зургыг Гандантэгчэнлэн хийдийн лам агсан гавж Данзан-Одсэрийн /1907-11978/ цуглуулгаас олж хэвлүүлэн товч тайлбар хийсэн байна.(53) 1997 онд Гандантэгчэнлэн хийдийн лам Р.Бямбаа “Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд” хэмээх ном бичиж хэвлүүлэв. Түүндээ өмнөх эрдэмтэдийн судалсан байдлыг товч дурьдаад Угалзын лам Лувсансодовжамцын /1878-1961/ “Үсгийн номлол тодорхой толь” хэмээх шинээр олдсон төвд хэлээрх зохиолыг уг эхээр нь хэвлэхийн хамт, латин галиг хийн, монгол хэлээр орчуулж, тайлбар сэлтийг хийн судалгааны хүрээнд оруулж, зохиогчийн намтрын хэсгийг тодотгон оруулж өгсөн хийгээд хэвтээ дөрвөлжин үсгээр байгаа 4 дурсгал, санскрит хэлээр байгаа 9 дурсгал, төвд хэлээр байгаа 3 дурсгалыг оруулан тусгай нэг бүлэг болгон хэвлэж тус бүрт нь тайлбар хийсэн нь хэвтээ дөрвөлжин үсгийн судлал, эх бичгийн судлалд төдийгүй монголчуудын утга соёлын түүхэнд тодорхой хувь нэмэр болсон бүтээл болжээ гэдэгт Монголын утга соёл, үсэг бичгийн судлаач эрдэмтэд эргэлзэхгүй байна. Гамшигт хэлмэгдүүлэлтийн дараа

энэ мэтээр монголчуудын бичиг үсгийн түүхэнд холбогдох олон хэрэглэгдэхүүн олдож байгаа нь тэр цагт хичнээн олон зуун сайхан соёлын үнэт бүтээлүүд хувьсгалч нарын гараар улаан галд шатан устаа бол хэмээх харуусслыг өөрийн эрхгүй төрүүлнэ. Энэ хоёр үсгээр уран барилгын чимэглэл хийж байсан нь уран барилгын гоёмсог өнгө төрхийг чимэх болон хээ угалз урлал чимэглэлийн хөгжилд зохих хувь нэмэр оруулсан юм. Өндөр гэгээний “Жанлав Цогзол” хэмээх энх амгалангийн ерөөл нь төвд утга зохиолд ихэд алдаршсан байна. Түүний цутгамал, баримал, зурмал, хөөмөл олон сонгодог бүтээл дэлхийн анхаарлыг татаж, шагших магтахын орон болсоор байгаа билээ. Түүний урлагийн бүтээл нь Ази, Дорно дахины гүн ухаан, үлгэр домгоос эх сурвалжтай монгол үндэстний урлагийн өвөрмөц байдлыг хадгалснаараа онцгой юм. (54),(55),(56)

▪6. Монгол үсгийн үндсэн дээр Манж үсгийг зохиосон хийгээд түүний хэрэглээ. (XVI зууны II хагас–XIX зууны эхэн)

Манж нарын өвөг Зүрчидийн Алтан улс /1115-1234/ их, бага хоёр бичигтэй байв. 1191 оноос их бичгээ бүрэн халсан билээ. Энэхүү их, бага хоёр бичгийг хэл, соёлын өргөн хэлхээт Хятан нарын их, бага бичгээс үүдэн гаргажээ. Хятан бичигт суурилсан үсэг бичгийн зэрэгцээ хөрш зэргэлдээ нангиадын дүрс үсгийг мөн авч хэрэглэж байв. Зүрчид бичгийн дурсгал 40 илүү олдоод байгаагийн хамгийн том дурсгал нь Сэрвэн хаалганы бичээс /Хэнтий, Баянхутаг сум/ юм. Үүнийг 1196 он түүхэн үйл явдлын дурсгалд зориулан мөн жилд бичиглэж босгожээ. Зүрчидийн үсэг бичиг Алтан улсын мөхлөөр цуг халагдсан байна.(57) XVII зууны үе бол Монгол оронд Буддын шашин хүчтэй нэвтэрэн орохын зэрэгцээ Манж Чин улсын хүчирхэгжин мандаж байсан үе байлаа. Шашны соёлыг дагаж бичиг үсгийн соёл шинэ шатанд гарсан хийгээд энэ нь манжийн эхэн үеийн хаадын анхаарлыг зүй ёсоор татаж байв. 1616-1911 оны хооронд оршин тогтнож ирсэн Дайчин /Их чин/ улсын албан ёсны бичиг болох манж бичиг нь монгол бичгээс үүссэн билээ. Манжийн төрийг үндэслэн байгуулагч Нурхачи хааны зарлигаар Эрдэнэ багш, Гагай заргач хэмээх хоёр хүн 159О онд монгол бичгийг манж хэлэнд тааруулан өөрчлөн зохиож 1634 онд албан ёсны хэрэглээнд оруулсан байна. Эрдэмтэн судлаач нар манж бичиг зохиосон энэ хоёр хүнийг монгол хүн байсан гэж үздэг. Эдгээр монгол мэргэд эхэн үедээ монгол бичгийг Манжийн төрийн албанд хэрэглүүлж, өөрсдөө энэ үйл хэрэгт хүчин зүтгэж явсан бөгөөд монгол бичгийн үндсэн элементийг авч нэг үсэгт нэг авиалбар, хос авиалбар тэмдэглэдэг монгол үсэгт дусал бинт нэмэх, гийгүүлэгчийн зурлагыг ялимгүй өөрчлөх замаар манжийн

шинэ үсгийг зохиожээ. Нөгөө талаар Нурхачи хүүхэд ахуй цагтаа монголын баян айлын мал адуулж, монгол хэл тэрчлэн монгол бичиг сурсан нь түүний ертөнцийг үзэх үзэлд чухлаар нөлөөлсөн хийгээд Манжийн олон овгийг нэгтгэж улс байгуулахдаа монгол бичиг мэддэг болон талархдгийн хувьд монгол бичигтэй мэргэдийг урьж төрийн хэрэгт хэрэглүүлэх болсон билээ. Монголчууд шинэ улс гүрэн байгуулахдаа төрийн тусгаар тогтнолын баталгаа болгон шинэ бичиг үсэг зохиодог уламжлал ч энд нөлөөлжээ. 1599-1632 оны хооронд буюу манж үсгийг бүрэн боловсруулж хэрэглэх хүртэл үйлчилж байсан үсгийг дусал бинтгүй бичиг /tongki fuqa xergen-I bidxe/ гэдэг. Уул бичгийг 4 дэвтэр нэгэн иж бичмэл эхийг Corpus scriptorum mongolorum цувралд Б.Ренчин эрхлэн гаргажээ. /Tom V, 1959/ Манж нар тухай бүртээ монголоос үсэг бичиг авч өөрсдийн хэл ярианд зохицуулан хэрэглэж ирсэн нь монгол, манж хэлний ойрын төрөл болдогтой холбоотой.(58) XVII зуунаас XX зуун хүртэл манж, монголын эрдэмтэд Манж-Монгол, Монгол-Манж, Монгол-Хятад-Манж, Манж-Монгол-Төвд-Хятад, Манж-Монгол-Төвд-Уйгар-Хятад гэх мэтийн хоёр, гурав, дөрөв, таван хэлний толь зохион хэвлэн гаргаж байв. Жишээлбэл: “Хааны бичсэн Манж-Монгол-Хятад үгний зүйлийн аялгуу нийлсэн толь бичиг”, “Хааны бичсэн Манж-Монгол үгийн толь” гэсэн 21 дэвтэр толь зэрэг XVIII зуунд хэвлэгдэн гарчээ.(59) Улс төрийн харилцаа, засаг захиргааны албан хэргийн шаардлага зэргээс бичиг үсгийн боловсролтой хүний хэрэгцээ гарч, сурвалжит гэрийн үр хүүхэд, дүү нарыг сургуульд оруулж монгол манж бичиг, манжийн хууль цааз зэргийг заадаг байжээ. Тэр үеийн сургууль нь ард түмний хөрөнгөөр байгуулагдаж байсан боловч дээд ангийн эрх ашгийн үүднээс сурвалжит гэрийн үр хүүхдийг түшмэл болгох зорилгоор

сургадаг байсан бөгөөд сургууль нь нийт олныг хамааруулах зорилго тавьдаггүй байв. Бичиг үсгийн чадвартай хүмүүс цөөн байснаас албаны бичээч нар хомсдож, бичээч болгох зорилгоор бага насны хүүхдийг монгол, манж бичигт сургадаг болжээ. 1767 онд Ховд хотноо хорин хүүхэдтэй бичгийн танхим байгуулж, тэр сургуульд Дөрвөдийн 8, Торгуудын 2, Алтайн Урианхайн 4, Өөлдийн 2, Захчины 2, бүгд 20 хүүхэд суралцаж байжээ. Энэ сургуулийн тухай эрдэмтэн А.М.Позднеев, Грумм-Гржимайло нар өөрсдийн зохиолд тэмдэглэсэн нь бас бий. Бадруулт төрийн үеэс засаг захиргааны албан харилцаа улам нэмэгдсэнээс манж сайдуудын зэрэг газрын албан хэрэгт хятад бичиг их хэрэглэгдэх болж, манжаар бичиглэхийн хажуугаар хятад бичиг, хэл мэддэг хүний хэрэгцээ их болсноос 1898 онд Хүрээ сайдын яамнаа манж хятад бичгийн сургууль байгуулж, Түшээт хан, Сэцэн хан хоёр аймаг, шавиас хөвгүүдийг авч сургах болжээ.

Орос монголын хооронд холбогдсон хэрэг үлэмж байсны улмаас Хүрээн дэх Оросын консулаас Хүрээний газраа орос бичгийн сургууль байгуулж монгол хөвгүүдийг сургая гэх зэргээр хэд хэдэн удаа санал тавьсныг Хүрээний /манж/ сайдууд удаа дараа элдвээр саатуулан өнгөрөөсөн байна. Манж нар монголд оросын соёл нөлөө нэвтрэхээс айн болгоомжилж, хардан сэжиглэж, хяхан хавчиж, орос монгол хоёрыг улс төр, эдийн засаг, соёлын ямар ч харилцаа холбоогүй байлгах гэсэн бодлогыг баримталж байжээ. Тэнгэр тэтгэсний 41 /1776/ онд Хан уулын чуулганы даргаас жасааны бичээч нар нас өтөлж албан хэрэгт зүтгэж чадахгүй болсон зэрэг шалтгаанаас цөөрсний учир хушуу бүрд, тэргүүн, дэд гутгаар зэргийн тайж нар ба албат харцсын хөвгүүдийг бичээч нарт дагалдуулан монгол бичигт сургаж мэдүүлэн ирүүл гэх зэргээр тушаасан ёсоор олон

хушууны газраа бага насны хөвгүүдийг монгол бичигт сургаж байжээ. Тэнгэрийн тэтгэсний 46 /1781/ оноос Хан уулын чуулганы газраас олон хушууны сургуулийн хөвгүүдийн дотроос нас бага хөвгүүдийг сонгон манж бичиг сургахаар тогтоож, жасааны газарт гэр, хөтөл хүн гурван сарын хэрэглэлийн хамт ирүүлэн суулгаж, манж бичиг сургах болжээ. 1785 онд Хан уулын чуулганы даргаас харьяат аймгаас манж бичиг сургахаар 17 наснаас дорогш сурвалжит тайж ба харцсын хөвгүүдээс сонгож 3 сарын хэрэглэлтэйгээр жасааны газраа суулгаж манж монгол бичиг сургаж байжээ.1790 он 6-р сарын 9-нд Хан уулын чуулганы даргаас харьяат жасааны газраа хөвгүүдийг суулгаж манж монгол бичигт сургах нь уул хушуундаа чирэгдэлтэй байна, иймээс жасааны газраа сургахыг байж, хушуу хушуунд нь сургая гэж хичээнгүй сайнаар сургаж, сурсан цагт нь мэдүүлэн ирүүл гэж тушааж байжээ. Хүрээ сайдын яамны газраа манж бичгийн сургуульд хүүхдийг сургаж, хэрэглэл зүйлий нь харьяат хушуунаас нь гаргадаг байжээ. Сайшаалт ерөөлтийн 16 /1811/ онд Хүрээний сайдын яамнаас буухиа замын халхын 14 өртөөний суурь бүгдэд дөрвөн хүнийг монгол бичигт сургатугай гэж тушааснаар заасан тооны хүмүүсийг монгол бичигт сургаж байжээ. Түгээмэл элбэгтийн /1851-1861/ үед Хүрээний сайдын газраас айлтгаж Түшээт хан, Сэцэн хан 2 аймгийн ван, гүн, засгуудын хүүхдээс сонгож тамгын газраа манж бичиг сургаж байжээ. Хүрээний сайдуудаас 1898 он 10-р сарын 1-нд тамгын газраа сургууль байгуулж, 2 аймаг, шавь, ван, гүн, хушууны түшмэд монгол хүний хөвгүүдээс сонгож сургуульд оруулж, манж хятад бичиг сургая гэж айлтгасанд, зарлигаар 1898 оны 10-р сарын 24-нд ёсоор болгожээ. Ингээд Түшээт хан, Сэцэн хан аймгийн ван, гүн, түшмэд, тайж, ард мөн шавийн түшмэд ардын

хөвгүүдээс авч сургуульд сургах болжээ. 1908 он 8-р сарын 16-нд Хүрээний сайдуудаас зөвлөлдөн албан хэрэгт хятад бичиг голлох болж, хятад бичиг, хэл мэддэг хүний хэрэгцээ их болсноос хятад бичиг, хэл мэддэг хүн бэлтгэх зорилгоор Хүрээнд манж, хятад, монгол бичиг үсэг сургах сургууль байгуулж, сурах бичиг нь “Хааны бичсэн дөрвөн зүйлийн үсэг хавсармал толь бичиг”-ийг гол болгон ...сургая гэх зэргээр айлтгасанд ёсоор болгож, “Сурган тэжээх сургууль”-ийг байгуулжээ. Энэ манж, /монгол/ хятад бичгийн сургуулийг 40 хүний оронтой тогтоон, шавиас 14, Түшээт хан Сэцэн хан аймгаас тус тус 13-ыг сонгон авч суулгажээ. Хэвт ёсны 2-р онд Улиастайн сайдаас Улиастайн газраа сургуулийн тэнхим байгуулж Засагт хан, Сайн ноён хоёр аймгаас 40 хөвгүүдийг ирүүлж сургахаас гадна бас өөр өөрийн аймгийн чуулганы даргын газраа тус бүр 30 хөвгүүдийг 2 сарын дотор хуруулж, багш 2 түшмэдийг томилон суулга гэж тушаажээ. Засагт хан аймгийн хушуу цөөн тул сургуулийн хөвгүүн 25 наснаас дорогш 15 наснаас дээш 17 хүнийг сонгон томилж Улиастайн газраа сургуульд суулгая, жич олон хушуунд сургуулийн танхим нэг нэгийг байгуулж бага насны хөвгүүдийг монгол бичигт сургасугай хэмээн Улиастайн сайдаас тушаасныг дагаж, Хэвт ёсны 2 /1910/ онд Засагт хан аймгаас Улиастайн манж, монгол хятад бичгийг хавсарган сургах сургуульд 17 хүнийг томилж, аймгийн чуулганы даргын газраа манж монгол бичиг сургахаар 30 хөвгүүнийг сургасан байна. 1911 оны 1-р сар гэхэд нас бага хөвгүүдийг монгол бичиг сургах сургуулийн танхим Засагт хан аймгийн 20 хошуу, Жалханц хутагт, Ялгуулсан хутагт, Номун ханын шанзудба 3 шавьд байгуулагдаж, бүгд 23 сургагч багштай, 220 хүүхэдтэй байжээ. Хэвт ёсны 3 /1911/ онд Түшээт хан аймгийн хэмжээгээр монгол бичгийн сургуулийн

хүүхэд 23, манж /монгол/ хятад бичгийн сургуулийн хүүхэд 10 байжээ. Сэцэн хан аймгийн хэмжээгээр монгол бичгийн сургуулийн хүүхэд 129, манж /монгол/ хятад бичгийн сургуулийн хүүхэд 12 байжээ. Засагт хан аймагт 7 наснаас дээш сургуулийн хүүхэд 230 байв. Өвөр Монголд ч энэ мэтээр сургуулийн танхим, бичгийн сургууль байгуулж байсан байна. Тухайлбал: Гүнсэнноров ноён 1902 оноос эхлэн харьяат хошуундаа анхны шинэ маягийн сургууль, охидын сургууль, цэргийн сургууль байгуулж Хятад ба Японоос тоо, байгалийн шинжлэл, хөгжим, биеийн тамир, урлаг, гадаад хэлний зэрэг мэргэжлийн багш нар урьж багшлуулах болсноос гадна авьяаслаг Монгол залуучуудыг дотор газар, болон Японд багш, цэрэг, нэхмэл, будаг гэх зэрэг мэргэжлийн сургуульд явуулж байжээ. Тэр харьяат хошуундаа шуудан цахилгаан холбооны газар байгуулан ажиллуулж байсан бөгөөд 1905 оноос сургуулийн танхимдаа сонины хэвлэлийн газар байгуулж “Инбао” гэдэг сонинг чулуун бараар хэвлэн тараах болсон ажээ. Олноо өргөгдсөний тэргүүн онд Хүрээ сайдын яамны манж, /монгол/ хятад бичгийн сургууль тараагүй байсан, харин Улиастайн сургууль нь Улиастайн манж сайдыг хөөн зайлуулах үед тарсан ажээ.(60) Сүүлийн жилүүдэд улсын алба ихсэж бичиг үсгийн чадвартай хүмүүс ихээр шаардагдах болсон тул заавал угсаа төрлийн ноёд гэх шаардлага суларсан байна. Энэ тухай “...төрлийн тайж нар ба албат харцсын дотроос ухаан сайтай, номхон төлөв, бага настай хүн нарыг тамганыхаа газраас сонгон томилж, бичгийн хэрэгт боловсорсон түшмэл бичээч нарыг дагуулан суулгаж чандлан тушааж, хэдэн жилийн дотор эрхгүй бичигт сургагтун” хэмээн амбан сайдын яамнаас тушааж байжээ.(61) Амбан сайдын яам, аймгийн чуулган, хошуу тамгийн газрын бичээчээс гадна нийт монгол дахины 150-иад

өртөө тус бүрт бичээч ажиллаж байв. Эдгээр бичээч нар бүгд монгол, манж бичиг үсэг мэддэг байв. Өртөөний суурийн бичээч нь өртөөлөн явах, элч, албаны хүмүүсийн улаа хэрэглэх эрх олгосон үнэмлэх, зар бичгийг шалган үзэж уул зар бичигт дурьдсан ёсоор улаа хүнс нийлүүлэхээс гадна хэдийд хаанаас ямар албан хэргээр аль газар очих, элч бичгийг нарийн тодорхой бүртгэх хийгээд аливаа элч, бичигт нийлүүлсэн гэр майхан, хүнс уналга, ачлагын тэмээ, улаач хэд хичнээн болохыг тухай бүр бүртгэнэ. Ялангуяа буухиа нэвтрүүлэхэд өөрийн өртөөний газар хэзээ, хүлээн авсан он, сар, өдөр, ямар цагт чухам аль өртөөний хэн гэгч хүнээс авсан хийгээд өөрийн өртөөнөөс аль он, сар, өдөр, цагт хэн гэдэг хүнд хүлээлгэн өгч нэвтрүүлсэн зэргийг маш тодорхой бүртгэж байсан байна. Тэрчлэн аливаа бичиг өртөөгөөр нэвтрүүлэхэд аль өртөөний хэнээс аль он, сар, өдөр хүлээн авсан хийгээд харьяат өртөөний хэнд хүлээлгэн өгч нэвтрүүлсэн зэргийг тодорхой бүртгэж байжээ. Өртөөний занги, бичээч нар өртөөлөн зорчигчдод нийлүүлсэн гэр, хүнс, уналга, ачлагын морь, тэмээ хэд хичнээн болохыг тодорхойлон тайлан цэс үйлдэж өөр өөрийн харьяат захиралд улирал тутам ба жилийн эцэст тогтмол мэдээлж байжээ.(62) Манж, хятад бичгийн сургууль 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж Монгол тусгаар улс болсноор зогссон юм. Одоо манай улсын номын сан болон Улсын төв архивт манж бичгийн тэмдэглэл, албан бичиг данс олон байна. Тэдгээр нь судлах эзнээ хүлээсээр байна.

Гуравдугаар бүлэгт ишлэсэн эх сурвалж болон ном зохиол

1. Ж.Цолоо. Орчин цагийн монгол хэлний авиа зүй. УБ., 1976, х.5
2. Д.Төмөртогоо. Монгол данжуур дахь эртний энэтхэг хэл шинжлэлийн зохиолууд. Монгол ба Энэтхэг. УБ., 1989, х.232
3. Ж.Надмид. Монгол хэл, түүний бичгийн хэлний түүхэн тойм. УБ., 1967, х.88
4. Д.Чойжилсүрэн. Буриад модон барын номын таван гарчиг. УБ., 1959
5. B.Rinchin. Four Mongolian historical records. New Delhi, 1959
6. И.Балжинням. Монгол бичгийн нэгэн гайхамшиг. Засгийн газрын мэдээ, 1993-11-7, №256
7. Б.Жаргалсайхан. Олон жилийн хууч. /Элчин сайдын тэмдэглэл/ УБ., 1997, х.15
8. Ц.Дамдинсүрэн. Монгол уран зохиолын дээж зуун билиг оршибай. УБ., 1959, х.320-335
9. Ж.Ж.Саундерс. Монголын байлдан дагуулал. УБ., 1992, х.21
10. Д.Цэрэнсодном. Монголын бурхны шашны уран зохиол. УБ., 1997, х.23
11. Мөн тэнд х.26
12. Мөн тэнд х.29
13. Т.Содномдаржаа. Монгол ард улсын ном хэвлэлийн хураангүй түүх. УБ., 1965, х.5-14
14. Буддизм. Москва, 1983, с.3
15. Г.Сүхбаатар. Эрт үед бурхны шашин монголын төрийн уламжлалд нөлөөлж байсан тухай. Монгол ба Энэтхэг. УБ., 1989, х.76

16. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 1987, х.195-196
17. Ж.Болдбаатар, Д.Лүндаажанцан. Монгол улсын төр, эрхзүйн түүхэн уламжлал. УБ., 1997, х.114-115
18. Б.Я.Владимирцов. Монгольская литература. Литература Востока, Сборник статей, Вып. II, 1920
19. Ю.Н.Рерих. Тибетский язык. Москва, 1961, с.35
20. Ч.Жүгдэр. З.Агваанбалдангийн гүн ухааны үзэл. Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл, УБ., 1978, х.40-50
21. Ч.Давгадорж. Монголын шашин суртахууны тайлбар толь. УБ., 1995, х.7
21. Монголын уран зохиолын дээжис. I боть, УБ., 1995, х.494
22. Ч.Дагвадорж. Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. УБ., 1998, х.154-155
23. Г.Аким. Диваажинд очихын хувь. х.1-44
24. Ш.Сонинбаярын орчуулга. Монголын их бандид Зава Дамдины намтар цэдэг оршвой.
25. Их бандид Зава Дамдин. /Засгийн газрын мэдээ/, No. 227, 1996
26. Ш.Бира. БНМАУ-ын соёл, түүхийн бичлэгийн асуудалд. УБ., 1977, х.28-29
27. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991, х.18
28. Ч.Баавгай, Б.Болдсайхан. Монголын уламжлалт анагаах ухаан. УБ., 1990, х.30-37
29. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991, х.20
30. Ч.Баавгай, Б.Болдсайхан. Монголын уламжлалт анагаах ухаан, УБ., 1990, х.30-37

31. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991, х.18
32. Б.Сумьяа. Монголын нүүдэлчдийн соёл. Оршихуй, эс оршихуй. УБ.,1998, х.37
33. С.Лочин. Хэлний эзэн хүндэт цол хүртэв. /Үнэн/. 1990-3-18, №59,
34. Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншлийн зарим асуудалд. УБ., 1997, х.28-29
35. Г.И.Рамстедт. Монгол бичгийн хэл. Халхын хүрээний аман аялгуу хоёрыг авиан зүйгээр харьцуулсан нь. Хэл зохиол, 1967, х.1-2
36. Т.Пагва. Төвд үсгээр үгчилсэн монгол ном зохиол. УБ., 1969, х.5
37. Монгол ардын хувьсгалт намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 1966, х.426
38. Ц.Дамдинсүрэн. Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой. ӨМАХХ, 1982, х.1966-1969
39. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991, х.12
40. Д.Төмөртогоо. Монгол хэл шинжлэлийн түүхэн уламжлал ба онолын үндэс. Хэл зохиол судлал, XVII боть, 1-20 боть, х.40
41. Б.Ренчин. Монгол бичгийн хэлний зүй. УБ., 1964, х.99-102
41. К.Ф.Голстунский. Монголо-Ойротские законы 1640 года, дополнительные указы Галдан-хун тайджия и законы, составленные для Волжских кальмыков при калмыцком хане Дондук-даши. Санктпетербург, 1880, х.2
43. Мөн тэнд х.3
44. Мөн тэнд х.4
45. И.Я.Залаткин. История Джунгарского ханства. Москва, 1964,

х.176-177
46. Мөн тэнд х.177
47. Равжамба Зая бандидын тууж сарны гэрэл хэмээх энэ мэт болой. УБ., 1959
48. Равжамба Зая бандидын туужийн хэвлэлийн оршилд. УБ., 1959
49. Ч.Давгадорж. Монголын шашин суртахууны тайлбар толь
УБ., 1995, х.67
50. Б.Батмөнх. Огторгуйн далай. /Ил товчоо/, 1998, No. 26-27
51. Монголын уран зохиолын тойм. II дэвтэр, УБ., 1977, х.250-252
52. Өндөр гэгээн Занабазар. ЭШБ, 1998, Л.Хүрэлбаатар, х.11-12
53. Ц.Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. УБ., 1981, х.98-110
54. Монголын уран зохиолын дээж. I боть, УБ., 1996, х.499
55. Ч.Дагвадорж. Монголын шашин суртахууны тайлбар толь. УБ., 1995, х.48
56. Өндөр гэгээн Занабазар. ШУА, ОУМСХ, Эрдэм шинжилгээний бичиг, УБ., 1998
57. Ж.Баянсан, Ш.Одонтөр. Хэл шинжлэлийн нэр томьёоны зүйлчилсэн тайлбар толь. УБ.,1995, х.60
58. Мөн тэнд х.64
59. Ж.Надмид. Монгол хэл, түүний бичгийн хөгжлийн түүхэн тойм. УБ., 1967, х.89
60. Манжийн дарангуйллын үеийн монголын сургууль. 1776-1911, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, УБ.,1965, х.4-7
61. Мэн тэнд х.10
62. Ц.Насанбалжир. Ар монголоос Манж чин улсад залгуулж байсан алба, 1691-1911, УБ.,1964, х.68

Дөрөвдүгээр бүлэг. XIX-XX зууны үеийн монголчуудын бичиг үсэг түүний халаа сэлгээ.

▪1. Вагиндарагийн үсэг буюу түүнийг зохиогч Агваан Дорж

XIX зууны дунд үеэс Буриад монголчуудын оюун санааны цэцэглэлтийн үе эхэлсэн бөгөөд XX зууны үе болоход улам эрч хүчээ авч Н.М.Хангалов, Ш.Л.Базаров, Г.Цыбиков, Базар Барадин, Цэвээн Жамсран зэрэг нэрт эрдэмтэд төрж гарсныг Д.Кара “Монголын нүүдэлчдийн ном”-доо дурьдсан байдаг.(1) Эдгээр мэргэд нийт монгол туургатны соёл боловсролыг хөгжүүлэхэд нэгэн мөрний хүч болж явсныг Цэвээн Жамсрангийн үйл амьдрал харуулдаг. Тэрээр Богд хаант монгол улсын хэвлэлийн ажлыг үүсгэн байгуулж, “Шинэ толь” сэтгүүл, “Нийслэл хүрээний сонин бичиг” хэмээх сонин гаргаж, түүндээ монгол түмний үндэсний ухамсар, урам зориг, эх оронч үзлийг сэргээхэд чиглэсэн “Хөх Монголын хөх туг”, Финляндын монголч эрдэмтэн Рамстедтийн “Уйгар улсын хураангүй түүх” зэргийг орчуулан хэвлэж, орчин цагийн мэдлэг ухаан, соёл боловсролын үр хөрөнгийг цацан дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэснийг цохон тэмдэглэвээс зохино.(2) Хожим ардын хувьсгалын дараа монгол төрийн үйл хэрэгт зүтгэж, соёл боловсролыг хөгжүүлэхэд болон монголын сэхээтнүүдийг гадаад оронд явуулж бэлтгэхэд их хүчин зүтгэл гаргасан билээ.(3) Монголчуудын бичиг соёлын гарамгай эрдэмтдийн нэг бол Агваандорж /1854-1937 болой. /Российские Монголведы-д 1853-1938 гэжээ/ “Агваан лхарамба”, “Бандид хамбо”, “Цаншав Дорж”, “Цаншав Агваандоржиев” гэх зэрэг нэрээр алдаршсан Агваандорж Буриадын Хорийн талын Хар шивэрт мэндэлж 14 настайдаа Их хүрээнд залран ном

сурсан хийгээд 18 настайдаа 1876 онд Төвдөд очиж Бэрээвэн хийд, Гомон дацанд цанид чойрын сургууль үйлдэн, 1888 онд лхарамбын дамжаа барьж, Буддын номд гүн нэвтэрсэн тэрээр 1889 онд XIII Далай ламын цаншав лам болж арваад жил шадар бараа болсны хувьд Төвдийн засгийн газар, хаант Оросын хооронд зуучилж байсан байна. Тэрээр Орост Далай ламын засгийн газрыг төлөөлж байсан бөгөөд Төв Азийн улс түмнүүд болон Хятад, Англи, Оросын ард түмнүүдийн харилцаанд их үүрэг гүйцэтгэсэн юм. “Цаншав” гэдэг Буддын гүн ухаанд суралцахад туслагч нөхөр бологчийн алдар ажгуу. Агваан лхаарамба Буриадын Бурхан шашны тэргүүн байлаа. Төвд, монгол хэлээр гүн ухаан, яруу найраг, хэл шинжлэлийн хэд хэдэн зохиол туурвисны дотор гол бүтээл нь болох “Бодьсадын явдалд орохуй хэмээхийн тайлбар хувь заяа сайнт” хийгээд 1921 онд “Дэлхийг эргэж бядсан домог сонирхлын бичиг төдий хэмээх” нэртэй өөрийн намтрыг монгол, төвд хэлээр шүлэглэн айлдсан нь ихээхэн алдаршсан болой. Намтар эхлэхдээ:

“Харж үзэгдэх өмнө зүгээс
Хан гарьд жигүүр дэлсэн мэт
Хад давхар цагааны зүүн сугаас
Хар Шивэр хэмээх горхи буусан түүнд
Эцэг Дорж хэмээх ба
Эх Долгор нараас
Эр модон барс жил төрөв
Эртний муу заяаны эрхээр
Гэргий авч 18 насан хүртэл
Гэмт явдлаар цаг нөгцөөв
Гэвч арван дөрвөн насанд
Ар Богдын хүрээний дэд хамбаас

Алгасалгүй увшийн санваар аваад
Архи тамхи тэргүүтнийг
Амин лугаа сацуулан тэвчив хэмээжээ.

Мөн 53 насан дээрээ 1905 оны намар Санктпетербург хотноо монгол, тод үсгээс эх авч буриад болон бусад монгол хэл аялгуу, түүнчлэн орос хэлний хэрэглэгдэхүүнийг тэмдэглэж болохуйц нэгэн зүйл монгол үсэг зохиосон нь “Вагиндрагийн үсэг” хэмээн олонд алдаршжээ. Вагиндрагийн үсэг хэмээсний учир гэвэл зохиогч энэ бүтээлдээ өөрийн төвд нэр Агваан гэдэг үгийг самгарьдаар орчуулан вагиндра хэмээн мутарласан нь явсаар “Вагиндрагийн үсэг” болжээ. Академич Б.Ренчин “Монгол үсгийн зүйлээс уламжлан гарсан үсгийн сүүлч нь” гээд “амин харилцаа, гар бичмэл тэмдэглэл зэрэг зүйлд хэрэглэж, тэдний соёлын хэрэгцээг залгуулж байсан боловч хэвлэсэн зохиол төдий л олонгүй, ерөөс утгазохиолын уламжлалгүй орчинд бага сага хэрэглэгдээд цаашдаа хөгжих нөхцөл эс бүрджээ” гэсэн байдаг.(4) Энэхүү бичгийн онцлог гэвэл монгол, тод үсгийн адил үгийн эхэн, дунд, адагт дүрс хувирдаггүй бөгөөд өрнө дахины бичгийн тогтолцооны нөлөө орсон байдаг. Вагиндра үсэгт нэг авиалбарт нэг үсэг оноож буриад болоод монгол хэл аялгуу, мөн орос хэлний онцлогыг тус тус үсэглэвэрээр ялгаж үзүүлсэн байна. Бичих тогтолцооны хувьд монгол, тод бичиг шиг дээрээс доош бичих бөгөөд угалз хээ мэт зурлага, дөрвөлжин гэдэс, нэмэлт олон тэмдэг зэрэг нь монгол бичиг шиг түргэн бичих боломжийг эс бүрдүүлжээ. Энэ бичгийг хэрэглэж ирсэн хүрээ төдий л өргөн дэлгэр бус. 1905-1910 онд Санкт-Петрбург хотноо чулуун барын арга хийгээд тусгай хэвлэлийн үсгээр нилээд хэдэн товхимол Вагиндрагийн үсгээр хэвлэн гаргажээ. Үүнд “Вагиндра шинэ хуучин үсэг тэргүүтнийг бичсэн дэвтэр оршив”,

“Бурхан багшийн гэгээний хураангүй намтар”, “Буянт хан хөвгүүний намтар оршив” гэх мэт байна. 1908 онд Вагиндрагийн үсгээр “Зүрхэн тольт”-ыг зохион чулуун бараар Санкт-Петрбургт хэвлүүлжээ. Энэхүү хэлзүйн бичгийг бүхэлд нь аваад үзвэл эртний Энэтхэг, Төвд хэлзүйн бичгээс улбаалсан монгол бичгийн уламжлалт зүрхэн тольтууд болон орос зэрэг өрнөдийн хэлзүйн нөлөө аль аль нь туссан монголын урьд үеийн хэлзүйчдийн зохиосон бүтээлээс нилээд өвөрмөц ном болжээ. Дээр дурьдсан намтарт өгүүлснээр Агваан Лхаарамба “Наран” хэмээх хэвлэлийн газар байгуулсан бөгөөд түүнийгээ “Монгол буриад ном бичиг гарах орон” гэж нэрлэсэн байдаг. Чулуун бараар ном хэвлүүлэхээс гадна вагиндрагийн үсэгт сайтар суралцагсадаар зарим номыг хуулуулан бичүүлдэг байсан бололтой. Буриадын ховор номын сан хөмрөгт байгаа “Ухаан сургаж, сэтгэл сайжруулах үлгэрнүүд оршив” хэмээх 33 хуудас номын төгсгөлийн үгэнд “Лхаарамба Агваан Доржийн сургуулийн багш Баярт, Ванпилай хоёр 1907 онд Декабрын 20-нд бичибэ. /Наран/ Монгол буриад ном бичиг гарах орон. Петрград хотод” гэсэн байгаа болой. Номын гарчиг, эх, төгсгөлийн хэсгийг хавсаргав.

Насан залуугаасаа харь холын олон газраар явж юм үзэж нүд тайлсан Агваандорж шинэ үсэг бичиг болон зүрхэн тольт зохиосон явдал нь дорнын буюу Панины хэл шинжлэлийн онолыг өрнийн хэл шинжлэлийн онолтой хослон хэрэглэснээрээ урьд үеийн бичиг үсэг зохиосон мэргэдээс хол давж гарсан хэрэг байв. Үүгээрээ монгол бичгийн хөгжлийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж, нийт буриад хэл аялгууны утга зохиолын хэл бий болгох гэснээрээ шинжлэх ухааны чухал үнэ цэнэтэй юм.(5),(6),(7)

▪2. Латин үсэгт шилжих төлөвлөгөө, түүний хэрэгжилт

1911-1912 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд Монголын ард түмэн манжийн 200 гаруй жилийн дарлалыг түлхэн унагаж, тусгаар тогтнолоо хэмжээгүй эрхт эзэн хаант төрийн агуулгаар сэргээн тогтоов. Хоёрдугаарт: Чингис хааны үеийн засаг захиргааны амин чухал нэгж бүхий ижил төстэй үүрэг эрхтэй улсын дээд, доод танхим бүхий хурал байгуулан ажилласан явдал юм. Гуравдугаарт: “Их Засаг хуул”-иа чиг болгохын зэрэгцээ Дэлхийн тэргүүний орнуудын үндсэн хуулийг судалж, Монгол улсын үндсэн хуулийг боловсруулах ажлыг эхлүүлсэн, Дөрөвдүгээрт: Цэрэг, ард, үр хүүхдийг сургах, түр хийгээд урт хугацаатай сургууль байгуулах, эрдэм боловсролтой, төрийн алба хаших тохь суурьтай хүмүүсийг бэлтгэх, их сургууль нээх асуудлыг хүртэл боловсруулах, тавдугаарт: мал аж ахуйн, газар тариалан, ахуйн хэрэгцээний бүтээгдхүүн, үйлвэрлэх уламжлалт аргаа сэргээн хөгжүүлэхийн зэрэгцээ зам тээвэр, харилцаа холбоо, оньсон техник хөгжүүлэх арга сүвэгчилэх, түүхий эд байгалийн баялгийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах ажил эхлүүлэхийг бүхий л талаар чармайх зэрэг ажилд шилжих зорилт тавьсан нь Монгол улс дэлхийн хөгжлийн замаар явах, шинэ соёлыг хөгжүүлэхийн эхэн болсон юм.(8) Монгол хэвлэл байгуулах асуудлыг 1911 оны өвөл Гадаад явдлын яам сэдэж бусад 5 яаманд бичиг илгээж орос сургуулийн багш Жамсрангаар удирдуулан дармал дарахыг заан сургах, мөн Орос улсын нийслэлээс төмөр хэвийн монгол үсэг 5 пүү, дармал дарах эргүүлэг машин нэгийг захиалан авахаар зөвлөлдөж байжээ. Үүнийг бусад яамд зүйтэй хэмээн олноо өргөгдсөний 2-р оны өвөл хариу илгээж 1500 цельков Сангийн яамнаас гаргуулан авч байв. 1912 онд алтан шүдэт Намсрай, хялааз Намсрай нарыг

Харбин хотын Юан Бо тан гэдэг гудамжны хэвлэлийн газарт явуулж мэргэжилтэй ажилтаныг бэлтгэжээ. 1913 оны 3-р сарын 5-нд “Шинэ толь” хэмээх сэтгүүл, 1915 оны 9-р сарын 1-ээс “Нийслэл хүрээний сонин бичиг” хэмээх сонин Хүрээнд хэвлэгдэн гарах болжээ. Эдгээр тогтмол хэвлэлийг үүсгэн гаргах үйлст Ж.Цэвээн тэргүүтэй ардчилсан дэвшилтэт үзэлтэй сэхээтэн их үүрэгтэй байжээ. Мөн бас бус ном товхимол хэвлэж эхэлжээ. Сургуулиудад зориулан “Монгол үсгийн цагаан толгой”, “Оюун түлхүүр”, “Цаасан шувууны тууж”, “Гадаад улсын товч түүх”, Хоёр загалын тууж”, “Орчлонгийн сав шим” зэрэг ном зохиолуудыг хэвлэн гаргажээ. 1918-1919 онд Монголын засгийн газраас зориуд эрхлэн “Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир” хэмээх 11 дэвтэр улсын албан түүхийг зохиолгожээ. Мөн энэ үе Ш.Дамдины “Шашны он цаг”, “Умар зүгийн монгол оронд шашин хэрхэн дэлгэрсэн нь”, “Алтан дэвтэр” зэрэг Монголын шашин, түүхийн томхон зохиолуудыг бичиж гаргажээ.(9) Шанзавын яамны дэргэд байгуулагдсан хэвлэлийн газар бол дөрвөн ажилчинтай, хэвлэлийн гар машин, чулуун хорын бар тус бүр нэгтэй байсан бөгөөд ихэвчлэн Богд хааны сургаал лүндэн зэрэг албан зүйлийг хэвлэдэг байсан байна.(10) Монголчуудын дунд орчин цагийн хөгжилтэй орнуудаас сурч гэгээрэх, тэдгээр орны үлгэр загвараар улс орноо тохинуулан засах хүсэл эрмэлзлэл их болжээ. Монгол улсын засгийн газар юуны урьд иргэний сургууль, гэгээрлийн ажлыг үүсгэн явуулжээ. Гадаад явдлын яамнаас 1914 онд Богд хаанд айлтгасан нэгэн нугалбар бичигт улс орныг тохинуулан засах үйл хэрэгт “хүн бүр эрхгүй бичиг эрдэм сурваас зохих”-ыг онцлон зааж Орос, Франц, Англи зэрэг улсуудын үлгэр жишээгээр иргэний төрөл бүрийн сургууль байгуулахын чухлыг цохон тэмдэглэсэн байна. Тэр үед

шашны хуучин олон сургуулийн зэрэгцээгээр орчин цагийн иргэний сургалтын эх үүсвэр анх бий болжээ. Сургууль гэгээрлийн ажлыг улсаас тусгайлан эрхлэн шийтгэж, өчүүхэн бага боловч төсөв зардлыг /жилд 52000 рубль/ энэ хэрэгт зориулан гаргах болжээ. Монголын хаант улсын үед бага, дунд, дээд сургуулиудын дүрмийг боловсруулж гаргасан нь тэр цагт олон зэрэг шатны сургуулийг зохион байгуулах бодлоготой байсныг харуулж байна. Богд хаант Монгол улсын анхны сургуулийг 1912 оны 3-р сарын 24-нд дөрвөн аймаг, шавь таван газраас зарлан ирүүлсэн 47 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр Гадаад явдлын яамны дэргэд нээжээ. Улсын төв архивын мэдээ баримтаас үзэхэд тэр үед аймаг, хошуудад удаа дараалан байгуулсан бага сургуулийн тоо 60 гаруй болсон байжээ.(11) Монгол улсын цаашдын соёл боловсролын хөгжилтөд 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал шинэ чухал үе шатыг нээсэн юм. Энэ хувьсгал нь аль ч утгаараа 1911 оны ҮЭЧХ-ний шууд үргэлжлэл байсан хийгээд амин сүнс нэгтэй билээ. Энэ нь нэгдүгээрт: улс үндэсний тусгаар тогтнолыг сэргээн тогтоох; хоёрдугаарт: төр засгийг шинэчлэн байгуулж босгох, гуравдугаарт; нийгэм-эдийн засаг, оюун санааны амьдралд шинэтгэл, хувьсгал хийх зорилттой гэх мэтийн гол гол нийтлэгтэй. 1911 оны ялгуулсан хөдөлгөөн Монгол улсынхаа тусгаар тогтнолыг сэргээн тогтоосон бол 1921 оны хувьсгал нь тусгаар тогтнолоо эргүүлэн олж Монгол улсынхаа хуучин төр, засгийг зугуухан халж шинэ засаг төрийг эдийн засгийн харилцаанд эрс тэс өөрчлөлт хийж, феодалын нийгмийн харилцааг халж хөрөнгөлөг нийгэм үүсч хөгжих, боловсрон гэгээрэх шинэ зам нээж өгсөн. Эдгээр түүхэн үзэгдлийн нийтлэг тал нь Монгол улсынхаа эрх ашгийг дээдэлсэн нэг л ард түмэн

өөрийн тэргүүний, соргог ухаалаг хүмүүсийн удирдлагаар босон тэмцэж эрх чөлөөний хөдөлгөөний ба 1921 оны хувьсгалын зорилтыг хэрэгжүүлсэн явдал юм.(12) Ардын засаг байгуулагдсаны дараахан 1921 оны 8-р сарын 14-нд засгийн газрын гишүүдийн хуралдаанаас бага сургууль байгуулах тухай тогтоол гаргаж “Олон хөвгүүд охидыг багад элдэв зүйлийн бичиг заан сургаж, оюуныг судлуулан олон түмний хэрэгт туслуулахыг” зааж удалгүй бага сургуулийн дүрмийг баталжээ. 1921 оны 11-р сард Судар бичгийн хүрээлэн байгуулах тогтоол гаргаж “Гадаад олон улсын зүйл бүрийн ухааны ба улс төрд хэрэглэгдэх судар бичгээс хэрэгтэйгий нь монгол үсгээр орчуулж авах ба уул монголын хэлээр зохиож дэлгэрүүлэх”-ийг заан удалгүй дүрмийг баталжээ. 1925 онд хуралдсан МАХН-ын IV их хурлаар баталсан намын мөрийн хөтөлбөрт “Монгол үсэг бичгийг шинэтгэн амар дөхөм болгох”-оор заасан байна. Манай улсын хэл бичгийн эрдэмтэн сэхээтэн нар дээрх асуудлын талаар нэгдсэн саналтай байгаагүй байна. Ж.Цэвээн, Онходын Жамъян, С.Шагж нарын зэрэг эрдэмтэд монгол бичгээ хэрхэвч сольж болохгүй бөгөөд олны сурахад дөхөмтэй болгох, гадаад үгийг тэмдэглэх үсэг боловсронгүй болгох зэргээр засамжилж болох юм хэмээн үзэж байжээ. Тэдний нэг С.Жамъян “Манай монгол улс эрдэм соёлыг бадруулахыг нэн ихэд хичээж, багачуудыг гадаадын олон улсын бичгийн сургуульд явуулж буй нь сайшаалтай бөгөөд гагцхүү монгол бичгийг шамдан сурваас зохино. Учир юун хэмээвээс гадаад улсын бичигт хэдий боловсорсон боловч монгол үсгийг төсөөлөн мэдэхгүй болвоос гадаад улсад элэглэгдэх төдийгүй, бас ч нэгэн зүйлийн хэрэг дутагдах буй заа” гэж бичиж байв. 1920-иод оны үеэс зөвлөлтийн араб, түрэг үндэстэн ястан олон үеийн турш хэрэглэсээр ирсэн араб бичгээ халж латин бичиг

хэрэглэж эхэлжээ. Энэ бол Сталины бодлогын илрэл байснаас биш эдгээр ард түмэн үндэснийхээ бичиг үсгээс сайн дурааараа татгалзсан нь бус гэдгийг оросын эрдэмтэд бичиж байна. Сталин болон түүний хүрээлэгчид энэ туршлагаа зөвлөлтийн бүрэлдэхүүнд багтаж байсан монгол угсаатан, улмаар БНМАУ-д дэлгэрүүлэхийг зорьж байсан нь илэрхий байдаг билээ. Зөвлөлт Буриадад монгол бичгээ солих эсэх талаарх асуудлаар эрдэмтэд, сэхээтнүүдийн дотор ширүүн тэмцэл өрнөж, сольж халах талынхан дээрээсээ дэмжлэгтэйгээр дийлж, эсрэг талынхаа үндэсний үзэлтэн, социализмын болон ардын дайсан хэмээн хүнд ялд унаган буруушаажээ. 1930 он гэхэд Монгол улсын соёл боловсролын эхийг тавьж , монгол улсад хэрэгтэй боловсон хүчнийг гадаадын орнуудад тэр дундаа европын өндөр хөгжилтэй орнуудад бэлтгэж, Германаас их, бага Нацагдорж, Бат-Очир, Санжаа, Бадарчин, Сэдэд, Гомбо, Батсүх, Галаа, Цэрэн, Бавуу, Намхайцэрэн, Д.Намдаг, Наваан-Юүндэн, Пагмадулам, Францаас Мэргэн гүний Гомбожав нарын 30-аад сэхээтэн төгсөн ирээд шинэ соёлыг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхэд зүтгэж эхэлсэн үе билээ. Тэд соёл боловсролыг хөгжүүлэх, шинэ урлаг утгазохиолыг бий болгох хэрэгт хүчин зүтгэж, шинэ хувьсгалт үзэл суртлын нөлөөгөөр хуучныг халж, шинээр хувьсгахын жигүүрээр амьсгалж байлаа. Монгол бичгээ сольж халах тухай санал, маргаан энэ үеэс эрчимтэй өрнөж эхэлсэн байв. Нилээд сэхээтнүүд түүний дотор Б.Ишдорж, Б.Дугаржав нарын зэрэг сэхээтэн хуучин монгол бичгээ халж, Буриад Монголын туршлагаар латин үсгийг авч хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байжээ. Эд бол намын IV их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх тухайд холбогдох хоёр дахь саналын гол төлөөлөгчид юм. Зөвлөлт оросын туршлагад зоригжин

социализмыг түргэн шуурхай байгуулах дэвэргэн хүсэлд автсан зүүний хугалаатан нар дээрх хүмүүсийн саналыг дэмжин МАХН-ын VIII, улсын IV их хурлын шийдвэрт латин үсгийг авч шинэ бичиг зохион, үндэсний бичгээ халах тухай заалтуудыг оруулжээ. Тэд “Монгол хуучин цагаан толгой ба бичиг үсэг нь хоцорсон бөгөөд түүний дотор эртний бүдүүлэг цагийн зүйл олон болохын дээр феодалын ёст хүнд суртлын үзэлтэй барилдсан, бас үсгийн дүрэм нь манж, хятад, төвд зэрэг улсын үсгийн дүрэм маягтай холилдон будлиантсан болох ажгуу…Хуучин үсэг бол үнэндээ шар, хар феодал нар ангийн талаар ноёлон дарангуйлах зэвсэг мөн бөгөөд ажилчин ард олныг бичиг үсэгт боловсруулахад онц саад боогдол учруулдаг болой” хэмээн хэт их үзэл суртлын талыг барин түүний олон сайхан чанарыг ор тас үгүйсгэн бичсэн нь ард олныг бичиг үсэг солих компанид нэгтгэн оруулж, үндэсний соёл боловсролын төлөө гэсэн зарим нэгэнд хар, шар феодалын хамаатан гэж хоч зүүх арга хэрэгсэлээ бэлдсэн нь энэ байв. Тэгээд нам, Эвлэлийн төв хороо, Үйлдвэрчний төв зөвлөл, Шинжлэх ухааны хүрээлэн, Цэргийн улс төрийн газраас зохих хүмүүсийг оруулан латин үсгийн зөвлөлийг байгуулж, латин үсэг авч хэрэглэх ажилд 1930 онд орохоор шийдсэн боловч намын VIII хурлын тогтоолд “…санал шүүмжлэлийг гаргуулан, дараагаар суралцан хэрэглэхэд бэлтгэл туршлагыг бүртгэн авч гүйцэтгүүлэхээр” заасан байна. Академич Ц.Дамдинсүрэнгийн дурсамжинд “миний бичсэн монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүллийг Амар гуай уншиж үзээд “латин үсэг хэрэглэж болох юм” гэж бичсэнийг зэмлээд дараа нь “залуу хүн бас ийм үг хэлж явах нь ч зүйтэй юм. Хэвээр үлдээ” гэж байсан хэмээн дурдсан нь байдаг. 1930 оны 10-р сарын 17-нд Засгийн газрын 66-р тогтоолоор долоо хоног бүрийн бямба гаригт ажлын бус

цагаар латин үсгийн хичээлийг хоёр цаг явуулж байхаар болж, Улаанбаатар хотод хэрэгжүүлж эхэлжээ. Ардын гэгээрүүлэх яамны дэргэд байгуулагдсан “Латин монгол үсгийн зөвлөл” латин үсгээр монгол хэлний авиаг тэмдэглэх цагаан толгойн үсэг 26 байхаар төлөвлөн боловсруулж, засгийн газар оруулж батлуулжээ. 1931 оны 1-р сард Москва хотноо бичиг үсгийг латинчлах асуудлаар тусгай зөвлөгөөн зохион байгуулахад түүнд Буриад монгол, Халимагийн төлөөлөгчдөөс гадна БНМАУ-ын төлөөлөгчид оролцжээ. Зөвлөгөөнөөр монгол бичгийг халах тухай хэлэлцэж “Монгол бичиг бол эдүгээ үед нэгэнт цагийн хөгжлөөс хоцрогдсон” хэмээн шүүмжлээд түүний оронд “ард түмний сурах, танихад хялбар дөхөм бөгөөд дүрс зурам нь орчин цагийн дэлхийн олон улс аймаг нийтээр хэрэглэж буй интернационалын чанар бүхий латин үсгийг авах” шийдвэр гаргажээ. БНМАУ-ын засгийн газар бас тусгай тогтоол гаргаж, бага, дунд сургууль, техникумд 1931 оноос эхлэн латин үсгээр бичүүлэх, түр сургууль, бичиг үсгийн дугуйлан зэрэгт монгол бичгийг таниулах төдийгөөр хязгаарлаад, латин үсгийг гол болгон сургах, сонин сэтгүүлд латин үсгийн булан бий болгох, латин үсгийн хэвлэлийн машин, үсэг өрөгч, хянагч нарыг бэлтгэх, албан газар, дэлгүүр хоршооны хаяг, албан бичгийн загвар, нүүр, ном зохиолын нэр, тамга тэмдгийн үсгийг 1931 оны 11-р сар хүртэлх хугацаанд латин үсгээр өөрчлөх, нам, улс, аж ахуйн ажилтан, ажилчдыг 1932 оны 5-р сарын 1 хүртэлх хугацаанд латин үсэгт албан журмаар сургах, 1933 оны 5-р сарын 1-ээс бүх албан бичиг хэргийг латин үсгээр хөтлөх шийдвэр гарган довтолгожээ. 1932 оны 4-р сарын 13-нд А.Амар нарын гарын үсэг зурж, ШУХ-ээс латин үсгийн зөвлөлд явуулсан нэгэн албан бичигт буриад аялгуунд тохируулан зохиосон зөв бичих дүрмийг

Б.Ишдорж хүчээр халх аялгуунд авч хэрэглэсэн нь тохиромжгүй байгааг шүүмжлэн, санал шүүмжлэлийг явуулах хэрэгтэй хийгээд ШУХ-нд шинэ бичгийн туршлагын дүрмийг халх аялгуунд ойртуулан зохиох ажлыг хариуцуулах саналыг МАХН-ын Төв хороонд оруулан шийдүүлж өгөхийг хүсчээ. Энэ нь монгол бичгээ сольж болох боловч монголын утга зохиолын хэлний үндэс болсон халх аялгуунд тохируулан зохиохыг санал болгосон гуравдахь хэсгийн төлөөлөгчид байв. МАХН-аас зүүний алдаа завхралыг засах ажлын хүрээнд латин үсгийн асуудлыг ч хамруулан авч үзээд 1932 оны 7-р сард латин үсгийн зөвлөлийг татан буулгаж тэнд ажиллаж байсан Ш.Лувсанвандан нарыг уг ажлаас нь чөлөөлж, зөвлөлийн хариуцаж байсан ажлыг Ардын гэгээрүүлэх яамны ардыг боловсруулах хэлтэст хавсаргажээ. Улмаар Улсын Бага Хурлын тэргүүлэгчид, Сайд нарын зөвлөлөөс 1932 оны 11-р сарын 1-нд хөдөлмөрчдийг бичиг үсэгт сургах ажлыг монгол үндэснийхээ бичгээр гүйцэтгэх, харин латин үсэг сурах явдлыг ард олны сайн дурын хэрэг болгон тогтоожээ. Энэ тогтоол гарахад тэр үед Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн дарга болоод байсан дорнын өндөр боловсролтой А.Амарын зүтгэл ихээхэн орсон юм. Бүх нийтийг эрчимтэй бичиг үсэгт сургахын тулд янз бүрийн хүмүүсийн зохиосон цагаан толгойг жигдлэн 29 үсэгтэй байхаар төлөвлөж Шагжийн толь зэрэг зөв бичих дүрмийн толь гарав. Мөн бас латин үсгийн дүрэм боловсруулах ажлыг ч хийж байв. 1934 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн тэргүүлэгчдийн хурлаас тогтоол гаргахдаа Д.Нацагдоржийн зохиосон латин үсгийн шинэ дүрмийг дуун ухааны кабинетэд шилжүүлж хянуулахаар шийдвэрлэсэн байна.(13) 1932 онд хэвлэгдсэн “Өөрөө suraad busadiig surga”

хэмээх сурах бичгээс үзэхэд цагаан толгойн үсгийг дараах байдалтай оноосон байна.

Aa, Bb, Gg, Dd, Zз, Ƶƶ, Ii, Ll, Mm, Nn, Өө, Oo, Pp, Rr, Ss, Tt, Uu, Yy, Kk, Cc, Çç, Şş, Ee, Jj.

Бичих байдал нь үг бүтээх зарчмыг их гол болгохыг зорьж байсан байна. Жишээлбэл: Aradiig Gegeeryylke Jaama, biyede kyregsediig surgaka, Kuuçin şine yseg kabsarsan 5 daki keblel, sedkyyl, saƶin гэх мэтээр бичсэн байна. Энд нэг онцлог зүйл бол тийн ялгалын нөхцлийг эр, эм үгийн гэж ялгаагүй байгааг дээрх үгнүүдээс харж болно. Я-гийн төрлийн үсгийг ганц j-аар тэмдэглэж хойно нь зохих эгшгийг дагуулдаг байна. Хэрэв урт эгшиг энэ үсгийн дараа орвол давхар үсэг бичихээр бодсон байна. Жишээ нь: Jaama, Tujaa гэх мэт. Зөөлөн гийгүүлэгчийг тэмдэглэх i-ийн дараа урт эгшиг бичихээр бодож байсан нь бас л сонин байна. Жишээ нь: tariaaçnar, Proletarinar гэх мэт. Энд бас олон тооны дагаварыг ч хойноос нь залган бичиж байсан байна. Ер нь нарийвчлан судалбал авиаг хэрхэн оноож байсныг нарийн гаргаж болох юм. Энд ийм зорилго тавьсангүй.

Монгол бичиг үсгийн асуудалд байнга анхаарал тавьж байсан бөгөөд МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн 1935 оны 3-р сарын 11-нд хуралдсан 10-р хурлын тогтоолд “Хэл бичгийг судлах ажлыг дэлгэрүүлэн явуулж, хэл бичгийг баялаг болгох ба дүрэм журамтай хэрэглэх болгож, ялангуяа бичгийн найруулгыг хялбар мэдэцтэй болгох ба феодал түшмэд нарын тусгүй заншил найруулгыг арилгах хийгээд ардын үг ярианд ойртуулах ба монгол хэлбичгийг баялаг болгохын тул ярианы хар үг ба бичгийн үг, нийтээр хэрэглэх гадаадын үгийг бүртгэн хэрэглэх нь чухал бөгөөд одоо зохион буй тайлбар толь ба нэр томьёоны

толийн үргэлжлэлийг яаравчлан гаргавал зохих ба бас ч хэл бичиг ба үсгийг дүрэмтэй болгох ба сайжруулахын тул үүн тухай толь бичгүүд ба сэтгүүлийг хэвлэж, нийтэлбэл зохино хэмээхээс гадна галиг үсгийн тухай дахин сайнаар боловсруулж, ирүүлэх явдлыг Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн товчооны гишүүдэд даалгасан байна. Монгол бичгийн нэгдсэн цагаан толгойг 1936 оны МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн хурлаар сайшааж, мөн оны 8-р сарын 14-нд Ардын сайд нарын Зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж, хэвлэх зардлыг зохих газруудаас гаргуулахаар тогтжээ. “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” сэтгүүл, Ш.Лувсанвандангийн “Монгол хэл зүй” болон нийгэм улс төр, шинжлэх ухаан, уран зохиолын олон номыг хэвлэн гаргажээ. 1932-1940 онд сургалтын ажил болон бүхий л албан хэргийг үндэсний бичгээрээ явуулж байлаа. Нийт ард түмнийг бичиг үсэгт сургах ажлын хүрээнд лам нарыг бичиг үсэгт сургах ажлыг эрчимтэй хийж МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн 1936 оны 2-р сарын 10-нд хуралдсан 46-р хурлын тогтоолын дагуу 1936 оноос хоёр долоо хоногт нэг удаа монгол хэлээр монгол, төвд үсгээр лам нарын сэтгүүл гаргаж нам засгийн бодлогыг таниулан 1935-1937 онд бүгд 20000 гаруй доорд лам нарыг үндэсний бичиг үсэгт сургах явдлыг хамруулж байжээ. Гэвч лам нарын ихэнхийг болон уламжлалт соёлт, сор болсон үндэсний сэхээтнүүдийнхээ ихэнхийг егүүтгэсэн их хэлмэгдүүлэлтийн дараа үндэсний бичгээ хараах, муучлах явдал дахин дэгдэв. МАХН-ын Төв хорооны 1937 оны 10-р сард хуралдсан III бүгд хурлын тогтоолын ардын соёл боловсролын талаарх хэсэгт “Соёл боловсролыг хөгжүүлэх ба ард түмнийг үсэг бичигт сургах явдлыг зохиож таван жилийн дотор латин үсгийг сургахаас гадна араб тоог хэрэглэх журмыг дэлгэрүүлэн

явуулсугай” хэмээжээ. Энэ тогтоолыг баталгаажуулж 1940 онд хуралдсан МАХН-ын X, Улсын VIII их хурлаас “Таван жилийн дотор латин үсгийг сургахаас гадна, араб тоог хэрэглэх журмыг дэлгэрүүлэн явуулах” заалт өгчээ. ШУХ-ийн хуучин туршлагыг хуулан хэрэглэж 26 үсэгтэй латин үсгийн цагаан толгойг гаргажээ. 1940 оны 5-р сарын 3-ны МАХН-ын тэргүүлэгчдийн хуралд ШУХ-ээс илтгэл оруулж үүний дагуу “Соёл боловсрол, дэлхийн олон улс орны бичиг үсгээс машид хоцорсон…соёлын хурц зэвсэг болж чадахгүй…шинжлэх ухааны нэр томьёог бичиж болохгүй” гэх мэтээр өөчлөн муулж дурдаад холбоот улсын түрэг хэлтэн улсуудын туршлагаар латин үсэг дэлгэрүүлж ардын дайснуудын сааруулсан ажлыг тууштай хэрэгжүүлэхээр заажээ. ШУХ-ийн боловсруулсан илтгэл, намын X хурал дээр Х.Чойбалсангийн хэлсэн үгтэй утга нэг байв. 1940 оны 6-р сарын 16-нд ШУХ-ийн тэргүүлэгчдийн хурлаар ШУХ, Ардын гэгээрлийн яам, Хэвлэлийн газраас хамтран боловсруулсан шинэ бичигт шилжин орох төлөвлөгөөг хэлэлцжээ. Тэр төлөвлөгөөгөөр 1941 оны 5-р сарын 15-аас эхлэн 1944 оны 1-р сар хүртэл бүх хүмүүсийг үе шаттайгаар латин үсэгт сургах, хэвлэлийн ажлыг мөн үсгээр гүйцэтгэсний үндсэн дээр 1944 оны 1-р сараас эхлэн хуучин монгол бичгийг хэрэглэхийг зогсоохоор заасан байна. Төлөвлөгөөг 1940 оны 7-р сарын 26-нд Ардын Сайд нарын зөвлөлд хэлэлцэн үндсэнд нь сайшаан баталжээ. Эндээс энэ ажил бага бус ажил тул комисс томилох нь зүйтэй хэмээн үзэж уг комиссын даргад Ю.Цэдэнбал, орлогчид Т.Машлай, нарийн бичгийн даргад Х.Далхжав, гишүүдэд Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Банзрагч, Д.Цэвэгмид, С.Тамжид, Д.Сурмаажав, Минжүүр, Б.Доржсүрэн нарын 17 хүнийг томилжээ.

1941 оны 2-р сарын 21-нд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид ба Ардын Сайд нарын Зөвлөлийн гишүүдийн хамтран хуралдсан XVII/XIII хурлаар шинэ боловсруулсан латин үсгийн төлөвлөгөөний тухай комиссын дарга Ю.Цэдэнбалын илтгэлийг сонсчээ. Хуралд бас нам, төрийн олон байгууллагын төлөөлөгчид оролцсон байна. Хурлаас гаргасан тогтоолд комиссын ирүүлсэн латин үсгийн цагаан толгойн 29 үсэг нь манай дуу авиаг тэмдэглэхэд хүрэлцэх ба тохирох тул батлахаар заагаад урт болон балархай эгшгийг тэмдэглэх зарчмыг тогтоож, зөв бичих дүрэм боловсруулж гаргахын наана 1941 оны 3-р сарын 20-оос өмнө түр дүрэм боловсруулахыг ШУХ-нд даалгажээ. Тогтоолд Ю.Цэдэнбал, Х.Чойбалсан нар гарын үсэг зуржээ. Хот, хөдөөд латин үсэг сургах их ажлыг эхлүүлэв. Гэтэл ганцхан сарын дараа 1941 оны 3-р сарын 25-ны өдөр Намын Төв Хорооны Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн гишүүдийн хамтарсан XV/XVIII хурал болж, латин үсгээ больж, орос /кирилл/ үсэг авах нь зүйтэй гэсэн илтгэлийг Ю.Цэдэнбал тавьж хэлэлцүүлэн батлуулжээ. Тус хурлын тогтоолд “Монгол үсгийн латинчлахад мөнхүү латин үсэгт монгол хэлэнд хэрэглэх тэмдэг дутагдалтай ба мөн хэвлэлийн талын бэрхшээл тохиолдож байна. Мөн тус орны соёл боловсролын цаашдын хөгжилт нь гагцхүү ЗХУ-ын ард түмэнтэй ахан дүүсийн холбоо байгуулж түүний бэлхэн соёлыг эзэмших замаар явах болно. Манай эрх чөлөөгөө олсон ард түмэнд чухам хэрэглэгдэх бүхий л хувьсгалын зохиол бичиг орос хэл дээр хэвлэгддэг ба монгол ард улсын бүхий л аж ахуйн салбаруудад хэрэглэгдэх үндэсний хүчнийг төлөв ЗХУ-д явуулж боловсруулдаг байна” гэж тэмдэглээд монгол бичгийг орос үсэг дээр шилжүүлэн авахыг нийтэд зарлан хэрэгжүүлэх, латин үсэг заах явдлыг зогсоох, нэг

сарын дотор орос үсэг дээр үндэслэсэн монгол шинэ бичгийн эцсийн төлөвлөгөөг боловсруулж, Намын Төв Хорооны Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн гишүүдийн хуралд оруулан батлуулахыг Ю.Цэдэнбал тэргүүтэй комисст даалгаж, латин үсгийн талаар урьд гаргасан тогтоолыг хүчингүй болгожээ. Ингэж латин үсэгт шилжих хөдөлгөөн бүрмөсөн зогсов. Латин үсэг шилжих энэ хөдөлгөөн бол хэт хувьсгалт өөрчлөлтийн давалгаан ядуу буурай монгол орныг дайрч үндэсний соёл боловсролын олон сайхан зүйлийг устгахын эхэн болсон юм.

▪3.Кирилл үсгийг авсан хийгээд түүний цаашдын хөгжилт

1941 оны 3-р сарын 25-ны өдөр Намын Төв Хорооны Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн гишүүдийн хамтарсан XXV/XVIII хурал болж, латин үсгээ больж, орос /кирилл/ үсэг авах нь зүйтэй гэсэн илтгэлийг Ю.Цэдэнбал тавьж хэлэлцүүлэн батлуулжээ. 1941 оны 4-р сарын 25-ны Намын Төв Хорооны Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлын дараа 4-р сараас эхлэн хот хөдөөд шинэ бичгийн багш нарыг түр бэлтгэх түр сургуулиудыг яаравчлан байгуулж, анхны 258 багшийг бэлтгэжээ. 1941 оны 5-р сарын 9-нд Намын Төв Хорооны тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн гишүүдийн хамтарсан XXV/XXVII хурлаас шинэ үсгийн цагаан толгойг 35 үсэгтэй байхаар батлаад зөв бичих дүрмийг долоо хоногийн дотор багтаан боловсруулж, нийтэд зарлах, цагаан толгой, сурах бичиг зэргийг ойрын хугацаанд бэлтгэн хэвлэхийг ШУХ, Ардын гэгээрлийн Яаманд даалгажээ. Мөн ард олон, ажилтан, албан хаагчдад шинэ үсэг сургах ажлыг зохион байгуулахыг нам, улс олон нийтийн бүх байгууллагуудад үүрэг болгож бүлгэм дугуйлан байгуулж хичээллүүлэх, бага

сургуулийн 1, 2 дугаар ангид 1941-1942 оны хичээлийн жилээс эхлэн бүх хичээлийг шинэ үсгээр явуулах, бүх сонинуудад шинэ үсгээр тусгай булан гаргахаар шийдэж, улс даяар шинэ үсгээр албан хэргийг хөтлөн явуулах хугацааг нэг сарын дотор багтаан боловсруулахыг ШУХ, Ардын гэгээрлийн Яаманд даалгасан тогтоол гаргаж Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарын гарын үсэг зурж баталжээ. 1941 оны 5-р сард Шинэ үсгээр үг холбох тухай гэдэг анхны түр дүрэм нийтлэгдэж, улмаар 1941 оны 11-р сарын 19-нд улсын комимсс шинэ үсгээр зөв бичих дүрмийг хэлэлцэн сайшаагаад Намын Төв Хорооны Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн хуралд батлуулахаар оруулжээ. Академич Ц.Дамдинсүрэн гуай 1980-аад оны эхээр уншигчидтай хийсэн нэгэн уулзалт дээр “Монгол бичгээ яагаад сольсон юм бэ?” хэмээх асуултад “Би шинэ үсгийн дүрмийг зохиосон хүн. Харин тэгэхдээ би анх энэ шинэ бичгийг буюу орос үсгийг хэрэглье гээгүй юм шүү. Нэг өдөр Төв хороон дээр дуудаад л чи шинэ үсгийн дүрэм зохио л гэсэн. Би тэгэхэд нь латин үсэг хэрэглэвэл зүгээр юм биш үү гэсэнд үгүй, үгүй, бид шийдсэн. Шинэ үсгийн дүрэм зохио гэсэн. Тэгээд л би тэр тушаалыг биелүүлсэн. Тушаалыг дагахгүй, давах биш. Яагаад ч монгол бичгийг өөрчлөх болсон юм. Бид гэдэг хэн хэн ч юм. Би одоо хүртэл үүнийг ойлгоогүй л яваа” хэмээн хариулсан байдаг. Шинэ үсэг авахад алс холын Москвагийн заавар, дэлхий даяар коммунизм ялна гэсэн хувьсгалч хэтэрхий өрөөсгөл итгэл үнэмшил нөлөөлсөн нь дамжиггүй юм. Ц.Дамдинсүрэнгийн 80-аад хуудастай шинэ үсгийн дүрэм 1941 оны сүүлээр хэвлэгдэн гарав. Түүнд “орос үсгийн цагаан толгой дээр “ө”, “ү” хоёрыг нэмсэн хийгээд “е”, “ё” хоёрыг орос үсэгт нэгэн үсэгт тоолдог хийгээд монголчилж авахад хоёр ялгавартай үсэг болох тул хоёр үсэгт тоолж бүгд 35

үсэг болгосон гээд ярианы хэлээр бичнэ” гэжээ. Орос хэлэнд урт эгшгийг тэмдэглэх тэмдэглэгээ хийгээд монгол бичигт ч ийм тэмдэглэгээ үгүй тул тод үсэг болон вагиндрагийн үсгийн уламжлалаар тухайн эгшгийн дээр зураас тавьж тэмдэглэхээр зохиожээ. Жишээ нь: ямā, гэжэ̄, барāн, вāр сав авāд, долō̄н адӯ ӯланд явна, ē хē̄рхий хӯе байз, маргāш явмāр юм, аюō̄лтай юм могой ю̄ гэх мэтээр тэмдэглэсэн бөгөөд харь үгний уртаар дуудагдах хэсгийг мөн адил дээр нь уртатгалын тэмдэг тавьж тэмдэглэж байсан байна. Кāрл Мāркс, коммӯнизм, пролетāри, монопō̄ли гэх мэт. Харин хос эгшиг болон “и”-ийн төрлийн урт эгшгийг одоогийн бидний бичиж байгаа хэлбэрээр бичихээр хийсэн байна. Жишээ нь: хийжэ̄, сайн нохой айлд хэрэгтэй, цайгā буцлага гэх мэт. Мөн тагнайшсан гийгүүлэгчийн дараахь урт эгшгийг “и” бичээд уртаар дуудах, дан эгшгийг бичиж уртатгалын тэмдэг тавихаар төлөвлөсөн байна. Жишээ нь: зохиō̄лч, мориō̄р гэх мэт. Тийн ялгалтай хамаатуулах нөхцөлтэй жишээ бичсэн байдлыг үзүүлье. Бӯныхā, бӯндā, бӯгā, бӯнāсā, бӯгāрā, бӯтайгā гэх мэт. Энэ цагаан толгойд нэг анхаарал татах зүйл нь кириллыг монгол үсгээр галигласан байдал юм. Тэр үед намын их хурлын материал болон бусад илтгэлд гадаад үгийг тэмдэглэхэд элдэв янзаар бүдүүлэгддэг хэмээн бичиж байсан боловч манай бичгийн мэргэд болон түүний залгамж халаа залуу эрдэмтэд галиг үсгийн тухай сайн мэдэхээр барахгүй үсгийн болон авианы галигийн үүднээс ямар галиг таарахыг хэл шинжлэлийн үүднээс нарийн тааруулсан байгаа болой. “В” үсгийг Аюуш гүүшийн

галигт үнэгний ᠸ “ва” үсгийг тэмдэглэдэг галиг ᡨ -аар, “Д” үсгийг бөгтөр ᡂ “да”-г тэмдэглэдэг ᡩ -ээр, “Е”-г монгол бичгийн “и” болон тод бичгийн ᡯ “э”-гээр, “Ё”-г монгол бичгийн ᡱ “и”, “о” хоёроор, “ж”-г монгол бичгийн ᡳ “ж”-ээр, “з”–г Аюуш гүүшийн галиг үсгийн саравгар ᡴ ᡳᡨ “за”-гаар, “К”-г галиг үсгийн буруу харсан ᡭ “ха”-гаар, “П”-г галиг үсгийн энэтхэг үсгийг тэмдэглэх “па”-гаар, “Ф”-ийг галиг үсгийн төвд үсгийн ᡮ “па”-гаар, “Т”-г галиг үсгийн төвдийн бүстэй ᡯ “та”-гаар, “Ц”-г галиг үсгийн ходоодон ᡵ ᡳᡨ “за”-гаар, “Ю”-г монгол үсгийн “и” болон “ү”, “у”-г ᡱᡨ ᡱᡩ нийлүүлэн галигласан байгаа нь үсгийн галиглах оноолтыг ихээхэн зөв гаргасан байгаа болой. Шинэ бичигт сургахын тул шинэ бичигт тайлагдсан шавь нарынх нь тоогоор багш нарт нь шагнал урамшуулал олгох, 13-19 насны хүүхэд, залуучуудыг шинэ бичигт сургах үүргийг шууд эцэг эхэд нь хариуцуулах, монгол бичиг мэдэгчдэд шинэ бичиг сурах явдлыг хугацаа заан үүрэг болгох, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад хяналтын тоо, төлөвлөгөө ногдуулах, сум бүрт орон тооны багш ажиллуулах, аймаг, сумдын уралдааны ажлын нэг гол үзүүлэлт болгох, шинэ бичигт сургах ажлыг хариуцсан тусгай комисс байгуулан ажиллуулах зэргээр бүхий л арга хэрэгслийг ашиглан шавдуулж байжээ. 1945 онд улсын хэмжээгээр шинэ бичиг мэдэгчдийн тоо 65 мянгад хүрсэн гэдэг албан ёсны тоо мэдээ байдаг. 1945 оны 5-р сарын 8-ны өдөр МАХН-ын Төв Хорооны

Тэргүүлэгчдийн болон Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаар бүх албан хэргийг 1945 оны 10-р сарын 1-нээс эхлэн шинэ үсгээр явуулах шийдвэр гаргажээ. 1946 оны 4-р сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны бүгд хурал 1947 оноос эхлэн 16-4О насны бүх хүмүүсийг ялангуяа нам, эвлэлийн гишүүдийг шинэ үсэгт заавал сургах журам тогтоожээ. Мөн бичигтэн бүхэнд жилд гурваас доошгүй хүнийг шинэ бичигт сургах орон тооны багш нар 5О-6О хүнийг бичиг үсэгт тайлсан байхыг үүрэг болгожээ. 1947 оны 7-р сарын 14-нд насанд хүрэгчдийг шинэ бичигт сургах улсын төлөвлөгөөг биелүүлсэн сумд, энэ талаар сайн ажилласан хүмүүс, уг ажлыг харъяалах нутаг дэвсгэр дээрээ сайн зохион байгуулсан сумдын дарга, намын үүрийн нарийн бичгийн дарга нарыг шалгаруулан өндөр шагнал олгох болзол зарлаж, улсын комисс байгуулжээ. 1941-1948 онд хөдөлмөрчдийг шинэ бичигт сургах хэрэгт улсаас 6314О7О төгрөг зарцуулжээ. 1949 оны 12-р сарын 1-нд МАХН-ын Төв Хороо хөдөлмөрчдийг шинэ бичигт сургаж байгаа ажлын явцыг хэлэлцээд тусгай тогтоол гаргажээ. Тэр тогтоолд насанд хүргэгчдийн 55 хувь нь шинэ бичигт суралцсан боловч 45 хувь нь мэдэхгүй байгааг дурдаад шинэ бичгийн мэдцийг улсын хэмжээгээр шалгах, 195О оны 7-р сарын 1-нээс албан бүх хэргийг заавал шинэ үсгээр хөтлөн явуулахыг яам, тусгай газар, аймаг, орон нутгийн удирдлагад үүрэг болгожээ. Шинэ бичигт сургах ажилд тооны хойноос их хөөцөлдөж байсан учир урьд сурсан хэмээн тайлан мэдээнд орсон хүмүүсээ дахин давтан сургахад ихээхэн хүч хөрөнгө зарцуулах хэрэг байнга гарсаар байлаа. Тэр үед үндэсний бичгээ хамгаалан хоцрох гэсэн эрмэлзлийг “Бид үндэсний үзэлтэн, бут цохигдсон феодал, лам нарын үлдэгдлийн зүгээс шинэ бичгийг авч хэрэглэх явдлыг

үндэсний бие даасан байдлаас ухарч, Монгол орныг оросчлох гэсэн оролдлогын илрэл гэж үзэж байгаа аливаа оролдлогод шийдвэртэй няцаалт өгөх ёстой“(14) гэж улс төрийн ноцтой хэрэг болгон, айлган сүрдүүлэх аргаар няцааж байжээ. Бид кирилл үсгийг авах болсныг зүйл бүрээр тайлбарлахыг оролдож, шинжлэх ухааны дүр төрхтэй болгохыг бүх хүчээрээ чармайсаар ирсэн билээ. Үүнд: бүх нийтийг түргэн хугацаанд бичиг үсэгтэй болгох нь манай орны цаашдын хөгжлийн чухал асуудал байсныг заан тэмдэглэдэг. Энэ үнэхээр чухал байсан нь маргаангүй, гэвч монгол бичгээс ч түвэгтэй бичиг үсэгтэй улс орон түүнийгээ халж солилгүйгээр дээрх зорилтыг амжилттай шийдсэн туршлага ЗХУ-ын зарим бүгд найрамдах улсад байсан. Манайд хэрэглэж байсан үсэг бичгээ хаяж, огт мэдэхгүй орос үсгийг авч хэрэглээд үсэг бичиг үл мэдэх явдлыг арилгах гэснээс үндэснийхээ бичиг үсгийг бичиг үсэг үл мэдэгчдэд заасандаа заагаад, гагцхүү тэр ажлыг эрчимтэй явуулсан бол дээрхи зорилтыг нэлээд хялбар шийдэх байсан ч байж мэднэ. Монгол бичгийн бичлэг, дуудлага хоёр бичгийн ба ярианы хэл зөрүүтэйг шалтгаан болгодог. Гэтэл англи хэл бичиг манайхаас ч илүү зөрүүтэй. Гэвч англичууд үндэсний бичгээ солилгүйгээр дэлхийн олон улсын харилцаанд хамгийн их дэлгэрсэн хэл бичиг болоод англи хэл, бичгийн тэр зөрүүг гадаадын хүн, түүний дотор монгол хүн ч учрыг нь олж сураад л байна. Шинэ бичгийг аваагүй бол орчин үеийн шинжлэх ухаан, техникийн хөгжлийн үр шимийг хүртэж чадахгүй байсан мэтээр бичдэг. Гэтэл япон бичиг монгол бичгийг бодвол түмэн бэрхшээлтэй атал Японыг дэлхийн тэргүүний орны нэг болж хөгжихөд нь саад тотгор болсонгүй. Дүрс үсэгтэй, хэдэн мянган ханз тогтоож байж төгс сурах хэрэгтэй болдог хятад үсэгтэй Хятадын ард түмэн соёл

боловсролоо хөгжүүлж хэдэн мянганы уламжлалаа залгамжилсаар XXI зуунд хөгжлөөрөө дэлхийн олон орныг гүйцэхээр тэмүүлж явна. Монгол бичгээр гадаад үг нэр томъёо, шинжлэх ухааны тэмдэглээг тэмдэглэж болдоггүй мэтээр ярьдаг. Гэтэл монгол хэлэнд байхгүй гадаад хэлний авиаг тэмдэглэх маш боловсронгүй галиг үсгийг аль эртнээс зохиож боловсронгуй болгосоор ирсэн бөгөөд энэтхэг, төвд, хятад зэрэг дорно дахины хэлнээс олон арван зохиолыг орчуулахдаа янз бүрийн ухааны нэр томьёо, газар усны болон хүний нэрсийг амжилттай тэмдэглэсээр ирсэн билээ.(15) Ер бичиг үсгийн хөгжлийн дээд шат буюу хамгийн боловсронгуй хэлбэр нь авианы бичиг байдаг. Бидний өвөг дээдэс 1500 гаруй жилийн тэртээгээс энэ боловсронгуй хэлбэрийг хэрэглэж ирсэн нь буурал түүхийн шаралсан хуудаснаас харагдаж бидэнд гайхамшгийг өгүүлсээр байдаг билээ. Одоо Монгол улсын бүх албан хэрэг болон сонин, сэтгүүлүүд кирилл үсгээр хэвлэгдэж байна. 1970–аад оны эцсээр Монгол улс бүх нийтээрээ бичиг үсэгтэн болсон хэмээн ЮНЕСКО-гийн шагнал хүртсэн. Гэвч монгол хэлний үгсийн сангийн баялаг байдал алдагдаж, орчуулгын модон хэл үгсийн санд олширч, эгшиг гийгүүлэгчийн харьцаа эвдэгдэн хэлний яруу сонсголонт байдал алдагдсан юм. Зөв бичих зүйн ээдрээтэй дүрэм нь одоо болтол цэгцэрч нэг мөр болж чадаагүй байна. Үндэсний хэмжээний бичиг үсгийн болон эх хэлний цэгцтэй бодлогогүй явж ирсний улмаас эх хэлээрээ яруу сайхан сэтгэж, бичих явдал мэргэжлийн хүнээр хязгаарлагдах болсон байна. Дунд сургуульд ч дан дүрмийн сургалтыг голлон явуулж өрөөсгөл хандсанаас болоод эх хэлнийхээ тансаг сайханд дурлах явдал алга болсон билээ. Ардчилал эхэлсэнээс хойш нийгмийн амьдралд олон сайхан өөрчлөлт болсон боловч эх

хэлний бодлого эзэнгүй болж яруу тансаг найруулга гэж ярихад бүр ч хэцүү болоод байна. Модон хэлтэй, унших яруу сайхан зүйлгүй олон арван сонины үер буулаа.

▪4.1990 оноос хойших Сонгодог монгол бичгийг сэргээн хэрэглэх хөдөлгөөн хийгээд үндсэн маргаан

1941 онд түүхийн ээдрээт нөхцөл шалтгаан, төр засгийн хатуу шийдвэрээр кирилл үсгийг албан ёсны бичиг болгон хэрэглэсэн боловч монголын уламжлалт худам монгол бичиг утга соёлын хэрэглээнээс бүрэн гарсангүй. 1990 оноос монгол бичигтээ эргэж орох тухай хурц маргаан үүсэж, түүнийг төрийн бичиг болгох олон нийтийн санал хүчтэй болсоор ирэв. Монгол бичгийг кириллээр сольсны дараа хамгийн их бэрхшээлтэй тулгарсан хүмүүс бол зохиолчид байсан. Монгол бичгээр зохиолынхоо эх дээр ажиллах нь хэл найруулга, дуудлага болоод бичлэгийн тансаг байдлыг эрхэмлэхэд илүү төхөмтэй учраас тэр юм. 1962 онд МЗЭ-ийн III их хурлын өмнө Улс төрийн товчоонд зохиолчдыг хүлээн авч уулзсан байна. Энэ үед “Тунгалаг тамир” романаа бичиж байсан нэрт зохиолч Ч.Лодойдамба гар бичмэлээсээ жишээ татаж ярихдаа: Монголоор бичиж, дараа нь шинэ үсгээр буулгачихаад эргээд уншихад сайхан нь алга болчихдог болохыг тайлбарлаж, бага цаг алдсан дээрээ эргэж монгол бичгээ хэрэглэе гэсэн санал тавихад нь Ю.Цэдэнбал няцаажээ. Монгол бичгийн хэлний сонгодог уламжлалыг өвлөн залгамжилсан Б.Ренчингийн хэл найруулгыг таашаахгүй байснаар үл барам түүний нөлөө залуучуудад халдварлахаас айж байсан. Хуучирсан үг хэрэглэж, хуучин бичгийн хэв маягаар хөөцөлдлөө гэж залуу шүлэгч нарыг хүртэл зэмлэж байжээ.(16) 1980-аад оны дунд үеэс өөрчлөн

байгуулалтын үзэл санаагаар цэнэглэгдсэн монголчуудын үндэсний ухамсар илтэд сэргэж, үндэсний монгол бичгээ сурах хөдөлгөөн газар сайгүй өрнөсөн билээ. Тэр ч бүү хэл дунд сургуульд 50-иад оны сүүлээс огт үзэхээ байсан монгол бичгийн хичээлийг дунд сургуулийн 7, 8-р ангид үзэх болж, дунд сургуулийн болон олон нийтэд үзэхэд зориулсан монгол бичгийн сурах бичгүүд зохиогдон гарч эхлэв. 1970-аад онд зохиогдсон Д.Чойжилсүрэн, Х.Далхжав нарын монгол бичгийн сурах бичгийн дараа 1986 онд Чой.Лувсанжав, Ж.Лувсандорж нарын дунд сургуульд үзэх монгол бичгийн сурах бичиг гарч, хот хөдөөд албан байгууллага, соёл үйлчилгээний газруудад монгол бичгийн дугуйлан, дамжаа хичээлүүлж эхлүүлэн, телевизээр МУИС-ийн багш Ш.Чоймаа монгол бичгийн хичээл зааж, сургалтын зарим материал хэвлэгдэн гарлаа. Үүний хажуугаар монгол ёс заншил, шашин соёлын зан үйл сэргэж эхлэв. 1990 он гэхэд үндэсний сэхээтнүүдийн дуу хоолой сонин болгоноор цууриатаж байлаа. 1990 оны 6-р сард Сайд нарын зөвлөлийн 285 тоот тогтоол гарч 1990-1995 онд багтааж бүх нийтийг хос бичигтэн болгох, улмаар монгол бичгийг төрийн албан бичиг болгохоор заав. Энэ тогтоолын дагуу Ардын болосролын яамны сайдын тушаалууд гарч нэгдүгээр ангиас монгол бичгээр сургалт явуулах шийдвэр гаргав. Ардчилсан холбоо болон ардчиллын удирдагч нар илтгэл, өгүүлэл, мөрийн хөтөлбөртөө эн тэргүүнд тусгаж, ардчилсан хувьсгалын нэг гол уриа нь мянган жилийн уламжлалт үндэсний бичгээ сэргээх явдал байв. Сонин сэтгүүлүүдэд “Монголчууд бид 1941 онд монгол бичгээ кирилл үсгээр сольж гучаад жилийн дотор ард түмнээ бичиг үсэгтэн болгож, тив дэлхийд гайхагдаж байсан боловч дэлхийн бичиг үсгийн соёлын санд оруулсан оюуны үнэт соёлоо орхиж том

алдаа хийсэн юм. …Хойч үедээ бид монгол бичгээ бүрэн өвлүүлэхийн тулд бүх нийтийн сургалтын бодлого явуулах нь зүйтэй”(17) “Манай зарим зохиолч хорьдугаар зуунд хос морьтой орохыг уриалсан билээ. Миний бодоход монгол бичиг гэдэг хүлэгт маань хөтөлгөө хэрэггүй бизээ. Бичиг минь, хүлэг минь бид чинь Таныгаа даруй дээдлэн залъя”(18) “Монгол бичгийн түүхэн урт үйл явцтай салшгүй нэгдэж бий болсон монгол шүлэг маань эргээд төрөлх бичгээ үгүйлж байгаа нь зайлшгүй байна”(19). “Тавиас доош насны иргэдийн дотор хуучин монголоор бичих байтугай, уншиж чадах хүн нэн ховорджээ. Үндэсний бичгээ мэдэхгүйн балгаар залуучууд ард түмнийхээ бүтээсэн соёлын өвтэй танилцан эзэмших боломжоор их л гачигдан боогдох болсон билээ.”(20) “1990 онд нийтээр бичиж уншиж сураад 1991 оноос гүнзгийрүүлсэн сургалтад орж болох юм. Монголын ард түмний эх оронч ухамсар, үндэсний бахархал бадран дэгжиж байгаа энэ үед үндэснийхээ соёлыг сэргээн мандуулахын төлөө зоримог алхам хийхээс хойш суух монгол хүн үгүй гэдэгт гүн итгэлтэй байна.”(21) гэх мэтээр бичиж байсан бөгөөд эрдэмтэн Ц.Шагдарсүрэн “Монгол бичиг, түүнийг үзэж сурахын учир” хэмээх гарчигтай хэл шинжлэлийн нарийн үндэстэй тайлбарласан өгүүлэл хэвлүүлсэн байна.(22) Мөн оноос Улсын хэвлэлийн газар монгол бичгээр ном хэвлэх боломжийг бүрдүүлж зарим сурах бичиг, “Монголын нууц товчоо” зэргийг монгол бичгээр хэвлээд байв. Монгол бичигтэй холбоотой газруудын санаачлагаар 21 хүний бүрэлдхүүнтэй Монгол бичгийн ардын хүрээлэн байгуулагдаж монгол бичгээ улс даяар дэлгэрүүлэн сургах ажлыг зохион байгуулахад саланги хэсгүүдийн ажлыг нэгтгэн чиглүүхэд үйлчлэнэ гэж тунхагласан байна. 1991 онд олон нийтийн эрчимтэй хөдөлгөөн, монголын эх

оронч дэвшилт сэхээтнүүдийн чармайлт зүтгэлээр албан хэргийг 1994 оноос монгол бичгээр хөтлөн явуулах 36-р тогтоолыг Улсын бага хурлын ухаалаг эрхэм гишүүд гаргав. Үүний дагуу БНМАУ-ын засгийн газар 1991 оны 6-р сарын 21-ны өдөр “БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай” 186-р тогтоол гаргав. Тогтоолд хавсралтаар бэлтгэлийг удирдан явуулах комиссын бүрэлдхүүнийг Засгийн газрын шадар сайд Д.Дорлигжав даргатай, Боловсролын сайд Н.Уртнасан, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Моломжамц нарын орлогч даргатай байгуулж гишүүдэд Боловсролын тэргүүн дэд сайд Б.Энхтүвшин, Хууль зүйн сайд Ж.Амарсанаа, Үндэсний хөгжлийн сайд Ж.Батсуурь, Худалдаа үйлдвэрийн сайд С.Баярбаатар, Сангийн сайд А.Базархүү, Соёл урлагын хорооны дарга Б.Бадар-Уган, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Баатар, Засгийн газрын дэргэдэх радио, телевизийн ерөнхий захирал Х.Цэвлээ, Улсын архивын хэрэг эрхлэх газрын дарга Л.Мэндсайхан нарын лут их хүчтэй комиссыг байгуулжээ. Энэ тогтоол нь: нийт хүн амыг 1991-1993 онд монгол бичигт сургах, хөтөлбөр, сурах бичиг, гарын авлага, монгол бичгийн зөв бичих зүйн толь боловсруулан гаргах, туршлагатай, монгол бичгийг төгс эзэмшсэн хүмүүсээр заалгах, их дээд сургуулийн монгол хэлний ангийн болон багшийн сургуулийн оюутнуудаар 1992 оноос хөдөлмөрчдийн дунд монгол бичиг заалгах, төрийн захиргаа, олон нийтийн байгууллагад ажиллах монгол бичгийн бичээч нарыг уг байгууллагуудын зардлаар нь сургаж бэлтгэх, орон нутагт сургах ажлыг орон нутгын засаг захиргаанд даалгах, төв, орон нутгийн хэвлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэн тоноглож, хэрэгцээт бичгийн машинаар 1992-1993 онд хангах, шаардагдах хөрөнгийг

гаргах, хэвлэл мэдээллээр сурталчлах, сонин сэтгүүлд нүүр булан гаргах, заримыг монгол бичгээр дагнан хэвлэх гэх зэргийн тус тусын яаманд хариуцуулсан бүх талыг хамарсан, монгол түмний сэтгэл зүрхийг баясаасан тогтоол болж гарсан юм.(23) 1991 оны хичээлийн жилээс эхлэн бага сургуульд орсон сурагчдад монгол бичгээр хичээл зааж эхлэн сурах бичгүүдийг хэвлэн гаргаж эхэллээ. Чой.Лувсанжав багшийн хичээл зүтгэлээр Япон улсад тусгай захиалан хийлгэсэн 1000 ширхэг цахим бичгийн машин хүрэлцэн ирж бичээч нарын курс зохион байгуулав. Шагжийн “Зөв бичих дүрмийн толь”-ийг Өвөрмонголд дахин хэвлүүлж Чой.Лувсанжав, Ж.Бат-Ирээдүй нарын зөв бичих дүрмийн толиуд гарав. 1991-1993 он бол монгол бичиг сурах их өрнөлтийн үе байлаа. Нэрт сэтгүүлч Т.Галдангийн санаачлагаар монгол улсад цор ганц “Хүмүүн бичиг” хэмээх сонин гарч, одоо хүртэл тасралтгүй хэвлэгдсээр байна. Гэвч 1993 оноос сургалтын эрч нь саарч эхэлсэн байна. Хамгийн түрүүнд монгол бичгээр сургалт явуулж байгаа сурагчдын эцэг, эх, тэд нарт зааж байгаа багш нараас эсэргүүцэл гарч эхэллээ. Монгол бичгээ байтугай эх түүхээ мэдэхгүй европжсон соёлт залуу эцэг эхчүүд хүүхдэдээ тусалж чадахгүйн бухимдал, үсэг нүдлүүлэх хялбар аргад дасаж сурсан, үеийн аргаар сургадаг уламжлалт аргыг мэдэхгүй багш нарын залхуурал нэгдэн нийлж монгол бичгийг муучлахын эхийг тавив. Үүнийг уухайн тас шүүрэн авч Монголын ардчилсан хүчний сонинууд монгол бичгийг сэргээхийн эсрэг компани дэгдээж дөчөөд оныг давтаж эхлэв. Энэ тухай “Ил товчоо” сонинд Чех улсын монголч эрдэмтэн Давид Лукаш “Одоогийн монголын сэхээтнүүд түүний дотор оппозиц хүчний сэхээтнүүдийн олонх нь орос дунд сургуулиар дамжиж, ЗХУ агсанд дээд боловсрол олсон, коммунист номенклатурын

хүүхдүүд мөн нь нууц биш. Тэд нэгэнт эх хэл, эх соёлоосоо бүрэн таслагдсан учраас дуудлага бичлэгийн зарим зөрөөтэй /англи, франц шиг их дөрөөтэй биш/ болсон монгол бичгийг сурахаас үнэнхүү бэрхшээж монгол бичгээ сэргээх байтугай харахыг ч хүсэхгүй байна. Монгол бичгийн эсрэг тэдний дэгдээж байгаа компанийг Сталин, Чойбалсангийн ачаар эрдмийн өндөр зэрэгтэй болж авсан хуучинсаг үзэлтэй зарим хүн өдөөн дэвэргэж, засгийн эрхийг баригч коммунист МАХН чимээгүйхэн сахал дотроо битүү инээмсэглэн харж байна" хэмээн бичиж байв.(24) 1941 онд кирилл бичгийг аваад сэхээтнүүд хамгийн хойрго хандаж, далдуур эсэргүүцэн байсан боловч нам төрийн хүчтэй нударгын шаардлагаар сурсан бол өнөөгийн монголын сэхээтнүүд бас л монгол бичгээ сэргээх шийдвэрийг эрчимтэй эсэргүүцэж ардчилсан нийгэм гэдэг үзлийн дор, нөгөө талаас угаасаа монгол сэтгэхүйгээсээ хэт холдсон учир огт ойлгохгүйгээсээ болж өөрсөд шигээ мунхарсан олныг хөөрөгдөн дагуулж монгол бичиг сэргээх компанит ажлыг төр олон нийтийн бүхий л хэрэгсэлээр эсэргүүцэн тэмцсэн юм. Энэ нь хүн амын тогтворгүй хэсэг болох залуучуудыг уруу татаж тэдний сурах эрчийг сааруулав. Мөн нөгөөтэйгүүр Улсын их хурлын зарим гишүүд латин үсгийг албан хэрэгт хэрэглэх төсөл өргөн барих зэргээр олон нийтийн анхаарлыг ихээхэн саармагжуулсан болой. "Кирилл бичиг авах үеийн сэхээтнүүдийн эсэргүүцэл бол яруу тансаг баялаг сайхан найруулгат дэлхийд хаана ч байхгүй үндэсний бичиг үсгээ гээж орхихын эсрэг бухимдал байсан. Харин энэ цагийн сэхээтнүүдийн энэ эсэргүүцэл бол залхуурал, ухаан мулгуугийн шинж хийгээд уламжлалт соёл, зан заншил, хэл сэтгэхүйгээсээ хэрхэн холдож, бие нь монгол, ухаан нь харийнх болсныг харуулсан тод жишээ болсон юм. Нөгөө талаар

хуучин биднийг бүх зүйлээр хянаж байсан улс, монголчуудын үндэсний ухамсар нэн ихээр өрнөн дэлгэрэхээс эмээсэн бодлын болгоомжилсон санаа бодол ч тэднээр дамжин хэрэгжсэн нь энэ болой. Сонгуульд ялахын тулд сонгогчдоос хамгийн их оноо авах гэж үндэсний үзлийг хуурамч хөөрөгдөж байсны илрэл бас болов" хэмээн монгол бичгийн хөдөлгөөнийхөн дүгнэж байв. 1993 онд хийсэн Албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг эрхлэх улсын комимссын хурлыг Монгол улсын шадар сайд Л.Энэбиш даргалан хийлгэж "Монгол бичиг сургах ажил үнэн чанартаа их үлбэгэр явж, төв орон нутгийн төрийн байгууллагууд жигд ажиллаж чадсангүй" гэсэн дүгнэлт хийсэн байна. Тэгээд 1994 онд сургалтыг эрчимжүүлж, монгол бичиг сайн мэддэг багш, оюутан, сурагчид, хүмүүсийг дайчлан оролцуулах нь зүйтэй бөгөөд засгийн газарт цаашдын бодлого чиглэлийг оруулж шийдвэр гаргуулах нь зүйтэй гэж тогтжээ. Мөн энэ үед монгол бичгийг дэмжигч эрдэмтэн, зохиолч, сэхээтнүүд нийгэмлэг байгуулж төрийн ордонд их хурлаа хийж төр засгийн удирдлагад өргөх бичиг илгээв. Үүний дагуу 1994 оны 3-р сарын 16-нд Монгол улсын засгийн газрын Албан хэргийг монгол бичгээр хөтлөх бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 64 тоот тогтоол гарав. Үүнд: Төрийн яам, газар, байгууллагуудын албан хаагчдыг 1994 онд багтаан монгол бичигт сургаж, 1995 онд төрийн албан хэргийг монгол бичгээр эрхлэх түвшинд хүртэл чадваржуулах, 16-49 насны бүх хүнийг 1995-1996 онд багтаан монгол бичигт тайлах ажлыг зохион байгуулах, зохион байгуулалт захирамжлалын баримт бичгийг стандартын холбогдох байгууллагуудтай хамтран 1994 онд багтаан боловсруулах, Ерөнхий боловсролын сургуулиудын I-IV ангийн бүх хичээлийг монгол бичгээр, V-X ангиудад

нийгмийн ухааны хичээлүүдийг монгол бичгээр, бусад хичээлийг кирилл үсгээр тус тус явуулж байгааг зүйтэй гэж үзэж цаашид монгол бичиг хэрэглэх явдлыг боловсролын бүх шатны сургалтад гүнзгийрүүлэх арга хэмжээ авах, бүх сонин хэвлэлийн зарим материалыг монгол бичгээр гаргах, батлагдан гарч байгаа хуулиудыг монгол кирилл бичгээр хамт хэвлэж байх, яам тусгай газрууд батлан гаргаж байгаа нийтлэг шинж чанартай эрх зүйн актуудыг монгол бичгээр бичиж харъяа байгууллагууддаа хүргэж байх, радио, телевизын хөтөлбөр, үзвэр үйлчилгээний зарлал, улс хоорондын харилцааны нот бичиг, гэрээ хэлцэл зэргийг монгол бичгээр үйлдэж байх, 1994 оноос монгол бичгээр хөтөлж эхлэх албан бичгийн төрөл, түүний жагсаалтыг энэ оны эхний хагаст багтаан баталж холбогдох газруудад хүргүүлж мөрдүүлэх, бэлтгэлийг хангах улсын комиссын нарийн бичгийн даргыг томилж ажиллуулах зэрэг заалтуудыг тус тусын хариуцсан газарт нь даалгажээ. Энэ тогтоолыг гарсны дараа Ж.Мягмарсүрэн нарын сэтгүүлчид “Сэрэхгүй бол сайхан зүүд” хэмээн тавлан Монголыг дундад зуунтай нь хадах гэлээ хэмээн бухимдан бичиж улсын их хурлын гишүүдийг сэнхрэхийг уриалж байв. Зарим сэтгүүлч өөрсдийн санасан бодсоноороо цэцэрхэж зарим нэг эрдэмтэд ч инээдтэй хөгийн юм бичиж нийтлэх болов. Эдгээр хөгийн юмны хариуд С.Дулам нарын эрдэмтэд их хурлын эрхэм гишүүдэд илгээлт явуулж “Ирээдүйгээ харж шийдэх ёстой асуудал гэж бас байдаг бөгөөд тэдний нэг нь монгол бичиг мөн. Монгол бичиг бол ирээдүй олон улиралд тодрон гэрэлтэх хүний оюуны эрхэм үнэт зүйлсийн нэгэн бөгөөд өнөөдөр үүсэл гарлыг нь монгол биш гэж шүүмжилж байгаа улс ирээдүйд харин ч дэлхийн олон үеийн олон үндэстний оюун билгээр шүүн тунгаагдаж, тэр дундаа монгол хүний сэтгэлгээний мөн чанарыг

гайхалтай хадгалснаараа улам ч гайхагдах болно гэдгийг сэхээрэх нь соёлт хүний өмнө хүлээх бидний нэг бичигдээгүй үүрэг нь юм" хэмээн харамсан анхааруулж 64-р тогтоолыг хэвээр үлдээхийг уриалж байв. Гэвч 1994 оны УИХ-ын хаврын чуулганы сүүлчийн өдөр баталсан 66-р тогтоол нь мянга гаруй жилийн түүхтэй хүн төрөлхтний соёлын өвийг уламжлан суралцах үр үндсийг эрх зүйн хувьд бүрэн тасалж түүхэнд үзэгдээгүй ихээр туйлшрав. Ерөнхийлөгч хориг тавиад ч дийлсэнгүй. "Төрийн толгойд уламжлал, зан заншил, түүх соёл, үндэсний хэлбичиг, ард түмнийхээ ахуй амьдралыг мэдэхгүй хүмүүс гарвал ямар аюултай гэдгийг яруу тод харуулав. Эргүү тэнэгүүдийг эзэн ноён суулгавал эрхгүй түмэн ардыг зовооюу хэмээсэн эрдэнийн сан субашидийн доторх сургаал юутай үнэн бэ. Монгол бичиг үсгийн түүх нь эхнээсээ аваад эцсээ хүртэл монголын ард түмний биеэ даасан байдал, тусгаар тогтнолын түүхтэй хамгийн нягт холбоотой байдаг гэдгийг тэд огт ойлгосонгүй."(25) Тэр үеийн монгол бичгийг дэмжигч сэтгүүлчид, үндэсний бичиг үсгийг сэргээхийн төлөө хөдөлгөөнийхөн Улсын их хурал архичинд гаргаагүй аагаа монгол бичигт гаргалаа хэмээн халаглан бичиж байв. Улс орноо хөгжүүлэхэд шинжлэх ухаан техникийн дэвшил, шинэ соёл маш чухал нь мэдээж боловч уламжлалт соёл, зан заншил, бичиг үсгээ гээнэ гэдэг улс үндэстэн мөхөхийн шинж болой. Харин орхигдсоныг буюу мартагдсаныг сэргээн бий болгож шинэтэй хослох нь улс үндэстэн мандан бадрахын эхэн юм. Соёл, зан заншил хийгээд хэл, үндэсний бичиг үсэг нь тухайн ард түмний тусгаар тогтнолын билэг тэмдэг болж байдаг. Шашин ч гэсэн ард түмний итгэл бишрэл соёл заншлын олон зүйлийг хадгалж явдгаараа тухайн ард түмний оюун санааны үнэт зүйл болж байдаг. Хэл, бичиг үсэг, соёл, шашнаас нь

хүмүүсийг салгаж өөрийн сэтгэхүйд оруулна гэдэг бага хугацаа шаардах зүйл. Европжуулах 50 жилийн их аяны эцэст монголоор сэтгэнэ гэдэг бол модон толгойн бодол гэж бодохдоо хүртэл бид өөрчлөгдсөн байна. Тухайн ард түмний сэтгэлгээ бол эх орон, эрх чөлөөт тусгаар тогтнолын баталгаа болсон түүх, хэл хийгээд хэл бичиг, зан заншил, шашин, соёл, ахуй амьдралын дэг жаяг, байгаль цаг уур, аж төрөх ёстой нягт холбоотой бүхэл бүтэн цогц байдаг. Эдгээрийг мэдэх буюу үзэж судлахгүйгээр юмыг хялбархнаар үгүйсгэн бодох нь ухаант хүний бус харин тэнэг хүний бодол болой. Олон зууны түүхтэй бичиг соёлын дурсгал болох Монгол бичиг маань хуучирч ойлгомжгүй болсондоо бус бидний ухаан мунхарч ойлгохыг хүсэхгүйдээ, ойлгож чадахгүй болсондоо байгаа билээ. 50-иад жил явцуу хүрээнд хэрэглэж байсан бичгийн хэлбэрийг амархан сэргээн хэрэглэж болохын жишээ бол Еврей хэл, бичиг үсгийг сэргээсэн Израиль улсын туршлага байна. Еврей хэл бичиг үсгийн сэргэн мандалт олон арван жилийн уйгагүй хөдөлмөрийн үр дүнд ярианы хэлнээ XX зууны эхээр хүн төрөлхтөний соёлын чухал зүйлийн нэг болон зохих байраа эзэлжээ. Одоо еврей хэл Израиль улсын албан ёсны хэл бөгөөд тус улсын аман болон бичгийн харилцааны үндсэн хэрэглүүр болж байна.

Израиль улсын хэлний гарамгай эрдэмтэн Элиэзер Бен-Иегуда, Эррец Исраэль нар болон орчин цагийн хэлний олон ухаалаг эрдэмтэд хийгээд улс үндэстэн, уламжлалт соёлоо гэсэн ард түмний ариун хүсэл зүтгэлээр энэ хэл хийгээд бичиг үсэг сэргэн мандсан юм. 1953 онд Еврей хэлний академи байгуулсан нь үүний нэг тод жишээ болой. Энэ академи эх хэлээ хөгжүүлэх түүнийг цэвэр ариун байлгах, журамлах ажил эрхэлдэг байна. Гэтэл бид хэл болоод бичиг үсгийнхээ хөгжил, түүх, зүй тогтлыг

судалдаг ганц Хэл зохиолын хүрээлэнгээ өөд татаж чадаж байна уу даа. Мартагдан сөнөсөн энэ хэлний олон арван мянган үгийг судар номын хэлнээс шинээр сэргээх буюу бий болгожээ. XIII зууны Хан-анагийн байлдан дагуулалтаас эхлээд Бар-Кохбын бослогын сүүл хүртэл Израильчууд еврей хэлээр бага сага ярьж байсан билээ. Түүний дараа еврей хэл амьд ярианы хэлнээс бүрмөсөн хасагдаж бүр зуун жилийн өмнө гэхэд ч еврей хэл амьд ярианы хэл болно гэхэд хэн ч итгэхгүй байсан буй заа. Вавилоны хаанчлалын үед тэд армейнаар мөн бас грекээр ярьж байсан байна. Үнэндээ МЭ 70 оноос 1948 он хүртэл еврейн ард түмэн нийтээр еврей хэлээр огт ярьж бичиж байсангүй. Энэ хэл гагц Иудийн сургаалд л үлдэж хоцорсон байна. Энэ хэлийг устаж байх үед энэ хэлээр шашин, байгалийн шинжлэх ухаан хийгээд яруу найраг, уран зохиолын арвин их бүтээлүүдийг туурвин гаргасан байжээ. Зарим оронд еврейчүүд хэлээ мартахгүйн тулд бичиг захидал болон бичиг баримтаа еврей хэлээр бичиж байсан байна. Жишээлбэл дундад зууны Англи оронд бараг зуугаад жил данс дараа еврей хэлээр хөтөлж байсан байна. Мөн зарим оронд наймаачдын хэл ч болж байв. Ялангуяа сүсэгтэн олон хагас сайн өдөр энэ хэлээр ярьдаг байсан нь буй. Гэвч Еврейн ард түмэн зөвхөн номонд бичигдсэн л ард түмэн байлаа. Еврей хэл дундад зууны үеэс энэ ард түмний тусгаар тогтнолын билэг тэмдэг байхаа больсон байв. Үгийн хэлбэрийн хувьд шинэ үг хуучин хоёрын ялгаа мэдэгдэхгүй болсон байна. Янз бүрийн үед зохиогдсон судар номыг судлах замаар одоогийн тэдний хэрэглэж байгаа үгсийн санг бүрэлдүүлжээ.

Еврейн библийн үгсийн сангийн бүрэлдэхүүн 30000 гарч байсан бөгөөд хожим библийн үгсийн санд 8000 болж үлдсэн байв. Судалгаанаас үзэхэд аливаа хэлний 1000 үгийн 85 хувь нь

ердийн үгээр бүтдэг байна. Еврей хэлний 1000 үгийн 800 үг нь судрын үгс байсан байна. Орчин цагийн 120000 үгсийн сангийн 60000-аас илүү олон үг судрын хэлний үг байна.

Сонины мэдээллийн ердийн текстийг ангилал хийж үзэхэд 60-70 хувь нь библийн судрын үгс бөгөөд 20 хувь нь Мишнын номд дайралддаг үгс хийгээд үлдсэн жаахан хувь нь дундад зууны буюу орчин үед бүрэлдэн бий болсон үгс байна.

Израиль улсын бичиг үсэг хийгээд амьд ярианы хэлээ сэргээн хөгжүүлсэн түүх бол улс үндэснийхээ түүх соёлыг дээдлэн хүндэлж цэцэглүүлсэн дэлхийн түүхэнд байхгүй гарамгай гавъяат үйлс билээ.

Шимона Бернфельд энэ тухай хэлэхдээ “Амьд ярианы хэл болно гэдэг миний бодлоор бараг бүтэшгүй зүйл байлаа. Тийм туршлага ч байгаагүй.

Хагарсан савыг бүтэн болгож болдоггүйтэйн адил хөгжихөө больж мартагдсан хэлийг сэргээнэ гэдэг бол түүх, утга зохиол, шашны хэлэнд түүхэн чухал үйл явдал болсноос гадна амьд ярианы хэлгүй ард түмэнд ч үлгэр дууриалт явдал болсон юм” гэжээ. Профессор Хайм Рабин “Еврей хэлний хувьд утга зохиолын хэл хийгээд амьд ярианы хэл болно гэдэг миний хувьд үзсэн цорын ганц тохиолдол” хэмээжээ.

Ухаант улс үндэстэн мартагдаж мөхсөнөө сэргээж маргаашийн ирээдүй рүү түүнийхээ хамт орохоор зүтгэж явахад амьд байгаа бичиг үсгийн соёлоо ад үзэн бусдын үсгээр явна хэмээн зүтгэхийн учир байна уу? үгүй юу. 1990-ээд оны эхэн, дунд үед төр засгын тогтоол, шийдвэрийн дагуу төр, захиргааны болон олон нийтийн бүх байгууллагын хаягийг монгол бичгээр хийж байсан боловч одоо эргээд ховх татан хаяж оронд нь англи, кириллээр буюу дан англиар бичих болсон байна. 70,80-

аад онуудад Улаанбаатарт ирж байсан хөдөөний хүн; -Би өөрөө очих газраа олно гэж яваад орой туйлын урам муутай ирээд:
-Дан гадаад үгээр бичсэн хаягаар очих газраа олж чадсангүй гэж хэлж байсан тохиолдол гарч байв.
Мөн монгол хэл соёлын сургалт, эх хэлний цэвэр ариун байдлын талаар бодлого огт байхгүй болж төрийн албаны хүмүүс ч яруу сайхнаар илтгэл номлол тавихаа байсан байна. Гадаад хэл төгс эзэмшсэн их сайхан залуус эрлийз болон модон хэлээр ярих, орчуулга хийх нь олшров. Доктор Э.Равдан “Гадаад хэл, түүний дэл сул үг, хэллэгээр чамирхах өвчин УИХ-ын ухаант гишүүдийг ч харамсалтай нь тойрсонгүй” хэмээн “Өнөөдөр” сонинд бичсэн нь туйлын үнэн билээ.(26)

Аливаа үндэстэн ястны хэл нь түүхийн янз бүрийн учир шалтгаанаар бусад хэлтэй сүлэлдэж, тэдгээртэй харилцан бие биеэ баяжуулж байдаг нь соёлын амьдралын нийтлэг зүй тогтлын илрэл юм. Харийн хэлийг төрийн тодорхой ухаалаг бодлогогүй, урсгалаар нэвтрүүлэх нь өнөөдөр төдийлөн хор уршиггүй мэт санагдавч, урьд бусад ард түмний унаган хэлэнд тохиолдсон эмгэнэлт явдлыг давтаж болох үр хөрөнгийг өөртөө агуулж байхыг үгүйсгэх аргагүй. Үүнийг өнөөдөр л сайн ухаарч мэдэрч төрөлх хэлээ хадгалж хамгаалах талаар санаа тавихгүй бол маргааш хичнээн ойлголоо ч гэсэн нэгэнт хожимдсон байх болно. Монголын төрөөс баримтлах хэлний бодлогыг жинхэнэ мэргэжлийн хүмүүс эрдэмтэд, судлаачдын санал дүгнэлтэд тулгуурлан гүнзгий ул үндэстэй боловсруулж, үндэсний аюулгүй байдлын хэмжээнд тавьж мөрдөхийн чухал нь эндээс харагдах биз ээ.(27) Эх хэл, бичиг үсгийн үндэсний бодлого боловсруулах цаг нэгэнт болсон байна.

“Финикээс үүсэлтэй, армейгээр дамжин салбарласан бичгийг хэрэглэж байсан согдууд VIII зуунд, уйгарууд XI зуунд арабын буюу лалын хүрээнд орж араб бичиг авсны учир түрүүчийн хэрэглэж байсан бичгээ орхисон билээ. Харин монголчууд бид согдоос авсан худам монгол бичгээ орхиж мартсангүй, харин ч монгол хэлэндээ таацуулан боловсруулж өнөөдрийг хүртэл хэрэглэж байгаа нь монголын ард түмнээс дэлхийн үсэг бичгийн түүхэнд гүйцэтгэсэн нэгэн чухаг хувь нэмэр даруй мөн” гэж доктор Ц.Шагдарсүрэн бичсэнтэй(28) санал нийлэхгүй байхын аргагүй юм. Манай ард түмэн уйгар бичгийг зөвхөн хуулбарлан хэрэглэсэн биш түүнийг монгол хэлний онцлогт тохируулан улам боловсронгүй болгон засаж хэрэглэсэн нь ч бас манай уламжлалт соёлын нэгэн том ололт мөн. ”XVI зууны эцэс хүртэл хэрэглэж байсан эртний уйгар монгол бичиг, түүнээс хойш хэрэглэж буй шинэ монгол бичиг хоёр нь бие биетэйгээ ихээхэн ойролцоо боловч маш их ялгаатай” гэж Б.Я.Владимерцов тэмдэглэсэн байдаг.(29) Өнөөгийн шатанд монголчууд биднийг болон бидний зарим нь өөрсдийгөө сая л нэг дэлхийн соёл иргэншлийн замд хөл тавьж эхэлж байгаа угийн бүдүүлэг хоцрогдсон улс гэж хочлон, ингэснээрээ өөрсдөө өндөр соёлтон болж харагдахыг оролддог. Гэтэл тэдгээр “Өндөр соёлтнууд” маань түүхэндээ арваад бичиг, түүний дотор тод, дөрвөлжин, соёмбо зэрэг нэн боловсронгуй авианы бичиг үсгийг зохион хэрэглэж тэдгээрийн дурсгал нь хүн төрөлхтний бичгийн соёлын түүхнээ баттай байр суурыг аль хэдийнээ эзэлсэн хийгээд эдүгээ нэгэнт дэлхийжсэн олдмол бичгийн зэрэгцээгээр өөрийн язгуурын уламжлалт бичгээ хэрэглэсээр байгаа монголоос өөр ямар ард түмнийг нэрлэж чадахсан бол. Босоо монгол бичиг нь төрөлх монгол хэлний онцлогт гайхамшигтай

зохицсон нэн боловсронгуй бичиг мөн бөгөөд гадаад үг, газар ус хүний нэр, орчин үеийн шинжлэх ухааны нэр томьёо, тэмдэг томьёолол сэлтийг тэмдэглэхэд ч саад бэрхшээл учрахгүйгээр зохиосон маш боловсронгүй галиг үсгийн системтэй билээ. Олон улсын амьдрал улам бүр дэлхийжиж, орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололт түргэн нэвтэрч, мэдээллийн олон улсын стандарт төлөвшиж англи хэл нь латин үсэг хэмээх “Унаатайгаа” хүн төрөлхтний ихээхэн хэсгийг байлдан дагуулж байгаа хийгээд Монгол улс өрнөдийн соёл иргэншлийн нөлөөнд хүчтэй татагдан орж буй бодит байдал нь язгуурын монгол бичгийн хувь заяаг ихээхэн ээдрээтэй болгож байна. Сүүлийн хэдэн жилийн дотор нэн хүчтэй болж байгаа төрөлх хэл эрлийзжих үйл явц уг хэлтэй амин судсаар холбогдсон монгол бичигт эрс тэс харшилж байна. Тэглээ гээд худам монгол бичиг бүрэн орхигдох бодитой нөхцөл шалтгааныг монголын эрдэмтэн мэргэд одоохондоо олж харахгүй байна. Хүн амын суурь боловсрол, албан ба албан биш сургалтад уламжлалт монгол бичгийнхээ эдлэх давуу эрх, байр суурийг хангаж, төрийн зарим хэрэг, жишээлбэл ёслол, хүндэтгэлийн баримт бичгийг монгол бичгээрээ үйлдэж, монголын түүх, уран зохиолын ном шаштираа эл бичгээр хэвлэж, ард иргэдийн харилцаанд худам монгол бичиг өргөн хэрэглэхийг үндэсний бахархал, эх оронч үзэл, ёс зүйн асуудал гэж үзэх сэтгэл зүйн уур амьсгалыг төлөвшүүлэх, орчин үеийн шинэ шаардлагад тохируулан уг бичигт сургах талаар зарим шинэчлэл хийх талаар монгол бичгийн эрдэмтэн мэргэд санаа тавих зэргээр монгол бичгийнхээ хэрэглээний талбарыг өргөтгөх бололцоо бүрэн байна. Гагцхүү төрөөс баримтлах хэлний ба бичиг үсгийн бодлого нэгдмэл байх, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, оньс хэрэгслэл нь боловсронгуй байх шаардлагатай

бөгөөд тэр бодлого нь язгуур уламжлалаа орхиж гээхгүйн зэрэгцээ орчин үеийн шинэ хэрэгцээг ч давхар бодолцсон шинжлэх ухааны гүн гүнзгий үндэстэй, ухаалаг мэргэн байвал зохилтой.(30)

Үзэл суртлын хатуу хяналтын цагт хэл шинжлэлийн зөв бодлого, шүүмжлэл зөв гольдролоороо хөгжиж чадаагүй нь одоо болтол үргэлжилсээр байна. Байгаа юмыг өөчлөн муучилж, сөнөөн устгах гэдэг туйлын хялбар хэрэг билээ. Байхгүй болсон буюу болгосон зүйлийг сэргээн бий болгох гэдэг маш хүнд хүчир бөгөөд асар их хөдөлмөр зардаг үйл явдал юм.

Би Монгол хүн гэж цээж дэлдэж л байгаа бол тэр хүнийг бүхнээс илүү илэрхийлэгч хэл, бичиг соёл, зан заншил, түүх соёлоо бүхнээс илүү мэдэж, хадгалж, хамгаалагч байх ёстой юм. Энд тэнд явахад би монгол хүн гэсэн мөртлөө ганц ч монгол үг мэдэхгүй хүн тааралдахад азийнхны царай адил юм чинь хэн мэдлээ л гэж бодогдоно.

Бид хэл, соёлынхоо төлөө анхаарал тавьж явахгүй бол их ч удахгүй хэдэн зууны дараа тэдэн шиг болж хичнээн ч би монгол хүн гэж цээжээ дэлдээд хэн биднийг үнэмших юм бэ? Үндэсний бичиг, яруу сайхан монгол хэлтэйгээ байсан цагт бид энэ ертөнцөд мөнхөд орших болно. Үндэстэн байгаа цагт үндэсний бичиг үсэг болон хэл байсаар байх болно.

Дөрөвдүгээр бүлэгт ишлэсэн ном зохиол

1. Д.Кара. Книги Монгольских кочевников. Москва, 1972, с.95-97
2. БНМАУ-ын түүх. II боть, УБ., 1968, х.591-592
3. Б.Цыбиков, Ш.Чимитдоржиев. Цыбен Жамцарано. Улан-Удэ, 1997, с.23
4. Б.Ренчин. Монгол бичгийн хэлний зүй. Удиртгал, УБ., 1964, х.160
5. Ц.Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. УБ., 1981, х.113
6. Р.Бямбаа. Ханд чин вангийн Дандар аграмбад XIII Далай лам Түвдэнжамц шавь орсон нь. Лавайн эгшиг. Гандантэгчилэн хийд, 1996, х.8-9
7. Росийские Монголведы. (XVIII -начало XX в.), Улан-Удэ,1997, с.91-95
8. Л.Бат-Очир, С.Отгонжаргал. XX зууны Монгол дахь улс төрийн түүхэн үйл явц. УБ., 1996, х.13-15
9. БНМАУ-ын түүх. II боть, УБ., 1968, х.590-591
10. Т.Содномдаржаа. Монгол ард улсын ном хэвлэлийн хураангүй түүх. УБ., 1965, х.5-14
11. БНМАУ-ын түүх. II боть, УБ., 1968, х.588-589
12. Л.Бат-Очир, С.Отгонжаргал. XX зууны Монгол дахь улс төрийн түүхэн үйл явц. УБ., 1996, х.29-30
13. Монголын уран зохиолын дээжис. УБ., 1996, х.225
14. УТТА.Ф. 23, хн 426. 25-р тал
15. С.Идшинноров, Г.Цэрэндорж. Үндэсний бичгээ халсан түүхээс гэрчлэх нь. /Үнэн/, 1990-3-3, №53
16. Г.Мэнд-Ооёо. Сонгодог уламжлалаа үгүйлсээр. /Утга зохиол/, 1990-2-9,№7

17. Л.Чулуунбаатар. Монгол бичгээ яах вэ. /Утга зохиол/, 1990-2-9, № 7
18. Г.Аким. Бичиг минь, хүлэг минь. /Утга зохиол/, 1990-2-9, № 7
19. Г.Мэнд-Ооёо. Сонгодог уламжлалаа үгүйлсээр. /Утга зохиол/, 1990-2-9, №7
20. С. Идшиннороов, Г.Цэрэндорж. Үндэсний бичгээ халсан түүхээс гэрчлэх нь. /Үнэн/, 1990-3-3, №53
21. Ж.Бямбаа. Үндэсний соёл сэргэнэ. /Утга зохиол/, 1990-3-23, №13
22. Мөн тэнд.№13
22. БНМАУ-ын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн эмхтгэл. БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай. 1991 он, х.320-323
23. Давид Лукаш. Монгол бичгийн эмгэнэлт хувь заяа. /Ил товчоо/, 1993-6-1-10, №14
25. Ц.Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. УБ., 1981, х.5
26. Э.Равдан. Монгол хэл, соёлын асуудалд. /Өнөөдөр сонин/, 1999 оны 3-р сар
27. Б.Сумьяа. Монголын нүүдэлчдийн соёл. Оршихуй, эс оршихуй. УБ.,1998, х.40
28. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991, х.137
29. Б.Я.Владмерцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия.1987, с.67
30. Б.Сумьяа. Монголын нүүдэлчдийн соёл. Оршихуй, эс оршихуй. УБ.,1998, х.42-43

Төгсгөлийн оронд

Дэлхий дахины санаа бичгийн дурсгалуудтай адил дурсгал бичиг Монгол нутагт арвин буй бөгөөд тэр нь түүх, угсаатны зүй, хэл шинжлэл, үсэг бичгийн эртний дурсгал болж байна. Хүннүгээс Кидан гүрэн хүртэлх (МЭӨ VI зуунаас МЭ XII зуун) монгол нутагт төр улсаа байгуулж явсан монгол үндэстнүүд өөр өөрийн төрийн онцлогт тохируулан бичиг үсэг авах буюу зохион хэрэглэж төр, соёл болон дипломатын үйл хэрэгтээ хэрэглэж байсан байна. Хүннү, Сүмбэ, Жужан /Нирун/, Түрэг нар рун бичиг хэрэглэж байжээ. Хүннү, Жужаны Авар нар руни бичгийг Европ дахинд хүргэсэн байна. Сүмбэ, Кидан хоёр хятадын дүрс үсгээс санаа авсан өөрийн бичиг үсгийг зохион хэрэглэжээ. Эртний монгол аймаг, улсуудын хэрэглэж байсан эдгээр бичиг үсэг нь монголчуудын бичиг үсгийн түүхэнд холбогдох боловч монгол хэлний бүтэц системийг тусгасан үндэсний бичгийн хэл болон нийтэд дэлгэрч чадсангүй, тухай тухайн үедээ бичгийн хэлний хэрэгцээг хангах төдий байжээ. Жужан /Нирун/ анх уйгар аймгийн хамт согдоос монгол бичгийг авсан бөгөөд Чингисийн үе хүртэл монгол овог аймгуудаар дамжин, төгөлдөржүүлэн уламжилж чадсан байна. Нэг шинэ улс гүрэн байгуулагдахад өөрийн үндэсний тусгаар тогтнолын онцлогыг харуулахын тулд өөрийн хэлэнд зохицсон бичиг үсэг авах буюу шинээр зохион хэрэглэх явдал олон овог аймгийг захиран удирдах болон гадаад гүрэн улстай харилцах зайлшгүй шаардлагын үүднээс Сяньби гүрний үеэс эхэлсэн байна. Монгол нутагт төр улсаа байгуулж явсан монгол аймгуудын бүтээсэн бичиг соёлын дурсгал хад чулуу, хөшөө дурсгал дээр үлдэж хоцорсон боловч арвин их зүйлс нүүдэлчдийн дайны хөлд

үрэгдэн устжээ. Үлдэж хоцорсон хөшөө дурсгалыг хадгалан хамгаалах, бүрэн гүйцэд судлан шинжлэх ажил өнөөгийн болон хойчийн хэл шинжлэлч, түүхч нарын үүрэг болж байна.

2. Монголын нэгдсэн гүрэн бий болсон нь нийтийг хамарсан нэгэн нэгдмэл бичгийн хэлтэй болох шаардлагыг бий болгож, энэхүү шаардлагыг хангахын тулд урьд цөөн аймгийн хэрэглэж байсан монгол бичгийг нийт монгол аялгуунуудын дундын байдлыг адил тэгш тусгасан илүү боловсронгуй бичгийн хэл болгож монгол хэл, соёлын хөгжилд туйлын том шинэтгэл хийхийн эхлэлийг тавьжээ. Монгол бичгийг XIII зуунд аваагүй нь эрдэмтэдийн судалгаанаас тодорхой байна. Бичиг үсгийн хөгжил нь бичгийн гарамгай мэргэдийг төрүүлсэн бөгөөд монгол нүүдэлчдийн түүх, уран зохиолын хосгүй дурсгалуудыг туурвин үлдээсэн байна. Монголын эртний улс гүрнүүдийн бичиг үсгийн системд Финик, Согд, Рунээр дамжсан эртний Энэтхэгийн Панины хэлзүй, хэл шинжлэлийн уламжлал хожим XIII зууны үед болж ирэхэд дахин Төвдөөр дамжин монголчуудын бичиг үсгийн системийг боловсронгуй болгоход бодтой туссан нь үзэгдэнэ. Жишээлбэл: Саж бандида Гунгаажалцан, Чойжи-Одсэр нар “Зүрхэн тольт” хэмээх хэлний зүйн бичиг зохиосон хийгээд Пагва лам дөрвөлжин үсгийг зохиож, дүрмийг зохиосон явдал юм. Нөгөөтэйгүүр нэг шинэ төр гүрэн үүсэхэд шинэ бичиг үсэгтэй болдог уламжлалын дагуу болон олон хэлийн улс орны нийтлэг эрх ашигт нийцэх нэгэн бичгийг зохиох шаардлага урган гарсанаас дөрвөлжин бичиг зохиогдон гарчээ.

3. XVII зууны эхэн гэхэд монгол бичгийн хэл үндэсний хэлний төгс хэлбэрийг олж, нутгын аялгуунуудыг төгс ижилсүүлэн

хөгжсөн хийгээд үсгийн хэлбэр тогтворжиж, үсгийн дүрмийн талаар хатуу тогтворжсон байна. Хатуу тогтворжсон явдал монголчуудын аялгуунаас хоцрох шалтгаан болжээ. Гэвч нутаг нутгийн аялгуугаар дуудаж болох түгээмэл хэлбэрийг олсон юм. Шашин номын олон арван зохиолыг хуулах болон амин хувь хийгээд албаны элдэв хэрэг явдлыг түргэн шуурхай тэмдэглэх, албан бичиг сийрүүлэх, тэмдэглэх, ном зохиолын эх ноорог хийх, ялангуяа хүний ярьсныг үг гээлгүй бичиж авах хэрэгцээнээс нөгөөтэйгүүр төвдийн шар бичгийн нөлөөгөөр монгол бичгийн таталган бичгийн хэлбэр энэ үед үүсчээ. Буддын шашин, соёлын нөлөөгөөр барын болон чимэглэлийн бичлэгийн олон хэлбэр үүсч олон зуун боть номыг орчуулан хэвлэж гаргасан байна. Монгол оронд шарын шашин өргөн дэлгэрсэн явдал нь төвд хэлийг хэрэглэх хэрэгцээг ихэсгэж, тухайн үедээ шашин номын хэл болж дорно дахины олон ухааныг цааш хөгжүүлсэн олон бүтээлийг бий болгожээ. Монгол бичиг мэдэхгүй хүмүүс төвд үсгийг ашиглан монгол хэлээр харилцах, ном зохиол бичих системийг бий болгожээ. Монгол хэлэнд орсон самгарьд, төвд, хятад зэрэг харь хэлний үг ухагдахуун, нэр томьёо олноор нэвтрэн орсноос нарийн зөв тэмдэглэх шаардлагыг буй болгож, энэ шаардлагын улмаас дэлхийн олон хэлний авиа, үсгийг тэмдэглэн чадах галиг үсгийн системийг монголчууд бий болгожээ. Эртний Энэтхэгийн болон дорно дахины хэл шинжлэлийн онолыг төгс эзэмшсэн монгол мэргэд яриа бичгийн хэлний зөрүүг арилгах өөрийн гэсэн шашин номын үсэг бичиг буй болгохын үүднээс тод, соёмбо, хэвтээ дөрвөлжин бичгийг зохион гаргасан байна. Дорно дахины номт мэргэд монголчуудын бичиг үсгийг сайжруулах, хөгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулж байсан бол XVI зуун болж ирэхэд монгол мэргэд өөрсдөө тэр

ухаанаас суралцан дэлхийн түүхэнд орох хосгүй бүтээлүүдийг туурвисан юм. Үүнд: Аюуш гүүш, Намхайжамц, Өндөр гэгээн Занабазар, Агваандандар, Агваандорж нарын олон мэргэдийн нэрийг дурьдаж болно. Соёмбо, хэвтээ дөрвөлжин хоёр үсгээр уран барилгын чимэглэл хийж байсан нь уран барилгын гоёмсог өнгө төрхийг чимэх болон хээ угалз, урлал чимэглэлийн хөгжилд зохих хувь нэмрийг оруулсан юм. Манжийн төрийн албанд монгол мэргэд ажиллаж, монгол бичгээр төрийн албыг залгуулж байгаад, монгол бичигт тулгуурлан манжийн шинэ үсгийг зохион гаргасан нь монгол бичгийн хөгжлийн гадаад нөлөөллийн нэг чухал үе болж байна. Манжид дагаар орсны дараа монгол нутагт манж бичгийг төрийн алба, өртөө улаа, сургалтын зарим газруудад явцуу хүрээнд хэрэглэж байв. Манж бичгийг төрийн албаны хэрэгцээнд хэрэглэхэд мөн л монгол мэргэд зүтгэж байв. Энэ нь 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнөөр зогссон бөгөөд арвин баян бичгийн дурсгалууд үлдэж хоцорчээ.

4. Вагиндрагийн үсэгт өрнө дахины бичгийн тогтолцооны нөлөө орсон бөгөөд энэ үсгээр зохиосон “Зүрхэн тольт” нь эртний Энэтхэг, Төвдийн хэлзүйн бичгээс улбаалсан монгол бичгийн уламжлалт зүрхэн тольтууд болон орос зэрэг өрнөдийн хэлзүйн нөлөө аль аль нь туссан, өрнө дорнын хэл шинжлэлийн онолыг хослон хэрэглэсэн хэлзүйн өвөрмөц бүтээл болсон юм. Латин, кириллд шилжих хөдөлгөөн бол хувьсгалч үзэл суртлын нөлөө байсан хийгээд кирилл үсэгт шилжсэнээр монголын ард түмэн бүх нийтээр бичиг үсэгтэн болж, утга зохиолын нэг нэгдмэл хэлтэй болсон хийгээд ярианы хэлэнд ойртсон гавьяатай боловч түүнийг хэрэгжүүлж ирсэн үзэл суртлын аргаас болоод уламжлалт монгол бичгийн яруу тансаг найруулга алдагдаж

сонин, сэтгүүлийн модон хэлний найруулга зонхилж хэл ядуурахад хүрсэн юм. Монгол бичиг бүхэлдээ оюун ухааныг дайчилж математик шиг сэтгэн бодуулдаг, үгийн үндэсийг эвдэхгүйгээр үг бүтээж болдог хийгээд дэлхийд хамгийн хурдан бичиж болдог бичиг болой. Монгол бичиг бол монголчуудын түүхэнд хамгийн урт удаан хэрэглэгдсэн, хэл, соёл, түүх, зан заншилтай нягт холбогдож, хэл, сэтгэхүйгээс салгаж болшгүйгээр нягт холбогдсон дэлхийн бичиг үсгийн түүхэнд зохих ёсны байраа бат эзэлсэн монголжсон бичиг үсэг юм. Тийм ч учраас монгол бичгийг сэргээх хөдөлгөөн эрчимтэй өрнөсөн боловч үндэсний бус сэтгэлгээ болон хялбарчлах сэтгэлгээг даван гарч чадаагүй юм. Монгол бичиг үсгийн түүх нь эхнээсээ аваад эцсээ хүртэл монголын ард түмний бие даасан байдал, тусгаар тогтнолын түүхтэй нягт холбоотой явж ирсэн билээ.

5. Монголчуудын бичиг үсгийн түүх нь дэлхийн бичиг үсгийн түүхэнд оруулсан салшгүй нэгэн үнэт хэсэг бөгөөд нүүдэлчин монголчуудын өндөр соёлтой байсны баталгаа болж байна.


6. Монголчуудын бичиг үсгийг зохиох, болон боловсронгуй болгоход Энэтхэг, Төвдийн мэргэн бандида нар оролцож байсан хийгээд хожим дорнын эрдэм ухааныг эзэмшсэн монгол мэргэд өөрсдөө үсэг бичгээ сайжруулах буюу зохион туурвих болсон байна. Энэ нь алдарт Панины хэл шинжлэлийн онолыг монгол мэргэд монгол нутагт бүтээлчээр хэрэгжүүлсэний баталгаа юм.


7. Монголчуудын үсэг бичиг болон түүгээр бичсэн хөшөө чулуу, хадны олон арван бичээсүүд болон судар номууд нь нүүдэлчин


монголчуудын үнэн бодит, дэлгэрэнгүй түүхийг дэлгэн харуулах толь болж байна.


8. Монгол бичгээ сурч судлах явдал монгол хүний үндэсний ухамсар, эх оронч үзлийн яруу тод илрэл мөн.


9. Монголчуудын бичиг үсгийн түүхийг харахад төв, хүрээний зарчим буюу арга, билгийн шүтэлцээгээр бие биеэ ээлжлэн халах өөрөөр хэлбэл, дахин шинээр хүчтэй боловсронгуй болон хэрэглэгдэж байсан байна.



HUNNU
Runi
Chinese
Sogd


SIYAMBI
Siyambi
Chinese
Runi



JUJAN
Mongol
script
Sogd
Runi
Chinese


TUREG
Runi
Brahma
Mongol



UIGAR
Mongol Uigar
Brahma
Runi


KIDAN
Siyambi
Chinese
Mongol


MONGOLIAN EMPIRE




YANI DINASTY




XVII-XX centeries MONGOLIA




ALI GALI 1587




JUNGARY




CHIN DINASTY




MONGOLIA 1911-1941



BURIYAT 1905-1930



MONGOLIA 1941-



НОМ ЗҮЙ

Монгол хэлээрх ном, өгүүллүүд.

1. Аким Г. Диваажинд очихын хувь. 1998
2. Аким Г. Бичиг минь, хүлэг минь. /Утга зохиол/, 1990-2-9, № 7
3. Алтангэрэл Ч. Монголын зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл. I, II дэвтэр. УБ., 1967
4. Ардын эрх. 1996-8-2, No 153/1371
5. Археологийн судлал. Ред. Н.Сэр-Оджав. XIII:I,1987
6. Баавгай Ч., Болдсайхан Б. Монголын уламжлалт анагаах ухаан. УБ., 1990
7. Бадарч С. Улсын дээд шүүгч. Чингисийн туг. 1990
8. Базылхан Б. Монгол-казак толь. УБ., 1984
9. Балжинням Н. Монгол бичгийн нэгэн гайхамшиг. /Засгийн газрын мэдээ/, 1993-11-7, №256
10. Батмөнх Б. Огторгуйн далай. /Ил товчоо/, 1998, No. 26-27
11. Бат-Очир Л., Отгонжаргал С. XX зууны Монгол дахь улс төрийн түүхэн үйл явц. УБ., 1996
12. Баянсан Ж., Одонтөр Ш. Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь. УБ., 1995
13. Бира Ш. БНМАУ-ын соёл, түүхийн бичлэгийн асуудалд. УБ., 1977
14. БНМАУ-ын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн эмхтгэл. БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай. 1991
15. Болд Л. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. УБ., 1990
16. Болдбаатар Ж., Лүндаажанцан Д. Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997

17. Бямбаа Ж. Үндэсний соёл сэргэнэ. /Утга зохиол/, 1990-3-23, №13
18. Бямбаа Р. Ханд чин вангийн Дандар аграмбад XIII Далай лам Түвдэнжамц шавь орсон нь. /Лавайн эгшиг. Гандантэгчилэн хийд/, 1996
19. Давид Лукаш. Монгол бичгийн эмгэнэлт хувь заяа. /Ил товчоо/, 1993-6-1-10, №14
20. Дагвадорж Ч. Монголын шашин суртахууны тайлбар толь. УБ., 1995
21. Дагвадорж Ч. Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. УБ.,1998
22. Далай Ч. Юан гүрний үеийн монгол. УБ., 1973
23. Далай Ч. Монголын түүх. Их Монгол улс. /1206-1260/, Дэд дэвтэр, УБ., 1994
24. Дамдинсүрэн А. Хүннү гүрэн 6-8 мянган жилийн түүхтэй. /Дээжис/, 1997, 1 сар, №01
25. Дамдинсүрэн А. Монгол дөрвөлжин бичиг. УБ., 1986
26. Дамдинсүрэн Ц. Монгол уран зохиолын дээж зуун билиг оршибай. УБ., 1959
27. Дамдинсүрэн Ц. Монгол хэл бичгийн тухай. УБ., 1957
28. Дорж Д. Төв хэл бичигт суралцах дэвтэр. УБ., 1961
29. Ёндон Д. Төвд монголын утга зохиолын харилцааны асуудалд. УБ., 1980
30. Жаргалсайхан Б. Олон жилийн хууч. Элчин сайдын тэмдэглэл, УБ., 1997, х.15
31. Жиованни Дель, Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988
32. Жүгдэр Ч. З.Агваанбалдангийн гүн ухааны үзэл. Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл. УБ., 1978

33. Жүгдэр Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 1987
34. Идшиннороv С., Цэрэндорж Г. Үндэсний бичгээ халсан түүхээс гэрчлэх нь. /Үнэн/, 1990-3-3, №53
35. Их бандид Зава Дамдин. /Засгийн газрын мэдээ/. №227, 1996
36. Лочин С. Хэлний эзэн хүндэт цол хүртэв. /Үнэн/, 1990-3-18, №59
37. Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. УБ., 1975
38. Лувсанбалдан Х. Ойрадын Зая бандидын орчуулгын тухай мэдээ. /Хэл зохиол/. Т.6. facs.6
39. Лувсанвандан Ш. Орчин цагийн монгол хэлний зүй. УБ., 1966
40. Мандир Т. Хөх төрийн хөтөч. Чингисийн туг, 1990
41. Манжийн дарангуйллын үеийн монголын сургууль. 1776-1911, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. УБ.,1965
42. Монголын автономит үеийн сургууль, 1911-1920, УБ., 1966
43. Монгол ардын хувьсгалт намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 1966
44. Монгол –Татарууд Ази Европт. УБ., 1984
45. Монголын их бандид Зава Дамдины намтар цэдэг оршвой. /Сонинбаярын орчуулга/
46. Монголын нууц товчоо. Хоёр дахь удаагийн хэвлэл. Хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлнээ Ц.Дамдинсүрэн орчуулав. УБ., 1947
47. Монголын уран зохиолын дээжис. УБ., 1996
48. Монголын уран зохиолын дээжис. I боть, УБ., 1995
49. Монголын уран зохиолын тойм. II дэвтэр. УБ., 1977
50. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ., 1995
51. Мэнд-Ооёо Г. Сонгодог уламжлалаа үгүйлсээр. /Утга зохиол/, 1990-2-9, №7

52. Наваан Д, Сумъяабаатар Б. Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал. УБ., 1987
53. Надмид Ж. Монгол хэл, түүний бичгийн хэлний түүхэн тойм. УБ., 1967
54. Намнандорж О. Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай. УБ., 1956
55. Насанбалжир Ц. Ар монголоос Манж чин улсад залгуулж байсан алба. 1691-1911, УБ.,1964
56. Өвөрмонголын их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. 1996, №6
57. Пүрэвжав С. Монгол дахь шарын шашны хураангуй түүх, УБ., 1978
58. Пагва Т. Төвд үсгээр үгчилсэн монгол ном зохиол. SM. Т.1, facs. 25, УБ., 1969
59. Пэрлээ Х. Хятан нар тэдний монголчуудтай холбогдсон нь. УБ., 1959
60. Пэрлээ Х. Хятан бичгийг уншин туршсан нь. SH.1965. V боть. 7-р дэвтэр
61. Пэрлээ Х. Гурван өгүүлэл. Чингисийн чулууны бичиг. SM. Т.3. facs.13. УБ., 1962
62. Равдан Э. Монгол хэл, соёлын асуудалд. /Өнөөдөр сонин/, 1999 оны 3-р сар
63. Равжамба Зая бандидын тууж сарны гэрэл хэмээх энэ мэт болой. УБ., 1959
64. Рамстедт Г.И. Монгол бичгийн хэл, Халхын хүрээний аман аялгуу хоёрыг авиан зүйгээр харьцуулсан нь. /Хэл зохиол/, 1967
65. Ренчин Б. Монгол үсгийн гарал, хөгжил. Хөх хот. 1956
66. Ренчин Б. Монгол бичгийн хэлний зүй. УБ., 1964
67. Сайшаалт. Чингис хааны товчоон. Хөх хот, 1985

68. Сандерс Ж.Ж. Монголын байлдан дагуулал. УБ., 1992
68. Содбилэг. Шашны толь. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. Хөх хот, 1996
69. Содномдаржаа Т. Монгол ард улсын ном хэвлэлийн хураангүй түүх. УБ., 1965
70. Сумьяа Б. Монголын нүүдэлчдийн соёл. Оршихуй, эс оршихуй. УБ.,1998
71. Сүхбаатар Г. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа, гарвал. УБ.,1980.
72. Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1988
73. Сүхбаатар Г. Сяньби нарын угсаа гарал, соёл, аж ахуй, нийгмийн байгуулал. УБ., 1971
74. Сүхбаатар Г. Их Нирун. УБ., 1983
75. Сүхбаатар Г. Монголын түүхийн дээж бичиг. I, УБ., 1992
76. Сүхбаатар Г. Монголын нууц товчоон дахь эртний уламжлал./Mongolica/. Vol. 1(22), 1990
77. Сүхбаатар Г. Хүннү бичигтэй байсан байсан тухай. ШУА-ийн мэдээ. 1967. №2
78. Сүхбаатар Г. Киданы эртний бичгийн тухай мэдээ. 1969. Т.7.17
79. Сүхбаатар Г. Сяньби нарын бичгийн тухай хэдэн мэдээ. /ШУА-ийн мэдээ/. 1969. №2
80. Сүхбаатар Г. Эрт үед бурхны шашин монголын төрийн уламжлалд нөлөөлж байсан тухай. /Монгол ба Энэтхэг/. УБ., 1989
81. Тогтох Н. Монгол хаадын тамгийн нууц./Монголын жаран сонин/, №1, 1990
82. Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншлийн зарим асуудалд. УБ., 1997
83. Төмөртогоо Д. Монгол хэлний түүхэн хэлзүй. УБ., 1992

84. Төмөртогоо Д. Монгол данжуур дахь эртний энэтхэг хэл шинжлэлийн зохиолууд. /Монгол ба Энэтхэг/. УБ., 1989
85. Төмөртогоо Д. Монгол хэл шинжлэлийн түүхэн уламжлал ба онолын үндэс. /Хэл зохиол судлал/, XVII боть, 1-20 боть
86. Утга зохиол. 1990-3-23, №13
87. Хүрэлбаатар Л. Өндөр гэгээн Занабазар. /ШУА, ОУМСХ, Эрдэм шинжилгээний бичиг/, УБ., 1998
88. Хүрэлбаатар Л. Төвд монгол данжуурын доторх төр ёсны найман шастир. /SM. T. 9. Facs/. 15. 1982
89. Цолоо Ж. Орчин цагийн монгол хэлний авиа зүй. УБ., 1976
90. Цэнд Д. XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалаас. SLL. T.2 /Эрдэм шинжилгээний өгүүллүүд/ f.10. УБ., 1964
91. Цэрэнсодном Д. Монголын бурхны шашны уран зохиол. УБ., 1997
92. Чойжилсүрэн Д. Буриад модон барын номын таван гарчиг. УБ., 1959
93. Чоймаа Ш. Төвд хэл сурах дэвтэр. УБ., 1993
94. Чоймаа Ш., Тэрбиш Л., Бүрнээ Д., Чулуунбаатар Л. Буддын шашин соёлын тайлбар толь. I, II боть. УБ., 1999, 2000
95. Чулуунбаатар Л. Монгол бичгээ яах вэ. /Утга зохиол/, 1990-2-9
96. Чулуунбаатар Л. Монгол ярианы хэл I , II дэвтэр УБ., 1996
97. Чулуунбаатар Л. Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон. Хамтын бүтээл, УБ., 2001
98. Чулуунбаатар Л. Гэрдбазарын Төвд- Монгол толийн тухай. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 1983 оны №1, 2
99. Чулуунбаатар Л. Төвд үсгийг галиглах Монгол галигийн асуудалд. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 1989 №6,
100. Чулуунбаатар Л.Төвд үсгээр бичсэн зохиол бүтээлд Монгол хэлний эгшиг авиаг тэмдэглэсэн байдал. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, 1990 он, №2

101. Чулуунбаатар Л. Санскрит үсгийг галиглах Монгол галиг. Монгол ба Энэтхэг 1989
102. Чулуунбаатар Л. Монголын эзэнт гүрний бичиг үсэг. Монгол судлалын сургуулийн эрдэм шинжилгээний бичиг, эрхэлсэн доктор Ц.Шагдарсүрэн 1992, №2
103. Чулуунбаатар Л. Мартаж болшгүй соёл. МУИС-ийн “Мэдлэг” сонин 1989.1. 24, №1
104. Чулуунбаатар Л.Монголоор сэтгэнэ гэдэг модон толгойн бодол. /Ил товчоо/ сонин 1998.2.10-20
105. Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991
106. Шагдарсүрэн Ц. Монгол үсэг зүй. УБ., 1981
107. Шагж. Монгол үсгийн дүрмийн толь бичиг. УБ., 1938
108. Ширэндэв Б. Эртний монгол бичгийн хуулбар ингэж манайд шилжиж ирэв. ШУАМ, 1968. №2
109. Эзэн богд Чингисийн “Их Засаг”. УБ., 1995

Орос хэлээрх ном зохиол.

1. Алтан товч. Лувсанданзан. Перевод с монгольского, введение, комментарий и приложения Н.П.Шастиной. М., 1973
2. Бадараев Б.Д. Об основах транскрипции и транслитерации для тибетского языка. Улан-Удэ, 1967
3. Балданжапов.П.Б. Altan Tobci.Монгольская летопись XVIII в. Улан-Удэ., 1970
4. Банзаров Д. Собрание сочинений. Изд. АН СССР. М., 1955
5. Бертагаев Т.А.Цыдендамбаев Ц.Б. Грамматика бурятского языка. Синтаксис. М., 1962
6. Бира Ш. Монгольская историография (XIII-XVII вв). М., 1978

7. Бобровников А. Грамматика монгольского-кальмыцского
8. Викторова Л.Л. Монголы. Происхождение народа и истоки культуры. М., 1981
9. Владимерцов Б.Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. М., 1987
10. Владимерцов Б.Я. Монгольская литература /Литература Востока/. Сборник статей. Вып. II, 1920
11. Владимерцов Б.Я. Монгольский международный алфавит XIII века. /Культура и письменность Востока/. М., 1931
12. Владимерцов Б.Я. Монгольские литературные языки. Ленинград., 1939
13. Воробьев М.В. Культура чжурчженей и государства Цзинь. М., 1983
14. Голстунский К.Ф. Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдан-хун тайджия и законы, составленные для Волжских калмыков при калмыцком хане Дондук-даши. Санкт-Петербург., 1880
15. Жуковская Н.Л. Ламаизм и ранние формы религии. М., 1977
16. Заятуев Г.Н. Цанид-хамбо Агван Доржиев (1853-1938). Улан-Удэ., 1991
17. Златкин И.Я. История Джунгарского ханства. Москва., 1964
18. Истрин В.А. Возникновение и развитие письма. М., 1965
19. Кара Д. Книги монгольских кочевников. Москва., 1972
20. Корнев.В.И. Буддизм и его роль в общественной жизни стран Азии. М., 1983
21. Кочетов А.Н. Буддизм. Москва., 1983
22. Новогородова Э.А. Мир петроглифов Монголии. Москва., 1984
23. Позднеев А.М. Буддизм в Монголии. Элиста., 1993

24. Поппе Н.Н. Квадратная письменность. Труды Московского ин-та Востоковедения. М-Л., 1941
25. Поппе Н.Н. Монгольский словарь Мукаддимат ал-Адаб. ч. I-II, М-Л., 1938
26. Пубаев Р.Е. Агван-Доржиев – организатор обновленческого движения в бурятском буддизм в 30-е гг. /Национально-освободительное движение бурятского народа/. Улан-Удэ., 1989
27. Пубаев Р.Е. “Пагсам-чжонсан” - памятник тибетской историографии XVIII века. Новосибирск., 1981
28. Пучковский Л.С. Некоторые вопросы научного описания монгольских рукописей. /Советское востоковедение/. II. М-Л., 1941
29. Пучковский Л.С. Заключительная формула в письмах Ильханов Аргуна /1289/ и Улзейту /1305/. /Советское востоковедение/. 1949. №6
30. Рашид-ад-дин. Сборник летописей. 1,2. Перевод с персидкого Ю.П.Верховского. М., 1960
31. Рерих Ю.Н. Тибетский язык. Москва., 1961
32. Российские Монголоведы. (XVIII -начало XX в.). Улан-Удэ.,1997
33. Роль кочевых народов в цивилизации Центральной Азии. Улаанбаатар., 1974
34. Санжеев Г.Д. Старописьменный монгольский язык. М.,1964
35. Санжеев Г.Д. Монгольский язык. М., 1960
36. Санжеев Г.Д. Синтаксис монгольских языков. М., 1934
37. Стариков. Материалы по дешифровке киданьского письма. М., 1970
38. Сүхбаатар Г. К вопросу о времени появления письменности у народов Центральной Азии. / SM. 1970. T.8.f.9/
39. Тахо-Годи А.А. Амазонки. / Мифы народов мира/. 1980

40. Цыбиков Б., Чимитдоржиев Ш. Цыбен Жамцарано. Улан-Удэ., 1997
41. Цыбыков Г.Ц. Монгольская письменность как орудие национальной культуры. Верхнеудинск., 1928
42. Шарма Р.Ш. Древнеиндийское общество. М., 1987

Бусад гадаад хэлд дээрх ном зохиол.

1. Altheim F. Geschichte der Hunnen. Erster Band. Berlin, 1969
2. Bawden Ch. Modern History of Mongolia. L., 1966
3. Ligeti L. Le Tabghatch, un dialecte de la language sien-pi /Mongolian Studies/. Budapest, 1970
4. Pelliot P. Les systemes d'ecriture en usage chez les anciens mongols /Asia Major/, vol. Secundum, 1925
5. Phillips E.D. The Mongols. London, 1969
6. Poppe N. The Mongolian Monuments in 'Phags-pa script. Second Edition Translated and Edited by John R.Krueger. Wiesbaden 1957
7. Rinchen B. Four Mongolian historical records. New Delhi, 1959
8. Robert L.Binnick. Modern Mongolian. A Transformational Syntax. University of Toronto, 1979
9. Rona Tas A. Some notes on the terminology of Mongolian writing /Acta Orientalia Hungarica/, t. 18, 1965
10. Shiro Hattori. The Mongolian Monuments found in Olon-Sume. /The Toho Gakuho №11/. Part 2. Tokyo, 1940
11. Yongsiyebu Rincen. Les inscription inconnues sur pierre et les plaques d'or ornamentees du harnais de Toyoucouc /Central Asiatic Journal/, vol 4, No 4
12. Kenneth Katzner. The languages of the World. London, 1999

Сурвалж бичиг.

1. Алтангэрэл Ч. Монголын зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл. I, II дэвтэр. УБ., 1967
2. རྣམ་དིན། ཇོར་ཆོས་འབྱུན། Rtam din Hor-chos' byun
3. Вэйшу. 4-р бүлэг
4. Монголын их бандид Зава Дамдины намтар цэдэг оршвой. Ш.Сонинбаярын орчуулга
5. Монголын уран зохиолын дээжис. УБ., 1996
6. Монголын уран зохиолын дээжис. I боть, УБ., 1995
7. Оюун түлхүүр. Гар бичмэл. Монгол улсын Улсын төв номын сан.
8. Равжамба Зая бандидын тууж сарны гэрэл хэмээх энэ мэт болой. УБ., 1959
9. Сүхбаатар Г. Монголын түүхийн дээж бичиг. I, УБ., 1992
10. Юань улсын судар. Гар бичмэл. Ч.Дандаагийн орчуулга. Улсын номын сан

Диссертац болон автореферат.

1. Дулам С. Образы монгольской мифологии и литературная традиция. Автореф. канд. дис. М., 1982
2. Ёндон Д. Монгольские и тибетские комментарии к Ламоиму. Автореф. канд. дис. УБ., 1976
3. Баттулга Ц. Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын зарим судалгаа. Автореф. канд. дис. УБ., 1999
4. Жанчив Е. Монгол дөрвөлжин бичгийн судалгаа, Автореф.канд.дис.УБ., 2000

Лувсанжавын Чулуунбаатар

Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн Б. Ариунзул

Хэвлэлтэнд 2002 оны 05-р сарын 25

Цаасны хэмжээ 60х90

Хэвлэлийн хуудас 15,6

Хэвлэсэн тоо 1000ш

МУИС-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

251

Лувсанжавын Чулуунбаатар

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр суманд 1952 онд төрсөн. Монгол Улсын Их Сургуулийн Монгол хэлний анги, Англи хэлний 2 жилийн оройн курс, ОХУ-ын Улаан-Үдийн Монгол-Төвд буддын судлалын хүрээлэнгийн аспирантурт тус тус суралцсан. Төвд, англи хэл, монгол хэл-уран зохиолийн багшийн мэргэжилтэй.

Гадаад хүнд монгол хэл заах чиглэлээр Монгол ярианы хэл I,II дэвтэр; Буддын шашин, соёлын тайлбар толь I,II дэвтэрийн болон Төв Азийн бичиг үсгийн товчоон номын хамтын зохиогч хийгээд эрдэм шинжилгээний 30 гаруй өгүүлэл бичиж, дотоод, гадаадад хэвлүүлэв. Олон улсын эрдэм шинжилгээний 6 хуралд оролцож, илтгэл тавьсан. Англи улсын Лондон, Кембрижийн их сургуульд Монгол хэлний багшаар, МУИС-д багш, аспирантур хариуцсан мэргэжилтэн, гадаад харилцааны хэлтсийн дарга, тэнхмийн эрхлэгч зэрэг ажлыг 1981 оноос хойш хийж байна.